



НЭЭЛТТЭЙ  
НИЙГЭМ  
ФОРУМ



# ШҮҮХИЙН ШИЙДВЭРИЙН СУДАЛГАА

ЦУВРАЛ 2



НЭЭЛТТЭЙ  
НИЙГЭМ  
ФОРУМ

# ШҮҮХИЙН ШИЙДВЭРИЙН СУДАЛГАА

---

## ЦУВРАЛ 2

Улаанбаатар 2021

ННА 67.3  
ДАА 340.009  
Ш-944



## ШҮҮХИЙН ШИЙДВЭРИЙН СУДАЛГАА ЦУВРАЛ 2

### СУДЛААЧИД:

1. Б.Батзориг
2. О.Мөнхцэцэг
3. Б.Пүрэвсүрэн
4. Ц.Цэлмэг, Д.Оросоо

Дугаар хариуцсан редактор Г.Оюунболд

© Нээлттэй Нийгэм Форум, 2021.

Энэхүү цувралд багтсан судалгаануудын дүгнэлт, санал нь судалгааг хийж гүйцэтгэсэн судлаачдын байр суурь, үзэл бодол бөгөөд Нээлттэй Нийгэм Форумын албан ёсны байр суурийг илэрхийлэхгүй болно.

ISBN 978-9919-9812-1-1

# Шүүхийн шийдвэрийн судалгаа

## ЦУВРАЛ 2



# 1

**АВЛИГЫН ГЭМТ ХЭРГИЙГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭСЭН  
УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН ШИЙДВЭРИЙН  
ДҮН ШИНЖИЛГЭЭ**

9

# 2

**УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН ХЯНАЛТЫН ШАТНЫ  
ЭРҮҮГИЙН ХЭРГИЙН ШҮҮХИЙН ШИЙДВЭРИЙН  
ДҮН ШИНЖИЛГЭЭ**

67

# 3

**ХУДАЛ МЭДЭЭЛЭЛ ТАРААХ ГЭМТ ХЭРГИЙГ  
ШИЙДВЭРЛЭСЭН ШҮҮХИЙН ШИЙДВЭРИЙН  
ДҮН ШИНЖИЛГЭЭ**

91



**ЗАЛИЛАХ ГЭМТ ХЭРГИЙГ ШИЙДВЭРЛЭСЭН  
ШҮҮХИЙН ШИЙДВЭРИЙН ДҮН ШИНЖИЛГЭЭ**

## ӨМНӨХ ҮГ

Нээлттэй Нийгэм Форумын Шүүхийн хараат бус байдлыг бэхжүүлэх хөтөлбөрийн хүрээнд эрүүгийн шүүхийн шийдвэрүүдэд хийсэн шинжилгээний дүнг Та бүхэнд танилцуулж байна. “Шүүхийн шийдвэрийн судалгаа” цувралын энэхүү дугаарт авлига, албан тушаалын гэмт хэрэг, олны анхаарал татсан гүтгэх гэмт хэргийг шийдвэрлэсэн шүүхийн шийдвэрийн дүн шинжилгээ багтсан болно. Түүнчлэн сүүлийн жилүүдэд нэмэгдэж, иргэдэд их хэмжээний хохирол учруулж буй залилангийн гэмт хэргийг шийдвэрлэж байгаа шүүхийн практик, анхаарах асуудлыг хөндсөн тойм судалгаа тус цувралд багтлаа.

“Шүүхийн шийдвэрийн судалгаа” цувралын Редакцын зөвлөлийн гишүүн, энэ удаагийн дугаарыг эрхлэн гаргасан эрүүгийн эрх зүйн тэргүүлэх судлаач, хуульч Г.Оюунболдод эдгээр тайланг хянан тохиолдуулж, агуулгын хувьд зөвлөн сайжруулж, бүтэц, зохион байгуулалтыг нь боловсронгуй болгох чиглэлээр судлаач бүртэй хамтран ажилласанд гүн талархал илэрхийлье.

Энэхүү цувралд орсон судалгааны тайлангууд нь эрүүгийн хууль тогтоомжийн шинэтгэлийг гүнзгийрүүлэх, шүүхийн практикт хууль хэрэглээг нэг мөр болгох, шинэ тутам зохицуулалтын хэрэгжилтийг хангахад шүүгч, прокурор,

практикийн бусад хуульчдад тус дөхөм болно гэдэгт найдаж байна. Эрхэм хуульч, судлаач Та бүхэн энэхүү судалгааны талаар санал шүүмжээ бидэнтэй харамгүй хуваалцаж, шүүхийн практик судалгааг хөгжүүлэх үйлсэд хувь нэмрээ оруулахыг хүсье.

П.Эрдэнэжаргал  
ННФ-ын Гүйцэтгэх захирал

## **РЕДАКТОРЫН ЗУРВАС**

Орчин үед эрх зүйн хөгжил хурдацтай өрнөхийн хэрээр хууль тогтоомжийн шинэтгэл эрчимтэй үргэлжилж байна. Энэхүү шинэчлэлийн процесс нь нэг талаасаа хууль зүйн судалгаа, шинжилгээний үр дүн бөгөөд нөгөө талаасаа аливаа шинэчлэл, хөгжил нь гагцхүү шинжлэх ухааны арга зүй, үр дүнд тулгуурладаг билээ.

Эрүүгийн эрх зүйн хөгжил, цаашдын чиг хандлага нь эрүүгийн хууль тогтоомжийн хэрэглээ, онолын болон шинжлэх ухааны тайлбар, гэмт хэргийн зүйлчлэл, ялын бодлогод хийсэн судалгаа, шинжилгээний үр дүнгээс ихээхэн хамаардаг. Энэ удаагийн эрүүгийн хэргийн шүүхийн шийдвэрт хийсэн дүн шинжилгээний тайлангууд нь залилах, худал мэдээлэл тараах, авлига, албан тушаалын зэрэг тодорхой төрлийн гэмт хэргийг шүүхээр шийдвэрлэсэн байдлыг судалгааны арга зүйд тулгуурлан, онолын болон практик асуудлыг дэвшүүлэн судалснаараа илүү онцлогтой юм.

Эдгээр судалгааны хүрээнд шинээр батлагдсан Эрүүгийн хуулийг хэрэгжүүлэх явцад тодорхой нэр томъёо, ухагдахууныг тайлбарлаж хэрэглэсэн, гэмт хэргийн зүйлчлэл хийсэн, эрүүгийн хариуцлага оногдуулсан шүүхийн шийдвэрийн агуулга, хэлбэр, үндэслэл зэргийг судалжээ. Түүнчлэн цаашид хуулийн зүйл, хэсэг, заалтыг практикт нэг мөр болгож,



хоёрдмол утгагүйгээр хэрэглэх талаар үндэслэл бүхий санал, зөвлөмж боловсруулсан нь энэхүү дүн шинжилгээний ач холбогдлыг дээшлүүлжээ.

Энэхүү шүүхийн шийдвэрийн дүн шинжилгээний тайлангуудыг хууль тогтоомжийн давхардал, хийдлийг арилгах практик, мөн хуульч, эрдэмтэн судлаач, хууль зүйн их, дээд сургуулийн оюутан, сонсогч тухайлсан сэдвээр гүнзгийрүүлэн судлах, сургалтад ашиглах боломжтой гэж үзэж байна.

Редакцын зөвлөлийн гишүүн  
Г.Оюунболд

# 1

## АВЛИГЫН ГЭМТ ХЭРГИЙГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭСЭН УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН ШИЙДВЭРИЙН ДҮН ШИНЖИЛГЭЭ

### СУДЛААЧИЙН ТАНИЛЦУУЛГА



#### БАДАМЫН БАТЗОРИГ

Хууль зүйн ухааны доктор, дэд профессор тэрээр эрүүгийн процесс, криминологийн чиглэлээр мэргэшсэн судлаач, багш.

Төрийн байгууллагад 30 жил ажилласан. Үүний дотор 1997 оноос сургалт, судалгаа шинжилгээний ажил, 2011 оноос хууль тогтоомж боловсруулах ажилд оролцож байна. Дангаараа болон бусадтай хамтран нэг сэдэвт 29 бүтээл, сурах бичиг, гарын авлага боловсруулжээ.

Судлаач:

Б.Батзориг

## ГАРЧИГ

Удиртгал .....	12
1. УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН ЭРҮҮГИЙН ХЭРГИЙН ШҮҮХ ХУРАЛДААНЫ ТОГТООЛД ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ	
1.1. Танилцуулах хэсэг .....	14
1.2. Хэргийн агуулга .....	14
1.3. Шийдвэрлэсэн байдал .....	16
2. ШҮҮХИЙН ШИЙДВЭРИЙН ШИНЖИЛГЭЭ .....	27
2.1. Хууль дээдлэх зарчим ба шүүхийн шийдвэр үндэслэлтэй байх .....	27
2.2. Хахууль өгөх, авах гэмт хэргийн нотолбол зохих байдал .....	33
2.2.1. Хээл хахуулийн гэмт хэрэг гарсан байдал, хахуулийн хэмжээ .....	34
2.2.2. Шударга ёсны зарчим ба хариуцлага хүлээлгэхэд хөнгөрүүлэх, хүндрүүлэх асуудал .....	36

2.3. Ялаас чөлөөлсөн байдал .....	39
2.4. Шүүгч шүүн таслах үүргээ хэрэгжүүлэхэд хөндлөнгөөс оролцохыг хориглох .....	39
2.5. Өмнө гарч байсан төсөөтэй хэрэг хянан шийдвэрлэсэн шүүхийн шийдвэртэй харьцуулсан байдал .....	44
Дүгнэлт, зөвлөмж .....	50
Ашигласан материал .....	53
Хавсралт .....	55

## УДИРТГАЛ

Нээлттэй Нийгэм Форум (ННФ)-аас хэрэгжүүлж буй Шүүхийн хараат бус байдлыг бэхжүүлэх хөтөлбөрийн хүрээнд Эрүүгийн хуулийн тусгай ангийн 22 дугаар бүлэгт заасан Авлигын гэмт хэргийг хянан шийдвэрлэсэн Улсын Дээд шүүхийн шийдвэрүүдээс 2020 оны 2 дугаар сарын 5-ны өдрийн 79 дүгээр тоот шийдвэрийг сонгон авч Шүүхийн ерөнхий зөвлөлийн Шүүхийн судалгаа, мэдээлэл, сургалтын хүрээлэнгээс 2015 онд боловсруулсан Шүүхийн шийдвэрт дүн шинжилгээ хийх аргачлалын дагуу дүн шинжилгээ хийлээ.

Тус удирдамжийн дагуу Эрүүгийн хуулийн тусгай ангийн 22 дугаар бүлэгт заасан “Авлигын гэмт хэрэг”-ийг хянан шийдвэрлэсэн Улсын Дээд шүүхийн тогтоолоос хэргийн бодит байдал, анхан шатны шүүхийн шийдвэрийн үндэслэлтэй танилцах боломжгүй байв. Иймд анхан шатны шүүхийн тогтоол, давж заалдах шатны шүүхийн магадлалыг тусгайлан судалсныг дурдах нь зүйтэй.

Шүүхийн шийдвэрийг сонгон авахдаа олон нийтийн анхаарал татсан, шүүх хуралдаан болохоос өмнө хэвлэл мэдээллийн хэрэгслээр хэргийн баримт, үйл явц давтамжтайгаар цацагдсан байдлыг харгалзан үзсэн болно. Түүнчлэн олон үйлдэлтэй гэмт хэргийн тухайн үйлдэл тус бүрийн нөхцөл байдлыг хэрхэн нотолж тогтоосон онцлог нь

судлаачийн зүгээс тус хэргийг тусгайлан судлахад нөлөөлснийг цохон тэмдэглэх нь зүйтэй.

Дүн шинжилгээний 1, 2, 3 дугаар хэсэгт хэргийн гол үйл баримт, процессын түүх, шийдвэрлэсэн байдлыг бодитой шинжлэн судалж, шийдвэрийн хууль зүйн үндэслэл бүрт дүн шинжилгээ хийж, өмнө гарч байсан ойролцоо төрлийн шүүхийн шийдвэрүүдтэй харьцуулан судалж, үнэлгээ өгснөөс гадна шүүхийн шийдвэрийн ач холбогдол, цаашид тулгамдаж байгаа асуудалд санал, дүгнэлт гаргахыг зорилоо.

# 1. УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН ЭРҮҮГИЙН ХЭРГИЙН ШҮҮХ ХУРАЛДААНЫ ТОГТООЛД ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ

## 1.1. ТАНИЛЦУУЛАХ ХЭСЭГ

- (1) Шүүхийн шийдвэрийн нэр: Нийтийн албан тушаалтан, аж ахуйн нэгжийн төлөөллөөс бүрдсэн 25 хүнд холбогдох Эрүүгийн хуулийн 22.4, 22.5 дугаар зүйлд заасан хахууль авах, хахууль өгөх гэмт хэрэг;
- (2) Шийдвэрлэсэн шүүх, огноо: Улсын Дээд шүүхийн эрүүгийн хэргийн танхим, 2020 оны 2 дугаар сарын 5-ны өдрийн 79 дугаартай тогтоол.

## 1.2. ХЭРГИЙН АГУУЛГА

### **Үйл баримт**

Мэргэжлийн хяналтын газрын экспорт, импорт, хилийн хорио цээрийн хяналтын газар, хэлтсийн дарга, ажилтнуудаас бүрдсэн зургаан албан тушаалтан иргэдээс гаргасан “Түргэн муудах болон хүнсний бүтээгдэхүүн экспортлох зөвшөөрөл, импортын мэдэгдэл авах хүсэлт”-ийг шийдвэрлэхгүй удаах, хясан боогдуулах замаар нэр бүхий 19 хүн, “хуулийн этгээд”-ээс 2017 оны 5 дугаар сарын 26-ны өдрөөс 2017 оны 12 дугаар сарын 7-ны өдрийн хооронд Чингэлтэй дүүргийн

4 дүгээр хорооны нутаг дэвсгэрт байрлах ажлын байран дээрээ удаа дараагийн үйлдлээр хахууль авсан.

Тус эрүүгийн хэрэг нь олон холбогдогчтой, хахууль өгөх, авах удаа дараагийн үйлдэлтэй тул шүүхийн шийдвэрт системтэй дүн шинжилгээ хийхийн тулд үйл баримтуудыг дөрвөн багц болгов. Үүнд:

*1 дүгээр багц үйлдэл холбогдлын хүрээнд:* Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын Экспорт, импорт, хилийн хорио цээрийн хяналтын хэлтсийн Э.А, газрын хэлтсийн дарга Н.Б нар бүлэглэн “Түргэн муудах болон хүнсний бүтээгдэхүүн экспортлох зөвшөөрөл, импортын мэдэгдэл авах хүсэлт”-ийг шийдвэрлэхгүй удаах, хясан боогдуулах замаар олон удаагийн үйлдлээр хахууль авсан.

*2 дугаар багц үйлдэл холбогдлын хүрээнд:* Шүүгдэгч Д.Д нарын 19 хүн Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын Экспорт, импорт, хилийн хорио цээрийн хяналтын хэлтэст хандан өгсөн “Түргэн муудах болон хүнсний бүтээгдэхүүн экспортлох зөвшөөрөл, импортын мэдэгдэл авах хүсэлт”-ийг тус газрын хэлтсийн дарга Н.Б, газрын дарга Э.А нарын зүгээс шийдвэрлэхгүй удаах, хясан боогдуулсны улмаас аргагүй байдалд орж, төрийн үйлчилгээг авахын тулд хахууль өгсөн.

*3 дугаар багц үйлдэл холбогдлын хүрээнд:* Шүүгдэгч Ш.Т нь Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын Экспорт, импорт, хилийн хорио цээрийн хяналтын хэлтсийн байгаль орчны улсын байцаагчаар ажиллаж байхдаа бусдад давуу байдал бий болгох зорилгоор Ж.С-тэй бүлэглэн хэлтсийн дарга Н.Б, газрын дарга Э.А нарт албаны чиг үүрэг, бүрэн эрх, албан тушаалын байдалтай нь холбогдуулан хахууль дамжуулан өгсөн.

*4 дүгээр багц үйлдэл холбогдлын хүрээнд:* Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын Экспорт, импорт, хилийн хорио цээрийн хяналтын хэлтсийн улсын ахлах байцаагч С.Б, Н.Э



нар нь хэлтсийн дарга Н.Б, газрын дарга Э.А нартай бүлэглэн тус газарт хандан гаргасан “Түргэн муудах болон хүнсний бүтээгдэхүүн экспортлох зөвшөөрөл, импортын мэдэгдэл авах хүсэлт”-ийг шийдвэрлэхгүй удаах, хясан боогдуулах замаар олон удаагийн үйлдлээр хахууль авсан гэмт үйлдэлд дэмжлэг үзүүлж, 2017 оны 10 дугаар сарын 13-ны өдөр тус бүр 5,000,000 төгрөгийн хахууль авсан.

### 1.3. ШИЙДВЭРЛЭСЭН БАЙДАЛ

#### **Процессын түүх**

Эрүүгийн хэргийн холбогдогч нэг бүрт хамаарах гэмт хэргийн зүйлчлэл, түүнийг анхан шатны шүүх хэрхэн өөрчилж ял оногдуулсан, давж заалдах шатны шүүх үүнийг хэрхэн дүгнэснийг авч үзлээ. Улсын Дээд шүүхийн хяналтын шатны эрүүгийн хэргийн шүүхээс гомдлыг хүлээн авч, хэргийг хэрхэн шийдвэрлэсэн талаар судлаачийн зүгээс товч томъёолсон.<sup>1</sup>

#### **Анхан шатны шүүхийн шийдвэрлэсэн байдал, үндэслэл**

Судалгаанд авч үзсэн эрүүгийн хэргийн долоон шүүгдэгчийн яллах дүгнэлтэд дараах байдлаар өөрчлөлт оруулжээ. Тухайлбал, Н.Б-гийн хувьд Эрүүгийн хуулийн 3.7 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасныг журамлан “22.4 дүгээр зүйлийн 5 дахь хэсэг” гэдгийн “Газрын дарга Э.А-тай бүлэглэж” гэснийг “Эрүүгийн хуулийн 22.4 дүгээр зүйлийн 5 дахь хэсэг” болгон өөрчилсөн, Э.А-г Эрүүгийн хуулийн 3.7 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасныг журамлан “22.4 дүгээр зүйлийн 5 дахь хэсэг” гэдгийг “Эрүүгийн хуулийн 18.6 дугаар зүйл” болгон тус тус өөрчилсөн.

<sup>1</sup> Дэлгэрэнгүй мэдээллийг Хавсралтаас үзнэ үү.

Анхан шатны шүүх нийт 23 шүүгдэгчийг гэм буруутайд тооцож, хоёр шүүгдэгчийн үйлдэл холбогдлыг хэрэгсэхгүй болгож, гурван шүүгдэгчийг хөөн хэлэлцэх хугацаа дууссан гэх үндэслэлээр хэрэгсэхгүй болгосон. Шүүгдэгч Д.З-г Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 2.8 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт заасныг удирдлага болгон 22.5 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан эрүүгийн хариуцлагаас чөлөөлсөн. Таван шүүгдэгч сайн дураараа ирж, зохих байгууллагад хүсэлтээ гаргаж ирүүлсэн үндэслэлээр тэдэнд 2,700,000 төгрөгийн торгуулийн ял оногдуулж, ялаас чөлөөлжээ.

Мөн анхан шатны шүүхийн шийдвэрт “...нэр бүхий шүүгдэгчид Н.Б-д 600.0 сая гаруй төгрөгийн хахууль өгсөн хэмээн яллах дүгнэлт үйлдэж, шүүх хуралдаанаар хэлэлцүүлсэн” гэсэн байхад, мөн бусад шүүгдэгч хэдэн төгрөг өгснөө мэдүүлээд байхад “...шүүгдэгч Н.Б-гийн авсан хахуулийн дүнг бодитоор тогтоох боломжгүй...” гэж дүгнэжээ.

Тухайн шийдвэрийг гаргахдаа дараах нотлох баримтыг үндэслэн шийдвэр гаргасан байна. Үүнд:

*Нэгдүгээр багц үйлдэл холбогдлын хүрээнд:* Анхан шатны шүүх шүүгдэгч Н.Б-г Эрүүгийн хуулийн тусгай ангийн 22.4 дүгээр зүйлийн 5 дахь хэсэгт заасан гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцож, нийтийн албанд томилогдох эрхийг нь таван жилийн хугацаагаар хасаж, тухайн зүйл, хэсэгт заасан торгуулийн хамгийн дээд хэмжээ болох 40,000,000 төгрөгөөр торгож, мөн эд мөрийн баримтаар хурааж ирүүлсэн 230,800,000 төгрөг, 70,000 юань, 152,177 ам. долларыг гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, орлого хэмээн үзэж улсын төсөвт шилжүүлэхээр; харин шүүгдэгчдээс нэмж хөрөнгө, орлого хураан авахгүй байхаар шийдвэрлэсэн болно.

Э.А-г “...уг гэмт хэргийг санаачилсан, зохион байгуулсан, удирдсан, хэн нэгэнд заавар зөвлөгөө өгсөн, үгсэн тохиролцсон гэх нөхцөл байдал тогтоогдоогүйгээс гадна Э.А-г хахууль

өгсөн этгээдүүдийн онцгой шаардлага, тулгамдсан хэрэгцээг ашиглан хахууль өгсөн тохиолдолд төрийн үйлчилгээ үзүүлэх талаар хүсэлт гаргасан этгээдүүдтэй биечлэн уулзаж тэдэнд амлалт өгч байгаагүй, мөн хахууль өгөхийг шаардаж, тулгаж байгаагүй гэдгийг мөрдөн шалгах ажиллагаанд болон шүүхийн хэлэлцүүлэгт хахууль өгсөн гэх шүүгдэгчид тодорхой мэдүүлсэн. Хэдийгээр хэрэгт авагдсан гүйцэтгэх ажиллагааны магадалгаагаар Э.А нь Н.Б-гээс мөнгө авсан гэх үйл баримт тогтоогдох боловч дан ганц энэ магадалгаагаар түүнийг “хясан боогдуулах аргаар бусдаас хахууль авсан” гэмт хэргийг бүлэглэж үйлдсэн гэж үзэх боломжгүй” гэж дүгнээд гэмт хэргийн зүйлчлэлийг Эрүүгийн хуулийн тусгай ангийн 18.6 дугаар зүйлийн 1 дэх хэсэг болгон өөрчилж, гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацаа дууссан гэх үндэслэлээр хэргийг хэрэгсэхгүй болгосон.

*Хоёрдугаар багц үйлдэл холбогдлын хүрээнд:* Прокурор нь Д.Д нарын зургаан хүнийг Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 3.1 дэх заалтыг журамлан Эрүүгийн хуулийн тусгай ангийн 22.5 дугаар зүйлийн 3-т заасан “хясан боогдуулсны улмаас аргагүй байдалд орж, хахууль өгөх” гэмт хэргийг компанийн нэрийн өмнөөс, хуулийн этгээдийн ашиг сонирхлын төлөө үйлдсэн гэмт хэрэгт холбогдуулан ял сонсож, яллах дүгнэлт үйлдэж ирүүлснийг анхан шатны шүүх “хуулийн этгээдийн ашиг сонирхлын төлөө хахууль өгсөн гэж үзэх боломжгүй” гэж дүгнэсэн. Энэ үндэслэлээр Д.Д нарын зургаан хүний гэмт хэргийн зүйлчлэлийг 22.5 дугаар зүйлийн 1 дэх хэсэг болгон өөрчилж, О.Б нарын 12 хүний хамтаар Эрүүгийн хуулийн тусгай ангийн 22.5 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцож, Ж.Б нарын 16 хүний нийтийн албанд томилогдох эрхийг хоёр жил хүртэлх хугацаагаар хасаж, хоёр мянга долоон зуун нэгжтэй тэнцэх хэмжээний буюу 2,700,000 төгрөгөөр тус тус торгох ялаар шийтгэж, Д.З-г “...өөрөө хууль бус үйлдэл хийснээ ухамсарлан

маргааш нь буюу 2017 оны 9 дүгээр сарын 20-ны өдөр МХЕГ-т очиж хүсэлтээ буцаан авч, Н.Б-гээс хахуульд өгсөн 1,500,000 төгрөгөө буцаан авсан” нь тогтоогдсон гэж үзээд Эрүүгийн хуулийн тусгай ангийн 2.8 дугаар зүйлийн 3-т зааснаар “гэмт хэрэг үйлдэж төгсөх боломжтойг ойлгож байсан боловч туйлд нь хүргэхээс өмнө сайн дураараа татгалзсан хүнд эрүүгийн хариуцлага хүлээлгэхгүй” гэх үндэслэлээр эрүүгийн хариуцлагаас чөлөөлсөн.

*Гуравдугаар багц үйлдэл холбогдлын хүрээнд:* Ш.Т-г Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 3.5 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасныг журамлан Эрүүгийн хуулийн тусгай ангийн 22.5 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тус тус тооцож, хорих ял оногдуулахгүйгээр нэг жилийн хугацаагаар тэнссэн.

*Дөрөвдүгээр багц үйлдэл холбогдлын хүрээнд:* Анхан шатны шүүх “Н.Б, С.Б нарыг албаны чиг үүрэгтэйгээ холбогдуулан бусдыг хясан боогдуулах талаар ямар нэгэн хууль бус үйлдэл хийж, дэмжлэг туслалцаа үзүүлсэн гэх нотлох баримт хэрэгт авагдаагүй; Н.Б, Э.А нартай тохиролцож, ажил үүргийн хувиар болон бусад нөхцөл байдлаар хахууль авах гэмт хэрэгт бүлэглэж, дэмжлэг үзүүлсэн гэх үндэслэл тогтоогдохгүй байна. Харин Н.Б бусдаас хясан боогдуулах аргаар хахуульд авсан мөнгийг “гэмт хэргийн улмаас олсон мөнгө, орлого гэдгийг мэдсээр байж авсан гэм буруутай гэж үзэх үндэслэлтэй бөгөөд нотлох баримтаар тогтоогдож байна” гэж дүгнээд Эрүүгийн хуулийн тусгай ангийн 18.6 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцож, хөөн хэлэлцэх хугацаа дууссан гэх үндэслэлээр хэргийг хэрэгсэхгүй болгосон.

### **Давж заалдах шатны шүүх хэргийг шийдвэрлэсэн байдал, үндэслэл**

Нийслэлийн Эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүхээс анхан шатны шүүхийн шийдвэрийг хүчингүй болгож, прокурорын эсэргүүцлийг хүлээн авсан. Тухайлбал, Давж заалдах шатны шүүхээс анхан шатны шүүхийн шийтгэх тогтоолыг бүхэлд нь хүчингүй болгож, хуулийн этгээдийн ашиг сонирхлын төлөө гэмт хэрэг үйлдсэн Д.Х, М.Ц, Э.О, М.Н, Д.Д, Б.Б нарын зургаан хүнийг яллагдагчаар татах асуудлыг шийдвэрлүүлэхээр хэргийг тусгаарлан, Нийслэлийн прокурорын газарт буюу мөрдөн шалгах ажиллагаанд буцаасан бол бусад 19 хүнд холбогдох хэргийг анхан шатны шүүхэд дахин хэлэлцүүлэхээр буцаасан.

Тухайн шийдвэрийг гаргахдаа дараах нотлох баримтыг үндэслэн шийдвэр гаргасан байна. Үүнд:

*Нэгдүгээр багц үйлдэл холбогдлын хүрээнд:* Давж заалдах шатны шүүх магадлалын тодорхойлох хэсэгт үндэслэлээ дараах байдлаар тодорхойлсон. Үүнд: “...Н.Б-гийн хувьд өөрийн бусдаас хясан боогдуулах аргаар хахууль авсны хариуд үзүүлэх чиг үүрэгтээ дэмжлэг авч, хахуульд авсан мөнгөнөөс Э.А-д өгч байсан, харилцан ойлголцож, хахуулийн мөнгийг авч нэг санаа зорилготой ажиллаж байсан нь хэрэгт авагдсан баримтуудаар тогтоогджээ...” гээд “анхан шатны шүүх мөн хуулийн тусгай ангийн 18.6 дугаар зүйлийн 1 дэх хэсэг болгон өөрчилж, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 1.5 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1.2-т зааснаар гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацаа дууссан гэх үндэслэлээр хэргийг хэрэгсэхгүй болгож шийдвэрлэсэн нь хууль зүйн үндэслэлгүй” гээд “Н.Б-д 40,000,000 төгрөгөөр торгох ял оногдуулсан нь түүний үйлдсэн гэмт хэрэг, гэмт хэргийн нийгмийн аюулын шинж чанар, хэр хэмжээ, гэм буруугийн хэлбэр, хувийн байдалд тохироогүй байна гэж давж заалдах шатны шүүхээс үзлээ” гээд анхан

шатны шүүх рүү буцаасан бол УДШ-ээс магадлалыг хэвээр үлдээсэн.

*Хоёрдугаар багц цйлдэл холбогдлын хүрээнд:* Давж заалдах шатны шүүх магадлалын тодорхойлох хэсэгт үндэслэлээ дараах байдлаар тодорхойлсон. “Арван гурван шүүгдэгчийг 2,700,000 төгрөгөөр торгох ялаар шийтгэсэн нь үйлдсэн гэмт хэргийн оролцоо, хахуульд өгсөн мөнгөний хэмжээ зэрэгт тохироогүй, нэг төрлийн ялыг адил хэмжээгээр оногдуулсан нь шударга ёсны зарчимд нийцээгүй байна. Мөн зургаан шүүгдэгчийг хуулийн этгээдийн өмнөөс, хуулийн этгээдийн ашиг сонирхлын төлөө үйлдсэн хэмээн яллах дүгнэлт үйлдсэн нь хууль зүйн үндэслэлгүй, мөрдөн шалгах ажиллагааны явцад хуулийн этгээдийг эрүүгийн хариуцлагад татан оролцуулаагүй атлаа зургаан хүнд холбогдуулан Эрүүгийн хуулийн тусгай ангийн 22.5 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт зааснаар хэргийг зүйлчилж, шүүхэд шилжүүлсэн, шүүх уг алдааг зөвтгүүлэхийн оронд Эрүүгийн хуулийн тусгай ангийн 22.5 дугаар зүйлийн 1 дэх хэсэг болгон зүйлчлэлийг өөрчилж шийдвэрлэсэн нь хууль зүйн үндэслэлгүй” гээд зургаан хүнд холбогдох хэргийг тусгаарлан прокурорт буцааж бусад холбогдогчийн хэргийг анхан шатны шүүх рүү буцаасан бол УДШ-ээс анхан шатны шүүхийн шийтгэх тогтоолыг хэвээр үлдээсэн.

*Гуравдугаар багц цйлдэл холбогдлын хүрээнд:* Давж заалдах шатны шүүх магадлалын тодорхойлох хэсэгт үндэслэлээ дараах байдлаар тодорхойлсон. Ш.Т-г хорих ял оногдуулахгүйгээр нэг жилийн хугацаагаар тэнсэж шийдвэрлэхдээ Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 5.7 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт “...энэ хуулийн тусгай ангид заасан тохиолдолд эрх хасах ялыг заавал оногдуулна” гэж, 3 дахь хэсэгт “Шүүх эрх хасах ялыг ...хорих ял оногдуулахгүйгээр үүрэг хүлээлгэх, эрх хязгаарлах албадлагын арга хэмжээ авсан бол албадлагын арга хэмжээ авсан үеэс хугацааг тоолно” гэж тус тус заасныг мөн Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 7.5 дугаар

зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө орлогыг албадан гаргуулах зэргийг анхаарч үзэлгүй, шийдвэрлээгүй орхигдуулсныг дахин хэргийг шийдвэрлэхдээ анхаарвал зохино” гэж тусгасан. Ингээд Ш.Т, Ж.С нарын үйлдэл холбогдлыг анхан шатны шүүх рүү буцаасан бол УДШ-ээс Ш.Т-г анхан шатны шүүх рүү буцаасныг хэвээр үлдээж Ж.С-ийн хэргийн анхан шатны шүүхийн шийтгэх тогтоолыг хэвээр үлдээсэн.

*Дөрөвдүгээр багц үйлдэл холбогдлын хүрээнд:* Давж заалдах шатны шүүх магадлалын тодорхойлох хэсэгт үндэслэлээ дараах байдлаар тодорхойлсон. “Г.Э, С.Б нарын ажил, чиг үүргийн хувьд хамаарал бүхий шүүгдэгч Э.А, Н.Б нарын бусдаас хахуульд авсан мөнгийг мэдсээр байж авсан үйлдлийн санаа зорилго, тэднийг бусдаас хахууль авах цаг хугацаанд ажил, чиг үүргийн хувьд хамааралтай ажиллаж байсан нөхцөл байдалд дүгнэлт хийж, хэргийг зүйлчлэх нь зүйтэй” гээд анхан шатны шүүх рүү буцаасан бол УДШ-ээс шийдвэрийг хэвээр үлдээсэн.

### **Хяналтын шатны шүүхийн шийдвэрлэсэн байдал ба үндэслэл**

Улсын Дээд шүүхийн 2020 оны 2 дугаар сарын 5-ны өдрийн 79 дугаартай тогтоолоор магадлалын тогтоох хэсгийн 1, 2 дахь заалтыг тус тус хүчингүй болгож Н.Б, Э.А, С.Б, Г.Э, Ж.Т, Д.Т нарын зургаан хүнд холбогдох хэргийг анхан шатны шүүхээр хэлэлцүүлэхээр буцаасан бол бусад 19 шүүгдэгчийн тухайд анхан шатны шүүхийн шийтгэх тогтоолыг хэвээр үлдээсэн.

Тухайн шийдвэрийг гаргахдаа дараах нотлох баримтыг үндэслэн шийдвэр гаргасан байна. Үүнд:

*Нэгдүгээр багц үйлдэл холбогдлын хүрээнд:* УДШ-ийн 2020 оны 2 дугаар сарын 5-ны өдрийн 79 дугаартай тогтоолын тодорхойлох хэсэгт үндэслэлээ дараах байдлаар тодорхойлсон.

Үүнд, “Гэмт хэрэг үйлдсэн хүнд эрүүгийн хариуцлага хүлээлгэхдээ Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан төрөл, хэмжээний дотор багтсан байх төдий бус мөн хуулийн ерөнхий ангийн хэм хэмжээнд нийцсэн, хууль ёсны зарчмыг хангахын зэрэгцээ тухайлан сонгон оногдуулж буй ялын төрөл, түүний хэмжээ нь гэмт хэргийн шинж чанар, хэрэг үйлдсэн тодорхой нөхцөл байдал болон гэмт хэрэгтний хувийн байдалд хамгийн зүй зохистой харьцаагаар нийцсэн байх Эрүүгийн хуулийн шударга ёсны зарчмыг хангасан байхыг шаарддаг. Хуулиар тогтоосон эрүүгийн хариуцлага хүлээлгэх үндэслэл, журмыг чанд баримтлан хэрэгжүүлэхдээ үүнд хамаарах нийтлэг зарчим нэг бүрийн шаардлага, шалгуур үзүүлэлтүүдийн цогц нэгдлийг илэрхийлж чадахуйц дүгнэлт хийсний үндсэн дээр ял оногдуулах нь шударга ёсны зарчмын агуулга, Эрүүгийн хуулийн зорилгод нийцдэг болно. Үйлдсэн гэмт хэргийн нийгмийн хор аюулыг хэт бууруулан үнэлэх байдлаар учруулсан хохирол, хууль бусаар олсон орлогоос олон дахин бага мөнгөн дүнгээр шүүгдэгчийг торгох, ял тэнсэх шаардлагыг хэрхэн хангаж буй тухай дүгнэлтгүйгээр уг зохицуулалтыг хэрэглэх, гэмт хэргийн оролцоо, санаа зорилгын нэгдэл хэзээ бий болсон талаар дүгнэлт хийж чадаагүйгээс гэмт хэрэгт хамтран оролцох асуудлыг шийдвэрлэж чадаагүй, гэмт хэрэг үйлдсэн давтамжийг эс тооцсон зэрэг ноцтой алдаа гаргасныг анхан шатны шүүхэд анхааруулах нь зүйтэй гэж тодорхойлон шүүгдэгч Н.Б, Э.А-д холбогдох хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцүүлэхээр анхан шатны шүүхэд буцааж” шийдвэрлэсэн байна.

*Хоёрдугаар багц, үйлдэл холбогдлын хүрээнд:* УДШ-ийн 2020 оны 2 дугаар сарын 5-ны өдрийн 79 дугаартай тогтоолын тодорхойлох хэсэгт үндэслэлээ дараах байдлаар тодорхойлсон. Үүнд, шүүгдэгч Д.Д нарын 19 хүнд холбогдох хэргээс ... ХХК-ийн ерөнхий менежер Д.Т-д холбогдох хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцүүлэхээр анхан шатны шүүхэд буцааж,



шүүгдэгч Д.Д, Б.Б, Э.О, М.Ц, Ж.С, О.Б, Ж.Б, Б.А, Н.М, Н.Г, Ц.О, Л.Н, Д.Э, Г.Д, Э.О, Т.Ч, Д.З нарт Эрүүгийн хуулийн тусгай ангийн 22.5 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар хариуцлага хүлээлгэсэн нь хуульд нийцсэн бөгөөд Д.Д, Б.А, Э.О, М.Ц нарт Эрүүгийн хуулийн тусгай ангийн 22.5 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт зааснаар ял сонсгож зүйлчилснийг шүүх хуралдаанаас зөвтгөж ЭХТА-ийн 22.5 дугаар зүйлийн 1 дэх хэсэг болгон өөрчлөх боломжтой гэж, мөн дээрх 17 шүүгдэгчид эрүүгийн хариуцлага хүлээлгэхдээ “Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн хэм хэмжээг зөв баримтлан гэмт хэрэг үйлдсэн нөхцөл байдал, хэргийн нийгмийн аюулын шинж чанар, учирсан хохирол, хор уршгийн хэмжээ, тэдний хувийн байдал, хариуцлагыг хөнгөрүүлэх, хүндрүүлэх нөхцөл байдлыг харгалзан үзэж, 2015 оны Эрүүгийн хуулийг зөв тайлбарлан хэрэглэсэн гэж Д.Х, М.Н-д Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 3.7 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасныг журамлан, Эрүүгийн хуулийн тусгай ангийн 22.5 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт заасан гэмт хэрэгт тус тус холбогдуулан ял сонсгож яллах дүгнэлт үйлдэж ирүүлснийг Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 1.5 дугаар зүйлийн 1.1 дэх хэсэгт зааснаар хэрэгсэхгүй болгож, Д.З-д ял оногдуулахдаа Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 2.8 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт заасныг үндэслэж эрүүгийн хариуцлагаас чөлөөлж, Н.Г, О.Б, Э.О, Т.Ч, Н.М нар “...энэ тухайгаа эрх бүхий байгууллагад сайн дураараа илчлэн ирсэн бол түүний төрөөс авсан үйлчилгээг хэвээр үлдээж ялаас чөлөөлнө” гэснийг үндэслэж хэргийг хэрэгсэхгүй болгож, эрүүгийн хариуцлага, ялаас чөлөөлж” тус тус шийдвэрлэсэн.

*Гуравдугаар багц, үйлдэл холбогдлын хүрээнд:* УДШ-ийн 2020 оны 2 дугаар сарын 5-ны өдрийн 79 дугаартай тогтоолын тодорхойлох хэсэгт үндэслэлээ дараах байдлаар тодорхойлж “Ш.Т-д холбогдох хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцүүлэхээр анхан шатны шүүхэд буцааж” шийдвэрлэжээ.

*Дөрөвдугаар багц цйлдэл холбогдлын хурээнд:* УДШ-ийн 2020 оны 2 дугаар сарын 5-ны өдрийн 79 дугаартай тогтоолын тодорхойлох хэсэгт үндэслэлээ дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд, “Шүүгдэгч С.Б, Г.Э-д холбогдох хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцүүлэхээр анхан шатны шүүхэд буцааж, Давж заалдах шатны шүүхийн магадлалын 1 ба 2 дахь заалтыг тус тус хүчингүй болгож, 3 дахь заалтын Н.Б, Э.А, Г.Э, Ж.Т, Д.Т нарт холбогдох хэргийг анхан шатны шүүхэд буцааж, 19 шүүгдэгчид холбогдох хэсэг болон 4 дэх заалтыг хэвээр үлдээж, нэр бүхий дөрвөн өмгөөлөгчийн хяналтын журмаар гаргасан “анхан шатны шүүхийн шийтгэх тогтоолыг хэвээр үлдээх тухай” гомдлуудыг хэрэгсэхгүй болгож” шийдвэрлэсэн.

### **Хяналтын шатны шүүхийн шийдвэрээр анхан шатны журмаар хянан хэлэлцсэн байдал**

Хяналтын шатны шүүхийн шийдвэрээр анхан шатны шүүхэд буцаасан хэргийг Чингэлтэй дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2020 оны 9 дүгээр сарын 21-ний өдрийн шийдвэрээр:

1. Н.Б-д Монгол Улсын Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 3.7 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасныг журамлан мөн хуулийн тусгай ангийн 22.4 дүгээр зүйлийн 5 дахь хэсэгт зааснаар шүүгдэгч Н.Б-д нийтийн албанд томилогдох эрхийг 5 (тав) жилийн хугацаагаар хасаж, 2 (хоёр) жил 8 (найм) сарын хугацаагаар хорих ял;
2. Э.А-д нийтийн албанд томилогдох эрхийг 5 (тав) жилийн хугацаагаар хасаж, 40,000 (дөчин мянга) нэгжтэй тэнцэх хэмжээний буюу 40,000,000 (дөчин сая) төгрөгийн торгох ял;
3. С.Б-д нийтийн албанд томилогдох эрхийг 5 (тав) жилийн хугацаагаар хасаж, 15,000 (арван таван мянга) нэгжтэй

тэнцэх хэмжээний буюу 15,000,000 (арван таван сая) төгрөгийн торгох ял;

4. Г.Э-д Монгол Улсын Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 3.5 дугаар зүйлийн 1 дэх хэсгийг журамлан мөн хуулийн тусгай ангийн 22.4 дүгээр зүйлийн 5 дахь хэсэгт зааснаар шүүгдэгч Г.Э-гийн нийтийн албанд томилогдох эрхийг 5 (тав) жилийн хугацаагаар хасаж, 13,000 (арван гурван мянга) нэгжтэй тэнцэх хэмжээний буюу 13,000,000 (арван гурван сая) төгрөгийн торгох ял;
5. Ш.Т-д Монгол Улсын Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 3.5 дугаар зүйлийн 1 дэх хэсгийг журамлан мөн хуулийн тусгай ангийн 22.5 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар шүүгдэгч Ш.Т-гийн нийтийн албанд томилогдох эрхийг 3 (гурав) жилийн хугацаагаар хасаж, 2,700 (хоёр мянга долоон зуу) нэгжтэй тэнцэх хэмжээний буюу 2,700,000 (хоёр сая долоон зуун мянга) төгрөгийн торгох ял;
6. Д.Т-д Эрүүгийн хуулийн тусгай ангийн 22.5 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар шүүгдэгч Д.Т-гийн нийтийн албанд томилогдох эрхийг 2 (хоёр) жилийн хугацаагаар хасаж, 9,000 (есөн мянга) нэгжтэй тэнцэх хэмжээний буюу 9,000,000 (есөн сая) төгрөгийн торгох ял тус тус шийтгэсүгэй гэсэн шийдвэр гарсан байна.

## 2. ШҮҮХИЙН ШИЙДВЭРИЙН ШИНЖИЛГЭЭ

Өмнөх хэсэгт авч үзсэн шүүхийн шийдвэрт тусгагдсан маргаантай асуудлыг дараах байдлаар томъёолон дүн шинжилгээ хийлээ. Үүнд:

### 2.1. ХУУЛЬ ДЭЭДЛЭХ ЗАРЧИМ БА ШҮҮХИЙН ШИЙДВЭР ҮНДЭСЛЭЛТЭЙ БАЙХ

Хууль нь төрийн жолоогүй засгийн зэвсэг эсхүл дураар авирлах явдлыг хязгаарлах механизм, төрөөс хууль ёсны зорилгоо хэрэгжүүлэх хэрэгсэл мөн<sup>2</sup> бөгөөд шүүх хэрэг, маргаан хянан шийдвэрлэх, шийдвэр гаргах явцад ч энэ зорилго нэгэн адил хэрэгжинэ.

Энэ утгаараа Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 16.15 дугаар зүйлийн 2-т зааснаар шүүгч нотлох баримтыг тал бүрээс нь нягт нямбай, бүрэн гүйцэд, бодит байдлаар хянаж үзсэний үндсэн дээр нотлох баримтыг өөрийн дотоод итгэлээр үнэлэх зохицуулалт орсон. Хэдий тийм боловч шийдвэр гаргахад өөрийн дотоод итгэлд тулгуурлах бус мөн хуулийн 36.2 дугаар зүйлийн 3-т зааснаар тодорхой, ойлгомжтой<sup>3</sup>, түүнийг биелүүлэхэд ямар нэгэн эргэлзээ төрөхөөргүй байхаар бичигдсэн байх ёстой гэж хуульчилсан. Энэ заалт нь шүүхийн шийдвэрийг оролцогч бүр өөр өөрөөр

<sup>2</sup> Ч.Нямсүрэн, Эрх зүйн ерөнхий онол, УБ., 2010, 119 дэх тал.

<sup>3</sup> Шинжлэх ухааны академийн Хэл зохиолын хүрээлэнгээс тодорхой гэдэг үгийг (i) илт, илэрхий, (ii) нэгд нэгэнгүй, дэлгэрэнгүй, (iii) бодитой; ойлгомжтой гэдэг үгийг (i) учир утга тодорхой, ухаж ойлгоход хялбар гэж тус тус тайлбарлажээ.

тайлбарлах, хуулийн дагуу явагдсан эсэхэд эргэлзээ, үл ойлголцол бий болохоос сэргийлсэн зохицуулалт бөгөөд дээрх шаардлагыг хангасан бол түүнийг биелүүлэхэд ямар нэгэн эргэлзээ төрөхгүй байх нь ойлгомжтой.

Хууль зүйн агуулгаар хяналтын журмаар хэргийг хянан шийдвэрлэсэн тогтоолд шүүх шийдвэрт тусгагдах үйл баримт, түүнийг нотолсон баримт, тэдгээрийн хууль зүйн болон учир утгын үндэслэл, түүнийг нотолсон гаргалгааг дурдах нь УДШ-ийн шийдвэрийг мөрдөгч, прокурор, өмгөөлөгч, шүүгч итгэл үнэмшилтэйгээр хэрэглэх боломж бүрдүүлэх нь ойлгомжтой.

Энэ байдлыг бий болгох зорилгоор “Шүүхийн шийдвэрийн тухай” Монгол Улсын Дээд шүүхийн 2006 оны 4 дүгээр сарын 24-ний өдрийн 21 дүгээр тогтоолд “Шүүхийн шийдвэр нь үндэслэл бүхий байх шаардлага хангагдах ёстой”-г тусгаж бүх шатны шүүхийн шүүгчдэд даалгасан байдаг.

Гэсэн ч дээр авч үзсэн шүүхийн шийдвэрүүдэд дүн шинжилгээ хийхэд дараах ойлгомжгүй нөхцөл байдал тусгагдсан байна. Тухайлбал:

1. Өмгөөлөгчийн гомдол болон шүүх хуралдаанд хэлсэн саналдаа “...хүндрүүлэх нөхцөл байдал ямар нотлох баримтаар нотлогдож байгааг магадлалд дурдаагүй...”, “...үндэслэл заахгүйгээр хавтгайруулж анхан шатны шүүхэд буцаасан...” гэсэн агуулга шүүхийн шийдвэрт тусгагдсан.
2. Шүүхийн гаргасан шийдвэр нь ерөнхий байдлаар “хуульд нийцсэн байна, эрх зөрчигдөөгүй гэж үзэж” гэх зэргээр бичигдэж, гаргасан тодорхой шийдвэр нь ямар нотлох баримтад тулгуурлаж, хуулийн тухайн заалтыг хэрхэн хэрэглэсэнээ тайлбарлаагүй байна.
3. Хяналтын шатны шүүхийн “анхан шатны шүүхийн дүгнэлт хэргийн жинхэнэ байдалд нийцсэн, хууль зүйн үндэслэлтэй байна, зүйл ангийг өөрчилсөн, эрүүгийн хариуцлага хүлээлгэн шийдвэрлэснийг өөрчлөх эсхүл

буруутган дүгнэх хууль зүйн үндэслэлгүй” гэх мэт дүгнэлтүүдийн үндэслэл, нотлох баримтыг тайлбарлаагүй байна.

Дээрх байдлаар хяналтын шатны шүүхийн шийдвэр үндэслэл бүхий байх шаардлага хангаагүй байсан нь анхан болон давж заалдах шатны шүүхийн шийдвэрийг зайлшгүй судлах шаардлага үүсгэсэн юм.

Хэдийгээр судлаач миний бие хэргийн нөхцөл байдлын талаар нэмэлт мэдээлэл авахын тулд анхан болон давж заалдах шатны шүүхийн шийдвэрүүдтэй танилцсан ч хангалттай дүгнэлт хийх боломж хязгаарлагдмал байсныг энд дурдах нь зүйтэй болов уу.

Монгол Улсын Дээд шүүхийн хяналтын шатны эрүүгийн хэргийн шүүх хуралдааны 2020 оны 2 дугаар сарын 5-ны өдрийн 79 дугаартай тогтоол нь удиртгал, тодорхойлох, тогтоох хэсгээс бүрдсэн байна.

Шүүхийн шийдвэрийн *удиртгал* хэсэгт Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 36.6-д заасан мэдээлэл болон анхан ба давж заалдах шатны шүүхээс хэрэг шийдвэрлэсэн байдал буюу гэм буруутайд тооцож, хүлээлгэсэн хариуцлагын талаар, мөн давж заалдах шатны шүүх хэргийг хэрхэн шийдвэрлэсэн талаар тусгаж, үргэлжлүүлэн хяналтын шатны шүүхэд гомдол гаргасан өмгөөлөгчдийн саналыг тусгажээ. Өөрөөр хэлбэл, *удиртгал* хэсэгт хуульд заасан илүү олон асуудал тусгагдсан нь хяналтын шатны шүүхийн ажиллагааны онцлогтой холбоотой боловч үүнийг хуульчилж өгөөгүй нь хяналтын шатны шүүхийн тогтоолын хэлбэр, бичих аргачлал хуулийн дагуу эсэхийг тогтооход хүндрэлтэй байв.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 36.7 дугаар зүйлд шүүхийн шийтгэх тогтоолын тодорхойлох хэсэг нь шүүгдэгчийг гэм буруутайд тооцох, эрүүгийн хариуцлага хүлээлгэх гэсэн хоёр хэсгээс бүрдэнэ гэж заасан байдаг.

Тус шүүхийн шийтгэх тогтоолын *тодорхойлох* хэсэг нь гурван хэсэгт хуваагдаж, 1, 2 дугаар хэсэг нь гэм буруутайд тооцох; 3 дугаар хэсэг нь эрүүгийн хариуцлага хүлээлгэх хэсэг гэж дүгнэгдэхээр байв. Тодорхойлох хэсгийн 1, 2 дугаар хэсэгт заасан дүгнэлтийн хэсгийг шинжлэн судалсан дүнг харуулбал:

1. Шүүгдэгчдийн гэмт үйлдлийн талаар товч дурдаад зөвхөн түүнд үндэслэж, анхан шатны шүүхийн шийдвэрийг үндэслэлтэй болсон гэж дүгнэсэн байв. Мөн хуулийн этгээдийн нэрийн өмнөөс, хуулийн этгээдийн ашиг сонирхлын төлөө хахууль өгөх гэмт хэрэг үйлдсэн гэж Эрүүгийн хуулийн тусгай ангийн 22.5 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт зааснаар ял сонсгож, яллах дүгнэлт үйлдэж ирүүлсэн Д.Д нарын зургаан хүнд холбогдох хэргийн зүйлчлэлийг 22.5 дугаар зүйлийн 1 болгож өөрчилснийг, шүүгдэгч Ж.С-д гэмт хэргийн гүйцэтгэгчээр ял сонсгосныг Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 3.7 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасныг журамлан “бүлэглэн гүйцэтгэсэн” гэж, О.Б нарын 17 шүүгдэгчид Эрүүгийн хуулийн тусгай ангийн 22.5 дахь хэсэгт зааснаар хариуцлага хүлээлгэсэн нь хуульд нийсэн байна гэж ямар нэгэн үндэслэл заалгүй шууд дүгнэжээ.
2. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 34.2-т “Шүүх нотлох баримтаар тогтоогдсон хэргийн нөхцөл байдлыг үндэслэн хэргийн зүйлчлэлийг хөнгөрүүлж болно” гэж заасан. Хуулийн этгээдийн захирал, менежер нарт Эрүүгийн хуулийн тусгай ангийн 22.5 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт зааснаар яллах дүгнэлт үйлдэгдсэнийг анхан шатны шүүх Эрүүгийн хуулийн тусгай ангийн 22.4 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар зүйлчилж шийдвэрлэсэн нь хэргийн зүйлчлэлийг хүндрүүлж байгаа хэлбэр мөн. Хяналтын шатны шүүх үүнийг “нэгдүгээрт, ял хүндрээгүй, хоёрдугаарт, яллагдагчаар татах тогтоолд буй шүүгдэгчдийг яллаж

буруутгасан хэргийн агуулга зөв, хэргийн үйл баримт тохирч байх тул хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны энэ үед баримтлах гол зарчмыг хангасан буюу шүүгдэгчийн ямар хэрэгт яллагдаж буйгаа мэдэх эрх зөрчигдөөгүй<sup>4</sup>” гэж үзэж “...анхан шатны шүүх хэргийн зүйлчлэлийг шүүхийн шатанд өөрчлөн шийдвэрлэснийг хэвээр үлдээсэн болно” гэжээ. Зүйлчлэл хөнгөрүүлэх тухай ойлголт нь ял хүндрэх, хөнгөрөхөөс тусдаа асуудал бөгөөд мөн 22.5 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт заасан гэмт хэргийн ялын хэмжээ 22.5 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт зааснаас бага юм.

3. Нэг удаагийн үйлдлээр хясан боогдуулсны улмаас 500,000 төгрөгийн хахууль өгсөн хүнд, олон удаагийн үйлдлээр нийт 66,000 (жаран зургаан мянга) ам. доллар өгөх гэх мэтчилэн их мөнгө өгсөн хүмүүст ижил хэмжээний хариуцлага тооцсон буюу анхан шатны шүүх хэрэг тус бүр дээр дүгнэлт хийж, хариуцлага тооцож чадаагүй байхад хяналтын шатны шүүх холбогдох шийдвэрийн холбогдох заалтыг хэвээр үлдээж шийдвэрлэсэн байв. Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 1.3 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Эрүүгийн хариуцлага нь тухайн хүн, хуулийн этгээдийн үйлдсэн гэмт хэрэг, гэмт хэргийн нийгмийн аюулын шинж чанар, хэр хэмжээ, гэм буруугийн хэлбэрт тохирсон байна” гэж заасан шинжүүдэд хахуулийн хэмжээ орох эсэх, мөн энэ заалтыг хахуулийн гэмт хэрэгт хэрхэн ойлгож хэрэглэх талд анхаарал хандуулах шаардлагатай байна.
4. УДШ шүүгдэгч Н.Б, Э.А нарын гэмт хэрэг үйлдэж олсон мөнгийг улсын орлого болгохдоо нийт үнийн дүнгийн талаар дүгнэлт хийлгүйгээр зөвхөн хураагдсан мөнгөний үнийн дүнгээр тооцон улсын орлого болгохоор

<sup>4</sup> Монгол Улсын Дээд шүүхийн хяналтын шатны эрүүгийн хэргийн шүүх хуралдааны 2020 оны 2 дугаар сарын 5-ны өдрийн 79 дугаар тогтоолын 12 дахь тал.



заасан нь үндэслэлгүй болсон гэж давж заалдах шатны шүүх дүгнэсэнтэй судлаачийн хувьд санал нэг байна. Цаашид хахууль авах гэмт хэргийн хүндрүүлэх нөхцөл байдалд гэмт хэрэг үйлдсэн сэдэл, гэм буруугийн хэлбэр, үйлдлийн тоо, мөнгөн дүнгийн хэмжээ зэргийг харгалзан үзэж ялыг ялгавартай оногдуулахад анхаарах шаардлагатай гэж үзэж байна. Эрх зүйн онолын хувьд “Шүүхийн шийдвэрийн тогтоох хэсэгт шүүгдэж байгаа этгээдэд холбогдох хэргийг хэрхэн шийтгэж, ямар ял шийтгэл оноож, таслах арга хэмжээг хэрхэн авах талаар заах буюу тогтоох хэсэгт хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны үр дүн тусгагдах ёстой” гэж үздэг. Гэтэл УДШ-ийн хяналтын шатны эрүүгийн хэргийн шүүх хуралдааны тогтоолын тодорхойлох хэсэгт эцсийн шийдвэрийг тусгаад байгаа нь логикийн хувьд ч тэр, мөн уг шүүхийн шийдвэрийн тогтоох хэсгийг л хэрэгжүүлэх ёстой гэсэн утгаар авч үзвэл тухайн хэрэгтэй холбогдуулан гаргаж байгаа ямар ч шийдвэр зөвхөн тогтоох хэсэгтэй байх ёстой.

Шийдвэрийн тогтоох хэсгийг гаргахдаа Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 40.8 дугаар зүйлийн 1.1, 1.3 дахь заалтыг удирдлага болгон, магадлалын тогтоох хэсгийн 1, 2 дахь заалтыг хүчингүй болгож, 3, 4 дэх заалтын зарим хэсгийг хэвээр үлдээж, шүүгдэгчдийн өмгөөлөгчийн гаргасан гомдлыг хэрэгсэхгүй болгон шийдвэрлэсэн байна.

Тогтоох хэсгийг ойлгохын тулд магадлалын заалтуудыг мөн давхар судлах шаардлага үүссэн. Өөрөөр хэлбэл, шүүхийн шийдвэрийн тогтоох хэсэг хэт товч бөгөөд зөвхөн хяналтын шатны шүүхийн шийдвэрийг хараад хэргийн оролцогч өөрт холбоотой хэргийг хэрхэн шийдвэрлэснийг ойлгох боломж хязгаарлагдмал байлаа.

## 2.2. ХАХУУЛЬ ӨГӨХ, АВАХ ГЭМТ ХЭРГИЙН НОТОЛБОЛ ЗОХИХ БАЙДАЛ

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 16.2 дугаар зүйлд хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт, шүүх хуралдааны явцад нотлохоор хуульчилсан зүйлийг дурдвал:

1. Гэмт хэрэг гарсан байдал (гэмт хэргийг хэзээ, хаана, яаж үйлдсэн болон Эрүүгийн хуульд заасан бусад байдал);
2. Гэмт хэргийг хэн үйлдсэн;
3. Гэмт хэргийн сэдэл, зорилго, гэм буруугийн хэлбэр;
4. Эрүүгийн хуульд заасан яллагдагчид оногдуулах ялыг хүндрүүлэх, хөнгөрүүлэх нөхцөл байдал;
5. Гэмт хэргийн улмаас учирсан хохирол, хор уршгийн шинж чанар, хэр хэмжээ;
6. Гэмт хэрэг үйлдэхэд нөлөөлсөн шалтгаан, нөхцөл.

Шүүхийн шийдвэрт дүн шинжилгээ хийхэд *хангалттай нотолсон нөхцөл байдал* (гэмт хэргийг хэн үйлдсэн, гэм буруугийн хэлбэр), *хангалтгүй нотолсон нөхцөл байдал* (гэмт хэрэг гарсан байдал, гэмт хэргийн сэдэл, зорилго, Эрүүгийн хуульд заасан яллагдагчид оногдуулах ялыг хүндрүүлэх, хөнгөрүүлэх нөхцөл байдал, гэмт хэргийн улмаас учирсан хохирол, хор уршгийн шинж чанар, хэр хэмжээ) байгаа нь тогтоогдож байна. Магадгүй, хавтаст хэрэгт цугларсан нотлох баримтад бусад нөхцөл байдал тогтоогдсон байхыг үгүйсгэх аргагүй ч шүүхийн шийдвэрт тусгагдсан мэдээлэлд тулгуурласан дүгнэлт болохыг цохон тэмдэглэж байна.

Гэмт хэрэг үйлдэхэд нөлөөлсөн шалтгаан, нөхцөлийг тогтоосон талаарх мэдээлэл шүүхийн шийдвэрт тусгагдаагүй байна. Н.Б-гийн өмгөөлөгч П.Одонтунгалаг “...нэг хүнийг буруутгахад нөгөө талын шалтгаан бас байна. Хуульд эрүүгийн хариуцлага хүлээлгэхдээ шалтгаан нөхцөлийг харгалзан үзнэ

гэж заасан буюу өгсөн хүмүүс бас буруутай. Хэрвээ Н.Б-г олон удаагийн үйлдэлд буруутгаж байгаа бол ажилдаа хайнга хандсан прокурор, мөрдөгчид хариуцлага хүлээлгэх ёстой”, “Н.Б өөрөө хүсэж хэрэг үйлдсэн мэт боловч илрүүлж байгаа гэх утгаар хоёр сарын турш үйлдэл хийлгэсэн. Гэтэл цагдаагийн байгууллагын зорилго гэмт хэргийг таслан зогсооход орших байтал хоёр сарын турш үйлдлийг нь харж, ажигласан” хэмээн дурдсан нь прокурор, мөрдөгчийн зүгээс дахин гэмт хэрэг үйлдэхэд нөлөөлсөн гэх сэжиглэл байгаа нь анхаарал татаж байна. Шүүх энэ мэдээллийг үгүйсгэх болон баталсан ямар нэгэн шийдвэр гаргаагүй байна.

### **2.2.1. Хээл хахуулийн гэмт хэрэг гарсан байдал, хахуулийн хэмжээ**

Шүүхийн шийдвэрт “...нөгөө талаар хэрэгт авагдсан бичгийн болон бусад нотлох баримтаар шүүгдэгч Н.Б-гийн авсан хахуулийн дүнг бодитоор тогтоох боломжгүй, шүүгдэгчдийн албан тушаалтанд өгсөн хахуулийн дүнг тэдний мэдүүлгээр үнэн зөв гэж тогтоох боломжгүй юм” хэмээн хахуульд өгсөн, авсан мөнгөн дүнг бодитоор тогтоогоогүй. Энэ нь Эрүүгийн хуулийн 7.5 дугаар зүйлийн 1-д “Гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, орлогыг эсхүл бусдад учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх зорилгоор гэмт хэргийн улмаас учруулсан хохиролтой тэнцэх хэмжээний хөрөнгө, орлогыг гэмт хэрэг үйлдсэн хүн, хуулийн этгээдийн хувьд ногдох хөрөнгө, орлогоос албадан гаргуулна” гэж заасантай хэрхэн нийцэх талаарх дүн шинжилгээний дүнг танилцуулбал:

1. Гэмт хэргийн улмаас учруулсан хохирол бодитоор тогтоогдоогүй.
2. Хахууль авах, өгөх гэмт хэргийн зүйлчлэл нь авсан, өгсөн хахуулийн хэмжээнээс хамаарч эрүүгийн хариуцлагыг хүндрүүлэх нөхцөлийг тодорхойлоогүй.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 1.15 дугаар зүйлийн 2-т “Эрүүгийн хэрэгт хамааралтай бүхий л нотлох баримтыг шалгасан боловч сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчийн гэм буруутай эсэхэд, түүнчлэн эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад Эрүүгийн хууль, энэ хуулийг тайлбарлах, хэрэглэхэд эргэлзээ гарвал түүнийг сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, ялтанд ашигтайгаар шийдвэрлэнэ” хэмээн заасныг баримталсан хэмээн шүүх шийдвэртээ тусгасан бол шүүхийн шийдвэр үндэслэл бүхий бичигдэх талаасаа оновчтой болох байсан. Тодруулбал:

1. Нийслэлийн давж заалдах шатны шүүхээс “...үйлдсэн гэмт хэргийн үйлдэл, оролцоо, хахуульд өгсөн мөнгөний хэмжээ зэрэгт тохироогүй, нэг төрлийн ялыг адил хэмжээгээр оногдуулсан нь шударга ёсны зарчимд нийцээгүй байна” гэсэн дүгнэлт оновчтой гэж үзэхээр байна. Өөрөөр хэлбэл, Дархан Сэлэнгэ ХХК-ийн захирал Ж.Батжаргал нэг удаа 500,000 төгрөг өгсөн бол Жи Эс Км ХХК-ийн дэд захирал маш олон удаагийн үйлдлээр нийт 66,000 ам. доллар өгсөн ба адилхан 2,700,000 төгрөгөөр торгох ялаар тус тус шийтгэгдэхэд хүрсэн.
2. Анхан шатны шүүх шүүгдэгч Э.А, Н.Б нарын гэмт хэрэг үйлдэж олсон мөнгийг улсын орлого болгохдоо нийт үнийн дүнгийн хувьд дүгнэлт хийлгүйгээр зөвхөн хураагдсан мөнгөний үнийн дүнгээр тооцож, улсын орлого болгохоор заасан нь үндэслэлгүй болжээ гэх Нийслэлийн давж заалдах шатны шүүхийн магадлалтай санал нэг байна. Шүүгдэгчдийн өгсөн мэдүүлгээс судлаач миний бие тооцож үзэхэд 550,770,000 төгрөг 120,350 ам. доллар буюу ойролцоогоор 800,000,000 (найман зуун сая) төгрөг байв. Мөн Шүүгдэгч Э.А-гийн өмгөөлөгч Ц.Д шүүх хуралдаанд гаргасан тайлбартаа “...мөрдөгч хохирлын тооцоог үйлдэхдээ 702,243,089 төгрөг хэмээн тооцсон байдаг” хэмээн дурдсан.

3. Улсын Дээд шүүхийн 79 дугаартай тогтоолын тодорхойлох хэсэгт “...үйлдсэн гэмт хэргийн нийгмийн хор аюулыг хэт бууруулан үнэлэх байдлаар учруулсан хохирол, хууль бусаар олсон орлогоос олон дахин бага мөнгөн дүнгээр шүүгдэгчийг торгох, ял тэнсэх шаардлагыг хэрхэн хангаж буй тухай дүгнэлтгүйгээр уг зохицуулалтыг хэрэглэх, гэмт хэргийн оролцоо, санаа зорилгын нэгдэл хэзээ бий болсон талаар дүгнэлт хийж чадаагүйгээс гэмт хэрэгт хамтран оролцох асуудлыг шийдвэрлэж чадаагүй, гэмт хэрэг үйлдсэн давтамжийг эс тооцон ял шийтгэлийг тэгшитгэн хавтгайруулж оногдуулсан зэрэг ноцтой алдааг анхан шатны шүүх гаргасан байгааг анхааруулах нь зүйтэй” хэмээн дүгнэсэн. Учруулсан хохирлыг бодитоор тогтоох талаар анхан шатны шүүхээс алдаа гаргасныг хүлээн зөвшөөрсөн боловч энэ асуудлыг хэрхэн шийдвэрлэх талаар дурдаагүй.

### **2.2.2. Шударга ёсны зарчим ба хариуцлага хүлээлгэхэд хөнгөрүүлэх, хүндрүүлэх асуудал**

Гэмт хэрэг үйлдсэн хүн, хуулийн этгээдэд оногдуулах ял, эрүүгийн хариуцлагын бусад арга хэмжээ нь тухайн этгээдийн үйлдсэн гэмт хэрэгт тохирсон буюу гэмт хэргийн нийгмийн аюулын шинж чанар, хэр хэмжээ, гэм буруутай этгээдийн хувийн байдал, гэмт хэрэг үйлдсэн нөхцөл байдалд тохирсон байх ёстой. Энэ зарчим нь анх *talio esto* буюу нүдийг нүдээр гэх талионы зарчмыг халан гэмт хэрэг үйлдсэн этгээд үйлдсэн гэмт хэрэгт нь тохирсон ял оногдуулах (тохирсон хариу арга хэмжээ биш) үзэл баримтлалаас үүсэн гарсан гэдэг.<sup>5</sup>

Эрүүгийн байцаан шийтгэх хуулиар шүүгдэгч гэмт хэрэг үйлдсэн гэм бурууг шүүх хуралдаанаар хэлэлцдэг, харин оногдуулах хариуцлага, түүнтэй холбоотой үүсэх бусад харилцааг тусгайлан хэлэлцэх боломжгүй байв.

<sup>5</sup> Г.Эрдэнэбат, Эрүүгийн эрх зүй, Гарын авлага, УБ., 2007, 49 дэх тал.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 36.1 дүгээр зүйлд шүүх хуралдаан нь гэм буруугийн болон эрүүгийн хариуцлага хүлээлгэх эсэхийг шийдвэрлэх гэсэн хоёр шаттай явагдахаар хуульчилсан. Энэ нь гэм буруугийн асуудлыг шийдсэний дараа эрүүгийн хариуцлага хүлээлгэхдээ нотлох баримтуудыг шинжлэн судалж байж хөнгөрүүлэх болон хүндрүүлэх шийдвэр гаргах боломж бүрдүүлсэн.

Шүүхийн шийдвэрт эрүүгийн хариуцлага хүлээлгэх асуудлыг хэлэлцэх шүүх хуралдаан явагдсан эсэх тухай мэдээлэл тусгагдаагүй. Энэхүү шийдвэрийн үндэслэл болсон нотлох баримтуудыг дурдаагүй байна.

Улсын Дээд шүүх анхан шатны шүүхийн шийдвэрийг хүчингүй болгож хэргийг дахин хэлэлцүүлэхээр буцаах болсон үндэслэл нь “...Учир нь гэмт хэрэг үйлдсэн хүнд эрүүгийн хариуцлага хүлээлгэхдээ Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан төрөл хэмжээний дотор багтсан байх төдий бус мөн хуулийн ерөнхий ангийн хэм хэмжээнд нийцсэн, хууль ёсны зарчмыг хангахын зэрэгцээ тухайлан сонгон оногдуулж буй ялын төрөл, түүний хэмжээ нь гэмт хэргийн шинж чанар, хэрэг үйлдсэн тодорхой нөхцөл байдал болон гэмт хэрэгтний хувийн байдалд хамгийн зүй зохистой харьцаагаар нийцсэн байх..., *...Үйлдсэн гэмт хэргийн нийгмийн хор аюулыг хэт бууруулан үнэлэх байдлаар учруулсан хохирол, хууль бусаар олсон орлогоосоо олон дахин бага мөнгөн дүнгээр шүүгдэгчдийг торгох, ял тэнсэх шаардлагыг хэрхэн хангаж буй тухай дүгнэлтгүйгээр уг зохицуулалтыг хэрэглэх, гэмт хэргийн оролцоо, санаа зорилгын нэгдэл хэзээ бий болсон талаар дүгнэлт хийж чадаагүйгээс гэмт хэрэгт хамтран оролцох асуудлыг шийдвэрлэж чадаагүй, гэмт хэрэг үйлдсэн давтамжийг эс тооцон ял шийтгэлийг тэгшитгэн хавтгайруулж оногдуулсан зэрэг ноцтой алдааг анхан шатны шүүх гаргасан” гэж дүгнэсэнтэй бас холбоотой. Үүнд:*

“...Учруулсан хохирол, хууль бусаар олсон орлогоосоо олон дахин бага мөнгөн дүнгээр шүүгдэгчийг торгох, ял тэнсэх шаардлагыг хэрхэн хангаж буй тухай дүгнэлтгүйгээр...” гэсэн нь Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 6.1 дүгээр зүйлийн 2 дахь заалт буюу “Эрүүгийн хариуцлага хүлээлгэхэд гэмт хэрэг үйлдсэн нөхцөл байдал, учирсан хохирол, хор уршгийн шинж чанар, гэмт хэрэг үйлдсэн хүний хувийн байдал, эрүүгийн хариуцлагыг хөнгөрүүлэх, хүндрүүлэх нөхцөл байдлыг тал бүрээс нь харгалзан үзнэ” гэж заасантай холбоотой.

Харин Эрүүгийн хуулийн 22.4 дүгээр зүйлд хахуулийн хэмжээнээс хамаарч эрүүгийн хариуцлагыг хүндрүүлэх нөхцөлийг заагаагүй нь улмаар практикт хахуулийн хэмжээ нь зүйлчлэлд нөлөөлөхгүй байх нь энэ төрлийн хэргийг шалгахдаа “хахуулийн хэмжээг тогтооход” ач холбогдол өгөхгүй байх буюу чухалчлан авч үзэхгүй байх нөхцөл бүрдүүлж байна гэсэн дүгнэлтэд хүргэж байна. Гэтэл давж заалдах шатны шүүхийн магадлал, хяналтын шатны шүүхийн шийдвэрийн дүгнэлтээс харахад шударгаар ял оногдуулахад хохирлын хэмжээ, хахуулийн хэмжээг харгалзахаар дүгнэж, хэргийг дахин хэлэлцүүлэхээр буцааж байгаа нь хохирлын хэмжээг тогтоох ёстойг дахин баталж байна.

Шүүхийн шийдвэрээс харахад Эрүүгийн хуулийн 6.5, 6.6 дугаар зүйлүүдэд заасан хөнгөрүүлэх, хүндрүүлэх нөхцөл байдлыг бүрэн хэрэглэх боломжгүй нь хуулийн зохицуулалттай шууд холбоотой. Тухайлбал, мөн хуулийн 6.5 дугаар зүйлд заасан эрүүгийн хариуцлагыг хөнгөрүүлэх долоон нөхцөл байдлаас “өөрийгөө илчилсэн, бусдын үйлдсэн гэмт хэргийг илрүүлэхэд тусалсан” гэснийг ашиглах боломжтой байгаа бол мөн хуулийн 6.6 дугаар зүйлд заасан нөхцөл байдлаар эрүүгийн хариуцлагыг хүндрүүлэх боломжгүй байна.

Эрүүгийн хуулийн 22.4 дүгээр зүйлийн 5 дахь хэсэгт дээр дурдсан эрүүгийн хариуцлага хүлээлгэх хүндрүүлэх болон хөнгөрүүлэх нөхцөл байдалд үндэслэн ял шийтгэлийг

ялгамжтай оногдуулах боломж хязгаарлагдмал тул шүүх мөн хуулийн 6.1 дүгээр зүйлийн 2-т зааснаар хээл хахуулийн гэмт хэрэг үйлдсэн нөхцөл байдал, учирсан хохирол, хор уршгийн шинж чанар, гэмт хэрэг үйлдсэн хүний хувийн байдлыг тал бүрээс нь харгалзан үзэж шийдвэр гаргажээ.

Эцэст нь дүгнэхэд гэмт хэрэгт гэм бурууд нь тохирсон ял оногдуулж чадсан эсэх нь эргэлзээтэй байна.

### 2.3 ЯЛААС ЧӨЛӨӨЛСӨН БАЙДАЛ

Гэмт хэрэг үйлдсэн гэм буруутай этгээд хариуцлагаас зайлсхийх ёсгүй. Хэдий тийм ч шударга ёсыг сэргээн тогтоох, гэмт хэргийг илрүүлэх, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх төрийн бодлогыг хэрэгжүүлэх зорилгоор гэм буруутай этгээдийг эрүүгийн хариуцлага, ялаас чөлөөлдөг. Эрүүгийн хуулийн 6.5 дугаар зүйлийн 1.5-д гэмт хэрэг үйлдсэн хүн өөрийгөө илчилсэн, бусдын үйлдсэн гэмт хэргийг илрүүлэхэд тусалсан бол хариуцлагыг хөнгөрүүлэхээр заасан.

Хэдий тийм боловч авлигатай тэмцэх зорилгоор Монгол Улсын Эрүүгийн хуулийн тусгай ангийн 22.5 дугаар зүйлийн тайлбарт хясан боогдуулсны улмаас аргагүй байдалд орж хахууль өгч, нийтийн албан тушаалтны хуулийн дагуу албаны чиг үүргээ гүйцэтгэж үзүүлэх төрийн үйлчилгээг авсан хүн энэ тухайгаа эрх бүхий байгууллагад сайн дураараа илчлэн ирсэн бол түүний авсан төрийн үйлчилгээг хэвээр үлдээж ялаас чөлөөлөхөөр тусгасан.

Дээр дурдсан үндэслэлээр шүүгдэгчдийг ялаас чөлөөлсөн.

### 2.4. ШҮҮГЧ ШҮҮН ТАСЛАХ ҮҮРГЭЭ ХЭРЭГЖҮҮЛЭХЭД ХӨНДЛӨНГӨӨС ОРОЛЦОХЫГ ХОРИГЛОХ

Монгол Улсын Үндсэн хуульд шүүх эрх мэдэл хууль тогтоох, гүйцэтгэх эрх мэдэлтэй харилцан хяналт тэнцвэртэй,



чиг үүрэг нь халдашгүй дархан, бие даасан удирдлага, зохион байгуулалттай болохыг үзэл баримтлалын төвшинд тодорхойлсон.

Шүүгчийн хараат бус байдлын нэг чухал ойлголт нь шүүн таслах үүргээ хэрэгжүүлэхэд хөндлөнгөөс оролцохыг хориглох Монгол Улсын Үндсэн хуулийн үзэл баримтлал<sup>6</sup> юм. Энэхүү хараат бус байдалд нөлөөлөх олон хүчин зүйл байдаг.<sup>7</sup>

Шүүхийн шийдвэрийг судлах явцад “Н.Г нь зохих байгууллагад хэргээ сайн дураараа илчлэн ирснийг үндэслэн ялаас чөлөөлсөн.. Уг шийдвэрийг Авлигатай тэмцэх газар соён гэгээрүүлэх ажилдаа ашиглаж, хэвлэл мэдээллийн хэрэгсэлд нийтэлсэн” гэх өмгөөлөгч Ц.Оюунчимэгийн гомдол, шүүх хуралдаанд хэлсэн санал, түүнчлэн өмгөөлөгч О.Сайнгэрэлийн гаргасан гомдол болон шүүх хуралдаанд хэлсэн саналд “...түүний ар гэр, нийгэмд эзлэх байр суурийг нийтээрээ ялласан. Миний үйлчлүүлэгчид холбогдох хэргийн гүйцэтгэх ажиллагааны нууц баримтыг прокурорын зөвшөөрөлгүйгээр нийтийн сүлжээнд цацсан. Уг мэдээллээр дамжиж түүний ар гэр гудамжинд, сургуульдаа явж чадахгүй давхар ял эдэлж байна” гэжээ.

Тус хэргийн давж заалдах шатны шүүх хуралдаан 2019 оны 9 дүгээр сарын 10-ны өдөр болсон. Шүүх хуралдаан болохоос өмнө буюу 2019 оны 7 дугаар сарын 30, 8 дугаар сарын 5, 9, 14, 30, 31, 9 дүгээр сарын 6-ны өдрүүдэд “Оймс Н.Б” хэмээх мэдээлэл хэвлэл мэдээллийн хэрэгслээр нэг өдөр зэрэг цацагдаж байсан байна. Давж заалдах шатны шүүх хуралдаан болохоос өмнө энэ мэдээллийг давтамжтайгаар цацсаныг шүүхэд нөлөөлөх зорилготой гэж хардах үндэслэлтэй. Учир нь анхан шатны болон хяналтын шатны шүүх хурал болохоос өмнө

<sup>6</sup> Монгол Улсын Үндсэн хуулийн 49 дүгээр зүйлийн 2. “Ерөнхийлөгч, Ерөнхий сайд, УИХ-ын ба Засгийн газрын гишүүн, төр, нам, олон нийтийн бусад байгууллагын албан тушаалтан, иргэн хэн боловч шүүгчээс шүүн таслах үүргээ хэрэгжүүлэхэд хөндлөнгөөс оролцож болохгүй”.

<sup>7</sup> <https://legaldata.mn/news/13>, “Шүүгчийн хараат бус байдал: Шүүх дэх нөлөөлөл” судалгааны ажил.

ийм мэдээлэл цацагдаагүй. Анхан шатны шүүх хуралдааны талаар ямар нэг мэдээлэл цацагдаагүй, хяналтын шатны шүүх хуралдааны явцад болон дууссаны дараа хэвлэл мэдээллийн хэрэгслээр мэдээлэл цацагдаж байжээ.

### Формаль шаардлага

<p>УДШ-ийн хяналтын шатны Иргэний хэргийн шүүх хуралдааны тогтоолд тавих хууль зүйн шаардлага<sup>8</sup></p>	<p>УДШ-ийн хяналтын шатны Захиргааны хэргийн шүүх хуралдааны тогтоолд тавих хууль зүйн шаардлага<sup>9</sup></p>	<p>УДШ-ийн хяналтын шатны Эрүүгийн хэргийн шүүх хуралдааны тогтоолд тавих хууль зүйн шаардлага<sup>10</sup></p>
<p><b>176 дугаар зүйл.</b> <b>Хяналтын шатны шүүх хуралдаан</b> 176.2. Шүүх хяналтын журмаар хэргийг дараах байдлаар хянан шийдвэрлэж тогтоол гаргана. 176.3. Тогтоолд шүүх хуралдаан даргалагч, илтгэсэн шүүгч гарын үсэг зурна. Тогтоолд анхан болон давж заалдах журмаар хэргийг хянан шийдвэрлэсэн шүүхийн шийдвэр,</p>	<p><b>127 дугаар зүйл.</b> <b>Хяналтын шатны шүүх хуралдаан</b> 127.2. Шүүх хяналтын журмаар хэргийг дараах байдлаар хянан шийдвэрлэж тогтоол гаргана. 127.3. Тогтоолд анхан болон давж заалдах журмаар хэргийг хянан шийдвэрлэсэн шүүхийн шийдвэр, магадлалын тогтоох хэсгийн агуулга, хяналтын журмаар гаргасан <i>гомдлын</i></p>	<p><b>40.8 дугаар зүйл.</b> <b>Хяналтын шатны шүүхийн шийдвэр</b> 1. Хяналтын шатны шүүх дараах шийдвэрийн аль нэгийг гаргана: 1.1. гомдол, эсэргүүцлийг хэрэгсэхгүй болгож, анхан болон давж заалдах шатны шүүхийн шийдвэрийг хэвээр үлдээх; 1.2. анхан болон давж заалдах шатны шүүхийн шийдвэрийг бүхэлд</p>

<sup>8</sup> Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль, 2002.

<sup>9</sup> Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, 2016.

<sup>10</sup> Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, 2017.

<p>магадлалын тогтоох хэсгийн агуулга, хяналтын гомдлын болон гаргаж байгаа тогтоолын үндэслэлийг тус тус тусгана.</p>	<p>болон гаргаж байгаа тогтоолын хуулийн үндэслэлийг тусгаж, шүүх хуралдаан даргалагч, илтгэгч шүүгч гарын үсэг зурна.</p>	<p>нь эсхүл зарим хэсгийг хүчингүй болгох, хэргийг хэрэгсэхгүй болгох; 1.3. энэ хуулийн 33.3 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 34.7 дугаар зүйлийн 6.2-т заасан үндэслэлээр анхан болон давж заалдах шатны шүүхийн шийдвэрийг бүхэлд нь эсхүл зарим хэсгийг хүчингүй болгож, хэргийг прокурорт эсхүл дахин хэлэлцүүлэхээр шүүхэд буцаах; 1.4. хэргийн зүйлчлэл, ялыг хүндрүүлэхгүйгээр анхан болон давж заалдах шатны шүүхийн шийдвэрт өөрчлөлт оруулах. Мөн зүйлийн 40.8 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт: 4. Хяналтын шатны шүүхийн шийдвэрт шүүх хуралдаан даргалагч, шүүх бүрэлдэхүүн гарын үсэг зурна.</p>
--	--	--

Эрүү, иргэн, захиргааны хэргийг хяналтын шатны шүүхээс шийдвэрлээд гарах шийдвэрийн хэлбэр, агуулгыг эрүү, иргэн, захиргааны хэргийн процессын хуулиудад хэрхэн хуульчилсныг харьцуулан судалж үзэхэд Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 176 дугаар зүйлийн 176.3-т “Тогтоолд анхан болон давж заалдах журмаар хэргийг хянан шийдвэрлэсэн шүүхийн шийдвэр, магадлалын тогтоох хэсгийн агуулга, хяналтын гомдлын болон гаргаж байгаа тогтоолын үндэслэлийг тусгана” гэж, Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 127 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт “Тогтоолд анхан болон давж заалдах журмаар хэргийг хянан шийдвэрлэсэн шүүхийн шийдвэр, магадлалын тогтоох хэсгийн агуулга, хяналтын журмаар гаргасан гомдлын болон гаргаж байгаа тогтоолын хуулийн үндэслэлийг тусгаж” гэж УДШ-ийн хяналтын шатны шүүх хуралдаанаас гаргах шийдвэрт тусгах нөхцөлийг хуульчилж өгсөн байна.

Харин Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 36.2 дугаар зүйлийн 3-т “Шүүхийн шийдвэр нь тодорхой, ойлгомжтой, түүнийг биелүүлэхэд ямар нэгэн эргэлзээ төрүүлэхгүй байхаар бичигдсэн байна” гэж хуульчилсан боловч энэ шаардлага давж заалдах болон хяналтын журмаар хэргийг хянан шийдвэрлэсэн шүүхийн шийдвэр, магадлалд хамаарах эсэх нь тодорхой тусгагдаагүй, зөвхөн шийдвэрийн тогтоох хэсэг буюу гаргах шийдвэрийн хэлбэрийг зааж өгсөн байна.

Иймд УДШ-ийн эрүүгийн хэргийн шүүх хуралдааны тогтоолд юу тусгахыг хуульчилж өгөөгүй нь тогтоолын бүтцийг тодорхойлоход хүндрэл учруулж, тогтоол логик дараалалгүй, эмх цэгцгүй бичигдэх үндэс суурь болж байна.

Судлаачийн хувьд УДШ-ийн тогтоолын эрүүгийн хэргийн шүүх хуралдааны 2020 оны 2 дугаар сарын 5-ны өдрийн 79 тоот тогтоолыг шууд уншаад ойлгоход бэрхшээлтэй, бүтцийг тодорхойлоход ч төвөгтэй, хуулийн дагуу бичигдсэн эсэхийг хянахад хүндрэлтэй байсныг дурдах нь зүйтэй. Энэ нь тухайн хэргийг хянан шийдвэрлэсэн анхан болон давж заалдах шатны шүүхийн шийдвэртэй танилцах үндэслэл болсон.

## 2.5. ӨМНӨ ГАРЧ БАЙСАН ТӨСӨӨТЭЙ ХЭРЭГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭСЭН ШҮҮХИЙН ШИЙДВЭРТЭЙ ХАРЬЦУУЛСАН БАЙДАЛ

Баянгол дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2017 оны 6 дугаар сарын 6-ны өдрийн 244 дүгээр шийтгэх тогтоол, Нийслэлийн Эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүхийн 2017 оны 8 дугаар сарын 24-ний өдрийн 639 дүгээр магадлалтай Монгол Улсын Дээд шүүхийн хяналтын шатны эрүүгийн хэргийн шүүх хуралдааны 2018 оны 1 дүгээр сарын 25-ны өдрийн 37 дугаартай тогтоолтой Б.Ц нарын 34 хүнд холбогдох эрүүгийн хэргийг сонгон авч судаллаа.

Харьцуулан судалж буй уг хэргийн холбогдогч Б.Ц нь 2002 оны Эрүүгийн хуулийн 268 дугаар зүйлийн 268.2 дахь хэсэгт заасан “Бусадтай бүлэглэн, хясан боогдуулах замаар, давтан үйлдлээр хээл хахууль авах” гэмт хэрэгт холбогдсон. Дараах төстэй байдлаар сонгон авч харьцуулан дүн шинжилгээ хийснийг харуулбал:

**Нэгдүгээрт:** зүйлчлэл адилхан;

**Хоёрдугаарт:** олон холбогдогчтой;

**Гуравдугаарт:** тухайн цаг үедээ нийгэмд уг гэмт хэргийн талаар нэлээд яригдсан<sup>11</sup>;

**Дөрөвдүгээрт:** Улсын Дээд шүүх хэрэг маргааныг эцэслэн шийдвэрлэж тогтоол гаргахдаа гол холбогдогч албан тушаалтныг гэм буруутайд тооцож ял шийтгэл оногдуулахдаа хөнгөн ял оногдуулсан хэмээн үзэж, хүндрүүлсэн.

<sup>11</sup> Харьцуулан судалж буй хэргийг гаалийнханд холбогдох хэрэг гэх бөгөөд судалж буй хэргийг мэргэжлийн хяналтынханд холбогдох хэрэг гэж хэвлэл мэдээлэл, нийтийн дунд яригддаг.

<p><b>Монгол Улсын Дээд шүүхийн хяналтын шатны эрүүгийн хэргийн шүүх хуралдааны тогтоол, 2020 оны 2 дугаар сарын 5, Дугаар 79.</b></p>	<p><b>Монгол Улсын Дээд шүүхийн хяналтын шатны эрүүгийн хэргийн шүүх хуралдааны тогтоол, 2018 оны 1 дүгээр сарын 25, Дугаар 37.</b></p>
<p>2015 оны Эрүүгийн хуулийн 22.4 дүгээр зүйлийн 5-д заасан гэмт хэрэг буюу “...аж ахуйн нэгжүүдийн зөвшөөрлийг олгохгүй удаах, хясан боогдуулах аргаар хахууль авсан”, “... түргэн муудах болон хүнсний бүтээгдэхүүн экспортлох, импортлох зөвшөөрөл авах хүсэлтийг шийдвэрлэхгүй хясан боогдуулсны улмаас аргагүй байдалд орж, төрийн үйлчилгээг авахын тулд хахууль өгсөн”.</p>	<p>Анхан шатны шүүх 2002 оны Эрүүгийн хуулийн 268 дугаар зүйлийн 268.2-т заасан “Хясан боогдуулах замаар, давтан үйлдлээр хээл хахууль авах гэмт хэрэг”, мөн хуулийн 269.1-д заасан “Албан тушаалтанд хээл хахууль өгөх гэмт хэрэг” үйлдсэн этгээдүүдэд 2002 оны Эрүүгийн хуулиар ял оногдуулсан ч хэргийг давж заалдах журмаар шалгах үед буюу 2017 оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс мөрдөгдөж эхэлсэн шинэчлэн найруулсан Эрүүгийн хуулийг буцаан хэрэглэсэн.</p>
<p>Дээрх хоёр хэрэг нь нийтийн албан тушаалтан албан тушаалын байдлаа ашиглан “хясан боогдуулах замаар” үйлдсэн гэдгээр ижил төсөөтэй.</p>	
<p>Үндсэн хуулийн цэцийн 2019 оны 3 дугаар сарын 13-ны өдрийн 01 дүгээр дүгнэлтээр Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 40.8 дугаар зүйлийн 1.4 дэх заалтын “эсхүл хүндрүүлж” гэсэн нь Үндсэн хууль зөрчсөн байна гэснийг Монгол Улсын Их Хурлын 2019 оны 3 дугаар сарын 26-ны өдрийн 27 дугаар тогтоолоор хүлээн</p>	<p>2015 оны Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 40.8 дугаар зүйлийн 1.4 дэх заалтыг баримтлан “...учруулсан хохирлоо нөхөн төлсөн гэх үндэслэлээр албан тушаалын байдлаа ашиглан зургаан удаагийн давтан үйлдлээр бусдаас хахууль авсан шүүгдэгч М.Э, Н.Б нарт оногдуулсан хорих ялыг торгох ял болгон хөнгөрүүлсэн</p>

зөвшөөрсөн тул дээрх 40.8 дугаар зүйлийн 1.4 дэх заалтыг “Хэргийн зүйлчлэл, ялыг хүндрүүлэхгүйгээр анхан болон давж заалдах шатны шүүхийн шийдвэрт өөрчлөлт оруулах” гэж өөрчлөн найруулсан. Иймд шүүх “үйлдсэн гэмт хэргийн нийгмийн хор аюулыг хэт бууруулан үнэлэх байдлаар учруулсан хохирол, хууль бусаар олсон орлогоос олон дахин бага мөнгөн дүнгээр шүүгдэгчийг торгох, ял тэнсэх шаардлагыг хэрхэн хангаж буй тухай дүгнэлтгүйгээр уг зохицуулалтыг хэрэглэх, гэмт хэргийн оролцоо, санаа зорилгын нэгдэл хэзээ бий болсон талаар дүгнэлт хийж чадаагүйгээс гэмт хэрэгт хамтран оролцох асуудлыг шийдвэрлэж чадаагүй, гэмт хэрэг үйлдсэн давтамжийг эс тооцон ял шийтгэлийг тэгшитгэн хавтгайруулж оногдуулсан зэрэг ноцтой алдааг анхан шатны шүүх гаргасан байгааг анхааруулах нь зүйтэй” гэж дүгнэсэн ч хэргийг дахин хэлэлцүүлэхээр анхан шатны шүүх рүү буцаасан.

нь эрүүгийн хариуцлага тухайн хүний үйлдсэн гэмт хэргийн нийгмийн аюулын шинж чанар, хэр хэмжээ, гэм бурууд тохирсон байх Эрүүгийн хуулийн шударга ёсны зарчимд нийцэхгүй байна” гэж үзэж ялыг хүндрүүлж, шүүхийн шийдвэрт өөрчлөлт оруулсан.

Дүн шинжилгээний объект болох Монгол Улсын Дээд шүүхийн хяналтын шатны эрүүгийн хэргийн шүүх хуралдааны 79 дугаартай тогтоолоор хэргийг дахин хэлэлцүүлэхээр буцаасан нь Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 40.8 дугаар зүйлийн 1.4 дэх заалтыг “Хэргийн зүйлчлэл, ялыг хүндрүүлэхгүйгээр анхан болон давж заалдах шатны шүүхийн шийдвэрт өөрчлөлт оруулах” гэж өөрчлөн найруулсантай холбоотой байна.

Чингэлтэй дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2019 оны 5 дугаар сарын 7-ны өдрийн шийтгэх тогтоолд “...Эрүүгийн хуулийн тусгай ангийн 22.4 дүгээр зүйлд заасан “Хахууль авах гэмт хэргийн зүйлчлэлд авсан хахуулийн хэмжээнээс хамаарч эрүүгийн хариуцлагыг хүндрүүлэх нөхцөлийг тодорхойлоогүй болно” гэж заасан. Харин Дээд шүүхийн хяналтын шатны эрүүгийн хэргийн шүүх хуралдааны тогтоолд “үйлдсэн гэмт хэргийн нийгмийн хор аюулыг хэт бууруулан үнэлэх байдлаар учруулсан хохирол, хууль бусаар олсон орлогоос олон дахин бага мөнгөн дүнгээр шүүгдэгчийг торгох...”-ыг алдаа гэж үзсэн байна.

37 дугаар Тогтоолын “тогтоох” хэсэгт “Харин учруулсан хохирлоо нөхөн төлсөн гэх үндэслэлээр албан тушаалын байдлаа ашиглан зургаан удаагийн давтан үйлдлээр бусдаас хахууль авсан шүүгдэгч М.Э, Н.Б нарт ногдуулсан хорих ялыг торгох ял болгон хөнгөрүүлсэн нь Эрүүгийн хуулийн шударга ёсны зарчимд нийцээгүй байна” гэж үзсэн байна.



<p>Хэдийгээр Эрүүгийн хуулийн тусгай ангийн 22.4-т хахуулийн хэм хэмжээг заагаагүй боловч Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 1.3 дугаар зүйлийн 1-д “Эрүүгийн хариуцлага нь тухайн хүн, хуулийн этгээдийн үйлдсэн гэмт хэрэг, гэмт хэргийн нийгмийн аюулын шинж чанар, хэр хэмжээ, гэм буруугийн хэлбэрт тохирсон байна” гэж заасан нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхдээ гэмт хэргийн нийгмийн аюулын шинж чанар, хэр хэмжээг харгалзан үздэг байх тул “хахуулийн хэмжээ”-г тогтоох, тодорхойлох шаардлага байгааг харуулж байна.</p>	
<p>Чингэлтэй дүүргийн эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2019 оны 5 дугаар сарын 7-ны өдрийн 363 тоот шийтгэх тогтоолд “Хэрэг мөрдөн шалгах ажиллагааны үед эд мөрийн баримтаар Э.А, Н.Б-гийн өмчлөлийн орон сууцнаас хураан авсан 230,800,000 төгрөг, 157,177 ам. доллар, 70,000 юанийг Эрүүгийн хуулийн 7.5 дугаар зүйлийн 3.4-т заасан гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, орлого гэж үзэх үндэслэлтэй байх тул улсын төсөвт шилжүүлэхээр шийдвэрлэв” гэжээ.</p>	<p>Баянгол Дүүргийн эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шийдвэрт “Шинэчлэн найруулсан Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 7.5 дугаар зүйлийн 1, 3, 6 дахь хэсэгт тус тус зааснаар хахууль авсан Б.Ц-ийн 15,040,000 төгрөг, Т.М-ийн 15,500,000 төгрөг, ...-ийг тэдгээрээс тус тус гаргуулж, улсын төсөвт шилжүүлсүгэй гэж, мөн дээрх заалтыг удирдлага болгон Шүүхийн тамгын газрын дансанд И.Н-ийн төлсөн 6,100,000 төгрөг, М.Э-гийн төлсөн 1,700,000 төгрөгийг улсын төсөвт шилжүүлсүгэй” гэж шийдвэрлэснийг хяналтын шатны шүүх хэвээр үлдээсэн байна.</p>
<p>Дээрх хоёр шийдвэрээс харьцуулж үзэхэд: Үндсэн судлагдахууныг шийдвэртэй харьцуулж байгаа Баянгол дүүргийн эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2017 оны 6 дугаар сарын 6-ны өдрийн 244 дүгээр шийтгэх тогтоолд шүүгдэгчдийн хахуульд авсан мөнгөн хөрөнгө, мөн шүүгдэгчдээс шүүхийн дансанд шилжүүлсэн мөнгөн хөрөнгө зэргийг улсын орлого болгосон, мөн Чингэлтэй дүүргийн эрүүгийн хэргийн анхан шатны шүүх мөрдөн шалгах ажиллагааны явцад хураан авсан мөнгөн хөрөнгийг улсын орлого болгосон байна.</p>	

Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 7.5 дугаар зүйлийн 2-т “Гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө орлогыг, ... гэмт хэрэг үйлдсэн хүн, хуулийн этгээдийн хувьд ногдох хөрөнгө, орлогоос албадан гаргуулна”, “гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, орлого гэж Монгол Улсад бол энэ хуулийн тусгай ангид заасан, гадаад улсад бол тухайн улсын хуулиар нэг жилээс дээш хугацаагаар хорих ял оногдуулахаар заасан гэмт хэрэг үйлдэж шууд, шууд бусаар олсон эдийн, эдийн бус хөрөнгө, түүний үнэ, түүнээс олсон ашиг, орлого, гэмт хэрэг үйлдэхэд ашигласан, ашиглахаар завдсан техник, хэрэгслийг ойлгоно” гэж заасан байна. “Гэмт хэрэг үйлдэж олсон эдийн, эдийн бус хөрөнгө, түүний үнэ, түүнээс олсон ашиг, орлого”-ыг гэж өргөн хүрээтэй заасан байх боловч Улсын Дээд шүүхээс Чингэлтэй дүүргийн эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2019 оны 5 дугаар сарын 7-ны өдрийн 363 тоот шийтгэх тогтоолоор шийдвэрлэгдсэн хэргийн “гэмт хэрэг үйлдэн олсон орлогын хэмжээ” дээр дүгнэлт гаргаагүй байна.

Харин Баянгол дүүргийн эрүүгийн хэргийн анхан шатны шүүх хахуульд авсан төгрөгийг шүүгдэгчдээс гаргуулахаар шийдвэрлэсэн шүүхийн практик буюу “гэмт хэрэг үйлдэж олсон орлого, шүүгдэгчдээс буцааж өгсөн орлогыг тус тусад нь авч үзэж байгаа” нь хахуулийн хэмжээг тогтоож шийдвэрлэсэн шүүхийн практик гэж үзэж болохоор байна. Мөн энэ шийдвэрийг хяналтын шатны шүүх хэвээр үлдээж шийдвэрлэжээ.

## ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ

Гэмт хэрэг үйлдсэн хүнд эрүүгийн хариуцлага хүлээлгэхдээ Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан төрөл, хэмжээний дотор багтсан байх төдий бус мөн хуулийн ерөнхий ангийн хэм хэмжээнд нийцсэн, хууль ёсны зарчим хангахын зэрэгцээ тухайлан сонгон оногдуулж буй ялын төрөл, түүний хэмжээ нь гэмт хэргийн шинж чанар, хэрэг үйлдэгдсэн тодорхой нөхцөл байдал болон гэмт хэрэгтний хувийн байдалд хамгийн зүй зохистой харьцаагаар нийцсэн байх Эрүүгийн хуулийн шударга ёсны зарчмыг хангасан байхыг шаарддаг.

Үйлдсэн гэмт хэргийн нийгмийн хор аюулыг хэт бууруулан үнэлж, учруулсан хохирол, хууль бусаар олсон орлогоос олон дахин бага мөнгөн дүнгээр шүүгдэгчийг торгох, ял тэнсэх шаардлагыг хангаж буй тухай дүгнэлтгүйгээр уг зохицуулалтыг хэрэглэх, гэмт хэргийн оролцоо, санаа зорилгын нэгдэл хэзээ бий болсон талаар дүгнэлт хийж чадаагүйгээс гэмт хэрэгт хамтран оролцох асуудлыг шийдвэрлэж чадаагүй, гэмт хэрэг үйлдсэн давтамжийг эс тооцон ял шийтгэлийг тэгшитгэн хавтгайруулж оногдуулсан зэрэг ноцтой алдааг анхан шатны шүүх гаргасан байгааг анхааруулах нь зүйтэй.

Дээрх дүгнэлт нь Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 6.5, 6.6 дугаар зүйлүүдэд заасан эрүүгийн хариуцлагыг хөнгөрүүлэх, хүндрүүлэх нөхцөл байдлыг хэрэглэх боломжгүй

тохиолдолд гэмт хэрэг үйлдсэн гэм буруутай этгээдэд ял, шийтгэл оногдуулах талаар гаргасан казуаль<sup>12</sup> тайлбар гэж үзэж болохоор байна. Энэ нь анхан шатны шүүх ял шийтгэл оногдуулах тухайд хуулийг зөв ойлгож хэрэглэх загвар болохоор байгаад шүүхийн шийдвэрийн ач холбогдол оршино.

Шүүхийн шийдвэр үндэслэлтэй, эргэлзээ төрүүлэхээргүй бичигдсэн эсэх, хээл хахууль өгөх, авах, гэмт хэргийн нотолбол зохих байдлыг (тэр дундаа хээл хахуулийн хэмжээг) шүүхийн хэлэлцүүлгийн явцад хэрхэн тогтоосон, хөнгөрүүлэх ба хүндрүүлэх нөхцөл байдлыг хэрхэн нотолж, тэрхүү нотолгоо нь гэм буруутай этгээдүүдэд ял оногдуулахад үндэслэл болсон эсэх, шүүгчээс шүүн таслах үүргээ хэрэгжүүлэхэд хөндлөнгөөс нөлөөлөх шинжтэй үйлдэл төрийн байгууллагаас гаргасан эсэх, хэрэв гаргасан бол хэрхэх талаар цаашид бусад судлаач гүнзгийрүүлэн судлах боломжтойг энэхүү шүүхийн шийдвэр харууллаа.

### **ЗӨВЛӨМЖ**

- Шүүх шийдвэр гаргахдаа Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 36.2 дугаар зүйлийн 3-т зааснаар тодорхой, ойлгомжтой, түүнийг биелүүлэхэд ямар нэгэн эргэлзээ төрүүлэхгүй байхаар бичих шаардлагыг хангах;
- Хяналтын журмаар хэрэг хянан шийдвэрлэхэд гэмт хэргийн нотолбол зохих байдал бүрэн нотлогдсон эсэхэд дүгнэлт гаргаж байх;
- Гэмт хэрэг үйлдсэн гэм буруутай этгээдэд ял шийтгэл оногдуулахдаа Эрүүгийн хуулийн тусгай ангийн хэм

<sup>12</sup> Тодорхой хэрэг шийдвэрлэх зорилгоор Дээд шүүхээс доод шатны шүүхэд хандан гаргаж байгаа тайлбар.

хэмжээнээс гадна Эрүүгийн болон Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн зарчмыг баримтлах;

- Эрүүгийн хэрэг шүүхээр хянан шийдвэрлэгдэх ажиллагаа эхлэхээс өмнө тухайн хэрэгтэй холбоотой мэдээллийг зөвхөн төрийн байгууллагаас олон нийтэд цацахыг “Шүүгчийн хараат бус байдалд хөндлөнгөөс оролцож байна” гэж үзэн шүүхийн захиргааны байгууллагаас хязгаарлах арга хэмжээ авах;
- Хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэх эрх зүйн зохицуулалтыг цаашид хэрэгжүүлж хэвших нэн шаардлагатай.

## АШИГЛАСАН МАТЕРИАЛ

1. Монгол Улсын Үндсэн хууль, 1992.
2. Эрүүгийн хууль, 2015.
3. Эрүүгийн байцаан шийтгэх тухай хууль, 2002.
4. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, 2017.
5. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль, 2002.
6. Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль, 2016.
7. Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хууль, 2012.
8. УДШ-ийн 2006 оны 4 дүгээр сарын 24-ний өдрийн 21 дугаартай “Шүүхийн шийдвэрийн тухай” тогтоол.
9. УДШ-ийн 2018 оны 10 дугаар сарын 29-ний өдрийн 01 дугаартай “Шүүхийн шийдвэрийг хүчингүй болгон, хэргийг дахин хянан хэлэлцүүлэхээр буцаах ажиллагааны эрх зүйн үндэслэл” тогтоол.
10. Ч.Нямсүрэн, Эрх зүйн ерөнхий онол, УБ., 2010, 119 дэх тал.
11. Г.Эрдэнэбат, Эрүүгийн эрх зүй, Гарын авлага, УБ., 2007, 49 дэх тал.
12. “Эрх зүй” сэтгүүл, 2017, №1, 37 дугаар цуврал, Т.Золбоо, “Эрүүгийн хэргийн шүүхийн шийдвэрт хийсэн дүн шинжилгээ”.

13. “Эрх зүй” сэтгүүл, 2017, №4, 40 дүгээр цуврал, Д.Баярсайхан, “Эрүүгийн хэргийн шүүхийн шийдвэрт хийсэн дүн шинжилгээ”.
14. “Шүүгчийн хараат бус байдал: Шүүх дэх нөлөөлөл”, судалгааны ажил.
15. Монгол хэлний их тайлбар толь, <https://mongoltoli.mn/dictionary/detail/86578>
16. Цахим мэдээллийн сайтууд.

## ХАВСРАЛТ

№	Овог нэр	Үйлдэл холбогдол	Яллах дүгнэлт	Анхан шатны шүүхийн шийдвэр	Давж заалдах шатны шүүх	Хяналтын шатны шүүх	Анхан шатны шүүх-2020.09.21
1	Н.Баярсайхан (хэлтсийн дарга)	230,800,000 төгрөг, 70,000 юань, 152,177\$- 138 удаагийн үйлдэлтэй, нэг удаадаа 120-130 сая авдаг.	3.7 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасныг журамлан 22.4 дүгээр зүйлийн 5 дахь хэсэг	Эрүүгийн хуулийн 22.4 дүгээр зүйлийн 5 дахь хэсэг болон бусадтай бүлэглэж гэснийг өөрчилж 40,000,000 төгрөгийн торгууль	Анхан шатны шүүхэд буцаасан.	Анхан шатны шүүхэд буцаасан хэвээр.	Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 3.7 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасныг журамлан мөн хуулийн тусгай ангийн 22.4 дүгээр зүйлийн 5 дахь хэсэгт зааснаар шүүгдэгч Н.Б-гийн нийтийн албанд томилогдох эрхийг 5 (тав) жилийн хугацаагаар хасаж, 2 (хоёр) жил 8 (найм) сарын хугацаагаар хорих ял



2	Э.Азаяа (газрын дарга)		3.7 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасныг журамлан 22.4 дүгээр зүйлийн 5 дахь хэсэг	18.6 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар болгон өөрчилж хөөн хэлэлцэх хугацаа дууссан гэх үндэслэлээр хэрэгсэхгүй болгосон.	Анхан шатны шүүхэд буцаасан.	Анхан шатны шүүхэд буцаасан хэвээр.	нийтийн албанд томилогдох эрхийг 5 (тав) жилийн хугацаагаар хасаж, 40,000 (дөчин мянга) нэгжтэй тэнцэх хэмжээний буюу 40,000,000 (дөчин сая) төгрөгийн торгох ял
3	С.Бүрэнтөгс (ахлах байцаагч)	5,000,000	3.5 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасныг журамлан 22.4 дүгээр зүйлийн 5 дахь хэсэг	18.6 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар болгон өөрчилж хөөн хэлэлцэх хугацаа дууссан гэх үндэслэлээр хэрэгсэхгүй болгосон.	Анхан шатны шүүхэд буцаасан.	Анхан шатны шүүхэд буцаасан хэвээр.	нийтийн албанд томилогдох эрхийг 5 (тав) жилийн хугацаагаар хасаж, 15,000 (арван таван мянга) нэгжтэй тэнцэх хэмжээний буюу 15,000,000 (арван таван сая) төгрөгийн торгох ял

Үргэлжлэл

4	Гомбосүрэн-гийн Элдэв-Очир (ахлах байцаагч)	5,000,000	3.5 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасныг журамлан 22.4 дүгээр зүйлийн 5 дахь хэсэг	18.6 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар болгон өөрчилж хөөн хэлэлцэх хугацаа дууссан гэх үндэслэлээр хэрэгсэхгүй болгосон.	Анхан шатны шүүхэд буцаасан.	Анхан шатны шүүхэд буцаасан хэвээр.	Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 3.5 дугаар зүйлийн 1 дэх хэсгийг журамлан мөн хуулийн тусгай ангийн 22.4 дүгээр зүйлийн 5 дахь хэсэгт зааснаар шүүгдэгч Г.Э-гийн нийтийн албанд томилогдох эрхийг 5 (тав) жилийн хугацаагаар хасаж, 13,000 (арван гурван мянга) нэгжтэй тэнцэх хэмжээний буюу 13,000,000 (арван гурван сая) төгрөгийн торгох ял
5	О.Багтер, Асуйн хөгжил ХХК, Ивээл буудай ХХК-ийн захирал	9,300,000+ 47600\$	Эрүүгийн хуулийн тусгай ангийн 22.5 дугаар зүйлийн 1 дэх хэсэг	2,700,000 төгрөгөөр торгож, ялаас чөлөөлсөн.	Анхан шатны шүүхэд буцаасан.	Анхан шатны шүүхийн шийтгэх тогтоол хэвээр.	

АВЛИГЫН ГЭМТ ХЭРГИЙГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭСЭН  
УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН ШИЙДВЭРИЙН ДҮН ШИНЖИЛГЭЭ

ШҮҮХИЙН ШИЙДВЭРИЙН СУДАЛГАА: ЦУВРАЛ 2

Үргэлжлэл

6	Э.Онон, Налгар тариалан ХХК	5,100,000	Эрүүгийн хуулийн тусгай ангийн 22.5 дугаар зүйлийн 1 дэх хэсэг	2,700,000 тегрөгийн торууль	Анхан шатны шүүхэд буцаасан.	Анхан шатны шүүхийн шийтгэх тогтоол хэвээр.	
7	М.Наран- гэрэл, Баатруудын тэнгэр ХХК- ийн менежер	2,000,000	3.7 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасныг журамлан 22.5 дугаар зүйлийн 3 дахь хэсэг	Хэрэгсэхгүй болгосон.	Нийслэл- лийн проку- рорг бу- цаасан.	Анхан шатны шүүхийн шийтгэх тогтоол хэвээр.	
8	Ш.Тэгвандан (улсын байцаагч)	Мэргэж- лийн хяналтын байгаль орчны байцаагч, 8,400,000	3.5 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасныг журамлан 22.5 дугаар зүйлийн 1 дэх хэсэг	Ял оногдуу- лахгүйгээр 1 жил тэнссэн.	Анхан шатны шүүхэд буцаасан.	Анхан шатны шүүхэд буцаасан хэвээр.	Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 3.5 дугаар зүйлийн 1 дэх хэсгийг журамлан мөн хуулийн тусгай ангийн 22.5 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар шүүгдэгч Ш.Т-гийн нийтийн албанд томилгодох эрхийг 3 (гурав) жилийн

Үргэлжлэл

9	Ж.Батжар-гал, Дархан Сэлэнгэ ХХК	500,000	Эрүүгийн хуулийн тусгай ангийн 22.5 дугаар зүйлийн 1 дэх хэсэг	2,700,000 төгрөгийн торгууль	Анхан шатны шүүхэд буцаасан.	Анхан шатны шүүхийн шийтгэх тогтоол хэвээр.	хугацаагаар хасаж, 2,700 (хоёр мянга долоон зуу) нэгжтэй тэнцэх хэмжээний буюу 2,700,000 (хоёр сая долоон зуун мянга) төгрөгийн торгох ял
10	Б.Алтангэрэл (иргэн Бат, Буудай ХХК)	35,600,000	Эрүүгийн хуулийн тусгай ангийн 22.5 дугаар зүйлийн 1 дэх хэсэг	2,700,000 төгрөгийн торгууль	Анхан шатны шүүхэд буцаасан.	Анхан шатны шүүхийн шийтгэх тогтоол хэвээр.	
11	Н.Маржангүл, Жи Эс Км ХХК-ийн дэд захирал	шонхор шувуу 66,000\$	Эрүүгийн хуулийн тусгай ангийн 22.5 дугаар зүйлийн 1 дэх хэсэг	2,700,000 төгрөгөөр торгож, ялаас чөлөөлсөн.	Анхан шатны шүүхэд буцаасан.	Анхан шатны шүүхийн шийтгэх тогтоол хэвээр.	

12	Д.Даваа-сүрэн, Уудам-Өнөр ХХК-ийн захирал, ахынхаа компанийн зөвшөөрлийг ашиглаж рапс гаргасан.	14 сая, 6750 \$	Эрүүгийн хуулийн тусгай ангийн 22.5 дугаар зүйлийн 3 дахь хэсэг	Эрүүгийн хуулийн тусгай ангийн 22.5 дугаар зүйлийн 1 дэх болгон өөрчилж 2,700,000 төгрөгийн торгууль	Нийслэлийн проку-рорт буцаасан.	Анхан шатны шүүхийн шийтгэх тогтоол хэвээр.	
13	Б.Бат-Оргил, Уудам-Оргил ХХК-ийн захирал	27,000,000	Эрүүгийн хуулийн тусгай ангийн 22.5 дугаар зүйлийн 3 дахь хэсэг	Эрүүгийн хуулийн тусгай ангийн 22.5 дугаар зүйлийн 1 дэх болгон өөрчилж 2,700,000 төгрөгийн торгууль	Нийслэлийн проку-рорт буцаасан.	Анхан шатны шүүхийн шийтгэх тогтоол хэвээр.	

14	Ж.Саруул, Бор банди агро ХХК- ийн захирал	8,400,000	3.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасныг журамлан 22.5 дугаар зүйлийн 1 дэх хэсэг	Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 3.7 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасныг журамлан тусгай ангийн 22.5 дугаар зүйлийн 1 дэх хэсэг	Анхан шатны шүүхэд буцаасан.	Анхан шатны шүүхийн шийтгэх тогтоол хэвээр.
15	Н.Гантулга, Түмэн хүнс ХХК-ийн хуулийн зөвлөх	Грийн гресс ланд -3,000,000	Эрүүгийн хуулийн тусгай ангийн 22.5 дугаар зүйлийн 1 дэх хэсэг	2,700,000 тегрөгийн торгууль оногдуулж ялаас чөлөөлсөн.	Анхан шатны шүүхэд буцаасан.	Анхан шатны шүүхийн шийтгэх тогтоол хэвээр.
16	Ц.Отгон- жаргал, Монга аржин ХХК, Эрүүл монгол мах эко ХХК-ийн захирал	Нордронд -3,500,000	Эрүүгийн хуулийн тусгай ангийн 22.5 дугаар зүйлийн 1 дэх хэсэг	2,700,000 тегрөгийн торгууль	Анхан шатны шүүхэд буцаасан.	Анхан шатны шүүхийн шийтгэх тогтоол хэвээр.

Үргэлжлэл

17	Л.Номин-гэрэл, Арвай цэцэгт ХХК-ийн орчуулагч	Хүн од -10,000,000	Эрүүгийн хуулийн тусгай ангийн 22.5 дугаар зүйлийн 1 дэх хэсэг	2,000,000 төгрөгийн торгууль	Анхан шатны шүүхэд буцаасан.	Анхан шатны шүүхийн шийтгэх тогтоол хэвээр.	
18	М.Цагаан-баатар, Монгол мах эко ХХК-ийн захирал	30,620,000	3.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасныг журамлан 22.5 дугаар зүйлийн 3 дахь хэсэг	Эрүүгийн хуулийн тусгай ангийн 22.5 дугаар зүйлийн 1 дэх болгон өөрчилж 2,700,000 төгрөгийн торгууль	Нийслэлийн прокуратураар буцаасан.	Анхан шатны шүүхийн шийтгэх тогтоол хэвээр.	
19	Д.Хандсүрэн (иргэн)	Монгол мах эко- 6,820,000	3.5 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасныг журамлан 22.5 дугаар зүйлийн 3 дахь хэсэг	Хэрэгсэхгүй болгосон.	Нийслэлийн прокуратураар буцаасан.	Анхан шатны шүүхийн шийтгэх тогтоол хэвээр.	

20	Дашдуламын Эрдэнэбат (иргэн)	Өөдрөг заяа, Их зам транс ХХК- 6,750,000	Эрүүгийн хуулийн тусгай ангийн 22.5 дугаар зүйлийн 1 дэх хэсэг	2,700,000 тегрөгийн торгууль	Анхан шатны шүүхэд буцаасан.	Анхан шатны шүүхийн шийтгэх тогтоол хэвээр.	
21	Д.Зандан- сүрэн (иргэн Оюун, Халиун ХХК-ийн нэрээр үржлийн адуу гаргах)	1,500,000	Эрүүгийн хуулийн тусгай ангийн 22.5 дугаар зүйлийн 1 дэх хэсэг	Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 2.8 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт заасныг удирдлага болгон 22.5 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан эрүүгийн хариуцлагаас чөлөөлсөн.	Анхан шатны шүүхэд буцаасан.	Анхан шатны шүүхийн шийтгэх тогтоол хэвээр.	
22	Г.Даваасүрэн, Өег ХХК- ийн захирал	26,000,000	Эрүүгийн хуулийн тусгай ангийн 22.5 дугаар зүйлийн 1 дэх хэсэг	2,700,000 тегрөгийн торгууль	Анхан шатны шүүхэд буцаасан.	Анхан шатны шүүхийн шийтгэх тогтоол хэвээр.	



23	Э.Оргил, Баатруудын тэнгэр ХХК- ийн менежер	2,000,000	3.7 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасныг журамлан 22.5 дугаар зүйлийн 3 дахь хэсэг	Эрүүгийн хуулийн тусгай ангийн 22.5 дугаар зүйлийн 1 дэх болон өөрчилж 2,700,000 төгрөгийн торгууль оногдуулж ялаас чөлөөлсөн.	Нийслэ- лийн проку- рорт буцаасан.	Анхан шатны шүүхийн шийтгэх тогтоол хэвээр.	
24	Т.Чингиз, Абсолют ХХК-ийн менежер	7,780,000	Эрүүгийн хуулийн тусгай ангийн 22.5 дугаар зүйлийн 1 дэх хэсэг	2,700,000 төгрөгийн торгууль оногдуулж ялаас чөлөөлсөн	Анхан шатны шүүхэд буцаасан.	Анхан шатны шүүхийн шийтгэх тогтоол хэвээр.	

Үргэлжлэл

25	Д.Төмөр-баатар, Улаанбаатар мах экспо ХХК-ийн ерөнхий менежер	337,500,00-64 удаагийн үйлдэлтэй.	Эрүүгийн хуулийн тусгай ангийн 22.5 дугаар зүйлийн 1 дэх хэсэг	2,700,000 төгрөгийн торгууль	Анхан шатны шүүхэд буцаасан.	Анхан шатны шүүхэд буцаасан хэвээр.	Эрүүгийн хуулийн тусгай ангийн 22.5 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар шүүгдэгч Д.Т-гийн нийтийн албанд томилогдох эрхийг 2 (хоёр) жилийн хугацаагаар хасаж, 9,000 (есөн мянга) нэгжтэй тэнцэх хэмжээний буюу 9,000,000 (есөн сая) төгрөгийн торгох ял
----	---	-----------------------------------	--	------------------------------	------------------------------	-------------------------------------	--



# 2

## УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН ХЯНАЛТЫН ШАТНЫ ЭРҮҮГИЙН ХЭРГИЙН ШҮҮХИЙН ШИЙДВЭРИЙН ДҮН ШИНЖИЛГЭЭ

### СУДЛААЧИЙН ТАНИЛЦУУЛГА



#### ОТГОНБАЯРЫН МӨНХЦЭЦЭГ

Хөгжлийн эрх зүйн төв ТББ-ын Гүйцэтгэх захирал, хууль зүйн магистр LL.M.

2011 онд МУИС-ийн Хууль зүйн сургуулийг эрх зүйн бакалавр зэрэгтэй төгсөж, 2014 онд хууль зүйн магистрын зэрэг, 2015 онд АНУ-ын Saint Thomas их сургуульд хүний эрхийн магистрын зэрэг хамгаалсан.

Тэмүүжин ресорс ХХК-д хуульч, Улсын ерөнхий прокурорын газарт туслах, Нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн Прокурорын газарт хяналтын прокуророор ажиллаж байсан. 2021 оноос Хөгжлийн эрх зүйн төв ТББ-д судлаачаар ажиллаж байна.

#### Судлаач:

О.Мөнхцэцэг

## АГУУЛГА

Удиртгал .....	69
1. Шүүхийн шийдвэрийн шинжилгээ .....	71
1.1. Цэгцтэй байдал ба бүтэц .....	71
1.2. Талуудын тайлбарыг авч үзсэн байдал .....	79
1.3. Хууль хэрэглээ .....	81
1.4. Итгэл үнэмшил төрүүлэхүйц үндэслэл .....	83
1.5. Шүүхийн шийдвэр нэг мөр байх асуудал .....	83
1.6. Хууль эрх зүйн орчны үр нөлөө .....	84
Дүгнэлт .....	88
Ашигласан материал .....	90

## УДИРТГАЛ

Монгол Улсын Эрүүгийн хуулийг 2015 онд шинэчлэн найруулж баталсан билээ. Үүнээс хойш буюу 2017 оны 7 дугаар сарын 1-ээс 2020 оны 6 дугаар сарын 1 хүртэл шүүхийн шийдвэрийн цахим санд Эрүүгийн хуулийн 22.1 дүгээр зүйлд заасан “Эрх мэдэл, албан тушаалын байдлаа урвуулан ашиглах” гэмт хэргээр нийт зургаан хэрэг хяналтын шатны шүүхээр шийдэгдсэн тухай шийдвэр байрлуулжээ.

Дээрх хэргүүдээс судлаач хяналтын шатны шүүхийн 2019 оны 9 дүгээр сарын 17-ны өдрийн 407 дугаартай шийдвэрийг сонгон авч дүн шинжилгээ хийлээ. Шүүхийн шийдвэрт дүн шинжилгээ хийх үндсэн зорилго нь хууль тогтоомжийг нэг мөр хэрэглэх, шүүхийн нэгдмэл практик тогтоох явдал байдаг. Бидний сонгож авсан хэрэг анхан шатны шүүхээс ял оногдуулж, давж заалдах шатны шүүхээс хэргийг хэрэгсэхгүй болгон шүүгдэгчийг цагаатгаж, хяналтын шатны шүүхээс эргээд анхан шатны шүүхийн шийдвэрийг хэвээр үлдээж шийдвэрлэсэн байгаагаараа шүүхийн нэгдмэл практик тогтоогүй болох нь илэрхий харагдаж буй хэлбэр юм. Үүний зэрэгцээ шат шатны шүүхээс Эрүүгийн хуулийн 22.1 дүгээр зүйл дэх хамгийн тодорхойгүй, эргэлзээтэй гэмт хэргийн шинжийг илэрхийлсэн ухагдахуун болох “өөртөө, болон бусдад давуу байдал олгох” тухай ойлголтыг тайлбарлаж, шүүхийн нэгдмэл практик тогтоохыг оролдсон тохиолдол байв.

Судлаач дээрх шүүхийн шийдвэрийг судлахдаа Шүүхийн ерөнхий зөвлөлөөс Олон улсын хөгжлийн эрх зүйн байгууллагын дэмжлэгтэй боловсруулсан Шүүхийн шийдвэрт дүн шинжилгээ хийх арга зүйг ашиглав<sup>1</sup>. Уг арга зүй нь Европын шүүгчдийн зөвлөлдөх зөвлөлөөс тунхагласан стандарт бөгөөд шүүхийн шийдвэр боловсруулах үйл ажиллагааны чанар болон шүүгчдийн ажлыг үнэлэх үйл ажиллагааг хэрхэн боловсронгуй болгох талаар өгсөн зөвлөмж юм.

---

<sup>1</sup> Шүүхийн шийдвэрт дүн шинжилгээ хийх арга зүй, “Шүүх эрх мэдэл” эмхэтгэл, 2017, №2, 113-122 дахь тал.

## 1. ШҮҮХИЙН ШИЙДВЭРИЙН ШИНЖИЛГЭЭ

### 1.1. ЦЭГЦТЭЙ БАЙДАЛ БА БҮТЭЦ

Монгол Улсын Дээд шүүхийн хяналтын шатны эрүүгийн хэргийн шүүх хуралдааны 2019 оны 9 дүгээр сарын 17-ны өдрийн 407 дугаартай тогтоолын<sup>2</sup> удиртгал хэсэгт шүүх, шүүх бүрэлдэхүүн, прокурор, шүүгдэгч, түүний өмгөөлөгч, нарийн бичгийн дарга зэрэг оролцогчийг дурдаад өмнө шийдвэрлэсэн шүүхийн шийдвэр, хэргийн дугаар, шүүгдэгчийн биеийн байцаалт, ял шийтгэл эдэлж байсан эсэх талаарх мэдээллийг тэмдэглэж шүүгдэгчийн холбогдсон хэргийн талаар тусгажээ. Үүнд, Б.Б нь Дорнод аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын даргаар ажиллаж байхдаа албан үүрэг, бүрэн эрхээ урвуулан ашиглаж “Мах, сүү, сүүний чиглэлийн үржлийн хээлтэгч, хээлтүүлэгч олгох” төслийн 3,000,000 төгрөгийн үнэ бүхий 16 толгой үхрийг төсөл сонгон шалгаруулалт явуулалгүйгээр аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгч Ч.Д, төрсөн дүү Ч.Б нарт 2017 оны 12 дугаар сарын 4-ний өдөр олгон, бусдад давуу байдал бий болгосон” гэмт хэрэгт холбогджээ.

Энэ хэргийг анхан шатны шүүх шийдвэрлэхдээ “...шүүгдэгч Б.Б-г нийтийн албан тушаалтан албан үүрэг, бүрэн эрх, албан тушаалын байдлаа урвуулан ашиглаж бусдад давуу байдал бий болгосон гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцон, Эрүүгийн хуулийн тусгай ангийн 22.1 дүгээр зүйлийн 1 дэх

<sup>2</sup> <http://new.shuukh.mn/eruuhyanalt/1884/view>



хэсэгт зааснаар шүүгдэгч Б.Б-гийн нийтийн албанд томилогдох эрхийг хоёр жилийн хугацаагаар хасаж, 5400 нэгжтэй тэнцэх хэмжээний буюу 5,400,000 төгрөгийн торгууль оногдуулан шийдвэрлэжээ.

Харин Дорнод аймгийн Эрүү, Иргэний хэргийн давж заалдах шатны шүүх шийтгэх тогтоолыг бүхэлд нь хүчингүй болгож, шүүгдэгч Б.Б-д холбогдох Эрүүгийн хуулийн тусгай ангийн 22.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасан хэргийг Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 34.19 дүгээр зүйлийн 1.1-д зааснаар хэрэгсэхгүй болгон цагаатгаж, мөн зүйлийн 2 дахь хэсэгт заасныг баримтлан хэргийг хэрэг бүртгэлтэд буцаан шийдвэрлэжээ.

Эл шийдвэрийг хяналтын шатны шүүхэд прокурор Ц.Лхамсүрэн эсэргүүцлийн бичигтээ “Магадлалыг эс зөвшөөрч эсэргүүцэл бичиж байна. Б.Б нь Дорнод аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын даргын үүрэг гүйцэтгэгчээр томилогдон ажиллаж байхдаа Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, материал худалдан авах тухай хуульд заасны дагуу сонгон шалгаруулалт явуулах ёстой байхад уг шалгаруулалтыг явуулалгүйгээр төслийн 16 тооны үхрийг Ч.Д, Ч.Б нарт олгохоор тушаал гаргаж албан үүрэг, эрх мэдлээ урвуулан ашигласан болох нь хэрэгт авагдсан нотлох баримтуудаар нотлогдон тогтоогдсон. Давж заалдах шатны шүүх Б.Б-д холбогдох хэргийг шийдвэрлэхдээ “давуу байдал олж авсан этгээдүүд үүнээсээ татгалзсанаар үйлдлийн хор уршиг арилсан, Б.Б-гийн үйлдлээр зөрчигдсөн дүрэм, журам нь хуульчлагдаагүй” гэж дүгнэсэн нь үндэслэлгүй байна. Учир нь Эрүүгийн хуулийн тусгай ангийн 22.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасан гэмт хэрэг нь хэлбэрийн бүрэлдэхүүнтэй ба бодитой хор, уршиг бий болсон эсэх, хохирлын хэмжээг харгалзан үзэхээргүй байхад Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 2.1 дүгээр зүйлийн 4 дэх хэсэгт заасан “гэмт хэргийн шинжийг хэлбэрийн төдий агуулсан, нийгмийн аюулын хэр хэмжээ нь энэ

хуулиар хамгаалагдсан эрх, ашигт бодит хохирол, хор уршиг учруулаагүй” гэх заалтад хамааруулж дүгнэсэн нь Эрүүгийн хуулийг буруу тайлбарлан хэрэглэсэн гэж үзэж байна. Мөн Б.Б-гийн зөрчсөн гэх дүрэм, журам нь Монгол Улсын Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа материал худалдан авах тухай хуулиар зохицуулагдах бөгөөд тэрээр төсөл сонгон шалгаруулалт явуулахгүйгээр, төсөл сонгон шалгаруулах ажлыг зохион байгуулах чиг үүрэг бүхий үнэлгээний хороо буюу ажлын хэсэгт нөлөөлж, төрөөс үзүүлж байгаа төсөл сонгон шалгаруулах үйлчилгээнд иргэдийн тэгш, шударгаар оролцох эрхийг хязгаарласан, төрийн үйл ажиллагааг хэвийн явуулахад харшилсан, эрх мэдлээ урвуулан ашигласан үйлдэл хийснээрээ Эрүүгийн хуулийн тусгай ангийн 22.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасан гэмт хэргийн шинжийг хангаж байна.

Энэхүү үйлдлийн улмаас зөвхөн нэг субъект биш нийтийн эрх ашиг хөндөгдөж байгаа тул хохирол, хор уршиг бодитойгоор шаардахгүй юм. Давж заалдах шатны шүүх Авлигын тухай хуулийг буруу тайлбарлаж, Эрүүгийн хуулийн тусгай ангийн 22.1 дүгээр зүйлд заасан “Эрх мэдэл, албан тушаалын байдлаа урвуулан ашиглах” гэмт хэргийн субъектив талын шинжид “хувийн ашиг сонирхлоо гүйцэлдүүлэх зорилго” зайлшгүй байх ёстой гэсэн хэт нэг талыг барьсан дүгнэлт хийж, Б.Б нь албаны эрх мэдлээ урвуулан ашигласны улмаас хувийн ашиг сонирхлоо гүйцэлдүүлсэн гэх нөхцөл тогтоогдоогүй тул гэмт хэргийн шинжгүй байна гэж түүнд холбогдох хэргийг хэрэгсэхгүй болгож цагаатгасан нь үндэслэлгүй байна. Өөрөөр хэлбэл, Авлигын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1-д “авлига” гэх нэр томъёог “Албан тушаалын эрх мэдлээ хувийн ашиг хонжоо олоход урвуулан ашиглах, бусдад давуу байдал олгох, иргэн, хуулийн этгээдээс тэрхүү хууль бус давуу байдлыг олж авах үйлдэл, эс үйлдэхгүйгээр илрэх аливаа эрх зүйн зөрчлийг ойлгоно” гэж, мөн хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.4-т “албан тушаалын эрх мэдлээ урвуулан ашиглах” гэдгийг

албан тушаалын эрх, мэдлийг “албаны эрх ашгийн эсрэг” буюу “хувийн ашиг сонирхлоо гүйцэлдүүлэх” зорилгод ашиглан хийх ёстой үйлдлийг хийхгүй байх, хийх ёсгүй үйлдлийг хийх” гэж тус тус тодорхойлсон байна. Дээрх тодорхойлолтоос үзэхэд “...хувийн ашиг хонжоо олоход урвуулан ашиглах...” гэсэн нэг ойлголт, “...бусдад давуу байдал олгох...” гэсэн өөр нэг ойлголтыг таслалаар заагласан, мөн “албаны эрх ашгийн эсрэг” буюу “хувийн ашиг сонирхлоо гүйцэлдүүлэх” гэсэн тус тусдаа гэмт хэргийн объектив шинжтэй ойлголт байхад “Хувийн ашиг сонирхлоо гүйцэлдүүлэхээр өөртөө эдийн болон эдийн бус ашигтай байдал бий болгосон бол албан тушаалын байдлаа урвуулан ашиглах гэмт хэргийн шинжийг бүрэн хангана” гэж дүгнэсэн нь үндэслэлгүй юм. Иймд давж заалдах шатны шүүх хэргийн бодит байдалд нийцээгүй дүгнэлт хийн, Эрүүгийн хуулийг буруу тайлбарлан хэрэглэж Б.Б-д холбогдох хэргийг цагаатгасан тул магадлалыг хүчингүй болгуулахаар прокурорын эсэргүүцэл бичив” гэжээ.

Харин шүүгдэгчийн өмгөөлөгч В.Давааням хэлсэн саналдаа “Прокурорын эсэргүүцэлд дурдсан Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа материал худалдан авах тухай хууль Монгол Улсад байхгүй. Харин 2005 оны 12 дугаар сарын 1-ний өдөр батлагдсан Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль Монгол Улсад хүчин төгөлдөр үйлчилж байна. Энэ хуулийн гол зохицуулах харилцаа нь төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр гаднаас бараа, ажил үйлчилгээ худалдан авах үйл ажиллагааг зохицуулах юм. Гаднаас бараа, ажил үйлчилгээ худалдан авахад уг хуулийг дагаж мөрддөг. Энэ нь нэгэнт тогтсон ойлголт юм. Улсын төсвийн хөрөнгөөр тодорхой үнийн дүнгээс дээш үнэтэй бараа, ажил үйлчилгээ худалдан авах шаардлагатай тохиолдолд нээлттэй сонгон шалгаруулалт зарлаж гаднаас бараа ажил, үйлчилгээ худалдаж авахдаа энэ хуульд заасан журмыг баримталдаг.

Гэтэл төр өөрийн дансны буюу өөрийн мэдлийн хөрөнгийг бусдын эзэмшилд түр шилжүүлж, иргэдийг малтай болгох үйл ажиллагаа явагдсан. Энэ харилцаа нь яагаад Тендерийн хуулийн дагуу зохицуулагдах харилцаа болсон нь ойлгомжгүй байна. Дорнод аймгийн Засаг даргын эрх шилжүүлэх тухай А/58 дугаар захирамж, түүний хавсралтаар Б.Б-гийн гэм буруу тогтоогдож байна гэж нотлох баримтаар авч үзсэн. Уг захирамж, түүний хавсралтаар малжуулах төсөлд хэрэглэгдэх нийт үхрийг худалдан авах эрхийг Хүнс, хөдөө аж ахуйн даргад шилжүүлээд энэ захирамж хэрэгжин үхрийг худалдаж авсан. Давж заалдах шатны шүүхээс хэрэгт авагдсан нотлох баримтыг үндэслэж Авлигын эсрэг хууль тогтоомжийг зөв хэрэглэн, хэргийг цагаатгасан гэж үзэж байна. Хор уршиг учирсан байхыг шаардаагүй бөгөөд хэлбэрийн бүрэлдэхүүнтэй гэмт хэрэг гэдэг нь хоёр шатны шүүхийн шийдвэрээс харагдаж байгаа. Харин давуу байдал бий болгохдоо эрх мэдэл, албан үүрэг, албан тушаалын байдлаа урвуулан ашигласан үйлдэл байгаа юу гэдэгт маргаан үүссэн. Урвуулан ашиглах гэдэг ойлголтыг Эрүүгийн хуульд заасан хууль ёсны зарчимд тусгасны дагуу Авлигын эсрэг хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.3-т зааснаар албаны эрх ашгийн эсрэг буюу хувийн ашиг сонирхлоо гүйцэлдүүлэх зорилгод ашигласан уу, үгүй юу гэдэгт давж заалдах шатны шүүх манай гомдлыг хүлээн аваад хэргийг цагаатгасан нь үндэслэлтэй. Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад шүүгдэгчийн хувийн дансны мэдээлэл зэргийг бүрэн цуглуулж шалгасан боловч хувийн ашиг сонирхлоо гүйцэлдүүлэх зорилго тогтоогдоогүй. ...иймд давж заалдах шатны шүүх хуулийн үзэл санааг зөв тайлбарлаж, Эрүүгийн хуулийн 22.1 дүгээр зүйлд заасан гэмт хэргийн шинж болон эрх зүйн зохицуулалтыг үндэслэлтэй дүгнэж хэрэгт авагдсан баримтад үндэслэж бодитой дүгнэлт гаргасан гэж үзэж байгаа тул давж заалдах шатны шүүхийн магадлалыг хэвээр үлдээж өгнө үү” гэв.

Прокурор Ц.Бурмаа хяналтын шатны шүүх хуралдаанд хэлсэн хууль зүйн дүгнэлтдээ “Прокурорын эсэргүүцлийг дэмжин оролцож байна. Б.Б-д холбогдох хэрэгт гэрчээр байцаагдсан Ч.Д, Ч.Б нар төрсөн ах дүүс бөгөөд 16 тоо толгой үхрийг хоёр малчинд олгох ажлыг Ч.Д буюу Дорнод аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгч, Дорнод аймгийн Хөдөө аж ахуйн дарга Б.Б-д явуулсан. Төслийг Дорнод аймгийн Гурванзагал сумын иргэдэд олгох байсан. Үүнээс үүдээд 2017 оны 9 дүгээр сарын 26-ны өдөр албан бичиг хүргүүлсэн. Б.Б тухайн үед Хүнс, хөдөө аж ахуйн газрын даргын түр орлон гүйцэтгэгчээр ажиллаж байсан бөгөөд 2017 оны 12 дугаар сарын 1-ний өдөр ажлын хэсэг байгуулах тухай А/16 дугаар тушаалаар ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг томилж, 2 дахь заалтад үхрийг хуулийн дагуу Гурванзагал суманд хүлээлгэж өгөхөөр заасан. Аймгийн Засаг даргын 2012 оны тушаалаар батлагдсан журамд төслийн сонгон шалгаруулалт явуулах ёстой байсан боловч үнэлгээний комисс байгуулж ажиллуулах талаар заасан байдаг. Гэтэл энэ журмын дагуу үнэлгээний комисс байгуулалгүйгээр шууд ажлын хэсэг байгуулсан. 2017 оны 12 дугаар сарын 4-ний өдөр Гурванзагал суманд 16 тоо толгой үхрийг хүлээлгэж өгөх акт гараад 2017 оны 12 дугаар сарын 28-ны өдөр нэр дурдсан хүмүүст үхрүүдийг өгсөн. Уг хэрэг нь хэлбэрийн бүрэлдэхүүнтэй байхад давж заалдах шатны шүүх заавал хор уршиг учирсан байхыг шаардаж, Эрүүгийн хэргийг буруу хэрэглэж шүүгдэгчийг цагаатгасан нь үндэслэлгүй байгаа тул шийтгэх тогтоолыг хэвээр үлдээж, давж заалдах шатны шүүхийн магадлалыг хүчингүй болгох саналтай байна” гэжээ.

*Шүүхийн шийдвэрийн тодорхойлох хэсэгт:* Прокурорын эсэргүүцлийг үндэслэн шүүгдэгч Б.Б-д холбогдох хэргийг хяналтын шатны шүүх хуралдаанаараа хэлэлцэж, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 40.5 дугаар зүйлд

заасны дагуу анхан болон давж заалдах шатны шүүхийн үйл ажиллагаа, шийдвэрийг бүрэн хянаж үзэв. Шүүгдэгч Б.Б нь Дорнод аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын даргаар ажиллаж байхдаа албан үүрэг, бүрэн эрхээ урвуулан ашиглаж “Мах, сүү, сүүний чиглэлийн үржлийн хээлтэгч, хээлтүүлэгч олгох” төслийн 6,500,000 төгрөгийн үнэ бүхий 16 тоо толгой үхрийг төсөл сонгон шалгаруулалт явуулалгүйгээр аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгч Ч.Д-гийн төрсөн ах Ч.Д, төрсөн дүү Ч.Б нарт 2017 оны 12 дугаар сарын 4-ний өдөр олгож, бусдад давуу байдал бий болгосон болох нь тухайн хэрэгт хамааралтай бөгөөд ач холбогдол бүхий, хуульд заасан үндэслэл, журмын дагуу цуглуулж бэхжүүлэн, шүүх хуралдаанаар хэлэлцсэн нотлох баримтуудаар нотлогдсон талаарх анхан шатны шүүхийн дүгнэлт хэргийн жинхэнэ байдалд нийцсэн, хууль зүйн үндэслэлтэй байна. Энэ хэрэгт Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 16.2 дугаар зүйлд заасан нотолбол зохих байдлуудыг хангалттай шалгаж тодруулсан, мөрдөн байцаалт болон шүүхээс хэрэг хянан шийдвэрлэх явцад оролцогчийн хуулиар хамгаалагдсан эрхийг хассан, хязгаарласан, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд заасан шаардлагыг зөрчсөн гэх ноцтой зөрчил тогтоогдоогүй болно. Анхан шатны шүүх шүүгдэгч Б.Б-гийн гэм буруугийн талаар үндэслэл бүхий дүгнэлт хийж, шүүгдэгчийн хувийн болон гэмт хэрэг үйлдсэн нөхцөл байдал, учирсан хохирол, хор уршгийн шинж чанарыг харгалзан хуульд заасан төрөл, хэмжээний ял шийтгэхдээ Эрүүгийн хуулийн холбогдох заалтыг зөв тайлбарлан хэрэглэжээ. Харин давж заалдах шатны шүүх Б.Б-д холбогдох хэргийг Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 2.4 дүгээр зүйлийн 4 дэх хэсэгт заасныг үндэслэн хэрэгсэхгүй болгон шүүгдэгчийг цагаатгаж шийдвэрлэсэн нь үндэслэлгүй бөгөөд Эрүүгийн хуулийг буруу тайлбарлан хэрэглэсэн байна. Учир нь Эрүүгийн хуулийн тусгай ангийн 22.1 дүгээр зүйлд заасан гэмт хэрэг нь хэлбэрийн бүрэлдэхүүнтэй ба хохирол, хор уршиг арилсан эсэхээс үл

хамааран нийтийн албан тушаалтан албан үүрэг, бүрэн эрх, албан тушаалын байдлаа урвуулан ашиглаж, бусдад давуу байдал бий болгосон үйлдэл, эс үйлдэхүй хийсэн тохиолдолд эрүүгийн хариуцлага оногдуулахаар хуульчлан тогтоосон. Албан тушаалын гэмт хэрэг нь хуулиар хамгаалсан нийгмийн ашиг сонирхлыг зөрчиж тодорхой материаллаг хохирол учруулахаас гадна төрийн албанд хууль дээдлэх, шударга ёсыг хангах, нийтийн ашиг сонирхлыг хамгаалж ажиллах зарчмыг ноцтой зөрчин, төрд итгэх олон нийтийн итгэлийг алдагдуулж, төрийн байгууллын үнэлэмжийг сулруулах зэрэг бусад хор уршиг учруулдгаараа нийгмийн аюулын шинж ихтэй байдаг. Шүүгдэгч Б.Б-гийн хувьд албаны эрх мэдэл, албан тушаалын байдлаа урвуулан ашиглаж, төрийн үйл ажиллагааны хүрээнд хэрэгжүүлж байгаа төслийн үр шим хүртэгчийг шалгаруулалтгүйгээр сонгож буй нь холбогдох хууль тогтоомжийн дагуу сонгон шалгаруулалтад оролцож уг төслийн үр шим, өгөөжийг шударгаар хүртэх байсан бусад иргэн, аж ахуйн нэгжийн хууль ёсны ашиг сонирхол, түүнчлэн дээрх харилцааг зохицуулахад чиглэсэн төрийн үйл ажиллагааны хууль ёсны байдлын аль алинд нь хор уршиг учруулсан байх тул эрх мэдэл, албан тушаалын гэмт хэргийн шинжийг бүрэн хангасан гэж үзнэ. Иймд анхан шатны шүүхийн шийтгэх тогтоолыг хэвээр үлдээж, магадлалыг хүчингүй болгож, прокурор Ц.Лхамсүрэнгийн бичсэн “...давж заалдах шатны шүүх хэргийн бодит байдалд нийцээгүй дүгнэлт хийн, Эрүүгийн хуулийг буруу тайлбарлан хэрэглэж, Б.Б-д холбогдох хэргийг цагаатгасан тул магадлалыг хүчингүй болгуулах” агуулгатай эсэргүүцлийг хангаж шийдвэрлэх нь зүйтэй гэж шүүх бүрэлдэхүүн шийдвэрлэлээ” гэжээ.

*Шүүхийн шийдвэрийн тогтоох хэсэгт:* Дорнод аймаг дахь сум дундын Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2019 оны 3 дугаар сарын 15-ны өдрийн 68 дугаар шийтгэх тогтоолыг

хэвээр үлдээн, Дорнод аймгийн Эрүү, Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн 2019 оны 5 дугаар сарын 15-ны өдрийн 17 дугаар магадлалыг хүчингүй болгож, Дорнод аймгийн прокурорын газрын хяналтын прокурор Ц.Лхамсүрэнгийн бичсэн эсэргүүцлийг хангаж шийдвэрлэсүгэй” гэжээ.

Дээрх шийдвэрээс үзвэл Монгол Улсын Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухайн хуулийн 36.2 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт шүүхийн шийдвэр нь “удиртгал”, “тодорхойлох”, “тогтоох” хэсгээс бүрдэнэ хэмээн заасан байх бөгөөд судлаачийн судалж буй шүүхийн шийдвэр нь энэ хуулийн шаардлагыг хангасан байна. Мөн шүүхийн шийдвэр нь бүтцийн хувьд цэгцтэй бөгөөд Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухайн хуулийн 36.2 дугаар зүйлд зааснаар хэлбэр, бүтцээ гаргасан байв. Түүнчлэн 36.6-36.9 дүгээр зүйл, 40.8 дугаар зүйлийн 1.1, 1.2 дугаар зүйлүүдэд заасан шаардлагыг хангасан зүйл хэсэгт тогтоосон дарааллын дагуу үйлдэгджээ.

## 1.2. ТАЛУУДЫН ТАЙЛБАРЫГ АВЧ ҮЗСЭН БАЙДАЛ

Прокурор эсэргүүцэлдээ Дорнод аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын даргаар ажиллаж байсан Б.Б нь мах, сүү, сүүний чиглэлийн үржлийн хээлтэгч, хээлтүүлэгч олгох төслийн 3,000,000 төгрөгийн үнэ бүхий 16 тоо толгой үхрийг Ч.Д болон Ч.Б нарт олгосон үйлдэл нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа материал худалдан авах тухай хуулиар зохицуулагдах харилцаа бөгөөд уг хуулийн дагуу төсөл сонгон шалгаруулах ажлыг зохион байгуулах ёстой байсан боловч тухайн хуулийг хэрэглэхгүйгээр тушаал гаргаж уг асуудлыг шийдсэн гэдэг.

Харин өмгөөлөгч саналдаа прокурорын хэлсэн Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа материал худалдан авах тухай хууль Монгол Улсад байхгүй бөгөөд харин 2005 оны 12 дугаар сарын 1-ний өдөр батлагдсан Төрийн болон орон нутгийн



өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль Монгол Улсад хүчин төгөлдөр үйлчилж байна. Гэсэн хэдий ч уг хуулиар болсон хэргийн үйл явдлыг зохицуулах боломжгүй. Учир нь дээрх хуулиар дотоодын харилцааг зохицуулах бус гаднаас худалдан авалт хийхэд хэрэглэгдэх хууль учраас өөрийн үйлчлүүлэгчийг хууль бус шийдвэр гаргаж эрх мэдлээ урвуулсан гэж үзэхгүй гэжээ.

Шүүхээс талуудын дэвшүүлсэн тайлбарыг хянан хэлэлцэж, үндэслэлд зүй ёсны дүн шинжилгээ хийнэ гэсэн хүлээлттэй байдаг бөгөөд ихэнх тохиолдолд шүүх тайлбарын үндэслэлийг нэг бүрчлэн илэрхийлж байдаг нь талуудад шүүхийн шийдвэрт эргэлзэх, хардах нөхцөлийг үгүйсгэж байдаг ач холбогдолтой<sup>3</sup>. Гэтэл хяналтын шатны шүүхээс өмгөөлөгч, прокурорын дээрх маргааны гол сэдэв болоод байгаа уг хууль нь Монгол Улсад хүчин төгөлдөр мөрдөгддөг эсэх, ямар хуулийн, ямар зүйл, заалтаар Б.Б-гийн тухайн үйлдлийг зохицуулах харилцаа байсан эсэх талаар шийдвэрт дурдагдаагүй байна.

Уг маргааны хоёр дахь дэд сэдэв нь Эрүүгийн хуулийн тусгай ангийн 22.1 дүгээр зүйлийн гэмт хэргийн шинж юм. Гэмт хэргийн субъектив болон объектив шинжийн талаар талууд маргасан байна.

Прокурор мөн “Төслийн 16 тооны үхрийг Ч.Д, Ч.Б нарт олгохоор тушаал гаргасан, албан үүрэг, эрх мэдлээ урвуулан ашигласан үйлдэл гаргасан...” гэхэд өмгөөлөгч “...давуу байдал бий болгохдоо эрх мэдэл, албан үүрэг, албан тушаалын байдлаа урвуулан ашигласан үйлдэл байгаа юу гэдэгт маргаан үүссэн. Урвуулан ашиглах гэдэг ойлголтыг Эрүүгийн хуульд заасан хууль ёсны зарчимд тусгасны дагуу Авлигын эсрэг хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.3-т зааснаар албаны эрх ашгийн эсрэг буюу хувийн ашиг сонирхлоо гүйцэлдүүлэх зорилгод ашигласан

<sup>3</sup> Шүүхийн шийдвэрт дүн шинжилгээ хийх арга зүй, “Шүүх эрх мэдэл” эмхэтгэл, 2017, №2, 113-122 дахь тал.

уу, үгүй юү гэдэгт давж заалдах шатны шүүх манай гомдлыг хүлээн аваад хэргийг цагаатгасан нь үндэслэлтэй...”; прокурор “...Авлигын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1-д “авлига”, 3.1.4-т “албан тушаалын эрх мэдлээ урвуулан ашиглах” гэх нэр томъёоны тайлбарын зөрүүтэй байдал...”; өмгөөлөгч “давж заалдах шатны шүүх манай гомдлыг хүлээн аваад хэргийг цагаатгасан нь үндэслэлтэй” гэх зэргээр талууд хэд хэдэн саналын зөрүүтэй үндэслэл дэвшүүлсэн байхад эдгээрт шүүхээс ямар нэгэн тайлбар өгсөн талаар шүүхийн шийдвэрт тусгагдаагүй байна. Талуудын дэвшүүлсэн саналд хууль тогтоомжийн дүн шинжилгээ хийх шаардлагатай юм.

### 1.3. ХУУЛЬ ХЭРЭГЛЭЭ

Шүүх шийдвэртээ талуудын гаргасан санал, дүгнэлтэд дүн шинжилгээ хийж, эргэлзээтэй нэр томъёог тайлбарлах учиртай. 2005 оны 12 дугаар сарын 1-ний өдөр Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль<sup>4</sup> батлагдаж, 2006 оны 2 дугаар сарын 1-ний өдрөөс дагаж мөрдөхөөр хуульчилсан бөгөөд уг хуулиар төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, зохион байгуулах, уг ажиллагаанд хяналт тавихтай холбогдон үүсэх харилцааг зохицуулах болсон. Дээрх хэрэгтэй холбогдуулан уг хуулийн хэд хэдэн тодорхой заалтыг хэрэглэн, шүүхийн шийдвэрийн хэт ерөнхий байдлыг тодруулах шаардлагатай. Тухайлбал, 17.1-д зааснаар “Нээлттэй тендер шалгаруулалтын урилгыг энэ хуульд заасны дагуу зарлан мэдээлж, сонирхогч этгээдийг тендер шалгаруулалтад оролцох тэгш боломжоор хангана”, мөн хуулийн 17.22-т зааснаар “Тендер оролцох сонирхолтой этгээд нь захиалагчаас тогтоосон хугацаанд

<sup>4</sup> <https://www.legalinfo.mn/law/details/493?lawid=493>

техникийн болон санхүүгийн саналыг хамтад нь ирүүлнэ”<sup>5</sup>. Энэ заалтын дагуу Дорнод аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын даргаар ажиллаж байсан Б.Б тендер шалгаруулалт явуулах тухай урилгыг зарлан мэдэгдсэн эсэх нь шүүхийн шийдвэрт тусгагдаагүй нь талуудад тодорхой бус байдлыг үүсгэсэн.

Мөн Б.Б нь төслийн 16 тоо толгой үхрийг сонгон шалгаруулалт явуулахгүйгээр Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгч Ч.Д, Ч.Б нарт олгосон үйлдэл нь Авлигын эсрэг хуулийн 3.1.3 дугаар зүйлд заасан “албан тушаалын эрх мэдлээ урвуулан ашиглах буюу албан тушаалын эрх мэдлийг албаны эрх ашгийн эсрэг буюу хувийн ашиг сонирхлоо гүйцэлдүүлэх зорилгод ашиглаж хийх ёстой үйлдлийг хийхгүй байх, хийх ёсгүй үйлдэл хийхийг”, мөн хуулийн 3.1.4 дүгээрт зааснаар “давуу байдал” гэж “энэ хуулийн 4.1-д заасан этгээд албан тушаалын эрх мэдлээ урвуулан ашигласнаар хувь хүн, хуулийн этгээдэд буй болох эдийн болон эдийн бус ашигтай байдлыг хэлнэ” зэрэг нэр томъёоны тайлбарыг ялган зааглаж ойлгох талаар талуудад үндэслэлтэй тайлбар хийх ёстой.

Мөн “Эрүүгийн хуулийн 22.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар нийтийн албан тушаалтан албан үүрэг, бүрэн эрх, албан тушаалын байдлаа урвуулан ашиглаж эсхүл зориуд хэрэгжүүлэхгүй байж өөртөө, бусдад давуу байдал бий болгосон<sup>6</sup> гэмт хэргийн шинжийн хувьд хэлбэрийн бүрэлдэхүүнтэй ба бодит хор уршиг бий болсон эсэхээс үл хамааран тухайн үйлдлийг хийснээрээ гэмт хэрэг үйлдэгдсэнд тооцдог” хэмээн шүүхээс 2019 оны 9 дүгээр сарын 17-ны өдрийн 407 тоот тогтоолоороо практик тогтоосон.

<sup>5</sup> <https://www.legalinfo.mn/law/details/493?lawid=493>

<sup>6</sup> <https://www.legalinfo.mn/law/details/11634?lawid=11634>

#### 1.4. ИТГЭЛ ҮНЭМШИЛ ТӨРҮҮЛЭХҮЙЦ ҮНДЭСЛЭЛ

Шүүх тодорхойлох хэсэгтээ “Албан тушаалын гэмт хэрэг нь хуулиар хамгаалсан нийгмийн ашиг сонирхлыг зөрчиж тодорхой материаллаг хохирол учруулахаас гадна төрийн албанд хууль дээдлэх, шударга ёсыг хангах, нийтийн ашиг сонирхлыг хамгаалж ажиллах зарчмыг ноцтой зөрчиж, төрд итгэх олон нийтийн итгэлийг алдагдуулан, төрийн байгууллын үнэлэмжийг сулруулах зэрэг бусад хор уршиг учруулдгаараа нийгмийн аюулын шинж ихтэй байдаг. Шүүгдэгч Б.Б-гийн хувьд албаны эрх мэдэл, албан тушаалын байдлаа урвуулан ашиглаж, төрийн үйл ажиллагааны хүрээнд хэрэгжүүлж байгаа төслийн үр шим хүртэгчийг шалгаруулалт явуулалгүйгээр сонгож буй нь холбогдох хууль тогтоомжийн дагуу сонгон шалгаруулалтад оролцож уг төслийн үр шим, өгөөжийг шударгаар хүртэх байсан бусад иргэн, аж ахуйн нэгжийн хууль ёсны ашиг сонирхол, түүнчлэн дээрх харилцааг зохицуулахад чиглэсэн төрийн үйл ажиллагааны хууль ёсны байдлын аль алинд хор уршиг учруулсан байх тул эрх мэдэл, албан тушаалын гэмт хэргийн шинжийг бүрэн хангасан гэж үзнэ” гэсэн нь ямар нэгэн холбогдох хуулийн зүйл, заалт дурдалгүйгээр ерөнхий байдлаар илэрхийлэгджээ.

#### 1.5. ШҮҮХИЙН ШИЙДВЭР НЭГ МӨР БАЙХ АСУУДАЛ

Шинэчлэн найруулсан Эрүүгийн хууль хэрэгжиж эхэлснээс хойш Эрүүгийн хуулийн тусгай ангийн 22.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасан зүйл ангиар шийдсэн шүүхийн долоон шийдвэр [www.shuukh.mn](http://www.shuukh.mn) веб сайтад нийтлэгдсэн байна. Үүнээс 2018 оны 10 дугаар сарын 12-ны өдрийн 440 дугаартай П.Ч, Я.А нарт холбогдох хэрэг<sup>7</sup> нь ижил төсөөтэй хэрэг байх бөгөөд

<sup>7</sup> Шүүгдэгч П.Ч нь ...ажиллаж байхдаа нийслэлийн төсвийн хөрөнгийн санхүүжилтээр хэрэгждэг хөгжлийн бэрхшээлтэй иргэд, ахмад настанд шаардлагатай орпотод,

шүүхийн шийдвэрийн тодорхойлох хэсэгт мөн зүйл ангийг хэрхэн ойлгож хэрэглэх талаар судалж буй хэрэгтэй, хэргийн өнгө болоод шүүхээс гаргасан дүгнэлт ойролцоо байгаа нь энэ төрлийн хэргийг Дээд шүүхээс хэрхэн ойлгож шийдвэрлэдэг талаар урьдчилсан байдлаар таамаглаж болохуйц эерэг нөлөө үзүүлжээ. Түүнчлэн доод шатны шүүхүүдэд удирдамж, чиглэл өгөхүйц байдлаар ойлгогдож байна.

## 1.6. ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН ОРЧНЫ ҮР НӨЛӨӨ

Энэ хэргийг шийдвэрлэсэн шат шатны шүүхийн шийдвэрт дүн шинжилгээ хийж үзэхэд Эрүүгийн хуулийн 22.1 дүгээр зүйлийг хэрэглэх, тайлбарлахад хууль тогтоомжоос хамаарч эргэлзээ төрүүлж буй хоёр төрлийн нэр томьёо буюу ухагдахуун байгаа нь:

- Энэ гэмт хэргийн хохирол, хор уршиг учрах байдал;
- Бусдад давуу байдал олгосон гэх ухагдахуун.

Дорнод аймаг дахь сум дундын Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх шүүгдэгч Б.Б-г нийтийн албан тушаалтан албан үүрэг, бүрэн эрх, албан тушаалын байдлаа урвуулан ашиглаж, бусдад давуу байдал бий болгосон гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцож шийдвэрлэсэн байна. Гэтэл Давж заалдах шатны шүүх Б.Б-д холбогдох хэргийг шийдвэрлэхдээ “давуу байдал олж авсан этгээдүүд нь үүнээсээ татгалзсанаар үйлдлийн хор уршиг арилсан, Б.Б-гийн үйлдлээр зөрчигдсөн

---

протез болон бусад тусгай хэрэгслийг холбогдох хууль, дүрэм журмын дагуу сонгогдсон аж ахуйн нэгж, байгууллагаар дамжуулан түгээх ёстой ажлыг зохих журмын дагуу хэрэгжүүлэлгүй, албаны бүрэн эрх, албан тушаалын байдлаа урвуулан ашиглаж, өөрийн гэр бүлийн хамаарал бүхий болон бусад нэгдмэл ашиг сонирхол бүхий хүмүүсийн компанид 2014 оны 2 дугаар сарын 21-ний өдрөөс 2015 оны 3 дугаар сарын 31-ний өдрийн хооронд 11 удаагийн үйлдлээр мөнгөн шилжүүлэг хийлгэж, тэдгээр компаниар дамжуулан иргэдэд тусгай хэрэгсэл тараан, төрийн үйл ажиллагааны хууль ёсны байдлыг алдагдуулж, байгууллагад нийт 44,770,000 төгрөгийн буюу хүнд хор уршиг учруулсан.

дүрэм, журам нь хуульчлагдаагүй” гэсэн үндэслэлээр хэргийг цагаатгаж шийдвэрлэжээ. Ингэж дүгнэхдээ Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 2.1 дүгээр зүйлийн 4 дэх хэсэгт заасан “гэмт хэргийн шинжийг хэлбэрийн төдий агуулсан, нийгмийн аюулын хэр хэмжээ нь энэ хуулиар хамгаалагдсан эрх, ашигт бодит хохирол, хор уршиг учруулаагүй” гэснийг үндэслэл болгожээ.

Эндээс харахад цаашид шүүхийн практикт Эрүүгийн хуулийн 22.1 дүгээр зүйлийг хэрэглэхдээ “Гэмт хэргийн хохирол, хор уршигийг хэрхэн тооцох вэ? Ямар нэгэн хохирол учирсан нөхцөл байдал тогтоогдоогүй бол Дорнод аймгийн эрүү, иргэний давж заалдах шатны шүүхийн нэгэн адил бодит хохирол, хор уршиг учраагүй тул гэмт хэргийн шинжийг хэлбэрийн төдий агуулсан гэж үзэх үү?” гэсэн эргэлзээ үүсэхээр байна.

Харин энэ асуудлыг УДШ хуулиар олгогдсон бүрэн эрхийнхээ хүрээнд тодорхой хэрэг маргааныг хянан шийдвэрлэх замаар тайлбар хийж шийдвэрлэсэн байх бөгөөд УДШ-ийн 2019 оны 9 дүгээр сарын 17-ны өдрийн 407 дугаар тогтоолын зургаа дахь талд “Учир нь Эрүүгийн хуулийн тусгай ангийн 22.1 дүгээр зүйлд заасан гэмт хэрэг нь хэлбэрийн бүрэлдэхүүнтэй ба хохирол, хор уршиг арилсан эсэхээс үл хамааран нийтийн албан тушаалтан албан үүрэг, бүрэн эрх, албан тушаалын байдлаа урвуулан ашиглаж, бусдад давуу байдал бий болгосон үйлдэл, эс үйлдэхүй хийсэн тохиолдолд.. гэж эрүүгийн хариуцлага оногдуулахаар хуульчлан тогтоосон.

Албан тушаалын гэмт хэрэг нь хуулиар хамгаалсан нийгмийн ашиг сонирхлыг зөрчиж тодорхой материаллаг хохирол учруулахаас гадна төрийн албанд хууль дээдлэх, шударга ёсыг хангах, нийтийн ашиг сонирхлыг хамгаалж ажиллах зарчмыг ноцтой зөрчиж, төрд итгэх олон нийтийн итгэлийг алдагдуулж, төрийн байгууллын үнэлэмжийг сулруулах зэрэг бусад хор уршиг учруулдгаараа нийгмийн

аюулын шинж ихтэй байдаг” хэмээн тайлбарласан байна. УДШ-ийн энэхүү тайлбар нь НҮБ-ын авлигын эсрэг конвенцын 18 дугаар зүйл, Авлигын эсрэг хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.3, 3.1.4 дүгээр зүйлд заасантай тус тус нийцэж байна. Учир нь эдгээр хууль тогтоомжид нийтийн албан тушаалтан эрх мэдэл, албан тушаалын байдлаа урвуулан ашигласанд тооцоход ямар нэгэн хохирол, хор уршиг учирсан байхыг шаардах талаар дурдаагүй байна. Харин хуулийг хэрэглэх, тайлбарлахад эргэлзээ үүсгэж буй хоёр дахь асуудал нь Эрүүгийн хууль дахь “бусдад давуу байдал олгосон” гэх ухагдахуун байна.

Харамсалтай нь УДШ одоогоор энэ асуудлыг тайлбарлаж шүүхийн нэгдмэл практик тогтоогоогүй байгаа бөгөөд “бусад” гэсэн үг нь хэл зүйн утгаараа тодорхой хэн нэгэн бус эзэн биегүй, тодорхойгүй хэн нэгнийг заасан утгатай байх бөгөөд шүүх энэ зүйлээр эрүүгийн хэргийг шийдвэрлэхдээ тодорхой хүрээ зааггүйгээр хэн нэгэнд л давуу байдал үүссэнийг эсхүл хэнд гэдэг нь тодорхойгүйгээр давуу байдал үүссэн гэсэн үндэслэлээр хэргийг зүйлчлэн шийдвэрлэж болохоор байгаа юм.

Авлига, ашиг сонирхлын зөрчлийн эрх зүйн зохицуулалтын зорилго нь нийтийн албан тушаалтан эрх мэдэл, албан тушаалын байдал, албаны нөлөөгөө хувийн ашиг сонирхолдоо зориулахтай тэмцэх явдал байдаг. Ийм ч учраас авлигатай тэмцэх, ашиг сонирхлын зөрчлийг зохицуулах, урьдчилан сэргийлэхдээ албан тушаалтан хувьдаа ашиг олох, өөртөө ашигтай байдал бий болгох, улмаар өөрийн хамаарал бүхий этгээдэд ашигтай буюу давуу байдал бий болгосон тохиолдолд гэмт хэрэг, зөрчилд тооцох, түүнээс урьдчилан сэргийлэх зохицуулалт хийдэг. Бусдад давуу байдал олгох нь эцсийн дүндээ хувийн ашиг сонирхлыг хангах явдал байх ёстой бөгөөд хэрэв хэн нэгэн хамааралгүй этгээдэд давуу байдал олгосон тохиолдол бүрийг гэмт хэрэгт тооцвол ерөөс амьдралд нийтийн албан тушаалтан аливаа тендер, бусад хэлбэрийн өрсөлдөөнт сонгон шалгаруулалт хийх тохиолдол бүртээ аль

нэг оролцогчийг нь сонгож түүнд ямар нэг утгаараа давуу байдал олгож байдаг. Харин ингэж хэн нэгнийг сонгож, шалгаруулсныхаа улмаас түүнээс шан харамж, хээл хахууль, бусад байдлаар өөртөө давуу байдал олж авч байвал энэ нь хээл хахууль авах гэх мэт өөр төрлийн гэмт хэрэгт тооцогдох учиртай.

Бидний авч үзэж буй хэргийн хувьд Б.Б нь өөрийн хамаарал бүхий этгээдэд давуу байдал олгосон нь хэрэгт авагдсан нотлох баримтаар тогтоогдсон байх тул хууль хэрэглэх, тайлбарлахад ямар нэгэн эргэлзээ үүссэнгүй. Харин шүүхийн практикт гарч байгаа бусад олон тохиолдлын нэгэн адил гэмт хэрэгт буруутгагдаж буй этгээдтэй “хамаарал бүхий этгээдэд тооцогдохгүй” буюу тухайн нийтийн албан тушаалтны эцэг, эх, төрсөн ах, эгч, дүү, гэр бүлийн гишүүн, хамтран амьдрагч, эхнэр (нөхөр)-ийн эцэг, эх, төрсөн ах, эгч, дүү, бусад нэгдмэл сонирхолтой этгээд биш бол ийнхүү бусдад давуу байдал олгосон гэх үндэслэлээр буруутгах нь эрүүгийн хуулийг төсөөтэй хэрэглэж буй явдал болно.

Иймээс цаашид эрүүгийн хууль тогтоомжийг боловсронгуй болгоход энэ байдлыг засах нь зүйтэй болов уу.



## ДҮГНЭЛТ

Шүүхийн шийдвэрт дүн шинжилгээ хийсэн үр дүнгээс үзвэл Эрүүгийн хуулийн 22.1 дүгээр зүйлд заасан “өөртөө, бусдад давуу байдал бий олгох” гэх гэмт хэргийн шинж нь эрүүгийн хууль тогтоомжийг нэг мөр ойлгож хэрэглэх, шүүхийн нэгдмэл практик тогтоох боломж олгохгүй байна. Уг гэмт хэргийн бусдад гэх ойлголтын хүрээ нь хэт өргөн, дээр өгүүлсэнчлэн шийдвэр болгоны ард хэнд ч хамаагүй, ерөөсөө хэн нэгэнд давуу байдал олгосон шийдвэр зайлшгүй гарч байхад гаргасан шийдвэр болгоны төлөө шийдвэр гаргагчийг буруутгах ёстой гэсэн логик гаргалгаа бүхий хууль зүйн томъёолол болсон байна.

Авлига, ашиг сонирхлын зөрчлийн хүрээг тухайн төрлийн харилцаанд оролцогч талуудын түвшинд нарийн хязгаарлах шаардлагатай гэж бид үзэж байна. Энэ үндэслэлээр Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 3.1.5, 3.1.6 дугаар зүйлд заасан нэгдмэл сонирхолтой этгээд, хамаарал бүхий этгээдийн хүрээнд давуу байдал олж авснаар буруутгагдах субъектийн хүрээг хязгаарласнаар энэхүү тодорхойгүй байдал арилах юм.

Бусдад давуу байдал олгох нь эцсийн дүндээ хувийн ашиг сонирхлыг хангах явдал байх ёстой бөгөөд хэрэв хэн нэгэн хамааралгүй этгээдэд давуу байдал олгосон тохиолдол бүрийг гэмт хэрэгт тооцвол ерөөс амьдралд нийтийн албан

тушаалтан аливаа тендер, бусад хэлбэрийн өрсөлдөөнт сонгон шалгаруулалт хийх тохиолдол бүртээ аль нэг оролцогчийг сонгож түүнд ямар нэг утгаараа давуу байдал олгож байдаг. Харин ингэж хэн нэгнийг сонгож, шалгаруулсны улмаас түүнээс шан харамж, хээл хахууль, бусад байдлаар өөртөө давуу байдал олж авч байвал энэ нь хээл хахууль авах гэх мэт өөр төрлийн гэмт хэрэгт тооцогдох учиртай.



## АШИГЛАСАН МАТЕРИАЛ

1. Авлигын эсрэг хууль, 2006.
2. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, 2005.
3. Эрүүгийн хууль, 2015.
4. Улсын Дээд шүүхийн 2019 оны 9 дүгээр сарын 17-ны өдрийн 407 дугаар тогтоол.
5. Улсын Дээд Шүүхийн 2018 оны 10 дугаар сарын 12-ны өдрийн 440 дугаар тогтоол.
6. Шүүхийн шийдвэрт дүн шинжилгээ хийх арга зүй, “Шүүх эрх мэдэл” эмхэтгэл, 2017, №2, 113-122 дахь тал.
7. Авлигын эсрэг Нэгдсэн Үндэстний Байгууллагын конвенц.

# З

## ХУДАЛ МЭДЭЭЛЭЛ ТАРААХ ГЭМТ ХЭРГИЙГ ШИЙДВЭРЛЭСЭН ШҮҮХИЙН ШИЙДВЭРИЙН ДҮН ШИНЖИЛГЭЭ

### СУДЛААЧИЙН ТАНИЛЦУУЛГА



#### БОЛДХУЯГИЙН ПҮРЭВСҮРЭН (LL.M)

МУИС-ийн Хууль зүйн сургуулийг эрх зүйч мэргэжлээр төгсөж, тус сургуульд “Монгол Улс дахь хэвлэн нийтлэх эрх чөлөөний хэрэгжилт, түлгэмдсан асуудал” сэдвээр магистрын зэрэг хамгаалсан.

Глоб Интернэшнл төвийн хуульч тэрээр хэвлэн нийтлэх, үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөний талаар эрдэм шинжилгээний 30 гаруй өгүүлэл, илтгэл бичиж, хэвлэн нийтэлсний зэрэгцээ шүүхийн шийдвэр, хууль тогтоомжид дүн шинжилгээ хийж, “Хэвлэн нийтлэх эрх чөлөө” нэг сэдэвт бүтээл хэвлүүлэн олны хүртээл болгоод байна.

#### Судлаач:

Б.Пүрэвсүрэн

## **АГУУЛГА**

Удиртгал .....	93
1. Шүүхийн шийдвэрийн дүн шинжилгээ .....	95
2. Худал мэдээлэл тараах гэмт хэргийн шүүхийн шийдвэрийн дүн шинжилгээ .....	103
Дүгнэлт, зөвлөмж .....	107
Ашигласан материал .....	111

## УДИРТГАЛ

Улсын Их Хурал (УИХ)-аас 2020 оны 1 дүгээр сарын 10-ны өдөр Эрүүгийн хуульд анх удаа “Худал мэдээлэл тараах” гэмт хэргийг шинээр хуульчлан уг хуулийн 13.14 дүгээр зүйлд оруулж өгсөн ба энэхүү нэмэлт нь 2020 оны 2 дугаар сарын 13-ны өдөр “Төрийн мэдээлэл” эмхэтгэлд нийтлэгдсэн.<sup>1</sup>

Худал мэдээлэл тараах гэмт хэргээр 2020 онд 258 хэрэгт мөрдөн шалгах ажиллагаа явуулснаас хэрэг бүртгэлийн шатанд хэргийг хааж шийдвэрлэсэн 181, хэрэгсэхгүй болгосон 1, шүүхэд шилжүүлсэн 24 хэрэг байгаа тухай Монгол Улсын Ерөнхий прокурорын газраас мэдээлсэн. 2020 онд Худал мэдээлэл тараах гэмт хэрэгтэй холбоотой 17 хэрэг шүүхээр эцэслэн шийдвэрлэгдээд байна<sup>2</sup>. Үүнээс найман хэрэгт нь ял оногдуулсан ба эдгээр нь улс төрийн өндөр албан тушаалтан, УИХ-ын гишүүн, төрийн албан хаагч, төрийн байгууллагаас гаргасан өргөдөл, гомдолд үндэслэж шийдвэрлэгдсэн хэргүүд байна.

Харин иргэний хэргийн нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүнд, эдийн бус гэм хорын хохирол учруулсантай холбоотойгоор 2020 онд шүүхээс шийдвэрлэгдсэн 106 хэрэг байна. Шүүхээс шийдвэрлэгдсэн хэргийн 37.5 хувийг төрийн өндөр албан тушаалтан, төрийн албан хаагч, төрийн байгууллагын нэхэмжлэл гаргагчид эзэлж байгаа аж. Түүнчлэн шүүхээр шийдвэрлэгдсэн энэ төрлийн гэмт хэргийн

<sup>1</sup> “Төрийн мэдээлэл” эмхэтгэл, 2020.02.13, №07 (1109), <http://parliament.mn/n/wzmy>

<sup>2</sup> “Хэвлэлийн эрх чөлөөний тайлан 2020”, Глоб Интернэшнл төв ТББ, 46 дахь тал.

хохилогчийн ихэнхийг улс төрд нөлөө бүхий этгээд эзэлж байгаа нь анхаарал татна.

Худал мэдээлэл тараасан гэх үндэслэлээр эсхүл нэр төрөө сэргээлгэх талаар иргэний болон эрүүгийн хэргийн журмаар өргөдөл гомдол, нэхэмжлэл гаргагчдын зонхилох хувийг улс төрд нөлөө бүхий этгээд, төрийн албан хаагч, төрийн байгууллага эзлэх хандлагатай байна. Глоб Интернэшнл төвөөс<sup>3</sup> жил бүр бэлтгэн гаргадаг Хэвлэлийн эрх чөлөөний тайланд<sup>4</sup> дурдахдаа 1999-2020 онд нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүнд болон гүтгэлэг, доромжлол, илт худал мэдээлэл тараахтай холбоотой шүүхээс шийдвэрлэгдсэн нийт 1079 иргэний болон эрүүгийн хэрэг байгаагаас 43.7 хувь нь сэтгүүлч, хэвлэл мэдээллийн хэрэгсэлд холбогдох хэрэг байв.

Худал мэдээлэл тараахтай холбоотой 17 хэргийг шүүхээс шийдвэрлэсний дотор хоёр нь нэг иргэнээс гаргасан гомдол буюу УИХ-ын гишүүн, Хууль зүй, дотоод хэргийн сайд Х.Нямбаатар<sup>5</sup>-ын гомдол байв. Энэхүү судалгаанд дээрх кейсийн шүүхийн шийдвэрийг сонгон авч судаллаа.

Уг судалгааг хийж гүйцэтгэхдээ 2015 онд Шүүхийн судалгаа, мэдээлэл, сургалтын хүрээлэнгээс гаргасан шүүхийн шийдвэрт дүн шинжилгээ хийх аргачлалыг ашиглав.

<sup>3</sup> Глоб Интернэшнл төв нь 1999 онд байгуулагдсан цагаасаа эхлэн үзэл бодлын эрх, илэрхийллийн эрх чөлөөг хөхиүлэн дэмжих, сэтгүүлчдийн мэргэжлийн эрх, мэдээлэл авах эрх, хэвлэл мэдээллийн эрх чөлөөг хамгаалах чиглэлээр тогтмол үйл ажиллагаа явуулж буй мэргэжлийн төрийн бус байгууллага юм.

<sup>4</sup> “Хэвлэлийн эрх чөлөөний тайлан 2020”, Глоб Интернэшнл төв ТББ, 48 дахь тал.

<sup>5</sup> Нээлттэй цахим сан (shuukh.mn)-гаас дээрх шүүхийн шийдвэрүүдийг 2021 оны 1 дүгээр сард татан авч, ахин байршуулаагүй байна.

## 1. ШҮҮХИЙН ШИЙДВЭРИЙН ДҮН ШИНЖИЛГЭЭ

Худал мэдээлэл тараах гэмт хэргийн шийдвэрлэсэн байдлыг судлахдаа улс төрд нөлөө бүхий этгээд буюу Хууль зүй, дотоод хэргийн сайдаас гаргасан нэхэмжлэлтэй холбоотой дараах шийдвэрт дүн шинжилгээ хийв. Үүнд:

1. Чингэлтэй дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2020 оны 8 дугаар сарын 20-ны өдрийн 689 дугаартай шийтгэх тогтоолоор “Шүүгдэгч Х.А нь 2020 оны 5 дугаар сарын 15-ны өдөр Нийслэлийн нутаг дэвсгэрээс “Гал Бороо” нэртэй өөрийн фэйсбүүк цахим хуудаснаас олон нийтийн сүлжээгээр Улсын Их Хурлын гишүүн буюу хохирогч Х.Нямбаатарыг “Нямбаатар чи 14-тэй охиныг яг яасан юм!!! МАНАН чинь чамайг ингэж дасгалжуулаа юу...”, “Коммунистууд өөрсдөө бага насны окидоор зугаагаа гаргахаа бодоод нэгэнт баталж гаргасан 14 настай хүүхдийг хүчиндэж болох хуулиа өөрчлөхгүй”, “Тэр хүчирхийлэгчдэд чинь эрүүгийн хэрэг үүсгэх боломж байхгүй. Чи 14 настай. Өнөөгийн УИХ-ын гишүүдийг сонгож гаргасан ээж, аавдаа гомд” гэж нэр төр, алдар хүндэд халдсан илт худал мэдээлэл олон нийтэд тараасан гэмт хэрэг үйлдсэн гэм буруутай” гэж үзэн, иргэн Х.А-г 450,000 төгрөгөөр торгох ял оногдуулсан.
2. Чингэлтэй дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2020 оны 9 дүгээр сарын 4-ний өдрийн 726 дугаартай шийтгэх тогтоолоор “Х.Г нь 2020 оны 5 дугаар



сарын 9-ний өдөр Улаанбаатар хотын нутаг дэвсгэрээс Х.З нэртэй өөрийн фэйсбүүк цахим хуудаснаас олон нийтийн сүлжээгээр Улсын Их Хурлын гишүүн буюу хохирогч Х.Нямбаатарыг “Нямбаатарын гаргасан хууль 14-тэй охин хүчиндвэл 450,000 төгрөгөөр торгуулаад л болоо, охины чинь хохь болно. Ийм новшийн юмнуудыг төрд дахин бүү гарга. Коммунистууд өөрсдөө бага насны охидоор зугаагаа гаргахаа бодоод 14 настай хүүхдийг хүчиндэж болох нэгэнт баталж гаргасан хуулиа өөрчлөхгүй. Тэр хүчирхийлэгчдэд чинь эрүүгийн хэрэг үүсгэх боломж байхгүй. Чи 14 настай. Өнөөгийн УИХ-ын гишүүдийг сонгож гаргасан ээж, аавдаа гомд” гэж нэр төр, алдар хүндэд халдсан илт худал мэдээллийг олон нийтэд тараасан гэм буруутай” гэж үзэж иргэн Х.Г-г 500,000 төгрөгөөр торгох ял шийтгэсэн.

Дээрх шийдвэрүүдэд хийсэн дүн шинжилгээний тоймыг харуулбал:

**А) Х.А-д холбогдох Худал мэдээлэл тараах гэмт хэрэг. Чингэлтэй дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2020 оны 8 дугаар сарын 20-ны өдрийн 689 дугаартай шийтгэх тогтоол. Эрүүгийн хуулийн 13.14 дүгээр зүйл.**

*1. Гэмт хэргийн шинжийн талаар:*

Эрүүгийн хуулийн 13.14 дүгээр зүйл (Худал мэдээлэл тараах)-ийн 1 дэх хэсэгт зааснаар “Хүний нэр төр, алдар хүнд, хуулийн этгээдийн ажил хэргийн нэр хүндэд халдсан илт худал мэдээлэл олон нийтэд тараасан” бол 450,000 - 1,300,000 төгрөгөөр торгох эсхүл 240–720 цаг хүртэлх хугацаагаар нийтэд тустай ажил хийлгэх эсхүл 1-3 сар хүртэлх хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах ял шийтгэнэ.

Энэхүү зохицуулалтаас харахад дараах ойлголт гарч ирж байна. Үүнд:

- хүний “нэр төр”, “алдар хүнд”;
- хуулийн этгээдийн “ажил хэргийн нэр хүнд”;
- “илт худал мэдээлэл”;
- “олон нийтэд тараах”.

Чингэлтэй дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2020 оны 8 дугаар сарын 20-ны өдрийн 689 дугаартай шийтгэх тогтоолд Х.Нямбаатарын нэр төр, алдар хүндийг тодорхойлоогүй, тухайн шүүгдэгчийн фэйсбүүкт оруулсан бичвэр нь илт худал мэдээлэл болохыг тодорхойлоогүй, “олон нийтэд тараах” гэдгийг “...бичвэр, зураг бүхий постыг 14 хэрэглэгч хуваалцаж (шэйрлэж), 16 хэрэглэгч уг постод дүрс зураг дарж, үзсэн болох нь тогтоогджээ” гэж тайлбарласан байна.

Эрүүгийн хуулийн 1.2 дугаар зүйлийн 2-т зааснаар “Эрүүгийн хуулийг төсөөтэй хэрэглэхгүй”, 1.2.4-т зааснаар “Энэ хуулийн нэр томьёо, ухагдахууныг тайлбарлахад Монгол Улсын хууль, Монгол Улсын хуулиар соёрхон баталсан, нэгдэн орсон олон улсын гэрээнд заасан тодорхойлолт, хэм хэмжээг баримтална”, түүнчлэн Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 1.15 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт зааснаар Эрүүгийн хууль, энэ хуулийг тайлбарлах, хэрэглэхэд эргэлзээ гарвал түүнийг сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, ялтанд ашигтайгаар шийдвэрлэнэ гэж дурджээ. Тиймээс шүүхээс дээрх хэргийг шийдвэрлэхдээ Х.Нямбаатарын “нэр төр”, “алдар хүнд”, түүнд халдсан “илт худал мэдээлэл” гэх ойлголтыг заавал тайлбарлах ёстой байжээ.

## *2. Нотлох баримт, нотолбол зохих байдлын талаар:*

Чингэлтэй дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2020 оны 8 дугаар сарын 20-ны өдрийн 689 дугаартай шийтгэх тогтоолд дараах нотлох баримтыг шинжлэн судалжээ. Үүнд:

- Шүүгдэгч Х.А-гийн шүүхийн хэлэлцүүлэгт өгсөн мэдүүлэг, мөрдөн шалгах ажиллагааны явцад яллагдагчаар

өгсөн мэдүүлэг;

- Хохирогч Х.Нямбаатарын мөрдөн шалгах ажиллагааны үед өгсөн мэдүүлэг;
- Гэрч Г.Б-ын мөрдөн шалгах ажиллагааны үед өгсөн мэдүүлэг;
- Галт Бороо нэртэй фэйсбүүк хаягт үзлэг хийсэн тухай тэмдэглэл;
- Гар утсанд үзлэг хийсэн тухай тэмдэглэл;
- Шүүгдэгч Х.А-гийн эрүүгийн хариуцлага хүлээж байсан эсэхийг шалгах хуудас;
- Шүүгдэгч Х.А-гийн иргэний үнэмлэхийн лавлагаа, түүний хувийн байдлын талаарх баримтууд.

Эндээс харахад “Галт Бороо нэртэй фэйсбүүк хаягт үзлэг хийсэн тухай тэмдэглэл”-ийг тооцохгүй бол шүүхийн шийдвэр үндсэндээ мэдүүлэгт тулгуурлажээ. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 16.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар шүүх хуралдааны явцад дараах байдлыг нотолно:

- гэмт хэрэг гарсан байдал (гэмт хэргийг хэзээ, хаана, яаж үйлдсэн болон Эрүүгийн хуульд заасан бусад байдал);
- гэмт хэргийг хэн үйлдсэн;
- гэмт хэргийн сэдэлт, зорилго, гэм буруугийн хэлбэр;
- Эрүүгийн хуульд заасан яллагдагчид оногдуулах ялыг хүндрүүлэх, хөнгөрүүлэх нөхцөл байдал;
- гэмт хэргийн улмаас учирсан хохирол, хор уршгийн шинж чанар, хэр хэмжээ;
- гэмт хэрэг үйлдэхэд нөлөөлсөн шалтгаан, нөхцөл.

Дээрх шүүхийн шийдвэрт гэмт хэргийн сэдэлт, зорилго, гэмт хэргийн улмаас учирсан хохирол, хор уршгийн шинж чанар, хэр хэмжээ, гэмт хэрэг үйлдэхэд нөлөөлсөн шалтгаан,

нөхцөлийг тогтоогоогүй байна. Эдгээр асуудлаар зөвхөн “улсын яллагчийн эрүүгийн хариуцлагын талаарх санал, шүүгдэгч болон түүний өмгөөлөгчийн өмгөөллийн үг зэргийг тус тус харгалзан үзлээ” гэжээ. Энэ нь харгалзан үзэх бус, нотлох ёстой зүйл юм.

“Худал мэдээлэл тараах” гэмт хэргээс Х.Нямбаатар өөрөө сэргийлэх арга хэмжээ авсан эсэхийг шүүх тодруулаагүй байна. Х.Нямбаатарын мэдүүлэгт “...Энэ сэдвээр хамгийн анх 2018 оны хавраас олон нийтийн мэдээллийн хэрэгслээр дээрх хуулийн заалтыг санаачилж батлуулсан мэтээр намайг гүтгэж доромжилсон илт худал мэдээлэл түгээж эхэлсэн бөгөөд үүнийг эсэргүүцэж тайлбар хийх, олон нийтэд зөв ойлголт өгөх зав чөлөө тэр болгон гараад байдаггүй юм” гэж хэлснээс харахад иргэдэд үнэн, бодит мэдээлэл өгөөгүй нь тус гэмт хэрэг гарахад нөлөөлсөн шалтгаан, нөхцөл болжээ.

Шүүгдэгч мэдүүлэгтээ “...цахим сайт болон олон нийтийн телевизээр 14 настай хүүхдийг насанд хүрсэн хүн гэж үзнэ гэсэн утгатай мэдээлэл явж байсан. Уг мэдээллийг уншихад УИХ-ын гишүүн Х.Нямбаатарын санаачилсан хуульд тэгж тусгагдсан байна гэсэн утга бүхий мэдээлэл фэйсбүүкээр тараад байхаар нь би үнэхээр тийм хууль санаачилж батлуулсан юм байх гэж бодоод, өөрөө охин хүүхэдтэй учир Нямбаатар гишүүний санаачилсан тэр хуулийг нь эсэргүүцэж пост бичсэн юм. Нямбаатар гишүүн үнэхээр тийм хууль санаачилсан эсэхийг би нягтлаагүй, буруу ташаа мэдээлэл олон нийтийн сүлжээнээс харж, өөрийн цахим хуудсанд байршуулж, бусдад түгээсэндээ маш их харамсаж байна. Би Нямбаатар гишүүнийг 14-тэй охинтой бэлгийн харьцаанд орж болно гэсэн хууль санаачлаагүй гэдгийг мэдээд өөрийн оруулсан постоо устгасан. Мөн өөрөөс нь фэйсбүүк чатаар нь уучлалт гуйсан” гэжээ.

Угтаа аливаа зүйлийг буруугаар ойлгосон эсхүл бусдын өгсөн мэдээллийг нягтлахгүйгээр нийтийн сүлжээнд нийтэлсэн нь “илт худал мэдээлэл тараах үйлдэл” мөн эсэх талаар

шүүхээс дүгнэлт өгөөгүй нь хууль хэрэглээний практик тогтоож чадаагүй байна.

**Б) Х.Г-д холбогдох Худал мэдээлэл тараах гэмт хэрэг. Чингэлтэй дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2020.09.04-ний өдрийн 726 дугаартай шийтгэх тогтоол. Эрүүгийн хуулийн 13.14 дүгээр зүйл.**

*1. Гэмт хэргийн шинжийн талаар:*

Эрүүгийн хуулийн 13.14 дүгээр зүйлд заасан зохицуулалтыг Чингэлтэй дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2020 оны 9 дүгээр сарын 4-ний өдрийн 726 дугаартай шийтгэх тогтоолд тайлбарлаагүй байна. “Шүүгдэгч Х.Г-гийн дээрх хэрэг нь Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлд заасан “... үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх...” гэсэн эрхээ эдэлж, одоогийн дагаж мөрдөж буй Эрүүгийн хуулийн тусгай ангийн 12.5 дугаар зүйлд заасан “Арван зургаан насанд хүрээгүй хүнтэй бэлгийн харьцаанд орох” гэсэн гэмт хэргийн төрлийг шүүмжилж, өөрийн “Х.Заяа” нэртэй хувийн цахим хуудаснаас олон нийтийн сүлжээгээр тараахдаа Монгол Улсын Үндсэн хуулийн 17 дугаар зүйлд хүний нэр төр, алдар хүнд, эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хүндэтгэх гэж заасан үүргээ биелүүлэлгүй... гэж бичиж хохирогч Х.Нямбаатарыг уг гэмт хэргийн төрлийг шинээр санаачлан Эрүүгийн хуульд тусгаж хууль тогтоогчоор батлуулсан мэтээр бусдад ойлгуулан нэр төр, алдар хүндэд нь халдсан илт худал мэдээлэл олон нийтэд тараасан” гэж үзжээ.

*2. Нотлох баримт, нотолбол зохих байдлын талаар:*

Шүүхээс нотлох баримтыг жагсааж бичсэн байх бөгөөд аль нотлох баримтаар ямар үйл баримтыг нотолж байгааг тайлбарлаагүй байна. Тухайлбал, шүүгдэгч Х.Г-гийн “Самсунг Нөүте-8” маркийн гар утсанд ...2020 оны 5 дугаар сарын 9-ний өдрийн 22 цаг 6 минутад татаж авсан, 66.96 КБ хэмжээтэй, 991×859 нарийвчлалтай, РВ-IMG-1589033806429.jpg гэсэн нэрээр хадгалагдсан, Х.Нямбаатарын зурагтай “Гаж донтнууд

хууль зохиож баталсаар байх уу?”, “14 настай охинтой бэлгийн харьцаанд орж болно...” гэсэн бичвэртэй нэг ширхэг зураг юуг нотолж байгаа талаар тайлбарлаагүй байна.

### *3. Шүүхээс хэрэглэвэл зохих эх сурвалжийн талаар:*

НҮБ-ын Хүний эрхийн хорооны 2011 оны 7 дугаар сарын 11-29-ний өдөр хуралдаж 102 дугаар чуулганаар хэлэлцэн баталсан ИБУТЭТОУП (Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт)-ын 19-р зүйлийн Ерөнхий тайлбар №34-ийн 42 дахь хэсэгт “Хэвлэл мэдээллийн хэрэгсэл, хэвлэн нийтлэгч, сэтгүүлчдийн гагцхүү Засгийн газар эсхүл Засгийн газрын дэмжлэгтэй улс төр, нийгэм, хуулийн тогтолцоог шүүмжилсний төлөө шийтгэл ногдуулахыг үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөний зайлшгүй хязгаарлалт гэж хэрхэвч үзэж болохгүй” тухай дурдсан. Түүнчлэн тус тайлбарын 47 дахь хэсэгт “...нийтийн албан тушаалтнуудтай холбоотой тайлбар, сэтгэгдлийн хувьд шийтгэх, санамсаргүй алдаа гаргаж, хорон санаа агуулалгүйгээр хэвлэн нийтэлсэн материалыг үнэн бус, хууль бус гэж үзэхээс зайлсхийвэл зохино” гэж тус тус заасан. Монгол Улсын Үндсэн хуулийн 10 дугаар зүйлийн 10.3-т “Монгол Улсын олон улсын гэрээ нь соёрхон баталсан буюу нэгдэн орсон тухай хууль хүчин төгөлдөр болмогц дотоодын хууль тогтоомжийн нэгэн адил үйлчилнэ” гэж заасныг үндэслэн олон улсын хэм хэмжээг баримтлах ёстой. Улс төрийн өндөр албан тушаалтны гаргасан гомдлын дагуу иргэн, сэтгүүлчийг буруутган, яллах талыг барих ёсгүй байсан. Улс төрийн өндөр албан тушаалтан нь өөрөө хүсэж энэ албыг хашдаг бөгөөд олон нийтийн шүүмжлэлд хүлээцтэй хандах үүрэгтэйгээрээ жирийн иргэнээс ялгарах онцлогтой. Үүнээс үзвэл шүүхээс ИБУТЭТОУП, түүний нэмэлт 34 дүгээр тайлбарыг шүүхийн шийдвэрийн үндэслэх хэсэгтээ баримтлаагүй байна.

**В) Иргэн Х.Г-гийн гомдлоор хянан шийдвэрлэсэн  
Нийслэлийн Эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүхийн  
2020.11.03-ны өдрийн 2020/ДШМ/1402 дугаар магадлал.  
Эрүүгийн хуулийн 13.14 дүгээр зүйл.**

*1. Гэмт хэргийн шинжийн талаар:*

Өмгөөлөгч Б.П-гийн давж заалдах шатны шүүхэд гаргасан тайлбарт “Энэхүү хэрэг нь сэтгүүл зүйн гэхээсээ илүүтэй иргэний үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөний хүрээнд бичсэн сэтгэгдэл байсан. Иймд нягтлан шалгах үүрэг сэтгүүл зүйн салбар шиг жирийн иргэнд оногддоггүй. Мөн шүүгдэгч Х.Г нь олон нийтийн санаа бодлыг дамжуулсан төдий бөгөөд үүнийг гомдол гаргагч Х.Н мэдүүлэгтээ хүлээн зөвшөөрсөн. Шинжээчийн 2020 оны 5 дугаар сарын 25-ны өдрийн 2552 дугаар дүгнэлтэд “Коммунистууд өөрсдөө бага насны охидоор зугаагаа гаргахаа бодоод нэгэнт батлагдаж гаргасан 14 настай хүүхдийг хүчиндэж болох хуулиа өөрчлөхгүй. Тэр хүчирхийлэгчдэд чинь эрүүгийн хэрэг үүсгэх боломж байхгүй. Чи 14 настай. Өнөөгийн УИХ-ын гишүүдийг сонгож гаргасан ээж, аавдаа гомд” гэсэн зурагт эвлүүлгийг үйлдсэн тухай дурдаагүй байдаг. Гэтэл анхан шатны шүүхээс алийг нь Х.Г бичиж сэтгэгдэл үлдээсэн, алийг нь цахим орчноос татаж утсандаа авсан бэ гэдэг дээр дүгнэлт хийлгүй гэм буруутайд тооцож шийтгэл оногдуулсан зэрэг алдаа гаргасан. Гурван тусдаа өөр дүрс, сэтгэгдэлд нэг хүнээс үйлдсэн мэтээр хамтатгаж шийтгэвэр оногдуулсан” тухай дурддаг.

Шүүхээс шийдвэрлэхдээ Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийг ноцтой зөрчөөгүй гэж үзсэн. Нотлох баримтуудыг хуульд заасан үндэслэл, журмын дагуу цуглуулж бэхжүүлсэн, шүүхээс үнэлж дүгнэх боломжтой, хоорондоо зөрүүгүй, гэмт хэргийн үйл баримтыг нотолж чадсан гэж үзэн, Чингэлтэй дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2020 оны 9 дүгээр сарын 4-ний өдрийн 726 дугаартай шийтгэх тогтоолыг хэвээр үлдээж шийдвэрлэжээ.

## 2. ХУДАЛ МЭДЭЭЛЭЛ ТАРААХ ГЭМТ ХЭРГИЙН ШҮҮХИЙН ШИЙДВЭРИЙН ДҮН ШИНЖИЛГЭЭ

Эрүүгийн хуулийн нэмэлт өөрчлөлтөөр УИХ-аас 2020 оны 1 дүгээр сарын 10-ны өдөр Монгол Улсын эрүүгийн эрх зүйн түүхэнд анх удаа худал мэдээлэл тараахыг гэмт хэрэгт тооцсон нь онцлог үйл явдал байв. Энэхүү батлагдсан 13.14 дүгээр зүйлийн 1 дэх зүйл “Худал мэдээлэл тараах” гэмт хэргээр Хөвсгөл аймгийн сум дундын Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхээс шийтгэвэр гарч 550,000 төгрөгөөр торгох ял оногдуулсан анхны тохиолдол 2020 оны 4 дүгээр сарын 3-ны өдөр гарсан. Монгол Улс эрүүгийн эрх зүй залхаан цээрлүүлэх шинжээс хүмүүнлэгийн шинж байдалд шилжин, эрх зүйт төрийн зарчмын үндсэн дээр эрүүгийн хэргийг боловсронгуй болгож байгаа гэж дотоодын эрдэмтэд үзэж буй хэдий ч шүүхийн шийдвэрийн үндэслэл хэсэг нь цээрлүүлэх, хүмүүжүүлэх шинжээр ял оногдуулж буй нь учир дутагдалтай гэж судлаачийн хувьд үзэж байна. Эрүүгийн хуулийн зөв хэрэглээний асуудал шүүхийн шийдвэрээр дамжин гарна. Иймээс эрүүгийн хэргийг шүүхээс хэр шинжлэх ухааны үндэслэлтэй шийдвэрлэж буй талаар дүгнэхийн тулд энэ төрлийн гэмт хэрэгт шийтгэвэр оногдуулсан анхны тохиолдлыг авч үзсэнээрээ энэхүү шүүмж нь ач холбогдолтой болж буй. “Худал мэдээлэл тараах” гэмт хэргийн эрүүгийн хэргийн шүүхийн шийдвэрт дүн шинжилгээ хийхийг үүгээр эрмэлзэв. Эрүүгийн хэргийн 13.14 дэх хэсэг “Худал мэдээлэл тараах”



заалт хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор шүүхийн хүчин төгөлдөр найман шийдвэр 2020 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн байдлаар гарсан байна. Эдгээрийн шийтгэврийн ихэнх тохиолдол нь орон нутагт гарчээ (Дэлгэрэнгүйг <http://new.shuukh.mn/eruuanhana> цахим хуудаснаас харна уу).

*1. Дүн шинжилгээ хийх хэргийн товч агуулга*

**Б.Б-д холбогдох Худал мэдээлэл тараах гэмт хэрэг. Хөвсгөл аймгийн сум дундын Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх. 2020.04.03 №00112. Эрүүгийн хуулийн 13.14 дүгээр зүйл.**

Шүүгдэгч Б.Б нь 2020 оны 2 дугаар сарын 29-ний өдөр өөрийн фэйсбүүкийн хаягаас “Хөвсгөл аймгийн нэгдсэн зар” группэд “Аймаг тойрсон эргүүлийн албаныхан яагаад бизнес эрхлээд байгаа юм бэ? Та нар орж гарахад хармааны мөнгө хийх зүгээр үү?” гэсэн пост бичсэнийг илт худал мэдээлэл олон нийтэд тарааж, хорио цээрийн дэглэмийн үед үүрэг гүйцэтгэн ажиллаж буй төрийн албан хаагчдын ажил хэргийн нэр хүндийг гутаан доромжилсон гэмт хэрэг үйлдсэнд холбогдуулан, прокурорын яллах дүгнэлт үйлдэж эрүүгийн хэргийн 2038002260132 дугаартай хэргийг шүүхэд шилжүүлсэн.

*2. Гэмт хэргийн шинжийн талаар:*

“Шүүгдэгч нь хүний халдашгүй чөлөөтэй байх эрхийн эсрэг гэмт хэрэг үйлдэхдээ өөрийн үйлдлийн хууль бус шинжийг ухамсарлаж, илтэд худал мэдээллийг олон нийтэд тарааж, хор уршигт зориуд хүргэж үйлдсэн нь гэм буруугийн санаатай, хэлбэртэй, төгссөн гэмт хэрэг үйлдсэн гэж үзэх үндэслэлтэй байна” гэж дүгнэжээ. Улмаар Эрүүгийн хуулийн тусгай ангийн 13.14 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар шүүгдэгч Б.Б-д таван зуун тавин нэгжтэй тэнцэх хэмжээний буюу 550,000 төгрөгийн торгууль оногдуулж шийдвэрлэсэн.

Анхан шатны шүүхийн шийдвэрт Б.Б-г Эрүүгийн хуулийн 13.14 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасан “Худал мэдээлэл

тараах” гэмт хэрэг үйлдэж, буруутай үйлдэл гаргасан хэмээн ял оноосон байна. Энэхүү шийдвэр нь үндэслэлтэй эсэхийг тодорхойлохын тулд эхлээд гэм буруугийн зарчмыг авч үзье.

Монгол Улсын Үндсэн хуулийн 16.16-д заасны дагуу иргэн нь үзэл бодлоо илэрхийлэх эрхтэй. Иргэний өөрийн угийн, ухамсарласан эсвэл таамагласан үзэл бодлын улмаас ямар ч хүн ИБУТЭОТУП-аар хамгаалагдсан аливаа эрхээ эдлэхдээ хохирох ёсгүй. Үүнтэй холбоотойгоор үзэл бодолтой байхыг эрүүгийн гэмт хэрэг гэж үзэх нь тус Пактын заалттай харшилна гэж тайлбарласан. Монгол Улс нь Үндсэн хуулиараа олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээ шударгаар сахин биелүүлэх бөгөөд нэгдэн орсон гэрээ, конвенц нь дотоодын хууль, тогтоомжийн нэгэн адил үйлчлэхээр заасан байдаг.

Монгол Улсын Эрүүгийн хуулийн 1.4 дүгээр зүйлийн 4 дэх хэсгийн “Хүний үзэл бодол, итгэл үнэмшлийн төлөө эрүүгийн хариуцлага хүлээлгэхгүй” гэсэн заалт нь энэ эрхийг хамгаалж буй зохицуулалт юм. Үзэл бодлын шалтгаанаар баривчлах, саатуулах, шүүх, шоронд хорихыг хамруулан дарамт үзүүлэх, айлган сүрдүүлэх, нэр хоч өгөх нь Пактын 19 дүгээр зүйлийг зөрчсөнд тооцогдоно. Иргэн өөрийнхөө цахим хуудсанд бичсэн сэтгэгдэл нь иргэний үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөний илрэн гарах нэг хэлбэр гэж болно.

Шүүхийн шийдвэрт энэ гэмт хэргийн улмаас хохирсон этгээдэд хэнийг хамаатуулан ойлгож байгаа нь тодорхойгүй байна. Тухайлбал, “хорио цээрийн дэглэмийн үед уртасгасан цагаар үүрэг гүйцэтгэн ажиллаж байгаа төрийн албан хаагчдын ажил хэргийн нэр хүндийг гутаан доромжилсон гэмт хэргийг үйлдсэн” гэж тодорхойлох хэсэгтээ дурджээ. Гэвч Эрүүгийн хуулийн 13.14 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Хүний нэр төр, алдар хүнд, хуулийн этгээдийн ажил хэргийн нэр хүндэд халдсан...” бол хариуцлага хүлээлгэнэ. Шүүх хуулийн этгээдийн болон хүний нэр төр хохирсон аль нь болохыг

тодорхойлолгүйгээр төрийн албан хаагчдын ажил хэргийн нэр хүнд гэж авч үзэхдээ өөрийн дотоод итгэл, үнэмшлээр “уртасгасан цагаар үүрэг гүйцэтгэн ажиллаж байгаа” гэх, хэрэгт ач холбогдолгүй урьдчилсан нөхцөлийг оруулж нэг талыг барьж шийдвэрлэсэн байх үндэслэлтэй байна.

*3. Нотлох баримт, нотолбол зохих байдлын талаар:*

Мөрдөн шалгах ажиллагааны шатанд нотолбол зохих асуудлыг бүрэн тогтоосон гэж шүүх үзсэн нь хэргийг бүх талаас нь бүрэн гүйцэд хянаж чадаагүй байна. Гэрчээр мэдүүлэг өгсөн Ё.Ш, Б.Н, Э.Б, Н.Н нарын мэдүүлэгт үндэслэсэн болохоос үнэхээр 30,000 мянган төгрөгөөр торгуулаад Хөвсгөл аймагт орж, гарсан хүн бий эсэхийг эрэн хайгаагүй, энэ талын ажиллагаа явуулаагүй нь хавтаст хэрэгт авагдаагүй байна.

## ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ

1. Эрүүгийн хуулийн 13.14 дүгээр зүйлд заасан “худал мэдээлэл тараах” гэмт хэргийн талаарх шүүхийн шийдвэр үндэслэл бүхий байж чадахгүй байна. Иймээс хангалтгүй гэж үзэхээр байна. Энэ нь шүүгчийн төдийгүй мөрдөгч, прокурор, өмгөөлөгчийн туршлага, ур чадвараас хамааралтай асуудал юм.
2. “Худал мэдээлэл тараах” гэмт хэргийн үндсэн шинж болох “илт худал мэдээлэл”-ийг хууль тогтоомжид тайлбарлаагүй, хохирогчийн зүгээс тийнхүү худал мэдээлэл тараахаас сэргийлэх, худал мэдээллийг залруулах хангалттай арга хэмжээ авсан эсэхийг харгалздаагүй, Иргэний хуулийн 21 дүгээр зүйлийн дагуу шийдвэрлэж болох иргэний гэм хорын асуудлыг эрүүжүүлсэн (гэмт хэрэгт тооцсон) нь Монгол Улсын Үндсэн хуулиар тунхагласан үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхийн хувьд ухралт болсон гэж үзэж байна.
3. Нийгэмд нэгэнт тогтсон ойлголтыг дамжуулсны, үзэл бодлоо илэрхийлсний төлөө тухайн иргэдийг буруутгаж шийтгэвэр оногдуулж байгаад анхан болон давж заалдах шатны шүүхээс хууль зүйн дүгнэлт хийгээгүй байна. Мөн хууль тогтоомж, нийгмийн систем болох Эрүүгийн хуулийн 12.5 дугаар зүйлд заасан “Арван зургаан насанд хүрээгүй хүнтэй бэлгийн харьцаанд орох” гэмт хэргийг

шүүмжлэхдээ иргэн Х.Н-ийг холбож бичсэн иргэн бүрт шүүхээс шийтгэвэр оногдуулж буй нь буруу бөгөөд тус хэрэгт анхны шийтгэвэр Х.Н-ийн талд гарснаар нэр төр, алдар хүндэд нь халдсан болох нь тогтоогдох боломжтой байсан юм.

4. Анхан шатны шүүхийн шийдвэр нь гэм буруугийн зарчмыг үндэслээгүй бөгөөд хэт нэг талыг барьж, ял оногдуулахыг зорьсон байна. Энэ нь хэргийн нотлох баримтыг, нотолбол зохих байдлуудыг бүрэн шалгаж тогтоолгүй, хэрэгт авагдсан нотлох баримтад тулгуурласан байх зэрэг формаль шаардлагыг хангаж чадаагүй байна.
5. Шүүгч хэдий өөрийн дотоод итгэл үнэмшилд үндэслэн хэргийг шийдэх хэдий ч шийдвэр нь ямагт үндэслэлтэй байхаас гадна тэрхүү үндэслэл нь хууль зүйн шинжлэх ухаанаас урган гарсан байх учиртай. Үндсэн эрхтэй холбоотой асуудлыг шийдвэрлэхдээ олон улсын хэм хэмжээг баримтлаагүй бөгөөд дан ганц дотоодын хууль тогтоомжоор яллах талыг барьж шийдвэрлэжээ.
6. Цар тахлын үед үнэн бодит мэдээлэл түгээх нь Засгийн газрын үүрэг болохыг харгалзан үзээгүй байна.

## ЗӨВЛӨМЖ

НҮБ-ын Хүний эрхийн зөвлөлөөс 2015 онд Монгол Улсад өгсөн дараах зөвлөмж болон Засгийн газрын 2016 оны 204 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан “НҮБ-ын Хүний эрхийн зөвлөлөөс гаргасан зөвлөмжүүдийг 2016-2019 онд хэрэгжүүлэх арга хэмжээний ерөнхий төлөвлөгөө”-г бүрэн хэрэгжүүлж, Эрүүгийн болон Зөрчлийн тухай хуулиудаас “илт худал мэдээлэл тараах”, “олон нийтийг төөрөгдүүлэх, худал мэдээ, мэдээлэл түгээсэн” гэмт хэрэг, зөрчлийг хасах шаардлагатай. Үүнд:

- Үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхийн харилцааг зохицуулсан хууль, журмуудад ИБУТЭТОУП-аар хүлээсэн Монгол Улсын үүрэгт бүрэн дүүрэн нийцүүлэх;
- Нэр төр гутаахыг эрүүгийн гэмт хэрэгт тооцохгүй байх;
- Интернет орчныг оролцуулан үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхийг бүх орчинд баталгаажуулах;
- Сэтгүүлчид, хэвлэл мэдээллийн ажилтнууд болон иргэний нийгмийн зүтгэлтнүүд үйл ажиллагаагаа олон улсын стандартад заасны дагуу шийтгэн цээрлүүлэх аливаа айдасгүйгээр чөлөөтэй эрхлэх бололцоог хангах;
- Олон нийтийн зүтгэлтэн, улс төрийн өндөр албан тушаалтантай холбоотой хэргийг шийдвэрлэхдээ олон улсын хэм хэмжээг баримтлах, шүүмжлэлт сэтгэлгээг хүлээн зөвшөөрөх;

- Нэр төр гутаах үйлдлийг эрүүгийн гэмт хэрэгт тооцохгүй байх, төрийн болон орон нутгийн эрх бүхий байгууллагын үйл ажиллагааг сурвалжилсан, шүүмжилсний улмаас мөрдөн хавчигдах эсхүл дарамт шахалтад орохоос хамгаалах орчныг бүрдүүлэх;
- Нэр төр гутаах үйлдлийг эрүүгийн гэмт хэргээс хасах, олон улсын хүний эрхийн хэм хэмжээнд нийцүүлэн иргэний хуулийн журмаар шийдвэрлэх;
- Эрүүгийн хуулийн гүтгэх, доромжлохтой холбоотой зүйл, заалтыг шүүмжлэл таслан зогсоох зорилгоор ашиглахгүй байх, сэтгүүлчдийн мэдээллийн эх сурвалж болон шүгэлдэгчийг хамгаалах.

## АШИГЛАСАН МАТЕРИАЛ

### 1. Хууль тогтоомж

1. Монгол Улсын Үндсэн хууль, 1992.
2. Монгол Улсын Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулга, 2017.
3. Монгол Улсын Эрүүгийн хууль, 2002.
4. Монгол Улсын Зөрчлийн тухай хууль, 2017.
5. Монгол Улсын Иргэний хууль, 2002.
6. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, 2017.
7. Монгол Улс 1974 онд соёрхон баталсан Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын Пакт, 1966.
8. Коронавируст халдвар (Ковид-19)-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хууль, 2020.
9. Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хууль, 1998.
10. НҮБ-ын Хүний эрхийн хорооноос 2011 онд баталсан Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын Пактын нэмэлт, 34-р ерөнхий тайлбар, Албан бус орчуулга.



## **2. Ном, өгүүлэл, нийтлэл**

1. Хэвлэлийн эрх чөлөөний тайлан, Глоб Интернэшнл төв (УБ., 2020).

## **3. Цахим эх сурвалж**

1. Legalinfo.mn
2. Shuukh.mn
3. GIC.mn
4. Parliament.mn
5. Mojha.gov.mn
6. Prokuror.mn
7. Judcouncil.mn

# 4

## ЗАЛИЛАХ ГЭМТ ХЭРГИЙГ ШИЙДВЭРЛЭСЭН ШҮҮХИЙН ШИЙДВЭРИЙН ДҮН ШИНЖИЛГЭЭ

### СУДЛААЧИЙН ТАНИЛЦУУЛГА



#### ЦОЛМОНГИЙН ЦЭЛМЭГ

Хууль зүйн ухааны доктор, профессор. Шихихутаг хууль зүйн дээд сургуулийг эрх зүйч мэргэжлээр төгсөж, МУИС-ийн Хууль зүйн сургуульд магистрын зэрэг, “Ойн тухай хууль тогтоомж зөрчих гэмт хэргийн Эрүүгийн эрх зүйн болон криминологийн асуудал” сэдвээр Хууль зүйн ухааны докторын (Ph.D) зэрэг хамгаалсан. Прокурор, өмгөөлөгч, шүүгчээр ажиллаж байсан түршлагатай. Шихихутаг хууль зүйн дээд сургуульд багш, Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн сургалтын төвийн эрхлэгчээр ажиллаж байв. 2017 оноос Их засаг Их сургуулийн проректорын албыг хашиж байна. Судалгаа шинжилгээний ажил эрхэлж 20 гаруй гарын авлага, эрдэм шинжилгээний 50 гаруй өгүүлэл, нийтлэл бичиж хэвлүүлсэн.



#### ДЭМБЭРЭЛИЙН ОРОСОО

Хуульч, өмгөөлөгч, арбитрач, МУИС-ийн докторант. Монголын хуульчдын холбооны Зөвлөлийн гишүүн, Хууль зүйн мэдээлэл, судалгааны хамтын ажиллагааны нийгэмлэгийн Гүйцэтгэх захирал, Өмгөөллийн “Эрх зүйн гүүр” ХХК-ийн Захирал, өмгөөлөгч, МҮХАҮТ-ын дэргэдэх Монголын Олон улсын арбитрачдын арбитрач.

#### Судлаач:

Ц.Цэлмэг  
Д.Оросоо

## АГУУЛГА

<b>УДИРТГАЛ</b> .....	117
<b>Нэг. Анхан шатны шүүхийн шийдвэрийн дүн шинжилгээ</b> .....	123
1.1. Эрүүгийн хуулийн тусгай ангийн 17.3 дугаар зүйлийн 3.1-д заасан хэргийн шийдвэрийн шинжилгээ .....	123
1.2. Цахим хэрэгсэл ашиглаж болон олон шатлалт маркетинг, пирамид тогтолцооны луйврын аргаар үйлдсэн зүйл ангиар шүүхээр шийдвэрлэгдсэн хэргийн дүн шинжилгээ .....	131
1.3. Залилах гэмт хэргийг цагаатгах тогтоолын дүн шинжилгээ .....	139
1.4. Иргэний хэрэг маргааныг залилах гэмт хэргээс ялган зүйлчилж буй шүүхийн практик, шийдвэрийн дүн шинжилгээ .....	148
1.5. Шүүхээс залилах гэмт хэрэгт оногдуулж байгаа ялын төрөл, хэмжээ ба үр нөлөө .....	158
1.6. Гадаадын зарим орны эрүүгийн хууль тогтоомжийн харьцуулсан судалгаа .....	172



<b>Хоёр. Залилах гэмт хэргийн нотолгооны процессын дүн шинжилгээ</b> .....	185
2.1. Нотолгооны зүйл, нотлох баримтыг шүүхээс хэрхэн үнэлж буй практик .....	185
2.2. Залилах гэмт хэргийн хохирлыг тооцож буй шүүхийн дүгнэлт .....	188
<b>Дүгнэлт, зөвлөмж</b> .....	193
<b>Ашигласан материал</b> .....	216
<b>Хавсралт</b>	
Хавсралт 1. Анхан шатны шүүхийн шийтгэх тогтоолууд .....	218
Хавсралт 2. Давж заалдах шатны шүүхийн магадлалууд .....	220
Хавсралт 3. Хяналтын шатны шүүхийн тогтоолууд .....	222

## ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

УДШ	Улсын Дээд шүүх
УИХ	Улсын Их Хурал
ЭХАШШ	Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх
ЭХДЗШШ	Эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүх
ЭХХШтХ	Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль
МӨХ	Монголын өмгөөлөгчдийн холбоо
ХХДХ	Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ
ОУЭЭЗ	Олон улсын эрүүгийн эрх зүй
ШЕЗ	Шүүхийн ерөнхий зөвлөл
ЭХЕА	Эрүүгийн хуулийн ерөнхий анги
ЭХТА	Эрүүгийн хуулийн тусгай анги
АНУ	Америкийн Нэгдсэн Улс
ОХУ	Оросын Холбооны Улс
ХБНГУ	Холбооны Бүгд Найрамдах Герман Улс
БНХАУ	Бүгд Найрамдах Хятад Ард Улс
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани

## УДИРТГАЛ


Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулга 2015 онд УИХ-ын хэлэлцүүлгээр зарим нэмэлт өөрчлөлт орж батлагдан, 2017 оны 7 дугаар сарын 1-нээс дагаж мөрдөгдсөнөөс хойш даруй дөрвөн жил өнгөрч байна.

Монгол Улсад 2020 онд 23,064 гэмт хэрэг бүртгэгдэж 13,470 эрүүгийн хэрэг шүүхээр хянан шийдвэрлэгдсэний 714 нь залилах гэмт хэрэг байна<sup>1</sup>. Эдгээр гэмт хэргийн улмаас төрийн өмчид 6,5; хувийн өмчид 246 тэрбум төгрөг тус тус, нийт 255 тэрбум төгрөгийн бодит хохирол<sup>2</sup> учирснаас 82.1 тэрбум төгрөгийн хохирлыг нь нөхөн төлүүлжээ. Залилах гэмт хэргийн нөхцөл байдал жил ирэх тусам хүндэрч байна (График 1-ийг харна уу). Санхүүгийн залилан, луйврын шинжтэй гэмт хэргийн улмаас иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад учирсан хохирлын хэмжээ 2016 онд 2 тэрбум орчим төгрөг байсан бол 2017 онд 6.4, 2018 онд 9.9 тэрбум төгрөг болж тус тус өссөн ба энэ үзүүлэлт 2020 онд 16 тэрбум төгрөгт хүрсэн байна.

<sup>1</sup> Статистикийн мэдээллийн нэгдсэн сан, [www.1212.mn](http://www.1212.mn)

<sup>2</sup> Мөн тэнд.

**График 1. Санхүүгийн залилан, луйврын улмаас  
учирсан хохирлын хэмжээ (тэрбум төг)<sup>3</sup>**



Энэ нөхцөл байдалтай холбоотойгоор Цагдаагийн Ерөнхий газар, Монгол банк, Монголын банкны холбоо хамтран иргэдийг санхүүгийн залилан, луйвраас сэрэмжлүүлэх зорилго бүхий “Ятгах тусам нягтал” нөлөөллийн ажил явуулж байгаа ч барьцтай үр дүн төдий л харагдахгүй байна.

Шүүхээр хянан шийдвэрлэгдсэн залилах гэмт хэргийн тоо 2020 онд 714 байгаа нь зөвхөн бүртгэгдсэн гэмт хэргийн статистик бөгөөд нуугдмал гэмт явдлыг тооцвол дээрх статистик даруй 3-10 дахин нэмэгдэх магадлалтай.

Эрүүгийн хуулийн (2002 оны) тусгай ангийн 148 дугаар зүйлд залилах гэмт хэрэг нь хуурч мэхлэх, итгэл эвдэх гэсэн хоёр аргаар илэрдэг гэж үзэж байсан бол 2015 оны Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулгаар уг гэмт хэрэг нь “хуурч эсхүл баримт бичиг, эд зүйл, цахим хэрэгсэл ашиглаж эсхүл зориудаар зохиомол байдал бий болгох, сүсэг бишрэлийг далимдуулах, бодит байдлыг нуух замаар бусдыг төөрөгдөлд оруулж эсхүл нэр хүнд, урьдын харилцааны явцад бий болсон итгэлийг урвуулан ашиглаж үйлдсэн” гэсэн дөрвөн аргаар илэрч болох талаар хуульчилжээ.

<sup>3</sup> Санхүүгийн зохицуулах хороо. Санхүүгийн луйвар болон понзи схем, <http://www.frc.mn/resource/frc/File>



Мөрдөн байцаалт, шүүхийн практикаас харахад залилах гэмт хэрэг нь дараах арга, хэлбэрүүдээр голчлон илэрч байна. Үүнд:

- 1) Хөдлөх болон үл хөдлөх эд хөрөнгө худалдах, худалдан авах, түрээслэх, түрээслүүлэх, арилжих, барьцаалах, иргэд хооронд өндөр хүүтэй мөнгө зээлэх нэрээр бусдыг залилах;
- 2) Гадаад улсад зорчих виз гаргаж өгнө хэмээн залилах;
- 3) Иргэдийн цахим шуудан, фэйсбүүк хаягт хууль бусаар нэвтрэн, тэдний нэрээр ойр дотнын найз нөхөд, ах дүү нарт нь мөнгөний яаралтай хэрэгцээ гарсан мэтээр тусламж гуйн мөнгө шилжүүлж авах;
- 4) Иргэдээс “Гар утас худалдаж авна”, “Утсаар чинь яриад өгье” гэх зэргээр гар утсыг нь авч зугтаах;
- 5) Хуурамч баримт бичиг ашиглан бусдын эд хөрөнгийн өмчлөх эрхийг залилах;
- 6) Олон шатлалт маркетинг, пирамид тогтолцооны арга буюу олны нэрлэж заншсанаар сүлжээний бизнес хэлбэрээр;
- 7) Төрийн байгууллагад ажилд оруулахад зуучлах нэрээр бусдыг залилах;
- 8) Цахим худалдаа, цахим сугалаа явуулах, цахимаар мөрийтэй тоглох зэрэг үйлдлийн аргуудаар түгээмэл илэрдэг.

Залилах гэмт хэргийг 2018-2020 оны байдлаар, хэрэг үйлдэгдэж буй нутаг дэвсгэрээр нь авч үзвэл нийт гэмт хэргийн 80 орчим хувь нь Улаанбаатар хотод бүртгэгдсэн байх ба үүнээс Баянгол, Баянзүрх, Сүхбаатар дүүрэгт энэ төрлийн гэмт хэрэг хамгийн их гарч байна. Орон нутгаас Орхон, Дархан-Уул аймаг болон хүн ам төвлөрсөн бусад аймгийн төвүүдэд өндөр үзүүлэлттэй байна.



Иргэдийн хууль эрх зүйн мэдлэг нимгэн, мөн гэнэн итгэмтгий байдлаасаа болоод мөнгө, эд зүйл болон эд хөрөнгө эзэмших эрхээ бусдад шилжүүлдэг, зарим тохиолдолд хоорондоо гэрээ, хэлцэл ч байгуулсан байдаг. Гэсэн хэдий ч гэрээгээр халхавчилж залилан мэхэлсэн үү эсвэл иргэний хэрэг маргаан уу гэдгийг ялгаж салгахаас эхлээд мөрдөн байцаалт, прокурор шүүхийн практикт эргэлзээтэй олон асуудал үүсдэг тул энэ чиглэлээр нарийвчилсан судалгаа хийх шаардлагатай байна.

Залилах гэмт хэргийг онолын түвшинд судалсан магистр, докторын судалгааны ажил (2004 онд Д.Адьяабазар хууль зүйн ухааны докторын зэрэг хамгаалсан) цөөн, түүнчлэн 2015 онд Эрүүгийн хууль шинэчлэгдэн батлагдсанаас хойш шүүхийн практик судалгааны ажил хийгдээгүй байгааг дурдах нь зүйтэй.

Сүүлийн жилүүдэд залилах гэмт хэргийн арга улам нарийсаж гэрээ, хэлцлээр халхавчлан үйлддэг, зарим тохиолдолд гэрээгээ нотариатаар батлуулах тохиолдол ч нэмэгдэх болсон бөгөөд гэрээ байгуулсан л бол иргэний гомдлыг хүлээн авахаас цагдаагийн байгууллага шууд татгалздаг нь олон хүний эрх ашиг хөндөгдөхөд хүргэж байна. Мөрдөн байцаалт, прокурор, шүүхийн шатанд залилах гэмт хэргийг шалгах, хянан шийдвэрлэх ажиллагаа хэтэрхий удааширч олон жил сунжирсны эцэст хөөн хэлэлцэх хугацаа нь дууссан гэх үндэслэлээр хэрэгсэхгүй болох явдал ч цөөнгүй гардаг.

Иймээс Монгол Улсын хэмжээнд залилан мэхлэх гэмт хэргийг эцэслэн шийдвэрлэсэн шүүхийн шийдвэр (шийтгэх тогтоол, магадлал)-т дүн шинжилгээ хийж, анхан болон давж заалдах шатны шүүхүүд хуулийг зөв хэрэглэж байгаа эсэх, шийдвэрийнхээ үндэслэлийг тайлбарлаж байгаа эсэх, нотлох баримтын аль нэгийг үнэлэхдээ нөгөөг нь үгүйсгэсэн үндэслэлээ зааж байгаа эсэхийг тодруулах шаардлагатай юм. Хохирлыг хэрхэн тооцон гаргуулж байгаа болон оногдуулсан ялын

бодлогын талаар ч судалгаа хийж дүгнэлт гарган, эрх зүйн орчныг улам боловсронгуй болгох, засаж залруулах, шударга ёсыг тогтоох зайлшгүй шаардлагатай байна.

## СУДАЛГААНЫ ЗОРИЛГО

Энэхүү судалгааны хүрээнд залилах гэмт хэргийн бүрэлдэхүүний шинж, төсөөтэй гэмт хэрэг, зөрчлөөс түүнийг ялган зүйлчлэх, иргэний эрх зүйн маргаанаас залилах үйлдлийг хэрхэн ялгах, гэрээгээр халхавчлан бусдын эд хөрөнгийг залилсан асуудлыг эрүүгийн хариуцлагад татахад учирч буй хүндрэл бэрхшээл, хохирлыг хэрхэн тооцох, шүүхээс нотлох баримтыг үнэлэх, хэргийн бодит байдалтай нийцээгүй дүгнэлт хийн, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийг ноцтой зөрчсөн анхан болон давж заалдах шатны шүүхийн шийдвэрт дүн шинжилгээ хийх юм. Түүнчлэн Эрүүгийн хуулийг буруу хэрэглэсэн асуудлыг илрүүлэн гаргаж, цаашид хуулийг нэг мөр хэрэглэх, Эрүүгийн хуулийн холбогдох заалтууд хийдэлтэй байгаа бол тухайн зүйл, заалтыг засаж боловсронгуй болгох санал гаргахад судалгааны ажлын зорилго оршино.

Судлаач бид хяналтын шатны буюу Улсын Дээд шүүх (УДШ)-ийн шийдвэрт үнэлэлт өгөх зорилт тавиагүй бөгөөд Шүүхийн тухай хуульд орсон нэмэлт, өөрчлөлтөөр УДШ нь Үндсэн хуулиас бусад хуулийн зүйл, заалтыг тайлбарлах эрхтэй, уг тайлбарыг хууль хэрэглэгч субъект бүр дагаж мөрдөх үүрэгтэй учир ихэнх тохиолдолд анхан шатны шүүхийн шийдвэр, зарим тохиолдолд давж заалдах шатны шүүхийн магадлалд дүн шинжилгээ хийлээ.

## СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ, ХАМРАХ ХҮРЭЭ

Судлаачдын зүгээс шүүхийн шийдвэрийн цахим сан ([www.shuukh.mn](http://www.shuukh.mn))-д байгаа 150 орчим шийдвэрээс 2015 оны Эрүүгийн



хуулиар залилах гэмт хэргийг хянан шийдвэрлэсэн анхан шатны шүүхийн 100 шийтгэх тогтоол, давж заалдах шатны шүүхийн 50 магадлалд дүн шинжилгээ хийсэн болно.

Шүүхийн шийдвэрт дүн шинжилгээ хийхдээ тухайн хэргийн зүйл ангийн онцлогоос хамаарч үндсэн бүрэлдэхүүнтэй хэргийн шийдвэр (ЭХТА-ийн 17.3 дугаар зүйлийн 1 дэх хэсэг); хүндрүүлэх бүрэлдэхүүнтэй хэргийн шийдвэр (ЭХТА-ийн 17.3 дугаар зүйлийн 2); онцлон хүндрүүлэх бүрэлдэхүүнтэй хэргийн шийдвэр (ЭХТА-ийн 17.3 дугаар зүйлийн 3) гэж төрөлжүүлэн төлөөлөх хэргийг сонгон авлаа. Түүнчлэн халдлагын зүйлийн онцлогийг харгалзан эд хөрөнгө болон эд хөрөнгийн эрхийг залилах, визийн болон сүлжээний залилан, цахим залилан зэргээр төрөл бүрээс нь сонгон авахыг хичээсэн болно.

Судалгаа нь тоон болон чанарын судалгааны аргад тулгуурлан хийгдсэн ба судалж буй асуудлын онцлог, хамрах хүрээнээс хамаарч дараах арга зүйг ашиглалаа. Үүнд:

- Эрүүгийн хуульд шинээр тодорхойлсон залилах гэмт хэргийн тоон үзүүлэлтэд дүн шинжилгээ хийж, өсөлт, бууралтын түвшин, түүнд нөлөөлсөн хүчин зүйлийг тодорхойлох;
- “Ятгах тусам нягтал” арга хэмжээний хүрээнд залилах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх талаарх иргэдийн хандлагад гарсан өөрчлөлтийг тодорхойлох;
- Статистикийн тодорхой аргачлалд үндэслэн залилах гэмт хэргийн чиг хандлагыг тодорхойлох зэрэг болно.

## **НЭГ. АНХАН ШАТНЫ ШҮҮХИЙН ШИЙДВЭРИЙН ДҮН ШИНЖИЛГЭЭ**

### **1.1. ЭРҮҮГИЙН ХУУЛИЙН ТУСГАЙ АНГИЙН 17.3 ДУГААР ЗҮЙЛИЙН 3.1-Д ЗААСАН ХЭРГИЙН ШИЙДВЭРИЙН ШИНЖИЛГЭЭ**

**Хэрэг 1. Баянгол дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2018 оны 11 дүгээр сарын 5-ны өдрийн 848 дугаартай шийтгэх тогтоол, Нийслэлийн Эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүхийн 2018 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн 1 дүгээр магадлалтай Б.У-д холбогдох 1705012280200 дугаартай эрүүгийн хэрэг.**

#### **Хэргийн талаар:**

Б.У нь иргэн М.О-д өөрийгөө “Засгийн газрын хэрэг эрхлэх газрын албаны даргаар ажилладаг, Хөдөө аж ахуйн яаманд тусламжаар ирж байгаа хүлэмж олж өгнө, мөн дүү нарт чинь Солонгос Улсын виз гаргаж өгнө” гэж зохиомол байдал бий болгон, бодит байдлыг нуух замаар 2017 оны 8 дугаар сарын 21-ний өдрөөс 11 дүгээр сарын 14-ний өдрийн хооронд Увс аймагт байхад нь болон Баянгол дүүргийн 9 дүгээр хороо, СОТ 2/1 дүгээр байрны 28 тоотод ирсэн байх үед нь 8,000,000 төгрөг;

М.О-гийн хадам эцэг Д.Г-д өөрийгөө “Засгийн газрын хэрэг эрхлэх газрын албаны даргаар ажилладаг, “Аж үйлдвэрийн гавьяат ажилтан” цол, тэмдэг авч өгнө” гэж зохиомол байдал зориуд бий болгон, бодит байдлыг нуух замаар 2017 оны 9 дүгээр сарын 19-ний өдрөөс 10 дугаар сарын 18-ны өдрийн

хооронд Д.Г-г Увс аймагт байхад нь болон Баянгол дүүргийн 9 дүгээр хороо, СОТ 2/1 дүгээр байрны 28 тоотод ирсэн байх үед нь итгэл төрүүлэн өөрөөс нь болон охин М.О-гоор дамжуулан 4,800,000 төгрөг авч, нийт 12,800,000 төгрөг залилсан гэмт хэрэгт холбогджээ.

### **Шүүхийн шийдвэрлэлт:**

Баянгол дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх шүүгдэгч Б.У-г “хуурч, зохиомол байдал зориудаар бий болгох, бодит байдлыг нуух замаар бусдыг төөрөгдөлд оруулж, өмчлөгчийн эд хөрөнгийг шилжүүлэн авсан гэмт хэрэг байнга үйлдэж амьдралын эх үүсвэр болгосон” гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцон, Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 2.2 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт заасныг журамлан мөн хуулийн тусгай ангийн 17.3 дугаар зүйлийн 3.1-д зааснаар Б.У-г таван жил хорих ялаар шийтгэж, Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 5.6 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт зааснаар Б.У-д оногдуулсан таван жил хорих ялыг эмэгтэйчүүдийн нээлттэй хорих байгууллагад эдлүүлэхээр тогтоожээ. Мөн Иргэний хуулийн 497 дугаар зүйлийн 497.1, 510 дугаар зүйлийн 510.1 дэх хэсэгт зааснаар шүүгдэгч Б.У-гаас 9,407,800 төгрөг гаргуулан хохирогч М.О, Д.Г нарт олгуулж, шүүгдэгч Б.У-гийн насанд хүрээгүй хүүхдүүд болох 2001 оны 7 дугаар сарын 24-нд төрсөн У.Э, 2005 оны 1 дүгээр сарын 18-нд төрсөн У.Э, 2017 оны 1 дүгээр сарын 18-нд төрсөн П.Х, 2018 оны 9 дүгээр сарын 1-нд төрсөн У.Х нарт асран хамгаалагч, харгалзан дэмжигч тогтоохыг Баянгол дүүргийн засаг даргад даалгуулж шийдвэрлэсэн байна.

Нийслэлийн Эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүх шийтгэх тогтоолыг хэвээр үлдээж, шүүгдэгч Б.У, түүний өмгөөлөгч О.Б нарын гаргасан давж заалдах гомдлуудыг хэрэгсэхгүй болгон шийдвэрлэжээ.



2019 оны 2 дугаар сарын 18-нд УДШ-ийн 65 дугаартай тогтоолоор “...Б.У-д бусдыг залилсан үйлдэл байнга үйлдэж амьдралын эх үүсвэрээ болгосон шинж тогтоогдохгүй байна” гэж дүгнээд дараах байдлаар шийдвэрлэжээ. Үүнд:

Баянгол дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2018 оны 11 дүгээр сарын 5-ны өдрийн 848 дугаартай шийтгэх тогтоол, Нийслэлийн Эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүхийн 2018 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн 1 дүгээр магадлалд “Прокуророос Б.У-д Эрүүгийн хуулийн тусгай ангийн 17.3 дугаар зүйлийн 3.1-д заасан гэмт хэрэгт холбогдуулан яллах дүгнэлт үйлдэж ирүүлсэн хэргийн зүйлчлэлийг мөн хуулийн тусгай ангийн 17.3 дугаар зүйлийн 1 дэх хэсэг болгон өөрчилсүгэй”, “Б.У-г зохиомол байдал зориудаар бий болгох, бодит байдлыг нуух замаар бусдыг төөрөгдөлд оруулж, өмчлөгчийн эд хөрөнгийг шилжүүлэн авсан гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцсугай”, “Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 2.2 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт заасныг баримтлан шүүгдэгч Б.У-г Эрүүгийн хуулийн тусгай ангийн 17.3 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар 2 (хоёр) жил хорих ял шийтгэсүгэй”, “Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 7.6 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасныг баримтлан шүүгдэгч Б.У-д 2 (хоёр) жил хорих ял оногдуулсан шүүхийн шийдвэр биелүүлэхийг 2 (хоёр) жил хүртэл хугацаагаар хойшлуулсугай” гэсэн өөрчлөлт тус тус оруулж, шийтгэх тогтоол, магадлалын бусад заалт, хэсгийг хэвээр үлдээсэн байна.

#### **Дүн шинжилгээ:**

Б.У нь бодит байдлыг нууж, зохиомол байдал үүсгэн, хохирогч М.О-гийн итгэлийг олж, түүнд өөрийгөө “Засгийн газрын хэрэг эрхлэх албаны даргаар ажилладаг, Хөдөө аж ахуйн яаманд тусламжаар ирж байгаа хүлэмж олж өгнө, дүү нарт чинь Солонгос Улсын виз гаргаж өгнө”, мөн хохирогчоор дамжуулан түүний хадам эцэг Д.Г-д ““Аж үйлдвэрийн гавьяат

ажилтан” цол, тэмдэг авч өгнө” хэмээн хуурч мэхлэн 2017 оны 8 дугаар сарын 21-ний өдрөөс 11 дүгээр сарын 14-ний өдрийн хооронд үргэлжилсэн үйлдлээр нийт 12,800,000 төгрөг залилан авсан үйл баримт хуульд заасан үндэслэл, журмын дагуу цуглуулж бэхжүүлсэн, шүүх хуралдаанд хянан хэлэлцэгдсэн нотлох баримтуудаар тогтоогджээ.

Энэ хэрэгт Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 16.2 дугаар зүйлд заасан нотолбол зохих байдлуудыг хангалттай шалгаж тодруулсан, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад оролцогчийн хуулиар хамгаалагдсан эрхийг хассан, хязгаарласан, шүүхийн шийдвэрт нөлөөлсөн эсхүл нөлөөлж болохуйц нөхцөл байдал бүхий зөрчил тогтоогдоогүй болно.

Шүүгдэгч Б.У нь хохирогч М.О-г залилан мэхлэх санаа зорилгоор тодорхой цаг хугацаанд хэд хэдэн удаагийн үргэлжилсэн үйлдлээр гэмт хэрэг үйлдсэн байхад шүүх бэлэн мөнгө авах болон мөнгөн гүйлгээ хийлгэсэн тохиолдол бүрийг тус тусдаа эхлэл, төгсгөл бүхий үйлдэл бүртээ бие даасан гэмт хэргийн шинж агуулсан хэд хэдэн гэмт хэрэг үйлдсэн мэтээр дүгнэж, гэмт хэргийн ойлголт, шинжийн талаарх эрүүгийн эрх зүйн хэм хэмжээний агуулгыг буруу тайлбарлан, Эрүүгийн хуулийг буруу хэрэглэсэн байна. Өөрөөр хэлбэл, шүүгдэгч Б.У-ын үйлдсэн гэмт хэрэг нь үргэлжилсэн үйлдэлтэй нэг гэмт хэрэг буюу Эрүүгийн хуулийн тусгай ангийн 17.3 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан залилах гэмт хэргийн үндсэн шинжид хамаарахаар байхад анхан болон давж заалдах шатны шүүх Б.У-г залилах гэмт хэрэг “байнга үйлдэж амьдралын эх үүсвэрээ болгосон” гэж хүндрүүлэн зүйлчилж, хэргийг шийдвэрлэсэн нь хууль зүйн үндэслэлгүй болжээ.

2015 оны Эрүүгийн хуулийн тусгай ангийн 17.3 дугаар зүйлийн 3.1-д заасан “Энэ гэмт хэргийг байнга үйлдэж амьдралын эх үүсвэр болгосон” гэх онц хүндрүүлэх шинж нь



хоорондоо шууд харилцан хамаарал бүхий нэг төрлийн гэмт хэргийг харьцангуй удаан хугацаанд, гурав буюу түүнээс дээш удаа давтан үйлдэж, мэргэшсэн байдал болон уг гэмт хэргийг үйлдэж олсон бага бус, түүнээс дээш хэмжээтэй ашиг орлогыг өөрийн болон гэр бүл, хамаарал бүхий хүмүүсийнхээ амьжиргааг залгуулах гол эх сурвалж эсхүл бусад үйлдвэрлэл, худалдаа, үйлчилгээ болон уг гэмт хэргийг үйлдэж олсон бага бус, түүнээс дээш хэмжээтэй ашиг орлогыг өөрийн болгож тогтвортой ашигласан байхыг хамааруулсан хууль зүйн ойлголт болно.

Иймд Б.У-гийн үйлдлийг Эрүүгийн хуулийн тусгай ангийн 17.3 дугаар зүйлийн 1 дэх хэсэг болгон өөрчлөх үндэслэлтэй.

**Хэрэг 2. Сүхбаатар дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2017 оны 8 дугаар сарын 22-ны өдрийн 276 дугаартай шийтгэх тогтоол, Нийслэлийн Эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүхийн 2017 оны 11 дүгээр сарын 9-ний өдрийн 772 дугаартай магадлал бүхий 201625023071 дугаартай эрүүгийн хэрэг.**

#### **Шүүхийн шийдвэрлэлт:**

Анхан шатны шүүх хэрэгт цугларсан нотлох баримтад үндэслэн шүүгдэгч Х.З-г өөрийгөө “Их сургуулийн багш, манай сургууль гадаад улс руу тэтгэлгээр оюутан явуулдаг, миний эгч их сургуулийн захирал, манай найз том албан тушаал эрхэлдэг, би ажил, сургуульд оруулж өгч чадна, их сургуулийн диплом авч өгнө” гэх зэргээр зохиомол байдлыг зориуд бий болгон иргэдийг төөрөгдүүлж, итгэлийг нь урвуулан ашиглаж 2016 оны 4 дүгээр сараас 11 дүгээр сар хүртэлх хугацаанд иргэн Г.Ж-гээс 54,000 ам. доллар буюу 108,656,640 төгрөг, 10,500,000 төгрөг, нийт 119,156,640 төгрөг, Г.Л-ээс 14,790,000, Ц.М-ээс 750,000, С.Ч-ээс 2,500,000 төгрөг тус тус, нийт 137,196,640 төгрөгийн их хэмжээний эд хөрөнгө, мөнгийг залилан авсан



гэх үйл баримтыг тогтоож, 2015 оны Эрүүгийн хуулийн тусгай ангийн 17.3 дугаар зүйлийн 3.1-д зааснаар зургаан жилийн хорих ял оногдуулсан байна.

Давж заалдах шатны шүүхээс Х.З-д холбогдох хэргийн зүйлчлэлийг хөнгөрүүлэн 2015 оны Эрүүгийн хуулийн тусгай ангийн 17.3 дугаар зүйлийн 2.2 болгон өөрчилж, таван жил хорих ял оногдуулж шийдвэрлэсэн.

### **Дүн шинжилгээ:**

Эрүүгийн хуулийн тусгай ангийн 17.3 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн 3.1-д заасан “энэ гэмт хэргийг байнга үйлдэж амьдралын эх үүсвэр болгосон” гэх хүндрүүлэх шинжийг анхан шатны шүүх цөөнгүй тохиолдолд буруу хэрэглэж хүнд ялтай зүйл ангиар таван жилээс дээш хугацаагаар хорих ял оногдуулж байгааг давж заалдах болон хяналтын шатны шүүхүүд илрүүлэн засах, өөрчлөлт оруулах, хүчингүй болгож дахин шийдвэрлэхээр заажээ.

Анхан шатны шүүх залилах үйлдлийн тоо, давтамжид голлон анхаарч гэмт этгээд залилах үйлдлийг гурав ба түүнээс дээш удаа үйлдсэн бол шууд “...байнга үйлдэж амьдралын эх үүсвэр болгосон” гэж дүгнэсэн нь буруу жишиг юм. Зүй нь шүүгдэгч этгээд амьдралын өөр эх үүсвэртэй буюу ажил хөдөлмөр эрхэлдэг эсэх, гэмт хэргээс өөр аргаар орлого олж байсан эсэх, гэмт хэргийн замаар олсон орлогыг амьжиргаандаа зарцуулсан эсэх зэрэг олон хүчин зүйлийг харгалзан дүгнэлт хийх ёстой. Гэтэл зөвхөн тоо, давтамжид анхаарал хандуулснаас дээд шатны шүүхээс анхан шатны шүүхийн тогтоол, шийдвэрийг хүчингүй болгож, өөрчлөлт оруулан, зүйл ангийг нь хөнгөрүүлж шийдвэрлэсэн зэрэг тохиолдол цөөнгүй гарчээ. Тухайлбал, 2018 оны 8 дугаар сарын 23-ны өдрийн 671 дүгээр шийтгэх тогтоолыг Нийслэлийн ЭХДЗШШ-ийн магадлалаар<sup>4</sup> Эрүүгийн хуулийн тусгай ангийн 17.3 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн 3.1-д зааснаар

<sup>4</sup> веб хуудас, [www.shuukh.mn](http://www.shuukh.mn)



зүйлчилснийг 17.3 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар хөнгөрүүлж өөрчилсөн байна.

Үндэслэл нь М. гэгч этгээдийн таван удаагийн үйлдэл 11 хоногийн дотор давтагдсан байх ба эдгээр үйлдлийг удаан хугацаанд тогтмол үйлдээгүй байх тул “байнга үйлдэж амьдралын эх үүсвэр болгосон” гэх шинжид хамааруулан үзэх боломжгүйгээс гадна нэг гэмт хэргийн шинжийг хэд хэдэн удаагийн үйлдэл, эс үйлдэхүйгээр хангасан, үргэлжилсэн гэмт хэрэг болгоныг “байнга үйлдсэн” шинжид хүндрүүлэн зүйлчлэх нь Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 1.3 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “...Эрүүгийн хариуцлага нь тухайн хүн, хуулийн этгээдийн үйлдсэн гэмт хэрэг, гэмт хэргийн нийгмийн аюулын шинж чанар, хэр хэмжээ, гэм буруугийн хэлбэрт тохирсон байна” гэсэн шударга ёсны зарчимд үл нийцнэ хэмээн давж заалдах шатны шүүхийн магадлалд дүгнэсэнтэй судлаачид бүрэн санал нэгдсэн.

Нөгөөтээгүүр “байнга үйлдэж амьдралын эх үүсвэр болгосон” гэх шинж нь “...гэмт хэрэг байнга үйлдэж, түүнээс олсон орлогыг амьдралын эх үүсвэр болгосон өөрөөр хэлбэл, залилах гэмт хэргийг өөрийн амьдралын зорилго, байнгын үндсэн ажил болгосон шинжтэй, нөгөө талаас байнга хэвшмэл маягтай, гэмт хэргийг үндсэн ажил болгосон” зэрэг онцлогтой бөгөөд анхан шатны шүүх гэмт хэргийн хүндрүүлэх шинжийн талаар буруу дүгнэлт хийх тохиолдол энэ мэтээр гардаг.

Залилах гэмт хэрэг нь гэмт этгээд бусдын өмч хөрөнгийг хуурч эсхүл зохиомол байдлыг зориудаар бий болгож, бусдыг төөрөгдөлд оруулж хууль бусаар завшиж өөрт хэрэглэх буюу ашиг орлого олох гэсэн шунахайн сэдэл, зорилготой байдаг бөгөөд гэмт этгээд тухайн эд хөрөнгийг хадгалан хамгаалж байсан эзнээс нь салгаж улмаар өөрийн болгон авч, захиран зарцуулах бодит бололцоог бий болгосон үеэс залилах гэмт хэрэг төгссөнд тооцогддог<sup>5</sup>.

<sup>5</sup> <https://mongolia.hss.de/mn/>

Залилах санаа зорилгоор тодорхой хүнээс тодорхой цаг хугацаанд хэд хэдэн удаагийн үргэлжилсэн үйлдлээр гэмт хэрэг үйлдсэн байхад шүүх бэлэн мөнгө авах болон мөнгөн гүйлгээ хийлгэсэн тохиолдол бүрийг тус тусдаа эхлэл, төгсгөл бүхий үйлдэл бүртээ бие даасан гэмт хэргийн шинж агуулсан хэд хэдэн гэмт хэрэг үйлдсэн мэтээр дүгнэж, гэмт хэргийн ойлголт, шинжийн талаарх эрүүгийн эрх зүйн хэм хэмжээний агуулгыг буруу тайлбарлан, Эрүүгийн хуулийг буруу хэрэглэсэн тохиолдол хэд хэд гарчээ. Жишээ нь, шүүгдэгч Б.У-гийн үйлдсэн гэмт хэрэг нь үргэлжилсэн үйлдэлтэй нэг гэмт хэрэг буюу Эрүүгийн хуулийн тусгай ангийн 17.3 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан залилах гэмт хэргийн үндсэн шинжид хамаарахаар байхад анхан болон давж заалдах шатны шүүх Б.У-г залилах гэмт хэрэг “байнга үйлдэж амьдралын эх үүсвэрээ болгосон” гэж хүндрүүлэн зүйлчилж, хэргийг шийдвэрлэсэн нь хууль зүйн үндэслэлгүй болсон гэж УДШ-ийн эрүүгийн танхимаас үзжээ<sup>6</sup>.

УДШ-ийн тогтоолд “...2015 оны Эрүүгийн хуулийн тусгай ангийн 17.3 дугаар зүйлийн 3.1-д заасан “Энэ гэмт хэргийг байнга үйлдэж амьдралын эх үүсвэр болгосон” гэх онц хүндрүүлэх шинж нь хоорондоо шууд харилцан хамаарал бүхий нэг төрлийн гэмт хэргийг харьцангуй удаан хугацаанд, гурав буюу түүнээс дээш удаа давтан үйлдэж, мэргэшсэн байдал болон уг гэмт хэрэг үйлдэж олсон бага бус, түүнээс дээш хэмжээний ашиг орлогыг өөрийн болон гэр бүл, хамаарал бүхий хүмүүсийнхээ амьжиргааг залгуулах гол эх сурвалж эсхүл бусад үйлдвэрлэл, худалдаа, үйлчилгээ зэрэг ашиг олох зорилготой үйл ажиллагааныхаа үндсэн хэрэгсэл, эх үүсвэр болгож тогтвортой ашигласан байхыг хамааруулсан хууль зүйн ойлголт болно” гэжээ.

---

<sup>6</sup> [www.shuukh.mn](http://www.shuukh.mn)



Үргэлжилсэн үйлдэлтэй гэмт хэргийн талаар анхан шатны шүүх буруу дүгнэлт хийх тохиолдол цөөнгүй гардаг бөгөөд шүүх нь Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 2.2 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт заахдаа “...Энэ хуулийн тусгай ангид заасан нэг гэмт хэргийн шинжийг хэд хэдэн удаагийн үйлдэл, эс үйлдэхүйгээр хангасан байвал үргэлжилсэн нэг гэмт хэрэг үйлдсэнд тооцно” гэсэн заалтыг тэр бүр анзаарахгүй байна.

## 1.2. ЦАХИМ ХЭРЭГСЭЛ АШИГЛАЖ БОЛОН ОЛОН ШАТЛАЛТ МАРКЕТИНГ, ПИРАМИД ТОГТОЛЦООНЫ ЛУЙВРЫН АРГААР ҮЙЛДСЭН ЗҮЙЛ АНГИАР ШҮҮХЭЭР ШИЙДВЭРЛЭГДСЭН ХЭРГИЙН ДҮН ШИНЖИЛГЭЭ

**Хэрэг 3. Баянзүрх дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2020 оны 2 дугаар сарын 3-ны өдрийн 199 дугаартай шийтгэх тогтоол.**

### **Хэргийн талаар:**

Т.Т, С.Э нар нь бүлэглэн 2018 оны 9 дүгээр сарын 23-ны өдөр цахим хэрэгсэл ашиглан иргэн Н.Б-гийн фэйсбүүк хаягт нэвтэрч, хохирогч С.Э-гээс “Би Москвад байна, нэг хүний данс руу яаралтай 500,000 төгрөг шилжүүлж өгөөч” гэж зохиомол байдлыг зориудаар бий болгон хуурч Баянзүрх дүүргийн 16 дугаар хорооны нутаг дэвсгэрт байрлах 16 дугаар хорооллын автобусны буудлын хажууд байх “Хаан” банкны АТМ-ээс 500,000 төгрөгийг Э.А-ын дансаар шилжүүлэн авч залилсан;

Т.Т нь 2018 оны 5 дугаар сарын 17-ноос 18-нд шилжих шөнө цахим хэрэгсэл ашиглаж “Ч.С” гэх цахим хаягаас Баянгол дүүрэгт оршин суух хохирогч Д.Г-ээс “...400,000 төгрөг зээлээч” хэмээн зохиомол байдлыг нуун хуурч 400,000 төгрөг шилжүүлэн авч залилсан;

М.Д нь 2018 оны 5 дугаар сарын 17-ноос 18-нд шилжих шөнө Т.Т нь бусдаас фэйсбүүк ашиглан залилж авсан 400,000 төгрөгийг гэмт хэргийн улмаас олж авсан мөнгө гэдгийг мэдсээр байж ашигласан гэмт хэрэгт тус тус холбогджээ.

Баянзүрх дүүргийн прокурорын газраас Т.Т, С.Э нарын үйлдлийг Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 2.2 дугаар зүйлийн 3 дахь хэсэг, 3.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, 3.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасныг тус тус журамлан тусгай ангийн 17.3 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар, М.Д-гийн үйлдлийг Эрүүгийн хуулийн тусгай ангийн 18.6 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар тус тус зүйлчлэн яллах дүгнэлт үйлдэж, хэргийг шүүхэд шилжүүлсэн байна.

### **Шүүхийн шийдвэрлэлт:**

Эрүүгийн хуулийн тусгай ангийн 17.3 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан цахим хэрэгсэл ашиглан, зохиомол байдал зориудаар бий болгон залилах гэмт хэрэг үйлдсэн, шүүгдэгч М.Д-г Эрүүгийн хуулийн тусгай ангийн 18.6 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан гэмт хэргийн улмаас олсон мөнгө гэдгийг мэдсээр байж ашигласан гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тус тус тооцож, Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 3.7 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасныг журамлан мөн хуулийн тусгай ангийн 17.3 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар Т.Т-г 6 сарын хугацаагаар хорих ялаар, С.Э-г нийтэд тусгай 720 цагийн ажил хийлгэх ялаар тус тус шийтгэж, Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 7.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасныг журамлан мөн хуулийн тусгай ангийн 18.6 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар М.Д-г хорих ял оногдуулахгүйгээр нэг жилийн хугацаагаар тэнсжээ.

Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 5.6 дугаар зүйлийн 3, 4 дэх хэсэгт тус тус зааснаар Т.Т-д оногдуулсан зургаан сарын хорих ялыг нээлттэй хорих байгууллагад эдлүүлэх, Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 5.4 дүгээр зүйлийн 4 дэх хэсэгт



зааснаар нийтэд тустай ажил хийлгэх ялыг биелүүлээгүй бол нийтэд тустай ажил хийлгэх ялын найман цагийн ажлыг нэг хоногоор тооцож хорих ялаар солихыг С.Э-д, мөн хуулийн ерөнхий ангийн 7.1 дүгээр зүйлийн 5 дахь хэсэгт зааснаар тэнссэн хугацаанд энэ хуулийн тусгай ангид заасан санаатай гэмт хэрэг үйлдсэн бол шүүх тэнссэн шийдвэрийг хүчингүй болгож, энэ хуулийн 6.8, 6.9 дүгээр зүйлд заасан журмаар ял оногдуулахыг М.Д-д тус тус тайлбарлаж өгсөн байна.

Түүнчлэн Иргэний хуулийн 497 дугаар зүйлийн 497.1, 510 дугаар зүйлийн 510.1 дэх хэсэгт тус тус зааснаар шүүгдэгч С.Э-гээс 70,000 төгрөг гаргуулан хохирогч С.Э-д олгож, шүүгдэгч Т.Т, С.Э, М.Д нар нь цагдан хоригдсон хоноггүй, энэ хэрэгт эд мөрийн баримтаар хураагдаж ирсэн зүйлгүй, битүүмжлэгдэн ирсэн хөрөнгөгүй, шүүгдэгч Т.Т, М.Д нар бусдад төлөх төлбөргүй, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зардал нэхэмжлээгүй болохыг тус тус дурдаж, шийтгэх тогтоол уншиж сонсгосноор хүчинтэй болох бөгөөд шийтгэх тогтоолд эрх бүхий этгээд давж заалдах шатны шүүхэд гомдол гаргасан, эсэргүүцэл бичсэн тохиолдолд тогтоолын биелэлтийг түдгэлзүүлж, шийтгэх тогтоол хүчин төгөлдөр болтол Т.Т-д авсан цагдан хорих, С.Э, С.Д нарт авсан хувийн баталгаа гаргах таслан сэргийлэх арга хэмжээг тус тус хэвээр үргэлжлүүлэхээр шийдвэрлэжээ.

Давж заалдах шатны шүүхээс “Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 1.7 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт “Шүүх хэргийн бодит байдлыг талуудын мэтгэлцээний үндсэн дээр тогтооно” гэсний дагуу анхан шатны шүүхийн шүүх хуралдааны мэтгэлцээнд тэгш эрхтэй оролцох эрх бүхий яллах болон өмгөөлөх талуудыг оролцуулан, хуульд заасан үндэслэл, журмын дагуу тэдний тайлбар, мэдүүлэг, дүгнэлт, шинжлэн судалсан бусад нотлох баримтад тулгуурлаж, шүүгдэгч Т.Т, С.Э нарыг цахим хэрэгсэл ашиглан, зохиомол байдал зориудаар бий болгон залилах гэмт хэрэг үйлдсэн; шүүгдэгч М.Д-г гэмт

хэргийн улмаас олсон мөнгө гэдгийг мэдсээр байж ашигласан гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тус тус тооцсон нь хэргийн бодит байдалтай нийцжээ Цахим хэрэгсэл ашиглан шүүгдэгч Т.Т, С.Э нар иргэн Н.Б-гийн фэйсбүүк хаягаар хохирогч С.Э-гээс Э.А-гийн дансаар шилжүүлэн 500,000 төгрөг авсан, шүүгдэгч Т.Т-гийн цахим хэрэгслийг ашиглан хохирогч Д.Г-гээс 400,000 төгрөг шилжүүлэн авсан үйлдлүүдийг Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 3.7 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасныг журамлан тусгай ангийн 17.3 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар; шүүгдэгч М.Д нь Т.Т-гийн бусдаас залилж авсан 400,000 төгрөгийг гэмт хэргийн улмаас олж авсныг мэдсээр байж ашигласан үйлдлийг Эрүүгийн хуулийн тусгай ангийн 18.6 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар тус тус зүйлчилсэн нь хууль зүйн үндэслэлтэй бөгөөд Эрүүгийн хуулийг зөв тайлбарлан хэрэглэжээ. Шүүхээс Т.Т-г Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 3.7 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасныг журамлан тусгай ангийн 17.3 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар зургаан сарын хугацаагаар хорих ял шийтгэсэн нь түүний гэмт хэрэг үйлдсэн нөхцөл байдал, үйлдсэн гэмт хэргийн нийгмийн аюулын шинж чанар, хэр хэмжээ, гэм буруугийн хэлбэрт тохирсон байна” гэж дүгнэсэнтэй судлаачид санал нийлсэн болно.

Олон шатлалт маркетинг, пирамид тогтолцооны луйврын аргаар үйлдсэн гэх хүндрүүлэх шинэ нөхцөлийг хууль тогтоогч Эрүүгийн шинэ хуульд нэмж оруулсан нь ашиг олох зорилгоор сүлжээний бизнес нэрийдлээр иргэдийг элсүүлж “Доороо дахин хүн элсүүлбэл оруулсан мөнгөө тэдэн хувиар өсгөж авна” гэхчлэн оргүй хоосон орон зайд мөнгө босгож, их хэмжээний ашиг амлаж байгаа үйлдэл бүхэн гэмт хэрэг болно гэдгийг хуульчилж өгсөн.

Олон шатлалт маркетинг, пирамид тогтолцооны луйврын арга гэдэг нь пирамид хэлбэрийн бүтцийн хүрээнд буюу пирамидын оройгоос доош олон үет шаталсан байдлаар



хүмүүсийг элсүүлэх замаар мөнгөн гүйлгээ буюу орлогыг пирамидын оройд татан төвлөрүүлэх схем буюу хууран мэхлэх онцгой арга юм.

Пирамид тогтолцооны луйвар нь пирамид бүтцийн схемээр бусдыг элсүүлэхийн тулд тодорхой хэмжээний хөрөнгө оруулалт шаардан, бусдыг элсүүлснийх нь төлөө мөнгө өгөх аргад суурилдаг бол олон шатлалт маркетинг нь бараа бүтээгдэхүүнд суурилдаг боловч тэдгээрийг борлуулах сүлжээг пирамид бүтцийн хэлбэрээр хүмүүсийг элсүүлэх, бэлэг, урамшуулал амлах замаар ажиллуулахаас гадна чанарын доголдолтой эсхүл хямд төсөр бараа бүтээгдэхүүнийг өндөр үнээр, их хэмжээгээр борлуулах хэлбэрээр илэрдэг.

Олон шатлалт маркетинг, пирамид тогтолцооны луйврын болон бусад аргаар гэмт хэрэг үйлдэж бусдад их хэмжээний хохирол учруулсан этгээд зарим хохирогчийг дахин төөрөгдүүлж, гэмт үйлдлээ иргэний шинжтэй маргаан хэмээн үзэж, иргэний хэргийн шүүхийн шийдвэр гаргуулсан тохиолдол цөөнгүй байна. Иргэний хэргийн шүүхийн шийдвэр гарснаар энэ нь залилах гэмт хэргийн шинжийг үгүйсгэх буюу өмчлөх эрхийг сэргээхгүй байх эсхүл эрүүгийн хариуцлагаас чөлөөлөх үндэслэл болохгүй. Харин залилах гэмт хэргийн шинжийг нотолсон баримтуудын хүрээнд шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас өмнөх иргэний хэргийн шүүхийн шийдвэрийг дахин хянуулах үндэслэл, шаардлага үүсдэгийг анхаарах учиртай.

Олон шатлалт маркетинг, пирамид тогтолцооны луйврын аргаар үйл ажиллагаа явуулахыг Монгол Улсад 2001 онд хориглосон. Тухайлбал, аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуульд “Олон шатлалт маркетинг буюу пирамид тогтолцооны замаар хууран мэхэлж ашиг хонжоо олох үйл ажиллагаа явуулах”-ыг хориглосон байдаг. 2015 онд баталсан Эрүүгийн хуульд олон шатлалт маркетинг, пирамид



тогтолцооны луйврын арга ашиглан залилах гэмт хэрэг үйлдсэн бол 5-12 жил хүртэлх хугацаагаар хорих ял шийтгэхээр зохицуулсан.

Манай улсын хувьд 1994 оноос сүлжээний анхны луйвар хэвлэл мэдээллийн хэрэгслээр дэлгэгдэж, олон зуун хүн хохирогч болж байсан түүх сүүлийн 25 жилийн хугацаанд олонтаа давтагдаж байна. Сүүлийн жишээ нь, гаднын хөрөнгө оруулалттай гэх “GOLDEN TIME” хэмээх компанийн нэр дор Казахстан Улсын иргэд манай 10,000 гаруй иргэнийг залилж, захирал Марат гэгч нь улсын хилээр 6.0 тэрбум төгрөг цүнхэлчихсэн гарах гэж байсныг баривчлан шалгаж байсан боловч хуулийн байгууллагын ажилтнуудын хуйвалдаанаар суллан явуулсан байдаг. Тухайн этгээд улсын хил даван оргон зайлсны улмаас 12,000 хохирогчтой энэ хэргийг өнөөдөр ч шүүхээр эцэслэн шийдвэрлэж чадахгүй гацсаар байна<sup>7</sup>.

Олон шатлалт маркетинг, пирамид тогтолцооны луйврын арга ашиглан үйлдэж буй гэмт хэрэгтэй холбогдуулан дэлхийн олон оронд *Ponzi* (пирамид) схемийн аргаар үйл ажиллагаа явуулахыг хориглосон байдаг. Энэ аргыг ашиглан үйл ажиллагаа явуулсан анхны тохиолдол 1920 онд АНУ-д бүртгэгджээ. Тухайн үед АНУ-ын иргэн Чарльз Понзи гэгч этгээд Бостон хотод хүмүүсээр шуудангийн тасалбар худалдан авхуулж, түүнийгээ эргээд бусдад борлуулах замаар мөнгө төвлөрүүлэх “хачин” төлөвлөгөө зохиосон байна. Тэрбээр сүүлд элсэн орсон хөрөнгө оруулагчдын мөнгөөр өмнөх хөрөнгө оруулагчдынхаа мөнгийг төлөх арбитрын төсөл санаачилж, үүнийгээ өөрийн нэрээр “Ponzi схем” гэж нэрлэн 90 хоногийн дотор хөрөнгө оруулагчдын мөнгийг хоёр дахин өсгөж өгөх нэрийдлээр мөнгө төвлөрүүлсэн байдаг. *Ponzi* схем дампуурахаас долоон сарын өмнө 30,000 хөрөнгө оруулагчаас 8,000,000 ам. доллар цуглуулсан тэрээр энэ үйлдлийнхээ төлөө

<sup>7</sup> <https://mongolia.hss.de/mn/>



14 жил хорих ялаар шийтгүүлсэн юм.

Монгол Улсын хувьд пирамид тогтолцоо, луйврын арга ашиглан бусдын эд хөрөнгийг залилах гэмт хэрэг анх 1998 онд цагдаагийн байгууллагад бүртгэгдсэн. Тухайн үед “Шинэ санаа төв” төрийн бус байгууллагаас үйл ажиллагааныхаа чиглэлийг “Иргэдийн шинэ санаачилгыг дэмжих зорилготой, нийгэмд үйлчилдэг төрийн бус байгууллага” гэж бүртгүүлэн, “хөрөнгө оруулалт” нэрээр пирамид тогтолцооны луйврын арга ашиглан, 2,000 гаруй иргэнээс 1,4 тэрбум төгрөг төвлөрүүлэн 1,200 орчим хүнд 920,000,000 төгрөгийн хохирол учруулсан байдаг.

2012-2019 онд олон шатлалт маркетинг, пирамид тогтолцооны луйврын арга ашиглан хууль бус үйл ажиллагаа явуулж байсан 27 аж ахуйн нэгжийн үйл ажиллагааг таслан зогсоож 7,600 орчим иргэнд 4.5 тэрбум төгрөгийн хохирол учруулсан 36 хүнд холбогдох хэргийг цагдаагийн байгууллага шалган, гэм буруутай нь шүүхээр тогтоогдсон этгээдэд зохих ял шийтгэл оногдуулжээ.

Энэ төрлийн гэмт хэргийн улмаас хохирсон хүн, хохирлын хэмжээг тооцож үзэхэд нийт 35,000 гаруй иргэнд 56,5 тэрбум төгрөгийн хохирол учирсан гэсэн тооцоо гарсан байна. Хохирсон иргэдийн 40-45 хувь нь 22-30 насны залуучууд байсан бол нийт элссэн хүмүүсийн 75 хувь нь эмэгтэйчүүд байв.

Олон шатлалт маркетинг, пирамид тогтолцооны арга ашиглан явуулж байгаа үйл ажиллагаанд элссэн нийт хүмүүсийн 16-20 хувь нь ямар үйл ажиллагаанд оролцож байгаагаа мэдэхгүйгээр зөвхөн ашиг хонжоо бодож гишүүнээр бүртгүүлсэн бол нийт элссэн хүмүүсийн 15-20 хувь нь ашиг, урамшуулал хүртэж, 80-88 хувь нь ямар нэгэн урамшуулал, ашиг хүртэхгүй хохирсон гэсэн тоон мэдээлэл байна.

Олон шатлалт маркетинг, пирамид тогтолцооны аргыг дан ганц бэлэн мөнгө байршуулан хүн элсүүлэх, улмаар

урамшуулал авах хэлбэрээр ашиглаж байгаа биш, сүүлийн жилүүдэд “хөрөнгө оруулалт” нэрээр мөнгө өсгөх, бусдад өндөр хувьтай хүү амлах зэрэг үйл ажиллагааг пирамид тогтолцооны арга ашиглан явуулж байгаа нь ажиглагдах болсон. Энэ нь Монгол Улсад тусгай зөвшөөрлийн үндсэн дээр эрхлэх санхүүгийн үйл ажиллагааг хууль бусаар явуулсан байж болохоор харагдаж байгаа. Тэгвэл энэ төрлийн харилцааг 2017 онд батлагдсан Зөрчлийн тухай хуулиар “Санхүүгийн үйл ажиллагааг хууль бусаар эрхэлсэн буюу хадгаламж, зээл, төлбөр тооцоо, даатгал, даатгалын мэргэжлийн оролцогчийн эсхүл хуульд заасны дагуу зөвшөөрөл, тусгай зөвшөөрөлтэй явуулах санхүүгийн бусад үйл ажиллагааг зөвшөөрөлгүйгээр эсхүл хууль бусаар явуулсан бол хууль бусаар олсон хөрөнгө, орлогыг хураан, учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж иргэнийг 300 нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг 3000 нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно” гэсэн зохицуулалттай.

Гол асуудал нь сүлжээнд эхэлж элссэн иргэн өөрийн ойр дотны хүмүүс, найз нөхөд, хамаатан саданг элсүүлдэг бөгөөд дараа нь залилангийн хэрэг үүссэн хойно “Эхний элсүүлсэн иргэнийг хохирогч гэх үү, яллагдагч гэх үү эсвэл иргэний хариуцагч гэх үү?” гэсэн хүндхэн асуудал үүсдэг. Мэдээж, хохирсон иргэд сүлжээний эздэд биш, өөрийн танил, найз, хамаатанд итгэсэн бөгөөд энэ хандлагаараа өөрийг нь элсүүлсэн хүнийг буруутгаж яллагдагчаар татахыг шаарддаг. Гэтэл эхний элсүүлсэн хүн өөрөө хууртсан, өөрийн оруулсан хөрөнгийг өсгөж авахын тулд бусдыг элсүүлсэн байдаг учир оруулсан мөнгөө олж авсан тохиолдолд түүнийг иргэний хариуцагчаар татаж, эд хөрөнгийн хариуцлага хүлээлгэх нь шударга ёсонд нийцнэ.

Харин бараа худалдах ил маркетинг буюу Орифлейм, Хербалайф зэрэг компани нь манай улсад бүртгэлтэй компанийн хэлбэрээр үйл ажиллагаа явуулдаг. Тэд иргэдийн



мөнгийг зүгээр авдаггүй, бараагаа зарж борлуулдаг учир сүлжээний луйвар гэж үзэж хараахан болохгүй юм.

“Зохион байгуулалттай гэмт бүлэг” гэдгийг Эрүүгийн хуулийн 3.5 дугаар зүйлд “...гэмт хэрэг байнга үйлдэж ашиг олох зорилгоор урьдчилан нэгдсэн гурав, түүнээс олон хүний тогтвортой нэгдлийг зохион байгуулалттай гэмт бүлэг гэнэ” гэж хуульчилжээ. 2002 оны Эрүүгийн хуульд байсан “зохион байгуулалттай бүлэг” болон “гэмт бүлэглэл” гэсэн хоёр ойлголтыг нэгтгэж “Зохион байгуулалттай гэмт бүлэг” гэж үзэх ба “ашиг олох зорилготой, гэмт хэрэг байнга үйлддэг, урьдчилан нэгдсэн, гурваас дээш тооны хүн байх, тогтвортой нэгдэл” гэсэн таван шинж агуулж байхаар хуульчилжээ.

### 1.3. ЗАЛИЛАХ ГЭМТ ХЭРГИЙГ ЦАГААТГАХ ТОГТООЛЫН ДҮН ШИНЖИЛГЭЭ

**Хэрэг 4. Сүхбаатар дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2017 оны 8 дугаар сарын 21-ний өдрийн 274 дүгээр цагаатгах тогтоол, Нийслэлийн Эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүхийн 2017 оны 11 дүгээр сарын 9-ний өдрийн 774 дүгээр магадлалтай, Б.С-д холбогдох 201725020252 дугаар бүхий эрүүгийн хэрэг.**

#### **Хэргийн талаар:**

Прокуророос Б.С нь шууд санаатай, шунахайн сэдэлтээр 2016 оны 9 дүгээр сарын 25-ны өдөр Сүхбаатар дүүргийн 1 дүгээр хороо, Үндэсний соёл амралтын хүрээлэнгийн хашаан дотор иргэн Х.С-д “БНХАУ-ын иргэнд төмөр гантель үнэд хүргэн 150,000,000 төгрөгөөр зарж өгнө” гэж бодит байдлыг гуйвуулан нэг талдаа “24”, нөгөө талдаа “СССР” гэсэн бичигтэй төмөр гантелиг 50,000,000 төгрөгөөр худалдан авхуулж онц их хэмжээний хохирол учруулсан байна. 2002 оны Эрүүгийн хуулийн тусгай ангийн 148 дугаар зүйлийн 148.4 дэх хэсэгт

зааснаар уг гэмт хэрэгт хэрэгтэн яллагдах үндэслэлтэй гэж үзэн хэргийг шүүхэд шилжүүлжээ.

### **Шүүхийн шийдвэрлэлт:**

Анхан шатны шүүх Б.С-д холбогдох хэргийн бүхий л асуудлыг шалгасан боловч шүүхийн хэлэлцүүлэгт өгсөн хохирогч Х.С-ийн “50,000,000 төгрөгийг Т.Х (З гэх) гэгчид өөрөө тоолж хүлээлгэн өгсөн, мөн гантель авахад зарцуулсан мөнгө ОХУ-ын иргэнийх байсан” гэсэн мэдүүлгээр Б.С нь Х.С-ийг залилсан гэмт хэрэг үйлдсэн эсэх нь эргэлзээтэй болжээ. Иймээс Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 1.15 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасан “Эрүүгийн хэрэгт хамааралтай бүхий л нотлох баримтыг шалгасан боловч шүүгдэгчийн гэм буруутай эсэхэд эргэлзээ гарвал түүнийг шүүгдэгчид ашигтайгаар шийдвэрлэнэ” гэсний дагуу Б.С-ийг цагаатгаж, хэргийг прокурорт буцааж шийдвэрлэсэн байна.

Сүхбаатар дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх 2015 оны Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 1.9 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасныг журамлан Б.С-д Сүхбаатар дүүргийн прокурорын газраас 2002 оны Эрүүгийн хуулийн тусгай ангийн 148 дугаар зүйлийн 148.4 дэх хэсэгт зааснаар яллах дүгнэлт үйлдсэнийг 2015 оны Эрүүгийн хуулийн тусгай ангийн 17.3 дугаар зүйлийн 2.2 болгон өөрчлөн зүйлчилж, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 1.15 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт зааснаар Б.С-ийг цагаатгаж, эрүүгийн 201725020252 дугаартай хэргийг Сүхбаатар дүүргийн прокурорын газарт буцаан шийдвэрлэжээ.

Нийслэлийн Эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүх цагаатгах тогтоолыг хүчингүй болгож, Б.С-д холбогдох эрүүгийн хэрэгт шүүхийн урьдчилсан хэлэлцүүлэг явуулахаар Сүхбаатар дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхэд буцааж шийдвэрлэсэн байна.



### **Дүн шинжилгээ:**

Давж заалдах шатны шүүх Б.С-ийг анхан шатны шүүх гэм буруугүй гэж дүгнэсэн нь хэргийн бодит байдалтай нийцээгүй, дүгнэлтэд онцгой ач холбогдол бүхий нотлох баримт харилцан зөрүүтэй байхад аль нэгийг нь авахдаа бусдыг нь хэрхэн үгүйсгэсэн тухай үндэслэлийг тогтоолдоо заагаагүй, Т.Х (З гэх) нь энэ гэмт хэрэгт оролцоотой талаар хохирогч Х.С, гэрч Б.Н, шүүгдэгч Б.С нар мэдүүлсээр байхад Б.С, Т.Х нарын гэмт хэрэгт хамтран оролцсон нөхцөл байдлыг нарийвчлан шалгаж тогтоолгүйгээр Т.Х-гийн үйлдлийг хэрэгсэхгүй болгосон нь хууль ёсны эсэхэд дүгнэлт хийлгүй, дүгнэлтэд нөлөөлж болох нөхцөл байдлыг анхаарч үзэлгүй орхигдуулсан гэж үзэж анхан шатны шүүхийн цагаатгах тогтоолыг хүчингүй болгон, хэргийг шүүхийн урьдчилсан хэлэлцүүлэгт буцаажээ.

Б.С нь бусдыг залилах гэмт хэрэг үйлдсэн нь тогтоогдсон боловч энэхүү гэмт хэрэгт Т.Х гэгч хамтран оролцсон талаар гэрч, хохирогч, шүүгдэгчид нь удаа дараа мэдүүлсээр байхад шүүгдэгчийг цагаатгахдаа үндэслэл бүхий дүгнэлт хийгээгүй, яллах талын ямар нотлох баримтыг үгүйсгэсэн, няцаасан болох нь тодорхойгүй, хууль ёсны шаардлага хангаагүй байна.

Б.С, Т.Х нарын хэнийх нь оролцоотойгоор хохирогч Х.С бусдад хууртагдаж 50,000,000 төгрөгийг Т.Х-д өгсөн талаар үйл баримтад тэдний хамтран оролцооны тухай огт дүгнэлт хийлгүйгээр Т.Х-гийн үйлдлийг прокурорын шатанд хэрэгсэхгүй болгосон нь хэргийн бодит үнэнд нийцээгүй гэсэн давж заалдах шатны шүүхийн дүгнэлт үндэслэлтэй байна.

Мөрдөн байцаалт, прокурорын шатанд гэмт хэрэгт хамтран оролцсон байж болох этгээдүүдээс хэн нэгнийг нь ийнхүү хууль зүйн үндэслэл бүхий дүгнэлт хийлгүйгээр хэрэгсэхгүй болгосон тохиолдолд хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байх, гэм буруутай эсэхийг гагцхүү шүүх тогтоох Үндсэн хууль болон Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн заалт,

зарчим алдагдах бөгөөд давж заалдах шатны шүүхийн магадлал, хяналтын шатны шүүх хуралдаанд оролцсон прокурорын дүгнэлт бүхэлдээ хууль зүйн үндэслэлтэй гэж үзсэн.

**Хэрэг 5. Сэлэнгэ аймаг дахь сум дундын Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2019 оны 9 дүгээр сарын 27-ны өдрийн 164 дүгээр цагаатгах тогтоол, Сэлэнгэ аймгийн Эрүү, Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн 2019 оны 12 дугаар сарын 4-ний өдрийн 92 дугаар магадлалтай, Б.Б-д холбогдох 1831003410126 дугаартай эрүүгийн хэрэг.**

**Холбогдох хэргийн талаар:**

Б.Б нь Сэлэнгэ аймгийн Сүхбаатар сумын 4 дүгээр багийн нутаг дэвсгэрт байрлах “Э” ХХК-ийн захирал Д.З-тэй фидуциар хангагдсан зээлийн гэрээ байгуулах нэрээр халхавчлан, урьдын харилцааны явцад бий болсон итгэлийг урвуулан ашиглаж 2017 оны 10 дугаар сарын 16-ны өдөр 3,000,000 төгрөг, 2018 оны 3 дугаар сарын 12-ны өдөр 4,000,000 төгрөг тус тус бэлнээр авч залилсан гэмт хэрэгт холбогджээ.

**Шүүхийн шийдвэрлэлт:**

Сэлэнгэ аймаг дахь сум дундын Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх Б.Б-д холбогдох Эрүүгийн хуулийн тусгай ангийн 17.3 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан гэмт хэргийг Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 34.19 дүгээр зүйлийн 1.1-д заасан “гэмт хэргийн шинжгүй” гэсэн үндэслэлээр хэрэгсэхгүй болгож, Б.Б-г цагаатгаж шийдвэрлэсэн байна.

Сэлэнгэ аймгийн Эрүү, Иргэний хэргийн давж заалдах шатны шүүх анхан шатны шүүхийн цагаатгах тогтоолыг хүчингүй болгож, хэргийг прокурорт буцаан шийдвэрлэжээ.

**Дүн шинжилгээ:**

Б.Б нь “Э” ХХК-ийн Сэлэнгэ аймаг дахь салбараас 2017 оны 10 дугаар сарын 16-ны өдөр өөрийн эзэмшлийн “Тоёота Эстима”



загварын 30-20 СЭҮ дугаартай тээврийн хэрэгсэл барьцаалж 3,000,000 төгрөг, 2018 оны 3 дугаар сарын 12-ны өдөр “Тоёота Альфард” загварын 55-52 СЭҮ дугаартай тээврийн хэрэгсэл барьцаалж 4,000,000 төгрөг тус тус зээлж, зээлийн гэрээний дагуу дээрх тээврийн хэрэгслүүдийг “Э” ХХК-ийн эзэмшилд улсын бүртгэлд бүртгүүлэх замаар шилжүүлсэн атлаа “мотор цохисон” гэх шалтгаанаар “Тоёота Эстима” загварын тээврийн хэрэгслийн арлын болон улсын бүртгэлийн дугаарыг өөрчлөн иргэн Д.Ш-д 1,200,000 төгрөгөөр зарсан, “онхолдсон” гэх шалтгаанаар “Тоёота Альфард” загварын тээврийн хэрэгслийг өөрийнх нь мэдүүлснээр “хотын танихгүй хүнд зарсан” үйл баримт мөрдөн шалгах ажиллагаагаар тогтоогджээ.

Анхан шатны шүүх прокуророос шүүхэд шилжүүлсэн хэргийн хүрээнд шүүгдэгч Б.Б-гийн гэм бурууг хянан хэлэлцэхдээ шүүгдэгчийн үйлдэл нь фидуцийн гэрээг үндэслэн хийгдсэн иргэний эрх зүйн харилцаа гэж дүгнэсэн нь хэргийн жинхэнэ байдалтай нийцээгүй, шүүх хэрэглэх ёсгүй хуулийг хэрэглэсэн гэсэн давж заалдах шатны шүүхийн хууль зүйн дүгнэлт үндэслэл бүхий болжээ.

Фидуцийн харилцаа нь үүргийн харилцаанд гүйцэтгэлийг хангах аргын хүрээнд зохицуулагдах ба зөвхөн Иргэний хуулиар зохицуулагдах үүргийн харилцаагаар тодорхойлогдох үүргийн гүйцэтгэлийг хангах арга юм.

Иргэний эрх зүйн харилцааны гэрээнээс залилангийн гэмт хэргийн ялгагдах гол шинж нь өнгөн дээрээ гэрээ, хэлцэл байгуулсан мэт харагдавч хууль бусаар дүр үзүүлсэн хуурамч гэрээ хэлцэл хийж, бусдаас авсан эд зүйл, мөнгийг буцааж өгөхгүй гэсэн субъектив санаатай, шууд идэвхтэй үйлдэл байна.

“Фидуциар хангагдсан зээлийн гэрээ” байгуулах нэрээр халхавчлах гэдэг нь өнгөн дээрээ хэлцэлтэй байгаа мэт харагдавч хууль бусаар дүр үзүүлсэн хуурамч гэрээ хэлцэл хийж, байхгүй зүйлийг бий болгон тухайн гэрээг шинээр



үйлдэх санаа зорилгыг анхнаасаа илэрхийлж байдаг. Ингэж итгэл үнэмшил төрүүлсний үндсэн дээр бодит байдалд байхгүй нөхцөлд гэрээ үйлдэгдэх юм бол энэ нь гэрээгээр халхавчлах буюу гэрээ хийх замаар залилах нөхцөл байдал бий болно.

Ийм гэрээгээр халхавчилсан гэмт хэргийн санаачлагч, гэрээ байгуулах санал гаргагч нь зээл авагч байна. Гэтэл хохирогч гэх “Э” ХХК нийтэд зар түгээх сурталчилгааны замаар, зөвхөн Б.Б гэж онцлоггүйгээр гэрээ байгуулах санал гаргасан байдаг. Б.Б нь хөдлөх эд хөрөнгө буюу автомашинаа унаж явах нөхцөлтэйгөөр “Э” ХХК-д зөвхөн өмчлөх эрхийг барьцаалсан тул Иргэний хуулийн 157 дугаар зүйлд заасан “Барьцааны зүйлийн талаар талуудын эдлэх эрх, хүлээх үүрэг”-тэй холбоотой асуудал яригдах юм.

Б.Б-гийн үйлдэлд бусдаас авсан мөнгийг буцааж өгөхгүй гэсэн субъектив санаатай, шууд идэвхтэй үйлдэл байхгүй болох нь Эстима маркийн автомашин барьцаалан 3,000,000 төгрөг зээлж, түүний таван сарын хүү болох 931,000 төгрөг, Альфард маркийн автомашин барьцаалан 4,000,000 төгрөг зээлж, түүний нэг сарын хүүд 243,500 төгрөг, мөн мөрдөн байцаалтын ажиллагааны явцад 1,000,000 төгрөгийг үндсэн зээл болон хүүд тус тус төлж барагдуулсан нь баримтаар тогтоогдоно.

Түүнчлэн урьдын харилцааны явцад бий болсон итгэл үзүүлэх үйлдэл нь хохирогч ирээдүйд эд зүйл, өмч хөрөнгөөрөө хохирохыг үл ухааран өөрийн хөрөнгийг гэмт хэрэгтэнд сайн дураараа шилжүүлсэн байдаг онцлогтой. Гэтэл гэрээний талууд харилцан тохиролцож, ирээдүйд гарах эрсдэлийг тооцоолон гэрээ байгуулсан бөгөөд гэрээний харилцаа нь иргэний хууль тогтоомжийн дагуу үүсэж, гэрээний биелэлтийн талаар мэдээлэл солилцон, харилцан гомдлын шаардлага гаргаж, гэрээгээ дүгнэсний эцэст эрсдэлд орсны улмаас үүссэн маргааныг өөрөөр хэлбэл, гэрээний эрсдэлийг залилан мэхлэх гэмт хэрэг гэж үзэхгүй.



Бусад гэмт хэрэгтэй харьцуулахад залилах гэмт хэргийг шүүхээр хянан шийдвэрлэх явцад анхан шатны шүүхээс цагаатгах тогтоол гаргах тохиолдол харьцангуй өндөр байна. Шүүхээр хянан шийдвэрлэсэн хэргийн тав орчим хувийг анхан шатны шүүхээс гаргажээ. Зарим тохиолдолд анхан шатны шүүхээс Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 36.9 дүгээр зүйлийн 1.1, 1.2-т заасан агуулга, үндэслэлүүдийг хангаагүй байхад шүүгдэгчийг цагаатгах тохиолдол гарсаар байна.

Хохирогч тал нь гомдолтой, хохирол барагдаагүй байхад “Гэрээ хийгдсэн, гэрээгээ нотариатаар батлуулсан нь иргэний эрх зүйн шинжтэй маргаанд тооцогдоно” гэсэн агуулгаар шүүх хэргийг хэрэгсэхгүй болгосныг давж заалдах болон хяналтын шатны шүүх сайтар нягталж, дээрх хуулийн зүйл, заалтыг бүрэн хангасан тохиолдолд цагаатгах ёстой.

Шүүх аливаа хэргийг хэлэлцэж, эцэслэн шийдвэрлэсэн тохиолдолд цагаатгах болон шийтгэх тогтоолын аль нэгийг гаргах эрхтэй боловч тэрхүү тогтоол нь хэлбэр болон агуулгын хувьд Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 36.6-36.9 дүгээр зүйлд заасан шаардлагыг хангасан байх ёстой.

Дээрх хэргийг прокурор яллах талын нотлох олон баримтаар нотолж, шүүхэд шилжүүлсэн бөгөөд анхан шатны шүүх үүний эсрэг шүүгдэгчдийг цагаатгахдаа яллах талын нотлох баримтуудыг үгүйсгэж няцаасан дүгнэлт хийлгүйгээр хэргийг хэрэгсэхгүй болгосон нь цагаатгах тогтоолын тодорхойлох буюу шүүхийн дүгнэлт хийх хэсэгт тавигдсан хуулийн шаардлагыг хангаагүй байна. Тухайлбал, цагаатгах тогтоолд яллах талын нотлох баримтыг ямар нотлох баримттай харьцуулахад үгүйсгэгдэж, яллах гэж буй Эрүүгийн хуулийн тусгай ангийн зүйл, хэсэг, заалт хууль зүйн ямар үндэслэлээр няцаагдаж байгаа талаар дүгнэлт хийгээгүй тул уг цагаатгах тогтоол хууль ёсны бөгөөд үндэслэлтэй байх хуулийн шаардлагыг хангаагүй гэж үзнэ. Яллах талын нотлох баримтуудаас урган

гарсан агуулга, үндэслэлийг хэрхэн, юугаар няцааснаас ямар үйл баримт тогтоогдсон, улмаар хууль, эрх зүйн ухамсрыг удирдлага болгож хууль хэрэглээний ямар дүгнэлтэд хүрсэн нь цагаатгах тогтоолд огт тусгагдаагүй байна<sup>8</sup>.

Шүүхээс цагаатгах тогтоол гарсан тохиолдолд Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 36.9 дүгээр зүйлийн 1.1, 1.2-т заасан агуулга, үндэслэлийг тодорхой илэрхийлсэн байхыг шаардах бөгөөд үүнийг хангаагүй тогтоолыг Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 39.8 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1.6 дахь заалтын дагуу ноцтой зөрчилд хамруулан үздэг. Иймээс цагаатгах тогтоолыг хүчингүй болгосон давж заалдах шатны шүүхийн магадлал хууль зүйн үндэслэлтэй гарсан гэж үзлээ.

Анхан шатны шүүх прокуророос шүүхэд шилжүүлсэн хэргийн хүрээнд шүүгдэгч Б.Б-гийн гэм бурууг хянан хэлэлцэхдээ шүүгдэгчийн үйлдэл нь фидуцийн гэрээг үндэслэн хийгдсэн иргэний эрх зүйн харилцаа гэж дүгнэсэн нь хэргийн жинхэнэ байдалтай нийцээгүй, шүүх хэрэглэх ёсгүй хуулийг хэрэглэсэн гэсэн давж заалдах шатны шүүхийн хууль зүйн дүгнэлт үндэслэл бүхий болжээ гэж хяналтын шатны шүүх бүрэлдэхүүн үзжээ.

Анхан шатны шүүх шүүгдэгч С.Э-гийн мэдүүлэгт үндэслэн хэргийг хэрэгсэхгүй болгон цагаатгаж шийдвэрлэсэн нь бусад баримтаар баталгаажгаагүй, дан нотлох баримтаар, ялангуяа шүүгдэгчийн өөрийгөө өмгөөлөх, хамгаалах эрхээс хамааран нотолгооны ач холбогдол нь буурсан ганц нэг баримт сэлтээр хэргийн нөхцөл байдлыг бодитой тогтоох боломж хязгаарлагдмал байдагтай холбоотойгоор эргэлзээ бүхий шийдвэр гэж үзнэ<sup>9</sup>.

Анхан шатны шүүх цагаатгах тогтоолдоо яллах талын нотлох баримтыг ямар нотлох баримттай харьцуулахад ямар

<sup>8</sup> [www.shuukh.mn](http://www.shuukh.mn)

<sup>9</sup> <https://mongolia.hss.de/mn/>



үндэслэлээр үгүйсгэгдэж буюу няцаагдаж байгаа талаар дүгнэлт хийгээгүйн улмаас хэргийг хэрэгсэхгүй болгож буй хууль зүйн дүгнэлт тодорхойгүй болсон байна.

Залилах гэмт хэрэг эхэлсэн, төгссөн цаг хугацааг нарийвчлан тогтоож, дүгнэлт хийх нь эрүүгийн хариуцлага хүлээлгэх, хөөн хэлэлцэх хугацаа дуусах болон эрх зүйн бусад үр дагаварт шууд нөлөөлдөг. Гэтэл шүүх дээрх нөхцөл байдал буюу аль үеэс итгэлийг нь урвуулан зээл авах нэрээр залилах гэмт хэрэг үйлдсэн, хэзээ төгссөн зэрэг эрүүгийн эрх зүйн тодорхой үр дагавар үүсгэдэг нөхцөл байдалд няцаасан дүгнэлт хийлгүйгээр ерөнхийд нь иргэний эрх зүйн зээлийн харилцааны үндэслэл зааж, үйл баримтын болон хууль зүйн дүгнэлтээ хооронд нь огт холболгүйгээр шийдвэр гаргасан байна.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 1.5 дугаар зүйлд “Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явуулж болохгүй тохиолдол” гэж заасан байх ба 1.4 дэх хэсэгт “...тухайн хэргийг урьд нь хэрэгсэхгүй болгосон тогтоол, магадлал хүчинтэй байгаа” гэж заасныг буруу тайлбарлан, хэргийг хэрэгсэхгүй болгож цагаатгах тохиолдол гарчээ.

Практикт хохирогчид эхлээд иргэний хэргийн шүүхэд хандаж хэргийг шийдвэрлүүлдэг, шүүхийн шатанд эвлэрлийн гэрээ байгуулж улмаар шүүхээс эвлэрлийг баталгаажуулсан шийдвэр гарсны дараа гэрээгээ биелүүлээгүй гэх шалтгаанаар цагдаад гомдол гаргах тохиолдол цөөнгүй байдаг. Цагдаагийн байгууллага ихэнх тохиолдолд гомдол хүлээн авахаас татгалздаг, цөөн тохиолдолд эрүүгийн хэрэг үүсгэн шалгасан боловч прокурор, шүүхийн шатанд тэдгээр хэрэг хэрэгсэхгүй болох буюу цагаадсан байна.

1806008010457 дугаартай хэрэгт анхан шатны шүүхээс шүүгдэгчийг гэмт хэрэг үйлдээгүй, гэмт хэргийн шинжгүй гэх үндэслэлээр цагаатгаж шийдсэнийг давж заалдах шатны шүүхээс үндэслэлгүй гэж үзэн анхан шатны шүүхийн цагаатгах

тогтоолыг хүчингүй болгож дахин хэлэлцүүлэхээр буцаасан байна. Гэтэл цагаадсан этгээдийн өмгөөлөгчид хяналтын шатанд хандсан байдаг. Ийм хэргүүдийн хувьд УДШ-ээс 10 тохиолдолд цагаатгах тогтоолыг хүчингүй болгосон магадлал хууль зүйн үндэслэлтэй гэж үзсэн бол таван тохиолдолд нь давж заалдах шатны магадлалыг хүчингүй болгож, анхан шатны шүүхийн цагаатгах тогтоолыг хэвээр баталжээ<sup>10</sup>.

Тухайн хэргийг урьд нь хэрэгсэхгүй болгосон тогтоол, магадлал хүчинтэй байгаа гэдгийг зөвхөн эрүүгийн хэрэгт тухайн хэргийг хэрэгсэхгүй болгосон тогтоол, шийдвэр гэж ойлгоно. Гэтэл мөрдөгч, прокурор, зарим шүүгч “урьд нь хэрэгсэхгүй болгосон тогтоол, магадлал хүчинтэй байгаа” гэдэг ойлголтыг иргэний хэрэгт хамааруулж, үүссэн асуудлыг иргэний шүүхээр шийдвэрлэсэн хэрэг болгон ял завшуулах нь үндэслэлгүй болохыг судлаачдын зүгээс тэмдэглэж байна.

#### 1.4. ИРГЭНИЙ ХЭРЭГ МАРГААНЫГ ЗАЛИЛАХ ГЭМТ ХЭРГЭЭС ЯЛГАН ЗҮЙЛЧИЛЖ БУЙ ШҮҮХИЙН ПРАКТИК, ШИЙДВЭРИЙН ДҮН ШИНЖИЛГЭЭ

**Хэрэг 6. Баянзүрх дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2019 оны 7 дугаар сарын 30-ны өдрийн 1207 дугаартай шийтгэх тогтоол, Нийслэлийн Эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүхийн 2019 оны 9 дүгээр сарын 17-ны өдрийн 941 дүгээр магадлалтай, Ү.С-д холбогдох 201525013077 дугаар бүхий эрүүгийн хэрэгт хийсэн дүн шинжилгээ.**

##### **Хэргийн талаар:**

Ү.С нь 2015 оны 9 дүгээр сараас 11 дүгээр сарын 9-ний хооронд Баянзүрх дүүргийн 16 дугаар хороо, 72 дугаар хотхонд байрлах өөрийн эзэмшлийн газар дээр Б.Ж-тэй барилгын хөрөнгө оруулалтын 178,000,000 төгрөгийн гэрээ байгуулж,

<sup>10</sup> www.shuukh.mn веб хуудас.



гурван давхар барилга бариулах ажил гүйцэтгүүлсэн боловч мөнгөө төлөлгүй 148,495,545 төгрөгийн хохирол учруулсан буюу уг барилгын ажлыг дахин өөр этгээдээр бариулан ашиглалтад оруулж, Б.Ж-гийн хөрөнгө оруулалт хийсэн мөнгийг төлөлгүй залилсан гэх гэмт хэрэгт холбогджээ.

### **Шүүхээс шийдвэрлэсэн байдал:**

Баянзүрх дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх бусдыг хуурч их хэмжээний хохирол учруулсан гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцож, Эрүүгийн хуулийн тусгай ангийн 17.3 дугаар зүйлийн 2.2-т зааснаар Ү.С-д гурван жил хорих ял шийтгэж, уг ялыг нээлттэй хорих байгууллагад эдлүүлж, Иргэний хуулийн 497 дугаар зүйлийн 497.1, 510 дугаар зүйлийн 510.1 дэх хэсэгт зааснаар Ү.С-ээс нийт 83,995,545 төгрөг гаргуулан хохирогч Б.Ж-д олгуулахаар шийдвэрлэсэн байна.

Давж заалдах шатны шүүхээс Ү.С-ийг 2015 оны 9 дүгээр сараас 11 дүгээр сарын 9-ний хооронд Баянзүрх дүүргийн 16 дугаар хороо, 72 дугаар хотхонд байрлах өөрийн эзэмшлийн газар дээр Б.Ж-тэй барилгын хөрөнгө оруулалтын гэрээ байгуулж, гурван давхар барилга бариулах ажил гүйцэтгүүлсэн боловч мөнгийг нь төлөлгүй 148,495,545 төгрөгийн хохирол учруулсан буюу уг барилгын ажлыг өөр этгээдээр дахин бариулан ашиглалтад оруулж, Б.Ж-гийн хөрөнгө оруулалт хийсэн мөнгийг төлөлгүй залилсан гэх гэмт хэрэг үйлдсэн, анхан шатны шүүхийн шийтгэх тогтоол үндэслэл бүхий болсон байна гэж үзээд шийтгэх тогтоолыг хэвээр үлдээж, шүүгдэгч Ү.С, түүний өмгөөлөгчдийн гаргасан давж заалдсан гомдлуудыг тус тус хэрэгсэхгүй болгон шийдвэрлэжээ.

Улсын Дээд шүүхээс Баянзүрх дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2019 оны 7 дугаар сарын 30-ны өдрийн 1207 дугаартай шийтгэх тогтоол, Нийслэлийн Эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүхийн 2019 оны 9 дүгээр

сарын 17-ны өдрийн 941 дүгээр магадлалыг тус тус хүчингүй болгож, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 34.19 дүгээр зүйлийн 1.1-д зааснаар гэмт хэргийн шинжгүй гэсэн үндэслэлээр Ү.С-д холбогдох хэргийг хэрэгсэхгүй болгож, түүнийг цагаатгаж шийдвэрлэжээ.

#### **Дүн шинжилгээ:**

Шүүхийн шийтгэх тогтоол, магадлал нь Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулиар тогтоосон шаардлагыг бүрэн хангахаас гадна эдгээрт дурдсан дүгнэлт нь хэргийн жинхэнэ байдалтай нийцсэн тохиолдолд хууль ёсны ба үндэслэл бүхий байх хуулийн шаардлагыг хангасан гэж үздэг.

Хэрэгт цугларсан нотлох баримтуудыг шинжлэн судалбал Ү.С нь Баянзүрх дүүргийн 16 дугаар хороо, 72 дугаар хотхонд байрлах өөрийн эзэмшлийн газар дээр баригдаж буй барилгын гүйцэтгэлийг бүрэн дуусгах, холбогдох хөрөнгө оруулалт олох зорилгын хүрээнд иргэн Б.Ж-тэй харилцан санал бодол, хүсэл зоригоо чөлөөтэй илэрхийлэн тохиролцож, барилгын хөрөнгө оруулалтын гэрээ байгуулжээ. Улмаар гэрээний үүргийн биелэлт, хугацаа, хөрөнгө оруулалтын дүнгийн хэмжээ зэрэг асуудлаар талуудын хооронд маргаан өрнөсөн байх бөгөөд энэ талаар Б.Ж нь цагдаагийн байгууллагад гомдол гаргаж, прокуророос эрүүгийн хэрэг үүсгэн, Ү.С-ийг Эрүүгийн хуулийн тусгай ангийн 17.3 дугаар зүйлийн 2.2-т заасан “бусдыг хуурч их хэмжээний хохирол учруулсан гэмт хэрэг үйлдсэн” гэж яллах дүгнэлт үйлдэн, хэргийг шүүхэд шилжүүлсэн нь үндэслэлгүй болжээ.

Эрүүгийн хуульд тодорхойлсон гэмт хэргийн бүх шинжийг агуулж буй үйлдэл хийсэн хүнд эрүүгийн хариуцлага хүлээлгэдэг бөгөөд эрүүгийн эрх зүйн онол болон эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны практикт нийгэмд аюултай тодорхой үйлдлийг гэмт хэрэг гэж тодорхойлж буй Эрүүгийн хуульд заасан объектив болон субъектив



шинжүүдийн нэгдлийг ойлгодог. Тодруулбал, энэхүү хоёр шинжийн аль аль нь хангагдсан тохиолдолд гэмт хэрэгт тооцох учиртай бөгөөд дан ганц үр дагаварт түшиглэсэн об'ектив яллах ажиллагааг эрүүгийн эрх зүйн онол, хууль ёсны зарчмаар хориглодог билээ.

Эрүүгийн хуулийн тусгай ангийн 17.3 дугаар зүйлд заасан залилах гэмт хэргийг шүүх шийдвэрлэхдээ гэм буруугийн сэдэл, санаа зорилго, түүнийгээ хэрэгжүүлсэн арга хэрэгсэл, гэм буруутай хүн болон хохирогчийн хувийн байдал, тэдгээрийн хоорондын харилцааны түүх зэрэг нөхцөл байдалд зөв дүгнэлт хийж, яллах болон цагаатгах нотлох баримтыг нэгэн адил цуглуулан, хэргийг бүх талаас нь шалгаж, бүрэн бодитой тогтоосон байвал зохино.

Дуусаагүй барилгын гүйцэтгэл, түүний хөрөнгө оруулалтын гэрээний харилцаанаас үүдэлтэй маргааны шинжийг шүүх буруу тайлбарлаж, гэрээний үүргийн үнэлгээг эс зөвшөөрч маргасан санаа зорилгыг бусдын эд хөрөнгийг буцааж өгөхгүй, хариу төлбөр огт хийхгүй байхаар урьдаас төлөвлөж хэрэгжүүлсэн байдаг залилан мэхлэх гэмт хэргийн субъектив санаатай адилтган буруу дүгнэлт хийснээс иргэний эрх зүйн харилцааны асуудлыг залилах гэмт хэрэгт тооцсон байна.

Ү.С-ийн үйлдэлд хуурч мэхлэх, итгэл эвдэх аргаар бусдын эд хөрөнгийг залилан авах санаа зорилго үгүйсгэгдэж байх бөгөөд тэрээр өөрийн өмчлөлийн барилгад Б.Ж-гийн зүгээс хөрөнгө оруулаагүй эсхүл түүний мөнгийг төлөхгүй гэж маргаагүй бөгөөд гагцхүү барилгын ажлын гүйцэтгэлийн зардал болон түүнд оруулсан бодит хөрөнгийг төлөх хүсэлтэй байгаагаа тогтвортой мэдүүлсэн нь хэрэгт авагдсан бусад нотлох баримтаар давхар батлагдаж байхад түүнийг гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцсон нь хууль зүйн үндэслэлгүй байх тул Ү.С-д холбогдох хэргийг Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 34.19 дүгээр зүйлийн 1.1-д заасныг баримтлан хэрэгсэхгүй болгож, түүнийг цагаатгах нь зүйтэй байна.



Талууд гэрээ байгуулан, гэрээний гүйцэтгэл хангалтгүйгээс шалтгаалан хохирсон тал нь цагдаагийн байгууллагад ханддаг, улмаар мөрдөн байцаалт явуулж гэрээний гүйцэтгээгүй үнийн дүнг хохиролд тооцон хэргийг шүүхэд шилжүүлдэг, шүүх хэргийг хүлээн авч гэм буруутайд тооцон ял оногдуулсан тохиолдол цөөнгүй гарчээ. Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан залилах гэмт хэргийг гэрээний харилцаа үүссэн иргэний эрх зүйн харилцаанаас ялгах онцлог шинж нь гэрээгээр хүлээсэн үүрэг биелэгдэх боломжтой байсан эсэх, гэрээний талууд гэрээний биелэлтийн талаар мэдээлэл солилцон, харилцан гомдлын шаардлага тавьж, гэрээгээ дүгнэн, гэрээний үүргээ харилцан тооцох боломжтой эсэхээрээ ялгагдах юм.

2019/ШЦТ/592 дугаартай шийтгэх тогтоолд байгуулагдсан гэрээг ямар үндэслэлээр хүчин төгөлдөр бус гэж үзсэн нь ойлгомжгүй, Иргэний хуульд заасан “хүчин төгөлдөр бус байх хэлцэл”, “хүчин төгөлдөр бус гэж тооцож болох хэлцэл”-ийн аль алинд хамаарахгүйгээс гадна уг гэрээний гол нөхцөлийн талаар талууд тохиролцож, гарын үсэг зураагүй учраас энэ нь хүчин төгөлдөр бус гэрээ биш, харин гэрээний төсөл гэж ойлгогдохоор байна гэж давж заалдах шатны шүүх дүгнэжээ<sup>11</sup>.

Иргэний эрх зүйн харилцаа тухайлбал, гэрээний харилцаагаар халхавчлан бусдын эд хөрөнгийг залилан мэхэлж авах гэмт хэргийн гол шинж нь гэрээний нөхцөл анхнаасаа биелэх боломжгүй эсвэл тэдгээрийг биелүүлэхийг зориудаар хөсөрдүүлсэн нөхцөлийн дор гэрээгээр шилжүүлэн авсан эд хөрөнгийг өөрийн үзэмжээр захиран зарцуулж буцаан өгөхгүй гэсэн шууд санаатай, идэвхтэй үйлдэл, эс үйлдэхүйгээр үйлдэгдсэн байхыг шаарддаг.

Залилах гэмт хэрэг, иргэний хэрэг хоёрын нийтлэг ба төстэй тал нь:

---

<sup>11</sup> [www.shuukh.mn](http://www.shuukh.mn)



- Хуулиар хамгаалагдсан бусдын өмчлөх эрхэнд халдаж гэм хор учруулсан байдаг;
- Иргэний хэргийн хариуцагч болон залилах гэмт хэрэг үйлдэж байгаа этгээдийн гэм буруутай сэтгэхүйн хандлага нь үйлдэл, эс үйлдэхүйтэй нь нөхцөлдөж байдаг;
- Иргэний хэргийн хариуцагч болон залилах гэмт хэрэг үйлдэж байгаа этгээд нь хэрэг хариуцах чадвартай, эцэстээ хууль зүйн хариуцлага хүлээдэг.

Залилах гэмт хэрэг, иргэний хэрэг хоёрын ялгаатай тал нь:

- Залилах гэмт хэргийн иргэний хэргээс ялгагдах гол шинж нь нийгмийн хор аюулаараа ямагт их, гэрээгээр халхавчилж үүргийн гүйцэтгэлийг биелүүлэхгүй гэсэн санаа, зорилго агуулсан байдаг;
- Иргэний хэрэгт итгэмжлэгдсэн төлөөлөгч, хуулийн этгээд нь залилах гэмт хэргийн субъект байх боломжгүй, иргэний хэргийн харилцаанд оролцогчид тэгш эрхтэй байдаг бөгөөд талуудын харилцан зөвшилцөл дээр тулгуурладаг. Харин залилах гэмт хэрэгт түүнийг үйлдсэн этгээд, нөгөө талаас төрийн хуулийн байгууллага давуу эрхтэй харилцаанд оролцдог;
- Хохирлын хувьд залилах гэмт хэргийн бодит хохирлыг төлүүлэхэд шүүх анхаарал хандуулдаг бол иргэний хэрэгт олох байсан орлого, алданги, мөнгөний хүү зэргийг тооцон гаргуулдаг.

Хохирогчдоос олон зүйл хамаарч байгаа бөгөөд зээлүүлсэн мөнгөө буцаан авч чадахгүй удсан тохиолдолд “Би залилуулсан” гээд цагдаад гомдол гаргадаг, цаад хүн нь “Бизнесийн эрсдэлд орсон, удахгүй төлнө” гээд байхад л залилах гэмт хэрэг гэж зүтгэх нь цөөнгүй. Иргэний маргаан гээд иргэний хэргийн шүүхээр асуудлыг шийдвэрлэх боломж байсаар атал иргэд яагаад заавал цагдаагаар шалгуулахыг

хүсэж байна вэ гэсэн асуултыг судалгаанд оролцсон 20 гаруй иргэнд тавихад тэд:

**Нэгдүгээрт:** Иргэний шүүхэд хандахад тэмдэгтийн хураамж төлдөг нь тэмээн дээр ямааны гарз болдог;

**Хоёрдугаарт:** Иргэний хэргийн шүүх асуудлыг шуурхай шийдвэрлэж чаддаггүй, жил тойрон сунжирдаг, хариуцагч нь шүүхэд ирэхгүй байхад шүүх яаж ч чаддаггүй, хурал хойшлуулаад л байдаг;

**Гуравдугаарт:** Иргэний хэргийн шүүхийн шийдвэр биелэгдэх чадвар муутай, ихэвчлэн хоосон шийдвэртэй хоцордог, харин цагдаагаар шалгуулах нь залилагч этгээд хохирогчоос салахын тулд хохирлыг хурдан төлөх хөшүүрэг болдог учир цагдаагаар шалгуулах сонирхолтой гэж хариулж байна.

Шинэ Эрүүгийн хуулийн үзэл баримтлалаар “Гэмт хэрэг үйлдсэн хүнийг нэг хэрэгт нь нэг л удаа шийтгэнэ” гэсэн зарчмын дагуу өмнөх Эрүүгийн хуульд байсан “онц аюултай гэмт хэрэгтэн”, “ялтай байдал”, “давтан гэмт хэрэг” гэсэн ойлголтуудыг халсан.

Дээрх заалтууд нь гэмт хэрэг үйлдсэн этгээд зохих хариуцлагаа эдэлж дууссаны дараа ч эрхийн хязгаарлалт нь үргэлжилдэг, гэмт хэрэгт дахин холбогдсон тохиолдолд өмнө нь гэмт хэрэг үйлдэж байсан нь хүндрүүлэх нөхцөл болно гэж үздэг, шийдвэр гаргагчдад гэм буруугийн талаар урьдчилсан үзэл бодол төрүүлдэг байсан учир шинэ Эрүүгийн хуулиар дээрх байдал давтагдахааргүй болсон.

Залилан мэхлэх гэмт хэргийн хувьд ч 2002 оны Эрүүгийн хуулийн 148 дугаар зүйлийн 148.2 дахь хэсэгт “...энэ гэмт хэргийг давтан, бүлэглэж, урьдчилан үгсэн тохиролцсон бүлэг үйлдсэн бол” гэсэн хүндрүүлэх гурван нөхцөл байдал байсныг шинэчлэн найруулсан Эрүүгийн хуулиар хасаж хуульчилсан.

Түүнчлэн зөвхөн залилан мэхлэх гэмт хэрэгт төдийгүй



хулгайлах, булаах, завших, дээрэмдэх гэмт хэрэгт шийтгүүлсэн этгээд онц аюултай гэмт хэрэг үйлдсэн бол онц хүндрүүлэхээр заасныг хассан нь дэлхий нийтийн жишигт нийцсэн, хүний эрхийг хангасан дэвшилт алхам болсон гэж судлаачийн хувьд үзэж байна.

Гэрээний харилцаа нь иргэний хууль тогтоомжийн дагуу үүсэж, гэрээний биелэлтийн талаар мэдээлэл солилцож, харилцан гомдлын шаардлага гаргаж гэрээгээ дүгнэж байгаад улмаар эрсдэлд орсноос үүссэн маргаан, гэрээний эрсдэлийг залилан мэхлэх гэмт хэрэг гэж үзэхгүй. Харин гэрээгээр хүлээсэн үүрэг нь биелэгдэх боломжгүй болмогц түүгээр шалтаглаж бусдын эд хөрөнгө эсхүл түүний өмчлөх эрхийг бүгдийг нь юм уу заримыг нь шилжүүлэхгүй байх гэмт санаа зорилго өвөрлөж, үүнийгээ хэрэгжүүлэхийн тулд эзэмшигч, өмчлөгчийг төөрөгдүүлэх замаар хуурч мэхлэх, итгэл эвдэх тодорхой үйлдэл хийсэн нь хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ажиллагааны явцад тогтоогдвол залилан мэхлэх гэмт хэрэг гэж үзэн, эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ.

Байгалийн давагдашгүй хүч, нийгэм, эдийн засгийн харилцааны зохицуулалтын өөрчлөлт, гэнэтийн осол, өвчин эмгэг, хорио цээр зэрэг талуудаас үл шалтгаалах хүчин зүйл буюу нөхцөл байдал урьдчилан тооцоолох боломжгүйгээр гэнэт өөрчлөгдсөний улмаас гэрээний үүрэг биелэгдээгүйг залилан мэхлэх гэмт хэрэг гэж үзэхгүй.

Залилах гэмт хэргийн бүрэлдэхүүний объектив талын шинж болох хуурч мэхлэх буюу итгэл эвдэх нь бусдын эд хөрөнгө эсхүл түүнийг өмчлөх эрхийг өөртөө олж авах санаа зорилго агуулж, үүнд чиглэсэн идэвхтэй үйлдлээр илэрдэг тул хуурч мэхлэх, итгэл эвдэх ямар нэгэн үйлдэл хийгээгүй бол гэмт хэрэгт тооцохгүй. Залилах гэмт хэргийн халхавч болсон гэрээ хэлцэл нь хуурч мэхлэх, итгэл эвдэх аргад үндэслэгдсэн, шунахайн сэдэлтээр, дан ганцаар ашиг олох, гэрээнд оролцогч нөгөө талаа хохироох зорилгоор хийгдсэн байдаг бол иргэний

эрх зүйн гэрээний харилцаа нь талуудын чөлөөт байдал, тэгш эрхэд суурилан, харилцан тодорхой үр дүнд хүрэхэд чиглэдэг учир гэрээ анхнаасаа биелэгдэх бодит боломжгүй байсан нь тогтоогдсон, гэрээний нэг тал үүнийг урьдчилан мэдсээр байж байгуулсан, нөгөө тал (хохирогч) нь мэдээгүй буюу мэдэх боломжгүй байсан бол залилан мэхлэх гэмт хэрэг гэж үзнэ.

Бусдын эд хөрөнгийг “зээл” нэрээр халхавчлан залилан мэхэлж авах нь уг зээлийг буцааж төлөх бодит баталгаагүй, тухайлбал, барьцааны хөрөнгөгүй, хөрөнгө нь байлаа ч эрхийн зөрчилтэй, тухайн эд хөрөнгийг барьцаалах бүрэн эрхгүй этгээд барьцаалсан, түүнчлэн Иргэний хуульд заасан барьцааны гэрээ байгуулах журмыг санаатай зөрчсөн байдаг зэргээр иргэний эрх зүйн зээлийн гэрээнээс ялгагдана.

Гэрээний үүргийн биелэлтийг баталгаажуулах зорилгоор барьцааны гэрээ байгуулахад барьцаалсан эд хөрөнгө нь үүрэг гүйцэтгүүлэгч гэрээний үүргийн шаардлагаа хангуулж авахад ямар нэгэн саад бэрхшээлгүй, боломжтой байх ёстой тул барьцааны эд хөрөнгө үүрэг гүйцэтгүүлэгчийн шаардлагыг анхнаасаа хангах боломжгүй байсан, үүрэг гүйцэтгэгч үүнийг мэдэж байсан ч санаатайгаар нуун далдалсан нь тогтоогдвол залилан мэхлэх гэмт хэрэг гэж үзнэ.

Худалдах-худалдан авах гэрээгээр худалдагч нь биет байдлын доголдолгүй, эрхийн зөрчилгүй эд хөрөнгө, түүнтэй холбоотой баримт бичгийг худалдан авагч буюу хүлээн авагчид шилжүүлэх, худалдан авагч нь тохирсон үнэ хөлс төлдөг бол залилан мэхлэх гэмт хэргийн үед шунахайн сэдэлтээр, өөртөө ашиг олох субъектив санаа зорилгоор чанар муутай эсхүл иж бүрдэл дутуу бүтээгдэхүүн буюу гэрээнд зааснаас цөөн тооны бүтээгдэхүүн нийлүүлэх, үнийг дутуу төлөх зэргээр бусдын эд хөрөнгийг хуурч мэхлэх, итгэл эвдэх аргаар, хууль бусаар шилжүүлж авдгаараа ялгагдана.

Худалдах-худалдан авах, түрээслэх, эд хөрөнгө хөлслөх



гэрээгээр халхавчлан бусдын эд хөрөнгийг залилан мэхэлж авах гэмт хэрэг нь анхнаасаа хууль, гэрээнд заасан эд хөрөнгийг нийлүүлэхгүй, үнэ болон хөлсийг зохих журмаар төлөхгүй байх санаа зорилго агуулж, түүнийгээ хэрэгжүүлсэн байдаг төдийгүй санаатайгаар чанар муутай буюу иж бүрдэл дутуу бүтээгдэхүүн нийлүүлж өөртөө ашиг олсон, төлбөр төлөх боломжтой атлаа зориуд дутуу төлсөн зэрэг хэлбэрээр илэрнэ.

Иргэний хуулийн 56 (Хүчин төгөлдөр бус байх хэлцэл), 57 (Хүчин төгөлдөр бус гэж тооцож болох хэлцэл), 58 (Ноцтой төөрөгдлийн улмаас хийсэн хэлцэл), 59 (Хууран мэхэлж хийсэн хэлцэл), 60 (Хүч хэрэглэж хийсэн хэлцэл) дугаар зүйлд тус тус заасан хэлцлээс үүссэн маргаанд шунахайн сэдэлтээр, бусдын эд хөрөнгө эсхүл түүнийг эзэмших эрхийг хуурч мэхлэх буюу итгэл эвдэх аргаар олж авах гэсэн гэмт санаа зорилго байдаггүй тул эдгээр хэлцлээс үүссэн маргаан болгон гэмт хэрэг болохгүй. Харин дээрх хэлцлүүдээр халхавчлан шунахайн сэдэлтээр хуурч мэхлэх буюу итгэл эвдэх аргаар бусдын эд хөрөнгө эсхүл түүнийг өмчлөх эрхийг хууль бусаар авсан бол залилан мэхлэх гэмт хэрэг гэж үзнэ.

Залилах хэрэг нь бусдын эд хөрөнгө эсхүл түүнийг өмчлөх эрхийг өөрийн мэдэлд авч захиран зарцуулах бодит боломж бүрдсэнээр төгс үйлдэгдсэнд тооцно.

Залилах хэрэг үйлдэхдээ хуурамч баримт бичиг, тамга тэмдэг, хэвлэмэл маягт болон компьютерын программ, сүлжээ, төхөөрөмж зэргийг ашигласан тохиолдолд нийлмэл гэмт хэрэг гэж үзэж захиргааны журмын болон компьютерын мэдээллийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэргээр давхар зүйлчлэхгүй. Харин хуурамч баримт бичиг, тамга тэмдэг, хэвлэмэл маягт болон компьютерын программ, сүлжээ, төхөөрөмж зэргийг мэдсээр байж залилан мэхлэх гэмт хэрэг үйлдэхэд ашиглуулсан этгээдийг энэ хэргийн хамтран оролцогч гэж үзэж эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ.

Залилах гэмт хэргийн улмаас учирсан хохирлын хэмжээг хуурч мэхлэх, итгэл эвдэх аргаар бусдад учруулсан шууд хохирлоор тодорхойлно. Харин шууд бус хохирлыг энэ гэмт хэргийн улмаас учирсан хохирлын хэмжээнд оруулан тооцохгүй бөгөөд түүгээр хэргийн зүйлчлэлийг өөрчлөхгүй.

Хохирогч нь өөрт зайлшгүй орох байсан орлогыг Иргэний хуулийн дагуу нэхэмжлэх эрхтэй бөгөөд ийнхүү гаргасан нэхэмжлэлийг эрүүгийн хэрэгтэй нь хамтатган шийдвэрлэнэ. Иргэний нэхэмжлэлийн тооцоог бүрэн хийх боломжгүй бол Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 122 дугаар зүйлийн 122.3-т зааснаар иргэний хэрэг хянан шийдвэрлэх журмаар нэхэмжлэлээ гаргахыг хохирогчид мэдэгдэнэ.

Бусдын өмчлөх эрхийг хуурч мэхлэх, итгэл эвдэх аргаар олж авсан тохиолдолд уг эрхээр баталгаажсан эд хөрөнгийн зах зээлийн үнэлгээгээр бодит хохирлыг тооцно, эд хөрөнгийн эрхийг үнэлж болохгүй тохиолдолд залилан мэхлэх гэмт хэргийг энгийн бүрэлдэхүүнтэй<sup>12</sup> гэж үзнэ.

Гэрээний харилцаагаар халхавчлан бусдын эд хөрөнгийг залилан мэхэлж авах гэмт хэргийг мөрдөн шалгах, хянан шийдвэрлэхэд хуурч мэхлэх, итгэл эвдэх аргаар бусдын эд хөрөнгө эсхүл эд хөрөнгийн эзэмших эрхийг олж авах гэсэн субъектив санаа зорилготой байсан эсэхийг заавал тогтоосон байвал зохино.

#### 1.5. ШҮҮХЭЭС ЗАЛИЛАХ ГЭМТ ХЭРЭГТ ОНОГДУУЛЖ БАЙГАА ЯЛЫН ТӨРӨЛ, ХЭМЖЭЭ БА ҮР НӨЛӨӨ

**Хэрэг 7. Баянгол дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2020 оны 9 дүгээр сарын 25-ны өдрийн 843 дугаартай шийтгэх тогтоол.**

<sup>12</sup> <https://mongolia.hss.de/mn/>



Шүүгдэгч Х.Э 2018 оны 6 дугаар сард орон сууц захиалгаар барих гэрээ, “...” ХХК-ийн төлбөрийн үүргээс чөлөөлсөн баримт бичгүүдийг хуурамчаар үйлдэж улмаар хуурамч гэдгийг мэдсээр байж 2018 оны 6 дугаар сарын 21-ний өдөр Баянгол дүүргийн Улсын бүртгэлийн хэлтэст хандаж ашигласан;

Мөн “...” 2018 оны 12 дугаар сарын 3-ны өдрийн 18/242 тоот ББСБ-ын төлбөрийн үүргээс чөлөөлсөн гэх баримт бичгийг хуурамч гэдгийг мэдсээр байж 2018 оны 12 дугаар сарын 10-ны өдөр Баянгол дүүргийн Улсын бүртгэлийн хэлтэст ашиглаж, Баянгол дүүргийн 6 дугаар хорооны нутаг дэвсгэрт байрлах “...” хотхоны 52 А байрны “...” ХХК-ийн өмчлөлийн 27, 54, 6, 62 тоот дөрвөн орон сууцны үл хөдлөх эд хөрөнгө өмчлөх эрхийн гэрчилгээг өөрийн нэр дээр гаргуулан авсан;

2017 оны 8 дугаар сарын 28-ны өдөр Баянгол дүүргийн 6 дугаар хорооны нутаг дэвсгэрт барьсан “...” хотхоны 52А байрны 27, 54, 6, 62 тоот, нийт 1,030,707,500 төгрөгийн үнэ бүхий “...” ХХК-ийн эзэмшлийн дөрвөн орон сууцыг худалдан авах гэж захиалах маягаар урьдчилгаанд нь 8,000,000 төгрөг төлж итгэл төрүүлэн хуурч, гэрээгээр халхавчлан бодит байдлыг нуух замаар бусдыг төөрөгдөлд оруулж, дээрх дөрвөн орон сууцны үл хөдлөх хөрөнгө өмчлөх эрхийн бичгийг хуурамч баримт бичиг ашиглан өөрийн нэр дээр гаргуулан авч залилсан;

2017 оны 8 дугаар сарын 28-ны өдөр Баянгол дүүргийн 6 дугаар хорооны нутаг дэвсгэрт байрлах “...” хотхоны 52А байрны 27 тоот 69,35 м.кв гурван өрөө орон сууцыг өөрийнх хэмээн иргэн Г.М-д итгүүлэн гэрээгээр халхавчлан, зохиомол байдлыг зориудаар бий болгож, хохирогч Г.М-ээс байрны урьдчилгаа төлбөр гэж хуурч 15,000,000 төгрөг шилжүүлэн авч залилсан;

2018 оны 3 дугаар сарын 12-ны өдөр Баянгол дүүргийн 6 дугаар хорооны нутаг дэвсгэрт байрлах “...” хотхоны 52А



байрны 26 тоот 68,01 м.кв гурван өрөө орон сууцыг өөрийнх хэмээн иргэн Б.Н-д итгүүлэн, гэрээгээр халхавчлан, зохиомол байдлыг зориудаар бий болгож, хохирогч Б.Н-ээс байрны урьдчилгаа төлбөр гэж хуурч 20,000,000 төгрөг шилжүүлэн авч залилсан;

2018 оны 1 дүгээр сарын 25-ны өдөр Баянгол дүүргийн 6 дугаар хорооны нутаг дэвсгэрт байлах “...” хотхоны 52А байрны 6 тоот 68,01 м.кв гурван өрөө орон сууцыг өөрийнх хэмээн иргэн Ц.Ө-д итгүүлэн, гэрээгээр халхавчлан зохиомол байдлыг зориудаар бий болгож, хохирогч Ц.Ө-өөс байрны төлбөрт гэж хуурч, 2018 оны 1 дүгээр сараас 2018 оны 11 дүгээр сарын 4-нийг хүртэлх хугацаанд 39,372,000 төгрөг шилжүүлэн авч залилсан;

2018 оны 6 дугаар сарын 29-ний өдөр Баянгол дүүргийн 6 дугаар хорооны нутаг дэвсгэрт байрлах “...” хотхоны 52А байрны 69,35 м.кв гурван өрөө 27 тоот, 92,8 м.кв гурван өрөө 54 тоот, 68,01 м.кв гурван өрөө 6 тоот, 156 м.кв таван өрөө тавилгатай 62 тоот гэсэн дөрвөн орон сууцыг өөрийнх гэж үнэмшүүлэн, эргэлтийн хөрөнгөд 400,000,000 төгрөг шаардлагатай хэмээн “...” ББСБ-д дээрх дөрвөн орон сууцны “үл хөдлөх хөрөнгө өмчлөх эрхийн гэрчилгээ”-г үзүүлж итгүүлэн, гэрээгээр халхавчлан зохиомол байдлыг зориудаар бий болгож, “...” ББСБ-аас 330,000,000 төгрөг шилжүүлэн авч залилсан;

2018 оны 9 дүгээр сарын 7-ны өдөр Баянгол дүүргийн 6 дугаар хорооны нутаг дэвсгэрт байрлах “...” хотхоны 52 А байрны 69,35 м.кв гурван өрөө 27 тоот орон сууцыг өөрийнх хэмээн иргэн М.З-д “үл хөдлөх хөрөнгө өмчлөх эрхийн гэрчилгээ”-г үзүүлж итгүүлэн, гэрээгээр халхавчлан зохиомол байдлыг зориудаар бий болгож, хохирогч М.З-гээс байрны төлбөрт гэж хуурч, 2018 оны 9 дүгээр сарын 7-ны өдрөөс 10 дугаар сарын 26-ны өдрийг хүртэлх хугацаанд 30,439,610 төгрөг



шилжүүлэн авч залилсан буюу “залилах” гэмт хэрэг байнга үйлдэн, амьдралын эх үүсвэр болгож, үргэлжилсэн үйлдлээр нийт 1,465,519,110 төгрөгийн хэмжээний ихээхэн хохирол бусдад учруулсан гэх гэмт хэрэгт холбогджээ.

Баянгол дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхээс Х.Э-г:

- Үүргээс чөлөөлсөн баримт бичиг, тэмдэг, хэвлэмэл маягтыг хуурамчаар үйлдсэн, хуурамч болохыг нь мэдсээр байж ашигласан гэж Эрүүгийн хуулийн тусгай ангийн 23.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар;
- Хуурч, зохиомол байдлыг зориудаар бий болгон, бодит байдлыг нуух замаар бусдыг төөрөгдөлд оруулж өмчлөгчийн эд хөрөнгө, эд хөрөнгийн эрхийг шилжүүлэн авсан, залилах гэмт хэрэг байнга үйлдэж амьдралын эх үүсвэр болгосон гэж Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 2.2 дугаар зүйлийн 3 дахь хэсгийг журамлан тусгай ангийн 17.3 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн 3.1 дэх хэсэгт зааснаар тус тус гэм буруутайд тооцож, нийт 7 жил 11 сарын хугацаатай хорих ял оногдуулан, хаалттай хорих байгууллагад эдлүүлэхээр шийдвэрлэжээ.

#### **Дүн шинжилгээ:**

Х.Э-г “залилах гэмт хэрэг байнга үйлдэж амьдралын эх үүсвэр болгосон” гэж анхан шатны шүүх дүгнэж Эрүүгийн хуулийн тусгай ангийн 17.3 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн 3.1 дэх хэсэгт зааснаар гэм буруутайд тооцон долоон жилийн хорих ялыг хаалттай хорих ангид эдлүүлэхээр шийдвэрлэсэн нь Эрүүгийн хуулийн зүйл, заалтыг буруу тайлбарлаж хэрэглэсэн гэж үзэж байна.

Залилах гэмт хэрэг байнга үйлдэж амьдралын эх үүсвэр болгосон гэх шинж нь тухайн гэмт хэргийг харьцангуй удаан хугацаанд тогтвортой буюу гурав ба түүнээс дээш удаа үйлдэж,

уг гэмт хэргийг үйлдэж олсон орлогоо өөрийн болон гэр бүл, хамаарал бүхий хүмүүсийнхээ амьжиргааг залгуулах гол эх сурвалж эсхүл үйлдвэрлэл, худалдаа, үйлчилгээ зэрэг бусад ашиг олох зорилготой үйл ажиллагааныхаа үндсэн хэрэгсэл, эх үүсвэр болгон, тогтвортой ашигласан байхыг хамааруулсан хууль зүйн ойлголт юм.

Тухайн гэмт хэрэг амьдралынх нь хэвшил болсон, бусдын эд хөрөнгийг шуналын сэдлээр, хууль бус аргаар өөрийн болгож, амар хялбар аргаар ашиг олох боломж байнга эрэлхийлж, үүнийгээ амьжиргааныхаа эдийн засгийн эх үүсвэр болгож байдаг харьцангуй тогтвортой үйлдлийн нэгдэл байдаг.

Залилах нэг гэмт хэргийн шинжийг хэд хэдэн удаагийн үйлдэл, эс үйлдэхүйгээр хангасан, үргэлжилсэн нэг гэмт хэргийг “байнга үйлдсэн” шинжид хүндрүүлэн зүйлчлэх нь Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 1.3 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “...Эрүүгийн хариуцлага нь тухайн хүн, хуулийн этгээдийн үйлдсэн гэмт хэрэг, гэмт хэргийн нийгмийн аюулын шинж чанар, хэр хэмжээ, гэм буруугийн хэлбэрт тохирсон байна” гэсэн шударга ёсны зарчимд үл нийцнэ.

Х.Э нь 2017 оны 8 дугаар сарын 28-нд Баянгол дүүргийн 6 дугаар хорооны нутаг дэвсгэрт барьсан “Блю жем” хотхоны 52 А байрны нийт 1,030,707,500 төгрөгийн үнэлгээтэй, “Өү энд Эн” ХХК-ийн дөрвөн ширхэг орон сууцыг 8,000,000 төгрөгийн урьдчилгаа төлж худалдан авах гэрээ байгуулан эзэмшилдээ авснаар давтагдсан үйлдлээр бусдыг хохироох эх үндэслэл нь тавигджээ. Энэ бүхнээс харахад Х.Э нь хохирогч дөрвөн иргэний мөнгийг “Өү энд Эн” ХХК-ийн захирал Б.О-гийн дансанд шилжүүлсэн, “Өү энд Эн” ХХК-ийн хувьд дөрвөн орон сууцаа эзэмшилдээ авч цаашид худалдан борлуулах боломж нь нээгдсэн учир хохирсон гэж үзэхгүй. Учир нь:

**Нэгдүгээрт,** Х.Э нэг удаагийн алдаатай үйлдлээ залруулахын тулд хохирогчдоос мөнгө авсан хэдий ч уг мөнгөө



“Өү энд Эн” ХХК-ийн захирал Б.О-гийн дансанд шилжүүлж байсан, бусдыг байнга залилж амьдрах гэсэн санаа, шуналын сэдэл тогтоогдоогүй, залилах үйлдэл амьдралынх нь хэвшил болоогүй, амар хялбар аргаар ашиг олох боломжийг байнга эрэлхийлсэн зүйлгүй, орж ирсэн мөнгийг бусдад шилжүүлсэн нь баримтаар нотлогддог. Мөн уг мөнгөөр амьжиргаагаа залгуулаагүй, нөхөр нь ар гэрийн амьдралаа хангалттай авч явдаг зэрэг олон нөхцөл байдлаар түүнийг залилах гэмт хэрэг байнга үйлдэж амьжиргааны эх сурвалж болгосон гэж дүгнэх, хүндрүүлэх бүрэлдэхүүн үгүйсгэгдэж байна.

**Хоёрдугаарт**, анхан шатны шүүх Х.Э-гийн хувийн байдал, бага насны гурван хүүхэдтэй эмэгтэй хүн, эх хүн, анх удаа гэмт хэрэг үйлдсэн зэрэг хөнгөрүүлэх нөхцөл байдлыг харгалзахгүйгээр шууд 7 жил 11 сарын хугацаатай хорих ялыг хаалттай дэглэмд эдлүүлэхээр шийдвэрлэсэн нь хатуудсан ял гэж үзэж байна.

Х.Э-гээс илүү буюу 3,5 тэрбум төгрөгийн хохирол олон иргэнд учруулсан атлаа нэг ч төгрөгийн хохирол төлөөгүй А.У гэгч эмэгтэйд “Бусдыг залилан мэхэлж их хэмжээний хохирол учруулсан” гэж Эрүүгийн хуулийн тусгай ангийн 17.3 дугаар зүйлийн 2.2-т зааснаар хоёр жилийн хорих ялыг нээлттэй дэглэмд эдлүүлэхээр шийдвэрлэсэн (Сүхбаатар дүүргийн ЭХАШШ-ийн 2018 оны 8 дугаар сарын 29-ний өдрийн 644 тоот шийтгэх тогтоол, Нийслэлийн ЭХДЗШШ-ийн 2018 оны 10 дугаар сарын 25-ны өдрийн 979 дугаартай магадлал, УДШ-ийн 2019 оны 2 дугаар сарын 15-ны өдрийн 69 тоот тогтоолоор хэвээр баталсан) зэрэг олон жишээг [shuukh.mn](http://shuukh.mn) веб хуудаснаас харж болно.

**Залилах гэмт хэрэгт ял оногдуулсан байдлын судалгаа**

<b>Эрүүгийн хууль (оноор)</b>	<b>Зүйл, хэсэг</b>	<b>Ялын төрөл, хэмжээ</b>	<b>Судалсан шийдвэр</b>
2002	148 дугаар зүйлийн 148.1 дэх хэсэг	ХХДХ (хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ)-г 5-50 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, 100-250 цаг хүртэлх хугацаагаар албадан ажил хийлгэх эсхүл 1-3 сар хүртэлх хугацаагаар баривчлах	8
2015	17.3 дугаар зүйлийн 1 дэх хэсэг	450 нэгжээс 14,000 нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох эсхүл 240-720 цаг хүртэлх хугацаагаар нийтэд тустай ажил хийлгэх эсхүл 6 сараас 3 жил хүртэлх хугацаагаар хорих	8
2002	148 дугаар зүйлийн 148.2 дахь хэсэг	ХХДХ-г 51-250 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, 3-6 сар хүртэлх хугацаагаар баривчлах эсхүл 2-5 жил хүртэлх хугацаагаар хорих	8
2015	17.3 дугаар зүйлийн 2 дахь хэсэг	10,000-40,000 нэгжтэй тэнцэх төгрөгөөр торгох эсхүл 2-8 жил хүртэлх хугацаагаар хорих	8



2002	148 дугаар зүйлийн 148.3 дахь хэсэг	ХХДХ-г 251-500 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох эсхүл 5-10 жил хүртэлх хугацаагаар хорих	7
2015	17.3 дугаар зүйлийн 3 дахь хэсэг	5-12 жил хүртэлх хугацаагаар хорих	7
Давж заалдах шат			2
Хяналтын шат			2

– *Анхан шатны шүцхээр шийдвэрлэсэн байдал*

а) 2002 оны Эрүүгийн хуулийн 148 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан гэмт хэргийг шийдвэрлэсэн зургаан шийтгэх тогтоолын дөрвийг буюу 66.6 хувийг нь “эвлэрсэн”, “хөөн хэлэлцэх хугацаа дууссан”, “өршөөл үзүүлэх тухай хуульд хамрагдсан” гэх үндэслэлээр хэрэгсэхгүй болгож, үлдсэн хоёр хэрэг дээр буюу 33.4 хувьд нь ХХДХ-г 5, 10 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний торгууль оноож шийдвэрлэсэн байна.

Торгох ялын хэмжээ нь ХХДХ-г дунджаар 5-10 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэж байгаа нь нийт торгох ялын дээд хэмжээ (5-50 дахин)-ний 20 хувьтай тэнцэж байна.

б) Мөн хуулийн 148 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасан гэмт хэрэг үйлдсэн этгээдэд холбогдох найман шийтгэх тогтоол судалснаас 5-6 сар хүртэл баривчлах ял оногдуулсан шийдвэр гурав байна. Түүнээс гадна шүүхийн хоёр шийдвэрт нь хоёр жилийн хугацаагаар хорих ял оногдуулан, биечлэн

эдлүүлэхгүйгээр тэнсэж, мөн шүүхийн хоёр шийдвэрт 2-3 жилийн хугацаагаар хорих ял оногдуулж биечлэн эдлүүлэхээр, эрүүгийн нэг хэргийг Өршөөл үзүүлэх тухай хуульд хамруулан хэрэгсэхгүй болгож шийдвэрлэжээ. Энэ нь тухайн үеийн Эрүүгийн хуульд заасан 2-5 жил хорих ялын хэмжээний дундаж хэмжээгээр ял оногдуулж байсныг илэрхийлж байна.

в) Мөн хуулийн 148 дугаар зүйлийн 148.3 дахь хэсэгт заасан хэргийн шийтгэх долоон тогтоол уншиж судлав. Үүнээс шийтгэх нийт гурван тогтоолоор Өршөөл үзүүлэх тухай хуульд хамруулан хэргийг хэрэгсэхгүй болгож, дөрвөн тогтоолоор 5-8 жилийн хугацаатай хорих ял оногдуулж шийдвэрлэжээ.

г) 2015 оны Эрүүгийн хуулийн 17.3 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан гэмт хэрэгт холбогдох найман шийдвэрийн ялын хэмжээг судлахад нэг хэрэгт 1 жил 9 сарын хорих ял (урьд өмнө үйлдсэн хэргийн шийдвэрт нэмж нэгтгэх замаар), хоёр шийдвэрээр хорих ял оногдуулахгүйгээр нэг жилийн хугацаатай тэнсэж, хянан харгалзахаар, хоёр шийдвэрээр нийтэд тустай ажил хийлгэх ял (300, 400, 420 цаг), мөн гурван шийдвэрээр 450-500 мянган төгрөгөөр торгох ял оногдуулсан байна.

д) Мөн хуулийн 17.3 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасан найман хэргийн шүүхийн шийдвэрийг судлав. Уг зүйлд 2-8 жил хорих ял оногдуулахаар заасан ба шүүхийн нэг шийдвэрээр хоёр жил хорих ял, мөн гурван шийдвэрээр 3-6 жилийн хугацаагаар хорих ял оногдуулж, нийт шийдвэрийн 50 хувьд нь буюу үлдсэн дөрөвт нь 10-12 сая төгрөгийн торгох ял оногдуулсан байна.

е) Мөн хуулийн 17.3 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт зааснаар шийдвэрлэсэн шүүхийн найман шийдвэрийг судалснаас прокуророос яллах дүгнэлт үйлдсэн дөрвөн хэргийн зүйлчлэл өөрчлөгдөж, 17.3 дугаар зүйлийн 1, 2.2 дахь хэсгээр тус тус өөрчлөн зүйлчилж гурван жилийн хорих ял оногдуулж



шийдвэрлэсэн байна. Үүний шалтгаан нь тус тусдаа үйлдэгдсэн олон удаагийн гэмт үйлдлийг шүүхээс нэг гэмт хэргийн шинж агуулсан хэд хэдэн удаагийн үйлдэл гэж үзэн, зүйлчилсэнтэй холбоотой байв. Мөн шүүхийн дөрвөн шийдвэрт 5-11 жилийн хугацаагаар хорих ял оногдуулж шийдвэрлэжээ.

– *Давж заалдах шатны шүүхийн шийдвэрлэсэн байдал*

Эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүхээр хэлэлцэн анхан шатны шүүхийн шийдвэрийг хүчингүй болгож нэмэлт мөрдөн байцаалтад буцаасан хоёр, шүүхийн урьдчилсан хэлэлцүүлэгт буцаасан нэг, шийтгэх тогтоолд өөрчлөлт оруулсан гурав, нийт зургаан шийдвэр судалж үзээд дурдсан үндэслэлийг багцлан харуулбал:

1. Урьд үйлчилж байсан 2002 оны Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 284 дүгээр зүйлийн 284.2 дахь хэсэгт заасан “...хуулийн бүх шаардлагад нийцүүлэн, хуульд үндэслэн гаргасан тогтоолыг хууль ёсны гэж үзнэ” гэсэн заалтад нийцэхгүй байна.
2. Давж заалдах шатны шүүх анхан шатны шүүхийг “Хэрэглэвэл зохих хуулийг хэрэглээгүй буюу Эрүүгийн хуулийг буруу хэрэглэсэн” гэж дүгнэсэн.
3. Мөрдөн байцаалтын ажиллагааг гүйцэд хийгээгүй, нотлогдвол зохих байдлуудыг шалгаж тогтоогоогүй.
4. Мөн 2017 оны Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 36.6 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1.6-д заасан “...шүүгдэгчийн холбогдсон хэрэг Эрүүгийн хуулийн ямар зүйл, хэсэг, заалтад хамаарах...”, 36.7 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн 3.3-т заасан “...урьд сонгосон ялыг шүүхээс хөнгөрүүлж өөрчилсөн бол түүний үндэслэл, тэдгээрийг нотлох баримтын агуулга...”-ыг тусгана гэж заасантай нийцэхгүй байна.



5. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 36.8 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1.6-д зааснаас үзвэл шүүхийн шийдвэрт “хохирол барагдуулах ажиллагааг тодорхой хугацаанд хийх” талаар тусгаж болохоор байсан ч уг хугацааны хэмжээ, хязгаарыг тодорхой хуульчлаагүй байна. Иймд шүүхээс хохирол барагдуулах хугацаа тогтоосон нь үндэслэлгүй гэж үзэн, шийтгэх тогтоолын тогтоох хэсгийн 6 дахь заалтад зохих өөрчлөлт оруулж шийдвэрлэжээ.
6. “Байнга” гэсэн шинжийг буруу хэрэглэсэн гэж үзэн Эрүүгийн хуулийн 2.2 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт заасныг журамлан, зүйлчлэлийг өөрчилж шийдвэрлэсэн байна.

– *Хяналтын шатны шүүхийн шийдвэрлэсэн байдал*

Хяналтын шатны шүүхээр хэлэлцэж баталсан хоёр тогтоолыг судлаад гаргасан үндэслэлийг дурдвал:

1. “Олон хохирогчийг залилсан үйлдэлд “энэ гэмт хэргийг байнга үйлдэж амьдралын эх үүсвэр болгож ашигласан” гэх нөхцөл байдал тогтоогдоогүй, энэ талаар давж заалдах шатны шүүх үндэслэл бүхий хууль зүйн дүгнэлт хийн, хэргийг Эрүүгийн хуулийн 17.3 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар хөнгөрүүлэн зүйлчилж, У.М-д гурван жилийн хорих ял оногдуулсан нь хэргийн жинхэнэ байдалд нийцсэн, шүүхээс оногдуулсан ял гэмт хэрэг үйлдэгдсэн нөхцөл, хохирлын хэр хэмжээ, шүүгдэгчийн хувийн байдалд тохирсон байна. Иймд Чингэлтэй дүүргийн прокурорын бичсэн эсэргүүцлийг хэрэгсэхгүй болгож, шийтгэх тогтоолд өөрчлөлт оруулж шийдвэрлэсэн давж заалдах шатны шүүхийн магадлалыг хэвээр үлдээх нь зүйтэй” гэж үзжээ.
2. Мөн “2015 оны Эрүүгийн хуулийн 17.3 дугаар зүйлийн 3.1-д заасан “энэ гэмт хэргийг байнга үйлдэж амьдралын



эх үүсвэр болгосон” гэх онц хүндрүүлэх шинжийг Эрүүгийн хуульд шинээр хуульчилсан тул Эрүүгийн хуулийн 1.9 дүгээр зүйлд заасан хууль буцаан хэрэглэх зарчмын дагуу 2015 оны Эрүүгийн хуулийг дагаж мөрдөж эхлэхээс өмнө буюу 2017 оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс өмнө үйлдэгдсэн гэмт хэрэгт энэхүү шинжээр хэргийг хүндрүүлэн зүйлчилж болохгүй” гэж дүгнэжээ.

3. Эрүүгийн хэргийг анхан шатны журмаар хянан шийдвэрлэсэн шүүх бүрэлдэхүүн цаашид шийтгэх тогтоол бичихдээ “Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 36.6 дугаар зүйлд заасан шүүхийн шийдвэрийн удиртгал хэсэгт тавигдах шаардлагад нийцүүлж, прокуророос шүүхэд шилжүүлсэн хэргийн товч агуулга, шүүгдэгчийн үйлдлийг Эрүүгийн хуулийн ямар зүйл, хэсэг, заалтад зааснаар зүйлчилж, яллах дүгнэлт үйлдэж ирүүлснээ заавал бичиж байх, энэхүү алдааг дахин давтахгүй байхыг зориуд анхааруулж байна” гэжээ.

Залилах гэмт хэргийн үндсэн бүрэлдэхүүн буюу Эрүүгийн хуулийн тусгай ангийн 17.3 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт 450-10,000 нэгжтэй тэнцэх хэмжээгээр торгох, 240-720 цаг хүртэл нийтэд тустай ажил хийлгэх ял эсвэл зургаан сараас гурван жил хүртэл хугацаагаар хорих гэсэн гурван төрлийн ял оногдуулахаар заажээ.

Анхан шатны шүүх Эрүүгийн хуулийн тусгай ангийн 17.3 дугаар зүйлийн хоёр дахь хэсэгт заасан гэмт хэргийг шийдвэрлэхдээ хохирлоо төлөөгүй, их хэмжээний хохирол учруулсан этгээдэд хэт хөнгөн буюу торгуулийн ял шийтгэж ял завшуулсан тохиолдол олонтаа гарч байна.

Шүүхээс 2018-2020 оны эхний хагас жилд залилах гэмт хэргийг шийдвэрлэхдээ 56 хувьд нь торгох, 15 хувьд нь нийтэд тустай ажил хийлгэх, 12 хувьд нь хорих ял тус тус оногдуулж,

16 хувьд нь хорих ял оногдуулахгүйгээр тэнсэн, хоёр хувийг нь эрүүгийн хариуцлагаас чөлөөлсөн<sup>13</sup> нь ялын үр нөлөө хангалтгүй байна гэж дүгнэхэд хүргэсэн. Торгох ялыг хохирлоо нөхөн төлсөн, торгууль төлөх санхүүгийн боломжтой шүүгдэгчид оногдуулах нь зохистой атал анхан шатны шүүх энэ шалгуурыг харгалзалгүйгээр үзэмжээрээ шийдвэрлэх нь түгээмэл байна.

Хохирогч тал давж заалдсан тохиолдолд давж заалдах шатны шүүхээс анхан шатны шүүхийн шийтгэх тогтоол үндэслэлгүй болохыг зааж шүүхийн урьдчилсан хэлэлцүүлгийн шатнаас дахин хэлэлцүүлэхээр буцаадаг.

Анхан шатны шүүх ял шийтгэл оногдуулахдаа тухайн төрлийн гэмт хэргийн улмаас нийгэмд учирч буй хохирол, хор уршиг зэрэгт анхаарч, эрүүгийн хариуцлага хүлээлгэхдээ ялын бодлогын хувьд анхааран авч үзэх нь Эрүүгийн хууль болон эрүүгийн хариуцлагын зорилгод нийцэх юм.

Эрүүгийн хуулийн тусгай ангийн 17.3 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 2.2-т заасан гэмт хэрэгт бусдад ноцтой эсхүл их хэмжээний хохирол учруулж үйлдсэн бол 10,000 нэгжээс 40,000 нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох эсхүл 2-8 жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэхээр хуульчилсан нь хохирогчийн эрх ашгийг хөндсөн, их хэмжээний хохирол учирсан тохиолдолд ялын бодлого нь хэтэрхий зөөлөн болсон гэж судлаачид дүгнэж байна. Учир нь үүнээс өмнө 2002 оны Эрүүгийн хуулийн тусгай ангийн 148 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт онц их хэмжээний хохирол учруулсан буюу 50,0 сая төгрөгөөс дээш хэмжээний хохирол учруулсан тохиолдолд 10-15 жилийн хорих ял оногдуулдаг байсан бол 2015 оны Эрүүгийн хуулиар залилах гэмт хэрэгт оногдуулдаг ялын бодлого хэтэрхий хөнгөрч 2-8 жилийн хорих ял оногдуулах болон торгуулийн ял эдлүүлэх боломжтой болсныг цаашид хуульд өөрчлөлт оруулах замаар засах шаардлагатай юм.

<sup>13</sup> [www.Judinstutute.mn](http://www.Judinstutute.mn)



201625021333 дугаартай А.У гэгчид холбогдох хэрэгт (3.5 тэрбум төгрөгийн хохиролтой) анхан шатны шүүх Эрүүгийн хуулийн тусгай ангийн 17.3 дугаар зүйлийн 2.2-т зааснаар хоёр жилийн хорих ял оногдуулсныг хяналтын шатны шүүхээс “ял хөнгөдсөн байна” гэж үзэн анхан шатны шүүхийн оногдуулсан хоёр жилийн хугацаатай хорих ялыг гурван жил болгон нэмэгдүүлсэн<sup>14</sup>. Гэсэн ч давж заалдах болон хяналтын шатны шүүх эрүүгийн хэргийг хянан шийдвэрлэхдээ доод шатны шүүхээс оногдуулсан эрүүгийн ял, хариуцлагыг хүндрүүлж болох эрх хэмжээг олгосон Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн холбогдох заалтууд Үндсэн хуульд нийцээгүй хэмээн Үндсэн хуулийн цэц шийдвэрлэснийг хууль тогтоогч хүлээн авч тухайн заалтуудыг хүчингүй болгосноор Улсын Дээд шүүх уг хэргийг дахин хэлэлцэж анхан шатны шүүхийн шийдвэрийг хэвээр үлдээж байх жишээтэй.

Олон иргэнийг хохироож 3.5 тэрбум төгрөгийн хохирол учруулсан, үйлдсэн гэмт хэргээ хүлээн зөвшөөрч гэм буруугаа ухамсарлаагүй, нэг ч төгрөгийн хохирол барагдуулаагүй этгээдэд анхан шатны шүүхээс хуульд заасан хамгийн бага буюу (2-8 жилийн хорих ялтай) хоёр жилийн хорих ял оногдуулж байгаа нь буруу гэдгийг УДШ тогтоолдоо дурдсан байна. Нөгөө этгээд хэрэг УДШ-ээр хянагдаж дууссаны дараахан буюу хоёр жил хоригдох ёстой ч 1.7 жил хоригдоод “ажлын хоног авсан” гэсэн үндэслэлээр хугацаанаасаа өмнө суллагдсан нь шударга ёсны зарчим амьдралд төдий л хэрэгжихгүй байна гэсэн дүгнэлтэд хүрсэн.

Түүнчлэн Сүхбаатар дүүргийн ЭХАШ-ны шүүх нь Б.А-д холбогдох хэргийн нөхцөл байдал, учирсан хохирол, хор уршгийн шинж чанар, гэмт хэрэг үйлдсэн хүний хувийн байдалд үндэслэл бүхий бодитой дүгнэлт хийлгүйгээр түүнд 10,000 нэгжээр торгох шийтгэл оногдуулсан нь Эрүүгийн

<sup>14</sup> [www.shuukh.mn](http://www.shuukh.mn)

хуулийн ерөнхий ангийн 1.3 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан “Эрүүгийн хариуцлага нь тухайн хүн, хуулийн этгээдийн үйлдсэн гэмт хэрэг, гэмт хэргийн нийгмийн аюулын шинж чанар, хэр хэмжээ, гэм буруугийн хэлбэрт тохирсон байна” гэсэн шударга ёсны зарчимд нийцээгүй байна хэмээн давж заалдах шатны шүүх дүгнэн, шийтгэх тогтоолыг хүчингүй болгож шүүх бүрэлдэхүүнийг өөрчлөн дахин хэлэлцүүлэхээр буцаасан байна. Тэгээд ч 1-200 тэрбум төгрөгийн дүн бүхий залилах гэмт хэрэг үйлдэж олон хүнд хохирол учруулсан этгээдэд хохирлоо төлөөгүй байхад нь Эрүүгийн хуулийн тусгай ангийн 17.3 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 2.2-т зааснаар торгох, эсвэл хоёр жилийн хорих ял оногдуулж байгаа нь хэтэрхий хөнгөдсөн ял байх бөгөөд тухайн этгээд гэм буруугаа ойлгож ухамсарлах нь бүү хэл давж заалдах, хяналтын шатны шүүхээр заргалдаж дуусах үед хугацаа нь дуусаж суллагдаж байгааг цаашид Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулан хариуцлагыг чангатгах шаардлагатай юм.

## 1.6. ГАДААДЫН ЗАРИМ ОРНЫ ЭРҮҮГИЙН ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ХАРЬЦУУЛСАН СУДАЛГАА

### **Нэг. ОХУ**

Тус улс нь төрөлжүүлэн нэгтгэсэн Эрүүгийн хуультай бөгөөд эдийн засаг, экологи, татвар, төсөв, захиргааны журам зөрчсөн болон бусад бланкет диспозицтэй хэргүүдийг тусдаа хуулиар бус, материаллаг эрх зүйн нэг л эх сурвалжаар зохицуулдаг онцлогтой.

1996 онд батлагдаж 2002 онд шинэчлэн найруулсан ОХУ-ын Эрүүгийн хуулийн тусгай ангийн 21 дүгээр бүлэг буюу “Өмчийн эсрэг гэмт хэрэг” хэмээх бүлгийн 159 дүгээр<sup>15</sup> зүйлийн 7 хэсэгт “Залилах” үйлдлийг төрөлжүүлэн хуульчилсан байна.

<sup>15</sup> Российское уголовное право, Особенная часть. Под ред. В.Н.Кудрявцева и А.В.Наумова, М., 2011, с.105.

**159 дүгээр зүйл. Залилан мэхлэх (мошенничество)**

1. Залилан мэхлэх буюу бусдын эд хөрөнгө, өмчлөх эрхийг хуурч мэхлэх эсхүл итгэл эвдэх замаар олж авсан бол 120 мянга хүртэл рубль эсхүл ялтны нэг жил хүртэл хугацааны цалин хөлс, бусад орлогын хэмжээгээр торгох эсхүл 360 цаг хүртэл хугацаагаар албадан хөдөлмөр эрхлэх эсхүл хоёр жил хүртэл хугацаагаар эрх чөлөөг хязгаарлах эсхүл дөрвөн сар хүртэл хугацаагаар баривчлах эсхүл нэг жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.
2. Энэ хэргийг урьдчилан үгсэн тохиролцсон бүлэг их хэмжээний хохирол учруулж үйлдсэн бол 300 мянга хүртэл рубль эсхүл ялтны хоёр жил хүртэл хугацааны цалин хөлс, бусад орлогын хэмжээгээр торгох эсхүл хоёр жил хүртэл хугацаагаар засан хүмүүжүүлэх ажил хийлгэх эсхүл нэг жил хүртэл хугацаагаар эрх чөлөөг хязгаарлах эсхүл таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.
3. Энэ хэргийг албан тушаалын байдлаа ашиглаж их хэмжээний хохирол учруулж үйлдсэн бол 100-500 мянга хүртэл рубль эсхүл ялтны нэгээс гурван жил хүртэл хугацааны цалин хөлс, бусад орлогын хэмжээгээр торгох эсхүл таван жил хүртэл хугацаагаар засан хүмүүжүүлэх ажил хийлгэх эсхүл хоёр жил хүртэл хугацаагаар эрх чөлөөг хязгаарлах эсхүл нэгээс зургаан жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

4. Энэ хэргийг зохион байгуулалттай бүлэглэл онц их хэмжээний эсхүл орон байраа алдах хэмжээний хохирол учруулж үйлдсэн бол хоёр жил хүртэл хугацаагаар эрх чөлөөг хязгаарлах юм уу хязгаарлахгүйгээр нэг сая хүртэл рубль эсхүл ялтны гурван жил хүртэл хугацааны хөдөлмөрийн хөлс, бусад орлогын хэмжээгээр торгож 10 жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.
5. Бизнесийн үйл ажиллагааны хүрээнд хүлээсэн гэрээний үүргийг санаатайгаар зөрчиж их хэмжээний хохирол учруулсан бол гурван зуун мянга хүртэл рубль эсхүл ялтны хоёр жил хүртэл хугацааны цалин хөлс, бусад орлогын хэмжээгээр торгох эсхүл 480 цаг хүртэл хугацаагаар албадан ажил хийлгэх эсхүл хоёр жил хүртэл хугацаагаар засан хүмүүжүүлэх ажил хийлгэх эсхүл нэг жил хүртэл хугацаагаар эрх чөлөөг хязгаарлаж таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.
6. Энэ зүйлийн тав дахь хэсэгт заасан хэргийн улмаас их хэмжээний хохирол учирсан бол 100-500 мянга хүртэл рубль эсхүл ялтны гурван жил хүртэл хугацааны цалин хөлс, бусад орлогын хэмжээгээр торгох эсхүл таван жил хүртэл хугацаагаар засан хүмүүжүүлэх ажил хийлгэх эсхүл нэг жил хүртэл хугацаагаар эрх чөлөөг хязгаарлах эсхүл зургаан жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.
7. Энэ зүйлийн тав дахь хэсэгт заасан хэргийг онц их хэмжээтэй үйлдсэн бол хоёр жил хүртэл хугацаагаар эрх чөлөөг хязгаарлах юм уу хязгаарлахгүйгээр нэг сая рубль эсхүл ялтны гурван жил хүртэл хугацааны цалин хөлс, бусад орлогын хэмжээгээр торгож арван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.



Түүнчлэн зээлийн залилангийн хэрэг, төлбөр хүлээн авахдаа залилан хийх, цахим хэрэгсэл ашиглаж залилах, даатгалын салбарт залилан хийх, компьютерын мэдээллийн салбарт залилан хийх гэмт хэргийг тусгайлан зүйлчилж өгсөн байдаг.

### **Хоёр. БНХАУ**

Хятадын эрүүгийн эрх зүй нь харьцангуй хосолмол бөгөөд социалист хэв шинж давамгайлсан байдгаас үүдэн гэмт хэргийн ойлголтыг материалист томъёоллоор тодорхойлсон ч уг институтийг хэрэглэх арга зарчим нь Хятадын гэсэн өвөрмөц онцлогийг тусган илэрхийлсээр иржээ.<sup>16</sup>

1979-2005 онд 22 удаагийн нөхцөлт нэмэлт, засвар орсон бөгөөд тус улс төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгаас зах зээлийн эдийн засагт шилжих явцад тулгарсан асуудлуудыг эрүүгийн эрх зүйгээр зохицуулах зайлшгүй шаардлагыг харгалзан 1997 онд Эрүүгийн шинэ хууль баталсан нь одоо ч хүчин төгөлдөр үйлчилж байна.

Торгуулийн ялыг нэмэгдэл чанартай хэрэглэх бөгөөд өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг үйлдэгсдэд эдийн засгийн хөшүүргийн механизмыг өргөн ашигладаг нь Эрүүгийн хуулийн олон зүйл ангиар хорьж хөдөлмөрлүүлэх, улмаар “зоосоор яллана” хэмээн давхар заасан байдгаас харагдана.

БНХАУ-ын Эрүүгийн хуулийн тусгай ангийн 5 дугаар бүлэгт “өмчийн эсрэг гэмт хэрэг” гэж хуульчилсан байх бөгөөд уг бүлгийн 266 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “...Залилан мэхлэх аргаар улсын болон хувийн өмчийг ашиглан шамшигдуулж үлэмж хэмжээний хор уршиг учруулсан бол гурван жил хүртэл хорих ял шийтгэх, нэмэгдэл ял зоосоор торгох”, мөн зүйлийн 2 дахь хэсэгт “...энэ хэргийн улмаас их хэмжээний хохирол учруулбал эд хөрөнгийг хурааж 3-10 жил хүртэлх хугацаагаар

<sup>16</sup> <http://ru.china-embassy.org/rus/zfhz/zgflyd/t1330730.htm>



хорих ял шийтгээд нэмж зоосоор торгож яллана”, уг зүйлийн 3 дахь хэсэгт “...онц их хэмжээний хохирол учруулсан бол эд хөрөнгийг хурааж 10 жилээс дээш хугацаагүй хорих ялаар шийтгэн, нэмж зоосоор торгох ялыг оногдуулна” гэж тус тус заажээ.

### **Гурав. БНСУ**

Тус улсын Үндсэн хууль, 1953 оны Эрүүгийн, 1954 оны Эрүүгийн процессын хуулиуд нь эрүүгийн эрх зүйн эх сурвалж болно. Эрүүгийн материаллаг болон процессын төрөлжүүлэн нэгтгэсэн хуультай учир эх газрын эрх зүйн бүлд хамаардаг. Мөн эрүүгийн хэргийг мөрдөн шүүх болон мэтгэлцэх зарчмын үндсэн дээр шийдвэрлэдэг онцлогтой. 2016 оны 12 дугаар сарын 20-нд шинэчлэн найруулсан Эрүүгийн хууль нь хүчин төгөлдөр болж үйлчилж эхэлсэн бөгөөд уг хууль 42 бүлэг, 372 зүйлээс бүрддэг. Хэрэг хариуцах нас нь 14 наснаас эхэлдэг бөгөөд манайх шиг зарим гэмт хэрэгт “16 наснаас эхэлнэ” гэсэн өөр шатлал байхгүй.

Хэрэг хариуцах чадваргүй этгээдийг эрүүгийн хариуцлагад татахгүй бөгөөд “хэлгүй, дүлий болон сохор хүн гэмт хэрэг үйлдсэн бол хариуцлагыг хөнгөрүүлнэ”<sup>17</sup> гэсэн заалттай.

Гэм буруугийн хэлбэрийг санаатай ба болгоомжгүй гэж ангилах ба гэм буруугийн андуурал, бодит байдлын андуурал, хууль зүйн андуурлыг Эрүүгийн хуулийн ерөнхий ангидаа тусгасан байна. “Хохирогчийн зөвшөөрлөөр аргагүй байдалд орж түүнд хохирол учруулсныг гэмт хэрэгт тооцохгүй” гэсэн заалттай.

Хамтран оролцогчдын хувьд хамтран гүйцэтгэгч, хатгагч болон хамжигч гэсэн гурван хэлбэр байхаар тусгажээ. Гэмт

<sup>17</sup> [https://ru.qwe.wiki/wiki/Penal\\_code\\_\(South\\_Korea\)](https://ru.qwe.wiki/wiki/Penal_code_(South_Korea))

хэрэгт хатгагчийг гүйцэтгэгчтэй адил, харин хамжигчийг гүйцэтгэгчээс зөөлөн шийтгэхээр хуульчилсан байна.

Давтан гэмт хэргийн талаар Эрүүгийн хуулийн 35 дугаар зүйлд хуульчилсан байх бөгөөд нэг гэмт хэргийг гурван жилийн дотор давтан үйлдвэл рецидивист гэмт хэрэгтэн гэж үзэж тухайн зүйл ангийн хамгийн хатуу ялаар шийтгэх ёстой гэж заажээ.

Хэд хэдэн гэмт хэрэг үйлдсэн тохиолдолд хуульд заасан хорих ялын дээд хэмжээнд багтаан ялуудыг нэмж нэгтгэнэ. Үүнд цаазаар авах ялтай хэрэг байвал багтааж нэгтгэнэ. Энэ ял хуульд нь байгаа ч сүүлийн 20 жил гүйцэтгээгүй байна. Энэ ялыг шүүхийн тогтоол хүчин төгөлдөр болсны дараа Хууль зүйн сайд болон Ерөнхийлөгчийн зөвшөөрлөөр гүйцэтгэнэ. Хуулийн этгээдийг эрүүгийн хариуцлагад татна, согтуурсан буюу мансуурсан үедээ гэмт хэрэг үйлдсэн бол хүлээх хариуцлагыг нь хөнгөрүүлдэг онцлогтой.

Эрх хасах ялыг нэмэгдэл буюу үндсэн ялын чанартай оногдуулдаг, хугацаа нь 1-15 жил хүртэл байх бол баривчлах ялын хувьд 1-30 хоногийн хугацаатайгаар тусгаарлан байрлуулдаг. Торгуулийн ялыг гүйцэлдүүлээгүй нөхцөлд гурван жил хүртэл, зөрчилд оногдуулсан жижиг торгуулийг төлөөгүй бол 1-30 хоног албадан ажил хийлгэх ялаар солино. БНСУ-ын Эрүүгийн хуулийн тусгай ангийн 39 дүгээр бүлэг нь “Залилан мэхлэх болон далайлган сүрдүүлж бусдын өмчид халдах” нэртэй бөгөөд залилангийн гэмт хэргийг доорх гурван зүйл ангид хуваан хуульчилжээ:



**Залилан мэхлэх болон далайлган сүрдүүлж  
бусдын өмчид халдах**

347 дугаар зүйл. Хуурч мэхлэх, бусад аргаар бусдын эд хөрөнгийг авсан бол хохирлын хэмжээнээс хамаарч 20 сая хүртэл воноор торгох буюу 10 жил хүртэлх хорих ялаар шийтгэнэ. Энэ зүйл ангид хуурамч баримт бичгээр хөнгөлөлт эдэлсэн, нийгмийн халамж хүртсэнийг мөн залилах гэмт хэрэгт хамааруулан ойлгодог байна.

348 дугаар зүйл. Компьютер, тусгай хэрэгсэл ашиглан бусдын эд хөрөнгийг хууран мэхэлж авсан гэмт хэрэг үйлдсэн бол хохирлын хэмжээнээс хамаарч 20 сая хүртэл воноор торгох буюу 10 жил хүртэл хорих ялаар шийтгэнэ.

349 дүгээр зүйл. “Мэргэшсэн залилан” гэдэг гарчигтай бөгөөд хүүхэд, сэтгэхүйн хувьд гүйцэд хөгжөөгүй хүнийг хууран мэхэлж эд зүйлийг нь авсан бол 20 сая хүртэл воноор торгох буюу 10 жил хүртэл хорих ялаар шийтгэнэ.

**Дөрөв. ХБНГУ**

Тус улсын Эрүүгийн хуулийн тусгай ангийн 22 дугаар бүлэг нь “Залилах, итгэл эвдэх” гэсэн гарчигтай бөгөөд дотроо 13 зүйл ангид хуваах байдлаар залилан мэхлэх гэмт хэргийг нарийвчлан зохицуулжээ.

### 263 дугаар зүйл. Залилах

1. Өөртөө болон гуравдагч этгээдэд эд хөрөнгийн давуу байдал үүсгэхийн тулд дүр эсгэх эсвэл бодит баримтыг гажуудуулах болон нуун дарагдуулах замаар андуурал бий болгох буюу андууралд хүргэж бусдад хохирол учруулсан бол таван жил хүртэл хугацаагаар хорих юм уу торгох ял шийтгэнэ.
2. Уг гэмт хэргийн завдалтад ял оногдуулна.
3. Онц ноцтой тохиолдлын хувьд 6 сараас арван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ. Онц ноцтой тохиолдол гэдэгт:
  - а) гэмт хэрэгтэн бизнесийн зорилгоор эсвэл хуурамч гэрчилгээ үйлдэх, залилах гэмт хэргийн зохион байгуулалттай бүлгийн гишүүний хувьд үйлдсэн;
  - б) их хэмжээний хохирол учруулсан эсвэл олон тооны хүмүүсийг эд хөрөнгөө алдах эрсдэлд оруулахын тулд залилах гэмт хэргийг байнга үйлдсэн;
  - в) бусдыг санхүүгийн хүнд байдалд оруулсан;
  - г) өөрийн бүрэн эрх, төрийн албан хаагч эсвэл Европын холбооны албан хаагч зэрэг албан тушаалын байдлыг урвуулан ашигласан;
  - д) өөртөө болон бусдад даатгалын тохиолдлыг зохиомлоор бий болгохын тулд үнэ бүхий эд юмыг шатаасан, эсвэл шатаах явцдаа тухайн эд юмсыг бүхэлд нь буюу хэсэгчлэн устгасан, хөлөг онгоцыг живүүлсэн буюу гүехэн усанд суулгасан зэргийг ойлгоно.

4. Энэ зүйлийн өмнөх хэсэгт заасан гэмт хэргийг зохион байгуулалттай гэмт бүлгийн гишүүний хувьд үйлдсэн бол 1-10 жилийн хугацаатай хорих ял, хүндэвтэр тохиолдлын хувьд 6 сараас таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

263а. Компьютерын залилан

1. Өөртөө болон гуравдагч этгээдэд эд хөрөнгийн давуу байдал үүсгэхийн тулд буруу зохион бүтээсэн программаар, худал эсвэл бүрэн бус мэдээллээр, зөвшөөрөлгүй мэдээлэл ашиглан эсвэл үйл явцад зөвшөөрөлгүйгээр нөлөөлөх зэргээр мэдээлэл боловсруулах ажиллагааны үр дүнд нөлөөлж бусдад хохирол учруулсан бол таван жил хүртэл хугацаагаар хорих юм уу торгох ялаар шийтгэнэ.
2. Ийм төрлийн гэмт хэрэг үйлдэх зорилгоор компьютерын программ үйлдвэрлэх, өөртөө олж авах буюу бусад этгээдэд олж өгөх, зарах, хадгалах эсвэл бусдад үлдээх зэргээр энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан гэмт хэрэгт бэлтгэсэн бол гурван жил хүртэл хорих юм уу торгох ялаар шийтгэнэ.

Тус бүлэгт мөнгөн тусламжийн залилан, хөрөнгө оруулалтын залилан, даатгалын залилан, хууран мэхлэх замаар ашиг олох, зээлийн залилан, спортын бооцооны залилан, мэргэжлийн спортын тэмцээний залилан, спортын болон мэргэжлийн спортын онц ноцтой залилан гэх зэрэг тусгайлан зүйлчилсэн гэмт хэргийг мөн тусгажээ.

### 266 дугаар зүйл. Итгэл эвдэх

1. Хуулийн дагуу, эрх бүхий байгууллагын даалгавраар эсвэл эрх зүйн хэлцлийн хүрээнд бусдын хөрөнгийг захиран зарцуулах буюу бусдад үүрэг хүлээлгэх бүрэн эрхээ урвуулан ашигласан эсвэл хүчин төгөлдөр хуулийн дагуу, эрх бүхий байгууллагын даалгавраар, эрх зүйн хэлцлийн хүрээнд эсвэл фидуцийн харилцааны дагуу бусдын хөрөнгийн ашиг сонирхлыг хамгаалах үүргээ зөрчсөний улмаас хөрөнгийн ашиг сонирхлоо итгэл хүлээлгэн даатгасан хүнд сөрөг нөлөө бий болгосон бол таван жил хүртэл хугацаагаар хорих эсвэл торгох ялаар шийтгэнэ.

Итгэл эвдэх хүрээнд ажил олгогч ажилтанд цалин хөлс өгөхгүй байх, шамшигдуулах, төлбөр төлөхтэй холбоотой чек болон зээлийн картыг урвуулан ашиглах зэрэг үйлдлийг гэмт хэрэг хэмээн тусад нь зүйлчилж оруулсан байдаг.

### **Тав. Япон Улс**

Тус улсын эрх зүйн тогтолцоонд Ром-Германы болон Англи-Саксоны эрх зүйн бүлийн нөлөө их, тиймээс холимог тогтолцоотой гэж үздэг.

Шүүхийн прецедент, Засгийн газрын болон нутгийн захиргааны байгууллагын гаргасан актууд нь зарим тохиолдолд эрх зүйн эх сурвалж болдог. Гэмт хэргийн нэгдсэн тодорхойлолт өгөөгүй, тэгэхдээ дотор нь:

- үйлдлээ хэрэгжүүлсэн байдлаар нь төгссөн, төгсөөгүй гэмт хэрэг;
- хор уршгаар нь хүнд, хүндэвтэр, цагдаагийн гэмт хэрэг;

- хуульчилсан үндэслэлээр нь хуульчлан зөвшөөрсөн (*естественный*), хуульчлан тогтоосон (*позитивный*) гэмт хэрэг;
- эрх зүйн хамгаалалтад халдсан байдлаар нь улс, нийгмийн болон хувийн ашиг сонирхолд халдсан гэмт хэрэг гэж хэд хэд ангилдаг.

Ялыг үндсэн болон нэмэгдэл гэж хоёр ангилахын дээр цаазаар авах, хорих, торгох, баривчлах, бага хэмжээний торгууль оногдуулах, эд хөрөнгө хураах зэрэг төрөлтэй.

Хорих ял нь хугацаатай ба хугацаагүй байхаас гадна албадан хөдөлмөрлүүлдэг болон хөдөлмөр эрхэлдэггүй ял гэж дотроо хуваагдана. Хугацаатай хорих ял нь нэг сараас 15 жилээр заагддаг. Хугацаагүй хорих ялтай этгээд 10 жилийн ялыг биечлэн эдлээд суллагдах хүсэлтээ илэрхийлж шүүх магадланд орох эрхтэй байдаг бол хугацаагүй хорих ялыг өөрчилсөн тохиолдолд 20 жилийн хорих ялаар сольж болно. Баривчлах ялын хувьд нэгээс 30 хоног тусгаарлаж баривчлах байранд байлгадаг.

Торгуулийн хувьд 10,000 иен болон түүнээс дээш хэмжээтэй байхад жижиг торгууль нь 1,000-10,000 иен байна<sup>18</sup>.

Япон Улсын Эрүүгийн хуулийн тусгай ангийн 37 дугаар бүлэгт “Залилан мэхлэх болон далайлган сүрдүүлэх” гэмт хэргийн бүрэлдэхүүнийг доорх байдлаар хуульчилжээ:

<sup>18</sup> <https://www.twirpx.com/file/239675/>



*246 дугаар зүйл.* Залилах. Бусдыг хуурч мэхлэн эд хөрөнгийг нь авсан бол 10 жил хүртэл хорих ялаар шийтгэнэ;

*246.2 дугаар зүйл.* Бусдыг хуурч мэхлэх үйлдлээ хэрэгжүүлэхдээ хуурамч баримт бичиг, тусгай техник хэрэгсэл, хувцас хэрэгсэл ашиглаж зохиомол орчин бий болгосон бол эд хөрөнгийг нь хурааж 10 жил хүртэл хорих ялаар шийтгэнэ;

*247 дугаар зүйл.* Итгэлийг хортойгоор урвуулах. Бусдын итгэлийг хортойгоор урвуулан ашиглаж эд хөрөнгийг нь завшсан бол 50,000 иенээр торгох буюу таван жил хүртэл хорих ялаар шийтгэнэ гэжээ.

Олон улсын түвшинд залилангийн хэргийг дараах үндсэн гурван хэлбэртэй байна гэж үздэг. Үүнд:

- 1) хуурч мэхлэх;
- 2) итгэл эвдэх, багаж хэрэгсэл хэрэглэх;
- 3) завших буюу ашиглан шамшигдуулах.

Эндээс хуурч мэхлэх, итгэл эвдэх, завших буюу ашиглан шамшигдуулах шинжүүд нь манай Эрүүгийн хуульд тодорхойлогдсон байдаг учраас “багаж хэрэгсэл ашиглах” гэсэн заалтыг тодруулан авч үзье.

Багаж хэрэгсэл ашиглан залилахыг “итгэл эвдэх”-тэй нэг дор авч үздэгийн учир нь итгэл эвдэхэд гэрээ, хөрөнгө оруулалт, худалдан авах хэлцэл зэргийг ашигладаг бол “багаж хэрэгсэл хэрэглэх” гэдэг нь тусгайлан бэлдсэн төхөөрөмж ашиглахыг хэлж байгаа юм. Жишээлбэл, гудамжны янз бүрийн жижиг үзүүлбэрээр луйвардах аргууд байдаг, үүнд манайд нэг хэсэг тоглуулж байсан гурван аяга эргэлдүүлэн резинэн бөмбөг хаана орсныг таалгадаг гудамжны тоглоом орно. Харин энэ хоёр



үйлдлийн адил төстэй зүйл нь хохирогч өөрийгөө залилангийн хохирогч болж байгаагаа буюу залилуулж байна гэдгээ мэдээгүй байдагт оршино.

Гадаадын зарим орны Эрүүгийн хууль тогтоомжид залилах гэмт хэргийн талаар хэрхэн тусгагдсан, оногдуулах ялын төрөл хэмжээ, улс орны онцлог зэргийг судлахад залилах гэмт хэргийг зөвхөн “Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг” гэсэн бүлгээр хязгаарладаггүй, төрөл бүрээр нь тусгайлан хуульчилсан байдаг онцлогтой. Тухайлбал, нийгмийн халамж, нийгмийн даатгалын залилан, үнэт цаасны залилан, хөдөлмөрийн залилан, даатгалын залилан, дампуурч залилах зэрэг олон төрлийг Эрүүгийн хуульдаа тусгасан байна.

Монгол Улсын Эрүүгийн хуулийн тусгай ангийн 18 дугаар бүлэг буюу “Эдийн засгийн гэмт хэрэг” гэсэн бүлгийн 18.9 дүгээр зүйлд үнэт цаасны зах зээлийг урвуулан ашиглах, 18.10 дугаар зүйлд зориуд, зохиомлоор дампуурах, 18.12 дугаар зүйлд хууль бусаар нийгмийн халамж, үйлчилгээ авах, 18.14 дүгээр зүйлд заасан нийгмийн даатгалын шимтгэл төлөхөөс зайлсхийх, 18.15 дугаар зүйлд заасан хууль бусаар даатгалын нөхөн төлбөр авах гэмт хэргүүд нь залилах гэмт хэрэгтэй төсөөтэй байдлаар тусгагджээ.

Харин хөдөлмөрийн залилангийн талаар Монгол Улсын хууль тогтоомжид тодорхой тусгагдсан зүйл байхгүй учир цаашид Эрүүгийн болон Зөрчлийн тухай хуулиудад нэмж оруулах шаардлагатай гэж судлаачдын зүгээс үздэг.

## ХОЁР. ЗАЛИЛАХ ГЭМТ ХЭРГИЙН НОТОЛГООНЫ ПРОЦЕССЫН ДҮН ШИНЖИЛГЭЭ

### 2.1. НОТОЛГООНЫ ЗҮЙЛ, НОТЛОХ БАРИМТЫГ ШҮҮХЭЭС ХЭРХЭН ҮНЭЛЖ БУЙ ПРАКТИК

Залилах гэмт хэргийн хувьд өргөдөл гомдол ирсэн даруйд холбогдогч этгээдийг гэрчээр дуудан мэдүүлэг авч дараа нь яллагдагчаар татдаг практик тогтжээ. Гэрчээр анх мэдүүлэг авах үедээ хууль журам сануулж “...Та үнэн зөв мэдүүлэг өгөх ёстой!” гэж анхааруулж байгаад тухайн этгээдийн өөрийнхөө болон гэр бүлийнхээ хүний эсрэг мэдүүлэг өгөхгүй байх, өмгөөлөгчтэй мэдүүлэг өгөх зэрэг эрхийг эдлүүлэхгүйгээр байцаалт явуулж, дараа нь уг мэдүүлгийг үндэслэн яллагдагчаар татаж байгаа нь Үндсэн хуулийн зөрчил хэмээн судлаачид үзлээ.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 16.3 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт зааснаар мэдүүлэг өгч буй этгээд мэдүүлгийнхээ эх сурвалжийг зааж чадаагүй бол тухайн мэдүүлэг нь дангаараа нотлох баримт болохгүй байхаар хуульчилсан. Урьдаас хөдөлбөргүй үнэн гэж тогтоогдсон ямар ч нотлох баримт байж болохгүй. Аливаа нотлох баримтыг шүүх бусад нотлох баримтаас дээгүүр тавьж, илүү хүчин чадалтай гэж үзэж болохгүй бөгөөд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад цугларч буй аливаа нотлох баримтыг шүүх үнэлэх, эргэлзэх эрхтэй, тэдгээрийг дэнсэлж, үнэлсний эцэст шийдвэрээ гаргах үүрэгтэй. Шүүгдэгч нотлох баримтаар дамжуулан өөрийн ашиг сонирхлыг шүүхэд илэрхийлдэг.

Иймээс шүүх аливаа этгээдийн гаргаж ирсэн баримтад эргэлзэхгүйгээр итгэх, түүнийг үнэлэхгүйгээр шийдвэрийнхээ үндэслэл болгох нь нэг талын ашиг сонирхолд хөтлөгдөх, шүүхийн хөндлөнгийн байр суурийг алдагдуулах ноцтой үр дагавар бий болгодог.

Шүүх хэрэгт авагдсан шүүгдэгчийн мэдүүлэг, уг хэрэгт хамааралтай баримт бүрийг тал бүрээс нь нягт нямбай, бүрэн гүйцэд, бодит байдлаар нь хянаж, бусад нотлох баримттай харьцуулах, эх сурвалжийг магадлах аргаар шалгасны эцэст нотлох баримтад тулгуурлан хэргийн үйл баримтыг тогтоох үүрэгтэй. Анхан болон давж заалдах шатны шүүх Д.Э-д холбогдох хэргийн нотлох баримтын нотолгооны ач холбогдол, хамаарал, хууль ёсны байдлыг дүгнэн цэгнэж, харьцуулан шинжилж, гэрчийн мэдүүлэг, шүүгдэгч, хохирогч, шинжээчийн дүгнэлтийн үнэн зөв байдлын нотломжийн түвшин, агуулга зэргийг үнэлэхдээ эрх зүйн ухамсрыг удирдлага болгон шийдвэрлэжээ<sup>19</sup>.

Прокурорын яллах дүгнэлтэд залилах гэмт хэрэг хаана үйлдэгдсэнийг тодорхой заагаагүй байхад анхан шатны шүүх хуралдаанаараа хэргийг нь хэлэлцүүлж шийдвэрлэсэн тохиолдол цөөнгүй гарчээ. Тухайлбал, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 16.2 дугаар зүйлд заасан “нотлогдвол зохих байдал”-д гэмт хэрэг хаана үйлдэгдсэнийг тогтоохоор заасныг олон үйлдэлтэй залилах хэрэг дээр шүүх орхигдуулах хандлагатай байна.

Давж заалдах шатны шүүхийн зарим магадлалд “Анхан шатны шүүх залилах гэмт хэрэг хаана үйлдэгдсэн талаар дүгнэлт хийгээгүй, энэ талаараа цаашид анхаарах шаардлагатай” гэж дүгнээд тогтоолыг хэвээр үлдээсэн тохиолдол гарсан байна. Өөрөөр хэлбэл, “...прокурор яллах дүгнэлтдээ гэмт хэрэг хаана үйлдэгдсэнийг тодорхой бичээгүй

---

<sup>19</sup> www.shuukh.mn



байх боловч энэ нь хэргийн үйл баримтын талаарх дүгнэлтэд ноцтой нөлөөлөхгүй учир анхан шатны шүүх хэргийг эцэслэн шийдвэрлэсэн нь зөв дүгнэсэн” гэж давж заалдах шатны шүүх үзсэн бөгөөд “...цаашид прокурор яллах дүгнэлт үйлдэхдээ дээрх байдлыг сайтар анхаарвал зохино” гэжээ.

Мөрдөн байцаалт, шүүхийн практикт хэн нэгэн хүнийг гэмт хэрэгт холбогдуулан шалгах үндэслэл бүхий гомдол, мэдээлэл, баримт сэлтийг хүлээн авсан үед худал мэдүүлэг өгвөл Эрүүгийн хуульд заасан хариуцлага хүлээлгэхийг тухайн гэмт хэрэгт сэжиглэгдэж буй хүнд урьдчилан сануулж, түүнээс гэрчийн мэдүүлэг авдаг. Энэ нь Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 14 дэх хэсэгт заасан “...өөрийн болон гэр бүлийн гишүүд, эцэг, эх, үр хүүхдийнхээ эсрэг мэдүүлэг өгөхгүй байх эрхтэй, өөрийнхөө эсрэг мэдүүлэг өгөхийг шаардах, мэдүүлэг гаргуулахаар шахалт үзүүлэх, хүч хэрэглэхийг хориглоно...” гэсэн заалтыг ноцтой зөрчиж буй хэрэг юм. Гэтэл Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 16.11 дүгээр зүйлд зааснаар шүүх тухайн мэдүүлгийг нотлох баримтаар тооцож, шүүхийн шийдвэрийн үндэслэл болгох тохиолдол цөөнгүй гарч байна.

Харин гэмт хэрэг үйлдсэн байж болох хүн, хуулийн этгээд тодорхойгүй байгаа үед мөрдөгч тухайн хэргийн талаар ач холбогдол бүхий нөхцөл байдлыг мэдэж байгаа гэж үзсэн хүнээс гэрчийн мэдүүлэг авч болох бөгөөд энэ тохиолдолд өөрийнхөө болон гэр бүлийнхээ гишүүний эсрэг мэдүүлэг өгөхгүй байх, өмгөөлөгчөөс хууль зүйн туслалцаа авах, өмгөөлөгчийн хамт мэдүүлэг өгөх эрхийг нь сайтар тайлбарлаж өгөх үүрэгтэй.

Шүүх хэрэгт цугларсан нотлох баримтыг үндэслэн хэргийн бодит байдлыг сэргээн тогтоохдоо прокуророос шүүхэд шилжүүлсэн хэргийн хүрээнд хэрэгт хамааралтай бүхий л нөхцөл байдлыг үнэлж дүгнэдэг. Тийнхүү нотолгооны ач холбогдолтой, хэрэгт хамааралтай баримт нэг бүрийг үнэлж

дүгнэхдээ нотлох баримтуудыг харьцуулах, эдгээр баримтын эх сурвалжийг магадлах арга ашиглахын хамт харьцуулсан, магадалсан үндэслэлээс шалтгаалан няцаасан эсхүл баталсан дүгнэлт хийж, тэдгээрийг шийтгэх, цагаатгах тогтоолын тодорхойлох хэсэгт тусгах талаар Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 36.7, 36.9 дүгээр зүйлүүдэд зохих хэм хэмжээ тогтоосныг зөрчсөн нь тус хуулийг ноцтой зөрчсөн зөрчилд тооцогдохоор зохицуулжээ.

## 2.2. ЗАЛИЛАХ ГЭМТ ХЭРГИЙН ХОХИРЛЫГ ТООЦОЖ БУЙ ШҮҮХИЙН ДҮГНЭЛТ

Шүүхийн өмнөх шатанд залилах гэмт хэргийн хохирлын хэмжээг үнэн бодитой тогтоох талаар учир дутагдалтай ажиллаж байна. Залилах гэмт хэргээр зүйлчлэх хохирлын хэмжээг хуурч мэхлэх, итгэл эвдэх аргаар бусдад учруулсан шууд хохирлоор тодорхойлно<sup>20</sup>. Харин шууд бус хохирлыг энэ гэмт хэргээр зүйлчлэх хохирлын хэмжээнд оруулан тооцохгүй бөгөөд түүгээр зүйлчлэлийг өөрчлөхгүй. Бусдын өмчлөх эрхийг хуурч мэхлэх, итгэл эвдэх болон бусад аргаар олж авсан тохиолдолд уг эрхээр баталгаажсан эд хөрөнгийн зах зээлийн үнэлгээгээр бодит буюу шууд хохирлыг тооцно.

Шүүхийн шийдвэрүүдээс ажиглахад олон үйлдэлтэй залилах хэргийн хувьд эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татахаас өмнө буруутай этгээд зарим хохирлыг барагдуулсан байх бөгөөд өмнө барагдуулсан хохирлыг эрүүгийн хэргийн хохирол гэж үзэх нь зөв эсэх дээр нэгдсэн ойлголтод хүрэх хэрэгтэй байна. Зарим шүүгч барагдуулсан хохирлыг хасах буюу эрүүгийн хэрэг үүсгэсэн үед төлөгдөөгүй байсан хохирлын хэмжээг баримталж байхад зарим нь тухайн хохирогчдод учирсан нийт хохирлыг гэмт хэргийн хохиролд тооцож, харин төлсөн хохирлыг хохирол барагдуулсан хэмээн дүгнэж байна.

<sup>20</sup> <https://mongolia.hss.de/mn/>



Эрүүгийн хариуцлага хүлээлгэхдээ Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн хэм хэмжээг зөв баримтлан, гэмт хэрэг үйлдсэн нөхцөл байдал, хэргийн нийгмийн аюулын шинж чанар, учирсан хохирол, хор уршгийн хэмжээ, шүүгдэгчийн хувийн байдал, хариуцлагыг хөнгөрүүлэх, хүндрүүлэх нөхцөл байдлыг харгалзан үзэж эрүүгийн хариуцлага хүлээлгэн шийдвэрлэснийг өөрчлөх эсхүл буруутган дүгнэх хууль зүйн үндэслэл тогтоогдохгүй байна.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 9.1 дүгээр зүйлийн 4 дэх хэсэгт “Шинжээч шинжилгээ хийж, дүгнэлт гаргахдаа энэ хууль, Шүүхийн шинжилгээний тухай хуульд заасан журмыг баримтална” гэж заасан. Тус хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1-д “Шинжилгээг шинжилгээний байгууллагаас гадуур хийлгэх бол... шинжилгээний байгууллагад ажилладаггүй шинжээчийг дуудан ирүүлж... сэжигтэн, яллагдагч, хохирогчтой ямар холбоотойг тогтоохоос гадна шинжээчээс татгалзан гарах үндэслэл байгаа эсэхийг шалгана” гэж заажээ. Мөн зүйлийн 9.2-т заахдаа “Энэ зүйлийн 9.1-д заасан ажиллагааг явуулсны дараа харшлах шалтгаан байхгүй гэж үзвэл шинжилгээ хийлгэх тухай тогтоол захирамжийг шинжээчид гардуулан өгч эрх, үүрэг, хариуцлагыг нь урьдчилан сануулж, гарын үсэг зуруулна” гэж заасан байдаг.

Хор уршгийн хувьд Эрүүгийн хуулийн 2.1 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт “...энэ хуулийн тусгай ангид заасан тохиолдолд гэм буруутай үйлдэл, эс үйлдэхүйн улмаас хохирол, хор уршиг учирсныг гэмт хэрэгт тооцно”, мөн зүйлийн 4 дэх хэсэгт “...Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан гэмт хэргийн шинжийг хэлбэрийн төдий агуулсан боловч тухайн этгээдийн хувийн байдал, үйлдэл, эс үйлдэхүйн нийгмийн аюулын хэр хэмжээ нь энэ хуулиар хамгаалагдсан эрх ашигт бодит хохирол, хор уршиг учруулаагүй үйлдэл, эс үйлдэхүйг гэмт хэрэгт тооцохгүй” гэж тус тус тусгажээ.

Эрүүгийн хуулийн 2.5 дугаар зүйлд “Гэмт хэргийн хохирол, хор уршиг”-ийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Хуулийн тусгай ангид заасан гэмт хэргийн улмаас хүний амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгө, бусад эрх, эрх чөлөө, нийтийн болон үндэсний ашиг сонирхол, аюулгүй байдалд шууд учирсан үр дагаврыг гэмт хэргийн хохиролд тооцно, хуулийн тусгай ангид заасан гэмт хэрэг үйлдэж хохирол учруулсны улмаас үүссэн үр дагаврыг гэмт хэргийн хор уршигт тооцно.
- Шүүх гэмт хэргийн хохирол, хор уршигийг тодорхойлж, бодит хохирлыг нөхөн төлүүлэх, хор уршигийг арилгахад гарах зардлын мөнгөн дүнгээр илэрхийлэгдэх хэмжээг тогтооно<sup>21</sup>.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 16.5 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “...Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад тусгай мэдлэг зайлшгүй шаардагдсан эсхүл эд зүйл, хөрөнгийн үнэлгээ тогтоохоор шинжилгээ хийлгэнэ” гэснээс үзэхэд шинэ хууль хэрэгжиж эхэлснээр эд зүйлийн үнэлгээ тогтоосон комиссын акт бус шинжээчийн дүгнэлт заавал шаардах болж байна. Тэгэхээр өмнө нь эрүүгийн хэрэг үүсгэн шалгаад эд зүйлийн үнэлгээ тогтоосон хэргүүд дээр дахин шинжээч томилох шаардлага гарч байна.

Хууль тогтоогч зөвхөн сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчийн эрх зүйн байдлыг дээрдүүлснээс гадна хохирогчийн эрх ашгийг бодолцдог. Жишээ нь, ноцтой хохирол учруулсан бол хариуцлагыг хүндрүүлэхээр заасан доорх заалт ихээхэн ач холбогдолтой гэж зарим судлаач үздэг.

<sup>21</sup> <https://mongolia.hss.de/mn/>



Тодорхой хэргийн хохирогчийн амьжиргааны цорын ганц эд хөрөнгийг залилан мэхэлж аваад тухайн хүнийг цаашид амьдрах аргагүй болгож байгаа тэр хатуу сэтгэлт луйварчныг их хэмжээний хохирол буюу 50 сая болон түүнээс дээш төгрөгийн хохирол учруулсантай адилтган хүндрүүлдэг. Тухайлбал, хүний амьжиргаагаа залгуулдаг суудлын автомашиныг нь “худалдах, худалдан авах” гэрээгээр халхавчлан залилан мэхэлж аваад мөнгийг нь төлөөгүй үйлдлийг “ноцтой хохирол учруулсан” гэж үзэхээс өөр аргагүй бөгөөд хохирогч чухамхүү тэр л автомашинаар хүн тээвэрлэж өдөр тутмын зайлшгүй хэрэгцээнийхээ зардлыг төлдөг байсан. Хэдийгээр тухайн хөрөнгөд үнэлгээ хийлгэхэд уг автомашин 3-4 сая орчим төгрөгийн үнэлгээтэй гарсан байсан ч энэ нь ноцтой хохирол гэгдэж хүндрүүлэх нөхцөлд хамаарах юм.

Хохирлын үнэлгээний асуудал Эрүүгийн болон Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай шинэ хуулийн дагуу үндсээрээ өөрчлөгдөж байгаа бөгөөд үнэлгээ тодорхойгүй тохиолдолд Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай шинэ хуулийн дагуу шинжээч томилж эд хөрөнгийн үнэлгээ хийлгэхээр болсон. Шинжээчийн дүгнэлт зарим тохиолдолд эргэлзээтэй гардгаас хэрэг дахин мөрдөн байцаалтад буцах, хохирогч талд ашиггүй байдал үүсгэж ял завших тохиолдол практикт цөөнгүй тохиолддог. Жишээ нь, автомашин худалдан авсан атлаа үнийг нь төлөөгүй учир залилах гэмт хэрэг гэж үзсэн шүүхийн тогтоолд шинжээчийн дүгнэлт илт алдаатай байхад шүүх залруулалгүй шийдвэрлэсэн байна. Уг нь халдлагын зүйл болох автомашины үйлдвэрлэсэн болон Монголд орж ирсэн он, гүйлтийн заалт үнэ тогтооход гол нөлөөтэй. Шинжээч 2019 оны 9 дүгээр сард үнэлгээ хийхдээ “Лексус 570” маркийн автомашины гүйлтийн заалтыг 120,150 км гэж үзэж дүгнэлт гаргажээ<sup>22</sup>. Автомашины үнэлгээг буруу тооцсоноос гадна

<sup>22</sup> www.shuukh.mn



ЗАЛИЛАХ ГЭМТ ХЭРГИЙГ ШИЙДВЭРЛЭСЭН  
ШҮҮХИЙН ШИЙДВЭРИЙН ДҮН ШИНЖИЛГЭЭ

хохирлын хэмжээг прокурорын яллах дүгнэлт болон анхан шатны шүүхийн шийтгэх тогтоолд буруу дүгнэсэн бөгөөд уг автомашин өнөөдрийг хүртэл ашиглагдаж байхад түүнийг худалдан авсан нийт үнийн дүнгээр нь буюу 130,0 сая төгрөгийн хохирол учирсан гэж прокурор болон анхан шатны шүүх дүгнэсэн нь үндэслэлгүй дүгнэлт байсан зэрэг жишээ дурдаж болно.

## ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ

Шүүх нотлох баримтад тулгуурлан хэргийн үйл баримтыг тогтоохдоо хэрэгт хамааралтай баримт нэг бүрийг тал бүрээс нь нягт нямбай, бүрэн гүйцэд, бодит байдлаар нь хянах үүрэгтэй бөгөөд анхан болон давж заалдах шатны шүүх холбогдох хэргийн нотлох баримтын нотолгооны ач холбогдол, хамаарал, хууль ёсны байдлыг дүгнэн цэгнэж, харьцуулан шинжилж, гэрчийн мэдүүлэг, шүүгдэгч, хохирогч, шинжээчийн дүгнэлтийн үнэн зөв байдлын нотломжийн түвшин, агуулга зэргийг эрх зүйн ухамсрыг удирдлага болгон үнэлж, шийдвэрлэж чадаж байна гэж судлаачид дүгнэлээ.

Цөөн тохиолдолд буюу нийт шийдвэрийн 10-15 орчим хувьд нь анхан шатны шүүх Эрүүгийн хуулийг буруу хэрэглэх, эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг ноцтой зөрчин нотлох баримтыг дутуу үнэлэх, үйл баримтыг үгүйсгэсэн нотлох баримт байхад түүнд үнэлэлт өгөхгүй байх, хохирлыг буруу тооцох зэрэг зөрчил гарч байна. Тухайлбал, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 39.5 дугаар зүйлийн 1.1-д зааснаар шүүхийн тогтоолд заасан үндэслэл нь хэргийн бодит байдалтай нийцээгүй бол шүүхийн шийдвэрийг хүчингүй болгохоор заажээ. Хэргийн бодит байдалтай нийцээгүй гэдгийг Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 39.6 дугаар зүйлд тайлбарласан ба уг зүйлийн 1.3-т “...дүгнэлтэд онцгой ач холбогдол бүхий нотлох баримт харилцан зөрүүтэй байхад аль нэгийг нь авахдаа бусдыг нь үгүйсгэсэн тухай үндэслэлийг заагаагүй бол” гэжээ.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулиар хэргийн бүхий л нөхцөл байдлыг тал бүрээс нь бүрэн бодитойгоор тогтоох, хэргийг үндэслэлтэй, хууль ёсны дагуу шийдвэрлэх зорилгоор уг хуулийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны хэлбэрийг тодорхойлж баталгаажуулсан байдаг. Энэхүү хуульчлагдсан хэлбэрийг чанд сахих нь шүүхийн өмнөх ба шүүхийн шатанд эрх бүхий этгээдээс гаргаж буй аливаа шийдвэр хуульд нийцсэн, Эрүүгийн хууль болон бусад хууль тогтоомжийг зөв хэрэглэсэн болохыг шалгах зайлшгүй нөхцөл нь юм. Шүүх хэргийн бодит байдлыг сэргээн тогтоохдоо хэрэгт цугларсан нотлох баримтыг үндэслэн, прокуророос шүүхэд шилжүүлсэн хэргийн хүрээнд нотолгооны ач холбогдолтой, хэрэгт хамааралтай бүхий л нөхцөл байдлыг дүгнэн үнэлдэг. Ийнхүү дүгнэж үнэлэхдээ хуульд тусгайлан заасан зохицуулалтыг зөрчсөн байвал Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийг ноцтой зөрчсөнд тооцож, шүүхийн шийдвэрийг хүчингүй болгон, хэргийг дахин хэлэлцүүлэх үндэслэл болдог.

Зарим хэрэгт шүүгдэгчдийг гэмт хэрэг үйлдэхэд хүргэсэн хүсэл, санаа зорилгын нэгдэл, үйлдэл, оролцоо огт харагдахгүй, ямар нотлох баримтад тулгуурлан бүлэглэж үйлдсэн гэж үзэж буй үндэслэл нь тусгагдаагүй, зөвхөн прокурорын яллах дүгнэлтийн тодорхой хэсгийг хуулж бичих замаар гэм буруутайд тооцох болсон нөхцөл байдлыг бичсэн байдаг. Тиймээс шүүгч уг хэргийг хянан шийдвэрлэхдээ гэмт хэрэг гарсан нөхцөл байдлыг ямар хэмжээнд сэргээн тогтоосон, үүнийгээ ямар нотлох баримтаар нотолж байгаа, тогтоосон нөхцөл байдалд эрүүгийн эрх зүйн онол, хуульд заасан хэм хэмжээ ямар шинжээрээ нийцэж байгаад дүгнэлт хийлгүй орхиж байна. Түүнчлэн холбогдох хэргийг хэрэгсэхгүй болгож, цагаатгахдаа прокурорын яллаж буй нотлох баримтуудыг няцаан үгүйсгэсэн талаараа үндэслэл, дүгнэлт огт хийлгүй орхигдуулж байна.



2017 оноос өмнө шүүхээр шийдвэрлүүлсэн хэрэг маш бага байсан бол Эрүүгийн хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль хэрэгжиж эхэлснээр шүүхээр шийдвэрлэх хэргийн тоо нэмэгджээ. Тухайлбал, 2018 онд эрүүгийн хэрэг 27,000 бүртгэгдсэнээс 7,000 орчим нь шүүхээр шийдвэрлэгдэж, үлдсэн 20,000 орчим хэрэг прокурорын шатанд хэрэгсэхгүй болох, түдгэлзүүлэх зэргээр эцэслэн шийдвэрлэгдээгүй байдалтай байжээ. Залилах гэмт хэргийн хувьд 3,000 орчим хэрэг бүртгэгддэг бол жилд дунджаар 700 орчмыг нь шүүхээр хянан шийдвэрлэж байгаа нь анхаарал татаж байна.

Шинэ Эрүүгийн хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн үзэл баримтлалаар залилах гэмт хэрэг үйлдэх үедээ хуурамч баримт бичиг, тэмдэг, хэвлэмэл маягт болон компьютерын программ, сүлжээ, төхөөрөмж зэргийг ашигласан тохиолдолд нийлмэл гэмт хэрэг гэж үзэхгүй ба эдгээр нь залилах гэмт хэргийн шинжид хамаарна. Харин хуурамч баримт бичиг, тамга тэмдэг, хэвлэмэл маягт болон компьютерын программ, сүлжээ, төхөөрөмж зэргийг мэдсээр байж залилан мэхлэх гэмт хэрэг үйлдэхэд ашиглуулсан этгээдийг энэ хэргийн хамтран оролцогч гэж үзэн эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ.

Хэлбэрийн бүрэлдэхүүнтэй гэмт хэрэг учир хор уршиг шаардахгүй, залилах үйлдэл хийгдсэнээр гэмт хэрэгт тооцно. Хүндрүүлэх бүрэлдэхүүнд байгаа ноцтой болон их хэмжээний хохирол нь объектив талын нэмэгдэл шинж болж байгаа учир мөрдөн байцаалтын явцад хохирол, хор уршгийг нь заавал тогтоох шаардлага үүснэ.

Залилах гэмт хэргийн криминологи шинжийг авч үзэхэд хүйсийн хувьд эрэгтэйчүүд 66 хувь, эмэгтэйчүүд 34 хувь эзэлсэн ба насны хувьд 19-25 насны залуучууд 18, 26-35 хүртэлх насныхан 44, 36-45 насны хүмүүс 27, 46-гаас дээш насныхан 10.3 хувийг тус тус эзэлж байна.

Манай улсын 100,000 иргэнд нэг жилийн хугацаанд 105 залилах гэмт хэрэг ногдож байгаа нь дэлхийд өндөрт тооцогдох үзүүлэлт бөгөөд энэ төрлийн хэргийн 11 хувь нь орон нутаг буюу аймгийн төвүүдэд, 89 хувь нь Улаанбаатар хотод үйлдэгдсэн байгаа нь залилан бол суурин газарт голчлон үйлдэгддэг гэмт хэрэг гэдгийг харуулна.

Нийгэм, эдийн засгийн хямрал, хувь хүний болон нийгмийн ухамсрын доройтол, дээрээс нь ажилгүйдэл, ядуурал нь залилах гэмт хэргийн шалтгаан болохгүй ч таатай хөрс суурийг нь бүрдүүлж өгдөг нийгмийн уг чанартайн дээр ажилгүй болох, ядуу байх, архинд орох нь хувь хүний мэдэх хэрэг тул аль алиныг нь хавсарсан шалтгаан гэж үзсэн. Иргэдийн хэт итгэмтгий, хууль эрх зүйн мэдлэг дорой байдал, хууль сахиулах байгууллагуудын үйл ажиллагааны доголдол зэрэг нь залилах гэмт хэргийн шалтгаан болж байна.

Залилах гэмт хэрэгтэй тэмцэх ажиллагааг эдийн засаг, улс төр, эрх зүй, зохион байгуулалт болон техникийн арга хэмжээний хүрээнд авч үзсэн. Жишээ нь, эдийн засгийн арга хэрэгсэл нь хүн амын амьжиргааны түвшнийг дээшлүүлэх, ажилгүйдэл, ядуурлыг бууруулах, ажлын байр нэмэгдүүлэх зэрэг олон талт үйл ажиллагааны явцад нэг хүнд ногдох үндэсний орлогыг дээшлүүлэхэд чиглэх бөгөөд хүн амын амьжиргаа сайжрахын хэрээр залилангийн хэрэг багасах учиртай юм.

Мөн төрийн цахим үйлчилгээг нэвтрүүлснээр хүмүүс найдваргүй хүнд итгэж, хөрөнгө мөнгөө даатгах шаардлагагүй болж, сонирхсон асуудлаараа хүссэн хариугаа тэр дор нь авч байгаа нь залилах гэмт хэрэгтэй цаашид тэмцэхэд голлох үүрэг гүйцэтгэнэ.

Шүүхээр залилах гэмт хэргийг шийдвэрлэж буй практик, шүүхийн шийдвэрт дүн шинжилгээ хийж үзээд дараах хэдэн чиглэлээр дүгнэлт хийлээ. Үүнд:



1. Залилах гэмт хэргийг зүйлчлэхдээ шүүх зарим тохиолдолд нийлмэл гэмт хэрэг гэж зүйлчлээгүй тохиолдол гарсан. Тухайлбал, Эрүүгийн хуулийн тусгай ангийн 18.7 дугаар зүйлд заасан “...мөнгөн тэмдэгт, үнэт цаас, төлбөр тооцооны хэрэгсэл хуурамчаар бэлтгэх, ашиглах” болон Эрүүгийн хуулийн тусгай ангийн 23.2 дугаар зүйлд заасан “Хуурамч баримт бичиг үйлдэх, ашиглах” төрлийн гэмт хэрэг хийсэн бол нийлмэл гэмт хэргээр зүйлчлэх учиртай. Хэрэв хуурамчаар үйлдсэн баримт бичиг нь Эрүүгийн хуулийн тусгай ангийн 18.7, 23.2 дугаар зүйлд заасан баримт бичигт хамааралгүй бол нийлмэл гэмт хэрэг хэмээн үзэж зүйлчлэхгүй.

Залилах гэмт хэргийг зохион байгуулалттай гэмт бүлэг үйлдсэн гэж хүндрүүлэн зүйлчлэх тохиолдолд Эрүүгийн хуулийн тусгай ангийн 20.3 дугаар зүйлийн тохирох хэсгээр нийлмэл гэмт хэргээр зүйлчилнэ.

Залилагч этгээд өмчлөх эрхийг хязгаарлах, шилжүүлэхтэй холбоотой илт хууль бус хэлцлийг гэрчлүүлэх эсхүл бүртгүүлэхэд нотариатч, улсын бүртгэгчидтэй гэмт санаагаар нэгдсэн буюу хамтран оролцсон бөгөөд харин залилах гэмт хэрэгт нотариатч, улсын бүртгэгчидтэй хамтарсан шинжгүйгээр тухайн илт хууль бус хэлцлийг гэрчилсэн, бүртгэсэн баримт ашигласан бол Эрүүгийн хуулийн тусгай ангийн 17.10, 17.3 дугаар зүйлүүдийн тохирох хэсгээр нийлмэл гэмт хэрэг гэж зүйлчлэх нь зохимжтой.

Хэрэв гэмт этгээд, нотариатч, улсын бүртгэгч нар анхнаасаа залилах гэмт хэрэг үйлдэхээр гэмт санаагаар нэгдсэн буюу өмчлөх эрхийг хязгаарлах, шилжүүлэхтэй холбоотой илт хууль бус хэлцлийг гэрчилж эсхүл бүртгэж, улмаар уг хууль бус баримтыг ашиглан бусдыг залилах гэмт хэрэгт хамтран оролцсон бол Эрүүгийн хуулийн тусгай ангийн 17.3 дугаар зүйлийн тохирох хэсгээр (хууль бус баримт бичиг, албан тушаалын байдлаа ашиглаж ноцтой буюу их хэмжээний хохирол учруулсан гэх мэт) зүйлчлэх үндэслэл болно.

Түүнчлэн анхан шатны шүүхээс Эрүүгийн хуулийн тусгай ангийн 17.4 дүгээр зүйл буюу “хөрөнгө завших” гэмт хэрэгтэй давхар зүйлчлэх эсвэл залилсан үйлдлийг хөрөнгө завших гэж үзэх, хөрөнгө завшсаныг залилах гэмт хэрэг гэж зүйлчлэх зэргээр дүгнэсэн тохиолдол гарсан. Зүйлчлэлийн энэ мэт маргаантай тохиолдолд мөрдөгч, прокурорын зүгээс тухайн этгээдийг хоёр зүйл ангиар давхар зүйлчилж, шүүхэд шилжүүлэх нь түгээмэл байдаг. Ийм тохиолдолд туршлагатай, чадвартай шүүгч прокурорын яллах дүгнэлтэд дурдсан хоёр зүйл ангийн нэгийг нь хэрэгсэхгүй болгож, нэг л зүйл ангиар яллаж байгаа бол шинээр томилогдсон, залуу шүүгчдийн хувьд прокурорын дүгнэлтэд хөтлөгдөн хоёр зүйл ангиар давхар яллах тохиолдол гарч байна.

2. Эрүүгийн хуулийн тусгай ангийн 17.3 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн 3.1-д заасан “...энэ гэмт хэргийг байнга үйлдэж амьдралын эх үүсвэр болгосон” гэх хүндрүүлэх шинжийг анхан шатны шүүх цөөнгүй тохиолдолд буруу хэрэглэж, хүнд ялтай зүйл ангиар таван жилээс дээш хугацаагаар хорих ял оногдуулж байгааг давж заалдах болон хяналтын шатны шүүхүүд илрүүлэн засах, өөрчлөлт оруулах, хүчингүй болгож дахин шийдвэрлэхээр заажээ.

Анхан шатны шүүх залилах үйлдлийн тоо, давтамжид голлон анхаарч, гэмт этгээд залилах үйлдлийг гурав ба түүнээс дээш удаа үйлдсэн л бол шууд “...байнга үйлдэж амьдралын эх үүсвэр болгосон” гэж дүгнэсэн нь буруу жишиг юм. Зүй нь шүүгдэгч этгээд амьдралын өөр эх үүсвэртэй буюу ажил хөдөлмөр эрхэлдэг эсэх, гэмт хэргээс өөр аргаар орлого олж байсан эсэх, гэмт хэргийн замаар олсон орлогыг амьжиргаандаа зарцуулсан эсэх зэрэг олон хүчин зүйлийг харгалзаж дүгнэлт хийх ёстой байдаг. Гэтэл зөвхөн тоо, давтамжид анхаарал хандуулснаар дээд шатны шүүхээс анхан шатны шүүхийн тогтоол, шийдвэрийг хүчингүй болгох, өөрчлөлт оруулах, зүйл ангийг нь хөнгөрүүлж шийдвэрлэсэн зэрэг тохиолдол цөөнгүй гарчээ.



3. Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн зүйл, заалтыг эрүүгийн хэргийн анхан шатны шүүх, шүүгч бүр өөр өөрөөр хэрэглэж байна. Ерөнхий ангийн зүйл, заалтыг Эрүүгийн хуулийг буцаан хэрэглэх, хөөн хэлэлцэх хугацаа тоолох, хамтран оролцогчдын чиг үүргийг тодорхойлох, гэмт хэрэгт бэлтгэх, завдах болон ял оногдуулах, албадлагын арга хэмжээ авахад заавал баримтлах учиртай. Шүүх залилах гэмт хэргийг шийдвэрлэхдээ Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн зүйл, заалтыг ерөнхийдөө баримталж байгаа боловч хэрэглээ нь хангалтгүй байна гэж судлаачид дүгнэсэн. Жишээ нь, залилах гэмт хэргийг цагаатгасан тогтоолыг авч үзэхэд 2002 оны Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн заалт, 2015 оны Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн заалтуудаас яллагдагч, шүүгдэгчид аль ашигтайг нь түүвэрлэн хэрэглэж, улмаар хэргийг хэрэгсэхгүй болгох, цагаатгах, хөөн хэлэлцэх хугацаа дууссанаар эрүүгийн хариуцлагаас чөлөөлж байгаа нь буруу жишиг юм.

Шүүх тухайн шүүгдэгчийн эрх зүйн байдлыг дээрдүүлсэн Эрүүгийн хуулийн нэг зүйл, заалтыг сонгон хэрэглэх нь эрх зүйн онол, шүүхийн практикт нэгэнт тогтсон, шударга ёсны зарчимд нийцсэн ойлголт учир анхан шатны шүүх уг жишгийг баримтлах учиртай.

4. Эрүүгийн хуулийн тусгай ангийн 17 дугаар бүлгийн 17.3 дугаар зүйлийн 2-т “ноцтой болон их хэмжээний хохирол” учруулсан бол хүндрүүлэх шинж болгохоор заажээ.

Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 2.5 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт зааснаар “...Энэ хуульд заасан “ноцтой хохирол, хор уршиг” гэж хохирогчийн амьдралын эх үүсвэр болсон эд хөрөнгийн эрхэд эсхүл улс орон, хүн амын аюулгүй байдалд ач холбогдол бүхий хохирол, хор уршиг учирсныг ойлгоно”<sup>23</sup> гэжээ.

<sup>23</sup> Энэ хэсгийг 2020 оны 1 дүгээр сарын 10-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан.



Мөрдөгч болон прокурорын зүгээс аль болох хүндээр нь зүйлчлэх бодлого баримталж, тухайн эд хөрөнгө хохирогчийн амьдралын эх үүсвэр болсон эсэхийг нарийвчлан тогтоохгүйгээр “ноцтой хохирол” хэмээн дүгнэдэг тал ажиглагдсан. Ялангуяа эд хөрөнгө хулгайлах гэмт хэрэг дээр хохирогчийн мэдүүлгээр буюу “Алдсан эд хөрөнгө бол миний амьдралын ганц эх үүсвэр” гэж мэдүүлэхэд л “ноцтой хохирол” хэмээн дүгнэж 17.3 дугаар зүйлийн 2.2-т зааснаар зүйлчилж байгаа нь яллагдагчийн эрх зүйн байдлыг дордуулж байна гэж судлаачид дүгнэсэн.

Бодит амьдралд дүүргийн цагдаагийн хэлтсийн нэг мөрдөгч 40-50 хэрэг, өргөдөл, гомдол шалгаж байдаг учир ажлын ачааллаас шалтгаалан гадуур явж хэргийн нөхцөл байдлыг тогтоох, мэдүүлгийг газар дээр нь шалгах, мөрдөн шалгах нууц ажиллагаа явуулах боломж, нөхцөл муу байна. Энэ бүхнээс шалтгаалан уламжлалт мэдүүлгийн аргаар хэргийг мөрдөж прокурорт шилжүүлдэг нь цаашдаа шүүхээс хэрэг буцах, шийдвэрлэгдэхгүй удах нөхцөл бүрдүүлж байна.

5. Залилах гэмт хэргээс олсон орлогыг зориулалтын бусаар зарцуулж үрэн таран хийснийг зарим тохиолдолд мөнгө угаах гэмт хэргээр давхар зүйлчлэх тохиолдол гарч байна. Тухайлбал, 1902005640238 тоот хэрэгт “Б.Э нь Номин ХХК-ийн захирал Ш.Б-гээс 20 тэрбум төгрөгийг бодит байдлыг нуух замаар төөрөгдөлд оруулж залилсан, уг залилах гэмт үйлдлийн улмаас бий болсон хууль бус эх үүсвэртэй мөнгөн хөрөнгийг өөрийн эхнэр, хүүхэд зэрэг дөрвөн хүний ... тоот данснүүдэд шилжүүлж, бэлэн болон бэлэн бусаар зарцуулан байнга, тогтвортой мөнгө угаасан” хэмээн Эрүүгийн хуулийн тусгай ангийн 18.6 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 2.2 дахь заалтад зааснаар зүйлчилжээ.

Эрүүгийн хуулийн тусгай ангийн 18.6 дугаар зүйлд заасан “мөнгө угаах” гэмт хэрэг нь:

- гэмт хэргийн улмаас олсон хөрөнгө, мөнгө, орлого гэдгийг мэдсээр байж түүнийг авсан, эзэмшсэн, ашигласан;

- түүний хууль бус эх үүсвэрийг нь нуун далдлах, гэмт хэрэг үйлдэхэд оролцсон аливаа этгээдэд хуулийн хариуцлагаас зайлсхийхэд туслах зорилгоор өөрчилсөн, шилжүүлсэн;
- түүний бодит шинж чанар, эх үүсвэр, байршил, захиран зарцуулах арга, эзэмшигч, эд хөрөнгийн эрхийг нуун далдалсан үйлдлээр<sup>24</sup> тус тус илэрдэг.

Залилсан мөнгө, эд хөрөнгөө бусдад шилжүүлсэн, үрэн таран хийсэн тохиолдолд энэ нь мөнгө угаах гэмт хэргийн шинж агуулахгүй. Учир нь уг мөнгөний эх үүсвэр нь хохирогчийн мөнгө, эд хөрөнгө учир гэмт хэргийн замаар олсон, хууль бус эх үүсвэртэй гэж үзэж болохгүй. Харин банк дээрэмдсэн, хар тамхины наймаа хийсэн зэрэг хууль бус эх үүсвэртэй мөнгийг хууль бус эх үүсвэрийг нь нуун далдлах зорилгоор өөрчилсөн, шилжүүлсэн, түүний бодит шинж чанар, эх үүсвэр, байршил, захиран зарцуулах арга, эзэмшигч, эд хөрөнгийн эрхийг нуун далдалсан бол мөнгө угаах гэмт хэрэг гэж үзнэ.

6. “Олон шатлалт маркетинг, пирамид тогтолцооны луйврын аргаар үйлдсэн” гэж хүндрүүлэх шинэ нөхцөл зааж 5-12 жил хүртэлх хугацаагаар хорих ял шийтгэхээр зохицуулсан. Сүлжээнд эхэлж элссэн иргэн өөрийн ойр дотнын хүмүүс, найз нөхөд, хамаатан саданг элсүүлдэг бөгөөд дараа нь залилангийн хэрэг үүссэн хойно “Эхний элсүүлсэн иргэнийг “хохирогч” гэх үү, “яллагдагч” гэх үү эсвэл “иргэний хариуцагч” гэх үү?” гэсэн асуудал үүсдэг. Хохирсон иргэд сүлжээний эздэд биш өөрийн танил, найз, хамаатандаа итгэж сүлжээнд элссэн байх нь олонтаа учир өөрийг нь элсүүлсэн хүнийг буруутгаж яллагдагчаар татахыг шаарддаг.

Олон шатлалт маркетинг, пирамид тогтолцооны луйврын болон бусад аргаар гэмт хэрэг үйлдэж бусдад их хэмжээний

<sup>24</sup> 2015 оны Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулга, [www.Legalinfo.mn](http://www.Legalinfo.mn)

хохирол учруулсан этгээд зарим хохирогчийг дахин төөрөгдүүлж, өөрийн гэмт үйлдлийг иргэний шинжтэй маргаан хэмээн үзэж, иргэний хэргийн шүүхийн шийдвэр гаргуулсан тохиолдол цөөнгүй байна.

Иргэний хэргийн шүүхийн шийдвэр гарснаар энэ нь залилах гэмт хэргийн шинжийг үгүйсгэх буюу өмчлөх эрхийг сэргээхгүй байх эсхүл эрүүгийн хариуцлагаас чөлөөлөх үндэслэл болохгүй. Харин залилах гэмт хэргийн шинжийг нотолсон баримтуудын хүрээнд шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас өмнөх иргэний хэргийн шүүхийн шийдвэрийг дахин хянуулах үндэслэл, шаардлага үүсдэгийг анхаарах учиртай. Гэтэл эхний элсүүлсэн хүн өөрөө мөн хууртсан, өөрийн оруулсан хөрөнгийг өсгөж авахын тулд бусдыг элсүүлсэн байдаг учир оруулсан мөнгөө олж авсан тохиолдолд түүнийг иргэний хариуцагчаар татаж, эд хөрөнгийн хариуцлага хүлээлгэх нь шударга ёсонд нийцнэ.

7. Залилах гэмт хэргийг иргэний хэргээс ялган зүйлчлэх нь тулгамдсан асуудал болж байна. Иргэний хууль тогтоомжийн дагуу үүсэж, гэрээний биелэлтийн талаар мэдээлэл солилцож, харилцан гомдлын шаардлага гарган гэрээгээ дүгнэж байгаад эцэст нь эрсдэлд орсны улмаас үүссэн маргаан, гэрээний эрсдэлийг залилан мэхлэх гэмт хэрэг гэж үзэхгүй. Харин гэрээгээр хүлээсэн үүрэг нь биелэгдэх боломжгүй болмогц түүгээр шалтаглаж бусдын эд хөрөнгө эсхүл түүнийг өмчлөх эрхийг бүгдийг нь юм уу заримыг нь шилжүүлэхгүй байх гэмт санаа зорилго өвөрлөж, үүнийгээ хэрэгжүүлэхийн тулд эзэмшигч, өмчлөгчийг төөрөгдүүлэх замаар хуурч мэхлэх, итгэл эвдэх, тодорхой үйлдэл хийсэн нь хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ажиллагааны явцад тогтоогдвол залилах гэмт хэрэг гэж үзэн, эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ.

Байгалийн давагдашгүй хүч, нийгэм, эдийн засгийн харилцааны зохицуулалтын өөрчлөлт, гэнэтийн осол, өвчин эмгэг, хорио цээр зэрэг талуудаас үл шалтгаалах хүчин зүйл



буюу нөхцөл байдал урьдчилан тооцоолох боломжгүйгээр гэнэт өөрчлөгдсөний улмаас гэрээний үүрэг биелэгдээгүйг залилах гэмт хэрэг гэж үзэхгүй.

Залилах гэмт хэргийн бүрэлдэхүүний объектив талын шинж болох хуурч мэхлэх буюу итгэл эвдэх нь бусдын эд хөрөнгө эсхүл түүнийг өмчлөх эрхийг өөртөө олж авах санаа зорилго агуулж, үүнд чиглэсэн идэвхтэй үйлдлээр илэрдэг тул хуурч мэхлэх, итгэл эвдэх ямар нэгэн үйлдэл хийгээгүй бол гэмт хэрэгт тооцохгүй.

Залилах гэмт хэргийн халхавч болсон гэрээ хэлцэл нь хуурч мэхлэх, итгэл эвдэх аргад үндэслэгдсэн, шунахайн сэдэлтээр, дан ганцаар ашиг олох, гэрээнд оролцогч нөгөө талаа хохироох зорилгоор хийгдсэн байдаг бол иргэний эрх зүйн гэрээний харилцаа нь талуудын чөлөөт байдал, тэгш эрх, харилцан тодорхой үр дүнд хүрэхийн тулд хийгддэг учир гэрээ анхнаасаа биелэгдэх бодит боломжгүй байсан нь тогтоогдсон, гэрээний нэг тал үүнийг урьдчилан мэдсээр байж байгуулсан, нөгөө тал (хохирогч) нь мэдээгүй буюу мэдэх боломжгүй байсан бол залилах гэмт хэрэг гэж үзнэ.

Бусдын эд хөрөнгийг “зээл” нэрээр халхавчлан залилах нь уг зээлийг буцааж төлөх бодит баталгаагүй тухайлбал, барьцааны хөрөнгөгүй, хөрөнгө нь байлаа ч эрхийн зөрчилтэй, тухайн эд хөрөнгийг барьцаалах бүрэн эрхгүй этгээд барьцаалсан, түүнчлэн Иргэний хуульд заасан барьцааны гэрээ байгуулах журмыг санаатай зөрчсөн байдаг зэргээр иргэний эрх зүйн зээлийн гэрээнээс ялгагдана.

Гэрээний үүргийн биелэлтийг баталгаажуулах зорилгоор барьцааны гэрээ байгуулахад барьцаалсан эд хөрөнгө нь үүрэг гүйцэтгүүлэгч гэрээний үүргийн шаардлагаа хангуулж авахад ямар нэгэн саад бэрхшээлгүй, боломжтой байх ёстой тул барьцааны эд хөрөнгө үүрэг гүйцэтгүүлэгчийн шаардлагыг анхнаасаа хангах боломжгүй байсан, үүрэг гүйцэтгэгч үүнийг

мэдэж байсан ч санаатайгаар нуун далдалсан нь тогтоогдвол залилан мэхлэх гэмт хэрэг гэж үзнэ.

Гэрээний харилцаагаар халхавчлан бусдын эд хөрөнгийг залилан мэхэлж авах гэмт хэргийг мөрдөн шалгах, хянан шийдвэрлэхэд хуурч мэхлэх, итгэл эвдэх аргаар бусдын эд хөрөнгө эсхүл эд хөрөнгийн эзэмших эрхийг олж авах гэсэн субъектив санаа зорилготой байсан эсэхийг заавал тогтоосон байвал зохино.

8. Анхан шатны шүүхээс залилах гэмт хэргийг цагаатгах тохиолдол бусад гэмт хэргийн шийдвэрлэлтээс харьцангуй өндөр буюу 5-10 хувьтай байна.

Анхан шатны шүүхээс Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 36.9 дүгээр зүйлийн 1.1, 1.2-т заасан агуулга, үндэслэлүүдийг хангаагүй байхад шүүгдэгчийг үндэслэлгүй цагаатгасан тохиолдол цөөнгүй гарчээ. Хохирогч тал нь гомдолтой, хохирол барагдаагүй байхад “Гэрээ хийгдсэн, гэрээгээ нотариатаар батлуулсан нь иргэний эрх зүйн шинжтэй маргаанд тооцогдоно” гэсэн агуулгаар шүүх хэргийг хэрэгсэхгүй болгосныг давж заалдах болон хяналтын шатны шүүх 50 хувьд нь цагаатгах тогтоолыг хүчингүй болгож дахин хэлэлцүүлэхээр буцаасан байна. Яллах талын нотлох баримтуудаас урган гарсан агуулга, үндэслэлийг хэрхэн, юугаар няцааснаас ямар үйл баримт тогтоогдсон улмаар хууль, эрх зүйн ухамсрыг удирдлага болгож хууль хэрэглээний ямар дүгнэлтэд хүрсэн нь цагаатгах тогтоолд огт тусгагдаагүй байв. Гэтэл шүүх дээрх нөхцөл байдал буюу аль үеэс итгэлийг нь урвуулан зээл авах нэрээр залилах гэмт хэрэг үйлдсэн, хэзээ төгссөн зэрэг эрүүгийн эрх зүйн тодорхой үр дагавар үүсгэдэг нөхцөл байдалд няцаасан дүгнэлт хийлгүйгээр ерөнхийд нь иргэний эрх зүйн зээлийн харилцааны үндэслэл зааж, үйл баримтын болон хууль зүйн дүгнэлтээ хооронд нь огт холболгүйгээр шийдвэр гаргасан байна.



Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 1.5 дугаар зүйлд “Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явуулж болохгүй тохиолдол” гэж заасан бөгөөд 1.4 дэх хэсэгт “...тухайн хэргийг урьд нь хэрэгсэхгүй болгосон тогтоол, магадлал хүчинтэй байгаа” гэж заасныг буруу тайлбарлан хэргийг хэрэгсэхгүй болгож цагаатгах тохиолдол гарчээ.

Шүүхийн практикт хохирогчид эхлээд иргэний хэргийн шүүхэд хандаж хэргийг шийдвэрлүүлдэг, шүүхийн шатанд эвлэрлийн гэрээ байгуулж улмаар шүүхээс эвлэрлийг баталгаажуулсан шийдвэр гарсны дараа гэрээгээ биелүүлээгүй гэх шалтгаанаар цагдаад гомдол гаргах тохиолдол цөөнгүй. Цагдаагийн байгууллага ихэнх тохиолдолд гомдлыг хүлээн авахаас татгалздаг, цөөн тохиолдолд эрүүгийн хэрэг үүсгэн шалгасан боловч прокурор, шүүхийн шатанд тухайн хэргүүд хэрэгсэхгүй болох буюу цагаадсан байна.

9. Залилах гэмт хэрэгт оногдуулж байгаа ялын үр нөлөө хангалтгүй байна. Анхан шатны шүүх Эрүүгийн хуулийн тусгай ангийн 17.3 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасан гэмт хэргийг шийдвэрлэхдээ хохирлоо төлөөгүй, их хэмжээний хохирол учруулсан этгээдэд хэт хөнгөн буюу торгуулийн ял эсвэл хоёр жилийн хугацаатай хорих ял шийтгэх тохиолдол давамгайлж байна.

Шүүхээс 2018-2020 оны эхний хагас жилд залилах гэмт хэргийг шийдвэрлэхдээ 56 хувьд нь торгох, 15 хувьд нь нийтэд тустай ажил хийлгэх, 12 хувьд нь хорих ял тус тус оногдуулжээ. Харин 16 хувьд нь хорих ял оногдуулахгүйгээр тэнсэн, хоёр хувийг нь эрүүгийн хариуцлагаас чөлөөлсөн<sup>25</sup> үзүүлэлтээр ялын үр нөлөө хангалтгүй байна гэж дүгнэсэн.

Торгох ялыг хохирлоо нөхөн төлсөн, торгууль төлөх санхүүгийн боломжтой шүүгдэгчид оногдуулах нь зохистой

<sup>25</sup> [www.Judinstutute.mn](http://www.Judinstutute.mn)

атал анхан шатны шүүх энэ шалгуурыг харгалзалгүйгээр огт хохирол төлөөгүй, торгуулийг хэрхэн төлөх нь тодорхойгүй этгээдэд хэсэгчлэн төлүүлэхээр шийдвэрлэх нь түгээмэл байна.

Өмнө нь 2002 оны Эрүүгийн хуулийн тусгай ангийн 148 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт онц их хэмжээний хохирол учруулсан буюу 50,0 сая төгрөгөөс дээш хэмжээний хохирол учруулсан тохиолдолд 10-15 жилийн хорих ял оногдуулдаг байсан бол 2015 оны Эрүүгийн хуулиар залилах гэмт хэрэгт оногдуулдаг ялын бодлого хэтэрхий хөнгөрч 2-8 жилийн хорих ял оногдуулах болон торгуулийн ял эдлүүлэх боломжтой болсныг цаашид Эрүүгийн хуульд өөрчлөлт оруулах замаар засах шаардлагатай.

201625021333 дугаартай А.У гэгч нь олон иргэнийг хохироож 3.5 тэрбум төгрөгийн хохирол учруулж, үйлдсэн гэмт хэргээ хүлээн зөвшөөрч гэм буруугаа ухамсарлаагүй төдийгүй нэг ч төгрөгийн хохирол барагдуулаагүй байхад хуульд заасан хамгийн бага (2-8 жилийн хорих ял) буюу хоёр жилийн хугацаатай хорих ялыг анхан шатны шүүх оногдуулж<sup>26</sup> байгаа нь буруу гэдгийг УДШ тогтоолдоо дурдсан байна.

10. Гадаадын зарим орны Эрүүгийн хууль тогтоомжийн онцлог, тэдгээрт залилах гэмт хэргийг хэрхэн тусгасан, оногдуулах ялын төрөл, хэмжээ ямар байдаг зэргийг судлахад залилах гэмт хэргийг зөвхөн “Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг” гэсэн бүлгээр хязгаарладаггүй ба төрөл бүрээр нь тусгайлан хуульчилдаг онцлогтой байна. Тухайлбал, нийгмийн халамж, нийгмийн даатгалын залилан, үнэт цаасны, хөдөлмөрийн, даатгалын залилан болон дампуурч залилах зэрэг олон төрлийг Эрүүгийн хуульдаа тусгасан байна.

Монгол Улсын Эрүүгийн хуулийн тусгай ангийн 18 дугаар бүлэгт заасан эдийн засгийн гэмт хэргүүд залилантай ойролцоо

<sup>26</sup> Сүхбаатар дүүргийн ЭХАШШ-ийн 2018.08.29-ний өдрийн 644 тоот шийтгэх тогтоол.  
[www.shuukh.mn](http://www.shuukh.mn)



байдлаар тусгагдсан ч хөдөлмөрийн залилангийн талаар манай улсын хууль тогтоомжид тодорхой тусгагдсан зүйл байхгүй байгаа учир цаашид Эрүүгийн болон Зөрчлийн тухай хуульд энэ талын заалт нэмж оруулах шаардлагатай. Хувийн хэвшлийн зарим компани “Ажилтан авна” гэсэн зар өгч нарийн мэргэжил шаардахгүйгээр боловсрол багатай залуусыг ажилд авч ямар нэгэн гэрээ байгуулалгүй ажиллуулж, хөдөлмөрийн хөлс хүчийг нь “сорсныхоо” дараа цалин урамшуулал өгөлгүй хөөж явуулах нь хөдөлмөрийн залилангийн илрэх гол хэлбэр юм. Түүнчлэн барилгын зарим бригад “Өдөрт нь цалин өгнө” гэж амлан ажиллуулаад мөнгийг нь өгөхгүй байх, зарим нь бүтэн сар ажиллуулсныхаа эцэст ямар ч цалин өгөхгүй байгаа нь мөн л хөдөлмөрийн залилангийн хэлбэр тул холбогдох хууль тогтоомжид үүнийг зайлшгүй тусган хуульчлах шаардлагатай юм.

11. Залилах гэмт хэргийн хувьд өргөдөл гомдол ирсэн даруйд холбогдогч этгээдийг гэрчээр дуудан мэдүүлэг авч, дараа нь яллагдагчаар татдаг практик тогтжээ. Гэрчээр анх мэдүүлэг авах үедээ хууль журам сануулж “Та үнэн зөв мэдүүлэг өгөх ёстой!” гэж анхааруулж байгаад тухайн этгээдийн өөрийнхөө болон гэр бүлийнхээ хүний эсрэг мэдүүлэг өгөхгүй байх, өмгөөлөгчтэй мэдүүлэг өгөх зэрэг эрхийг эдлүүлэхгүйгээр байцаалт явуулж, дараа нь уг мэдүүлгийг үндэслэн яллагдагчаар татаж байгаа нь Үндсэн хуулийн зөрчил хэмээн судлаачид үзсэн.

Прокурорын яллах дүгнэлтэд залилах гэмт хэрэг хаана үйлдэгдсэнийг тодорхой заагаагүй байхад анхан шатны шүүх уг хэргийг шүүх хуралдаанаараа хэлэлцүүлж шийдвэрлэсэн тохиолдол цөөнгүй гарчээ. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 16.2 дугаар зүйлд заасан “нотлогдвол зохих байдал”-д гэмт хэрэг хаана үйлдэгдсэнийг тогтоохоор заасныг олон үйлдэлтэй залилах хэрэг дээр шүүх орхигдуулах хандлагатай байна.



12. Шүүхийн өмнөх шатанд залилах гэмт хэргийн хохирлын хэмжээг үнэн бодитой тогтоох талаар учир дутагдалтай ажилладаг гэж дүгнэлээ. Залилах гэмт хэргээр зүйлчлэх хохирлын хэмжээг хуурч мэхлэх, итгэл эвдэх аргаар бусдад учруулсан шууд хохирлоор тодорхойлно. Харин шууд бус хохирлыг энэ гэмт хэргээр зүйлчлэх хохирлын хэмжээнд оруулан тооцохгүй бөгөөд түүгээр зүйлчлэлийг өөрчлөхгүй. Бусдын өмчлөх эрхийг хуурч мэхлэх, итгэл эвдэх болон бусад аргаар олж авсан тохиолдолд уг эрхээр баталгаажсан эд хөрөнгийн зах зээлийн үнэлгээгээр бодит буюу шууд хохирлыг тооцно.

Шүүхийн шийдвэрүүдээс ажиглахад олон үйлдэлтэй залилах хэргийн хувьд эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татахаас өмнө буруутай этгээд зарим хохирлыг барагдуулсан байх бөгөөд өмнө барагдуулсан хохирлыг эрүүгийн хэргийн хохирол гэж үзэх нь зөв эсэх дээр нэгдсэн ойлголтод хүрэх хэрэгтэй байна. Зарим шүүгч барагдуулсан хохирлыг хасах буюу эрүүгийн хэрэг үүсгэсэн үед төлөгдөөгүй байсан хохирлын хэмжээг баримталж байхад зарим нь тухайн хохирогчид учирсан нийт хохирлыг гэмт хэргийн хохиролд тооцож, харин төлсөн хохирлыг хохирол барагдуулсан хэмээн дүгнэж байна.

13. Хуулийн этгээд, иргэд бизнесийн үйл ажиллагаанд хамтран ажиллах, хувь нийлүүлэх, хөрөнгө оруулах зэрэг гэрээ, хэлцлээр халхавчлан, улмаар хуулийн этгээдийн хөрөнгө, орлогыг үнэгүйдүүлэх, нуун дарагдуулах, хөрөнгө оруулалтад хяналт тавих боломжийг алдагдуулах зэрэг аргаар залилах гэмт хэрэг үйлдсэн буюу үйлдлийнх нь арга хувьсан улам нарийсаж байгаа нь шүүхийн шийдвэрүүдээс харагдлаа.

Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэгт хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр заагаагүй бөгөөд цаашид Эрүүгийн хуулийн тусгай ангийн 17.3 дугаар зүйл буюу залилах гэмт хэрэгт хуулийн этгээдийн нэрийн өмнөөс залилах гэмт хэрэг үйлдсэн, эд хөрөнгийг компанидаа авсан нь нотлогдсон



тохиолдолд хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэх боломжийг Эрүүгийн хуулиар нээж өгөх шаардлагатай.

Залилах гэмт хэрэгтэй тэмцэхэд хамгийн гол нь иргэдийн хууль эрх зүйн мэдлэг, ухамсрыг дээшлүүлэх, албан бус сургалт явуулах зэрэг дэс дараатай арга хэмжээ авах шаардлагатай юм. Үүний тулд иргэдэд хууль сурталчлах, эрх зүйн албан бус сургалт өргөнөөр явуулахад шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг төр тогтмол гаргаж байх үүрэгтэй.

Иргэдийн хувьд залилах гэмт хэргийн хохирогч болохоос өөрийгөө болон гэр бүл, ойр дотнын хүмүүсээ хамгаалах, энэ хэргээс урьдчилан сэргийлэхийн тулд хууль эрх зүйн тодорхой мэдлэг, боловсролтой байх шаардлагатай юм. Залилагчид өөрийнх нь үг, үйлдэлд хууртах гэнэн, итгэмтгий хүмүүсийг сонгож луйвар хийдэг учир иргэд наанадаж хуульчаас зөвлөгөө авдаг хэвшилд суралцах нь зүйтэй юм.

Судлаачид дээр дурдсан дүгнэлтэд үндэслэн дараах зөвлөмжийг боловсрууллаа. Үүнд:

**А. Эрүүгийн хууль тогтоомжийг боловсронгуй болгох хүрээнд:**

1. “Давтан гэмт хэрэг” гэх тодорхойлолтыг Эрүүгийн хуулийн ерөнхий ангид сэргээн хуульчлах шаардлагатай гэж үзэж байна. Давтан гэмт хэргийг Эрүүгийн хуулийн ерөнхий ангиас хасаж, түүний орон зайг үргэлжилсэн үйлдэлтэй нэг гэмт хэрэг эсвэл нийлмэл гэмт хэрэг гэсэн ойлголтуудаар нөхөж болно гэх ойлголт практикт хүндрэл учруулж, арга ядахдаа “байнга үйлдэж амьжиргааны эх үүсвэр болгосон” гэдэг хүндрүүлэх шинжийг залилан зэрэг зарим зүйл ангид нэмж хуульчилсан ч асуудлыг шийдвэрлэж чадахгүй байна.

2002 оны Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 18 дугаар зүйлд гэмт хэрэг давтан үйлдэх талаар тодорхойлохдоо “Эрүүгийн хуулийн нэг зүйл, нэг хэсэгт заасан гэмт хэргийг хоёр ба түүнээс дээш удаа үйлдсэн байхыг давтан гэмт хэрэг гэнэ”

гэжээ. Тусгай ангийн хэд хэдэн зүйл, хэсэгт заасан хоёр ба түүнээс дээш гэмт хэрэг үйлдэх нь зөвхөн тусгай ангид заасан тохиолдолд давтан гэмт хэрэгт тооцогдоно. Хуульд заасан үндэслэл, журмын дагуу эрүүгийн хариуцлагаас чөлөөлөгдсөн, ялгүй болсон, ялгүйд тооцогдсон этгээд гэмт хэрэг шинээр үйлдсэн нь давтан гэмт хэрэг болохгүй.

2. Хүчин төгөлдөр үйлчилж буй Эрүүгийн хуулийн 2.5 дугаар зүйлд хохирлын хэмжээг бага, үлэмж, их гэж гурав ангилсан бөгөөд онц их хэмжээний хохирлыг хуульчлаагүйгээс залилах гэмт хэрэг үйлдэж, тэрбумаас дээш хэмжээний хохирол учруулсан этгээдүүд хэт хөнгөн ял авч, хохирол барагдахгүй байх нөхцөл бүрджээ.

2002 оны Эрүүгийн хуулиар онц их хэмжээний хохирол учруулсан залилан мэхлэгчид 10-15 жилийн хорих ял оногдуулдаг байсан бол хүчин төгөлдөр үйлчилж буй 2015 оны Эрүүгийн хуулиар 2-8 жилийн хорих ял оногдуулахаар заасан ч шүүх голчлон доод хэмжээг баримталж байна<sup>27</sup>. Иймд Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 2.5 дугаар зүйлд онц их хэмжээний хохирол гэж 500,000 нэгж<sup>28</sup> ба түүнээс дээш хэмжээний хохирлыг ойлгоно гэж, тусгай ангийн өмчийн эсрэг гэмт хэргүүд ялангуяа 17.3 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт “онц их хэмжээний хохирол учруулсан бол” гэж хуульчлах шаардлагатай байна.

Түүнчлэн “ноцтой хохирол”, “хор уршиг” гэх ойлголт нь шүүхийн тайлбар, шүүгчийн дотоод итгэлээр дамжин илэрдэг, хэрэглэхэд төвөгтэй учир Эрүүгийн хуулийн тусгай ангийн 17.3 дугаар зүйлийн 2.2-т өөрчлөлт оруулж “үлэмж хэмжээний хохирол учруулсан бол” гэж өөрчлөх нь зүйтэй. Өөрөөр хэлбэл, 10-50 сая төгрөгийн хохирол учруулсан бол 17.3 дугаар зүйлийн 2.2-т зааснаар, онц их хэмжээний хохирол учруулсан бол 17.3

<sup>27</sup> Сүхбаатар дүүргийн ЭХАШШ-ийн 2018.08.29-ний өдрийн 644 тоот шийтгэх тогтоол, [www.shuukh.mn](http://www.shuukh.mn)

<sup>28</sup> Судлаачдын гаргасан санал, нэг нэгж нь 1000 төгрөгтэй тэнцэнэ.



дугаар зүйлийн 3-т зааснаар тус тус зүйлчлэх нь зүйтэй гэсэн зөвлөмж гаргаж байна.

3. Залилах гэмт хэргийн үйлдлийн аргуудыг хэт дэлгэрүүлэн тайлбарлах аргаар буюу нэг нь нөгөөгийнхөө утга агуулгыг илэрхийлсэн арга, хэлбэрийг давхардуулан хуульчилсныг өөрчлөн “бусдын эд хөрөнгө эсхүл түүнийг өмчлөх эрхийг хуурч мэхлэх, итгэл эвдэх аргаар олж авсны улмаас багаас дээш хэмжээтэй хохирол учруулсан бол” гэж заах нь зохистой юм.

Онолын бүтээл, шүүхийн практикаас үзэхэд залилах гэмт хэргийн хуурч мэхлэх, итгэл эвдэх аргуудын илрэх хэлбэр олон янз байхаас гадна урьдчилан мэдэх боломжгүйгээр хувьсан улам нарийсаж байх тул хуурч мэхэлсэн, итгэл эвдсэн аргуудын илрэх хэлбэр бүрийг нарийвчлан хуульчлах нь төвөгтэй асуудал юм.

4. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 7 дугаар бүлэгт сэжигтний эрх, үүргийг тодорхойлох шаардлагатай. Өмнө дурдсанчлан эхлээд гэрчийн мэдүүлэг авна гэж дуудан ирүүлж буруутай байдлаар өөрийнх нь эсрэг мэдүүлэг авсны дараа яллагдагчаар татаж хэргийг прокурорт шилжүүлдэг байдал нэлээд хавтгайрчээ. Харин хуульд сэжигтний эрх, үүргийг тусгавал дуудагдсан этгээд өөрийг нь сэжигтнээр татах тохиолдолд мэдүүлэг өгөхөөс татгалзах, өмгөөлөгч авах, өөрийнхөө болон гэр бүлийнхээ эсрэг мэдүүлэг өгөхгүй байх зэрэг Үндсэн хуульд заасан эрхээ эдлэх бололцоо бүрдэх юм.

5. Хөдөлмөрийн залилангийн талаар Монгол Улсын хууль тогтоомжид тодорхой тусгагдсан зүйл үгүй учир цаашид Эрүүгийн болон Зөрчлийн тухай хуульд нэмж оруулах шаардлагатай.

Хувийн хэвшлийн зарим компани “ажилтан авна” гэсэн зар өгч нарийн мэргэжил шаардахгүй ажилд боловсрол багатай залуусыг авч, ямар нэгэн гэрээгүй ажиллуулаад

хөдөлмөрийн хөлс хүчийг нь ашиглаад цалин, урамшуулал өгөлгүй хөөж явуулах нь хөдөлмөрийн залилангийн илрэх гол хэлбэр юм. Барилгын зарим бригад “өдөрт нь цалин өгнө” гэж ажиллуулсныхаа дараа хөлс төлөхгүй бултах, зарим нь бүтэн сар ажиллуулсныхаа эцэст ямар ч цалин өгөхгүй байгаа нь мөн л хөдөлмөрийн залилангийн нэг хэлбэр мөн. Тиймээс цаашид “Хохирлын хэмжээ 300 нэгжид хүрэхгүй бол Зөрчлийн хуулиар, 300 нэгжээс дээш хохиролтой бол Эрүүгийн хуульд “залилах гэмт хэрэг” гэж тусгах нь зүйтэй” гэж судлаачид үзсэн.

### **Б. Эрүүгийн хуулийг нэг мөр, зөв хэрэглэх тухайд:**

1. Эн түрүүнд хэргийн зүйлчлэлд анхаарах шаардлагатай байна. Эрүүгийн хуулийн тусгай ангийн 17.3 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн 3.1-т заасан “энэ гэмт хэргийг байнга үйлдэж амьдралын эх үүсвэр болгосон” гэх хүндрүүлэх шинжийг хэрэглэхдээ зөвхөн залилах үйлдлийн тоо, давтамжид голлон анхаарч гэмт этгээд залилах үйлдлийг гурав ба түүнээс дээш удаа үйлдсэн л бол шууд “...байнга үйлдэж амьдралын эх үүсвэр болгосон” гэж дүгнэх нь буруу юм. Зүй нь шүүгдэгч этгээд тогтвортой буюу тодорхой хугацаанд давтамжтайгаар залилах гэмт хэрэг үйлдсэн эсэх, амьдралын өөр эх үүсвэртэй буюу ажил хөдөлмөр эрхэлдэг эсэх, гэмт хэргээс өөр аргаар орлого олж байсан эсэх, гэмт хэргийн замаар олсон орлогыг амьжиргаандаа зарцуулсан эсэх зэрэг олон хүчин зүйлийг харгалзан үзэж байж дүгнэлт хийх ёстой.

2. Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн зүйл, заалтыг зөв хэрэглэх шаардлагатай байна. Эрүүгийн хуулийг буцаан хэрэглэхдээ 2002 оны болон 2015 оны Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн заалтуудын аль ашигтайг (яллагдагч, шүүгдэгчийн хувьд) нь түүвэрлэн хэрэглэх бус харин нэг хуулийн зүйл, заалтуудыг дагнан хэрэглэх нь зөв практик болно. Өөрөөр хэлбэл, 2002 оны Эрүүгийн хуулийн заалтыг



баримталсан л бол уг хуулийн дагуу шийдвэрлэнэ, түүнээс биш зарим тохиолдолд 2015 оны хуулийн зүйл, заалтаас сонгон хэрэглэхгүй гэсэн жишиг барих нь зүйтэй.

3. Залилах гэмт хэргийн улмаас олсон орлого, эд хөрөнгө, мөнгийг зориулалтын бусаар зарцуулсан, үрэн таран хийсэн тохиолдолд мөнгө угаах гэмт хэргээр давхардуулан зүйлчлэх шаардлагагүй. Залилсан мөнгө, эд хөрөнгөө бусдад шилжүүлсэн, үрэн таран хийсэн тохиолдолд энэ нь мөнгө угаах гэмт хэргийн шинж агуулахгүй. Учир нь уг мөнгөний эх үүсвэр нь хохирогчийн мөнгө, эд хөрөнгө учир гэмт хэргийн замаар олсон, хууль бус эх үүсвэртэй гэж үзэж болохгүй юм. Харин банк дээрэмдсэн, хар тамхины наймаа хийсэн зэрэг хууль бус эх үүсвэрийн мөнгийг эх үүсвэрийг нь нуун далдлах зорилгоор өөрчилсөн, шилжүүлсэн; түүний бодит шинж чанар, эх үүсвэр, байршил, захиран зарцуулах арга, эзэмшигч, эд хөрөнгийн эрхийг нуун далдалсан бол мөнгө угаах гэмт хэрэг гэж үзнэ.

4. Олон шатлалт маркетинг, пирамид тогтолцооны луйврын аргаар залилах гэмт хэрэг үйлдсэн тохиолдолд сүлжээнд эхэлж элсээд өөрийн ойр дотны хүмүүс, найз нөхөд, хамаатан саданг элсүүлсэн хүн өөрөө мөн л хууртсан, өөрийн оруулсан хөрөнгийг өсгөж авахын тулд бусдыг элсүүлсэн байдаг учир оруулсан мөнгөө олж авсан тохиолдолд түүнийг иргэний хариуцагчаар татаж, эд хөрөнгийн хариуцлага хүлээлгэх нь шударга ёсонд нийцнэ.

5. Анхан шатны шүүхээс залилах гэмт хэргийг цагаатгахдаа Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 36.9 дүгээр зүйлийн 1.1, 1.2-т заасан агуулга, үндэслэлийг хангах шаардлагатай. Хохирогч тал нь гомдолтой, хохирол барагдаагүй байхад “Гэрээ хийгдсэн, гэрээгээ нотариатаар батлуулсан нь иргэний эрх зүйн шинжтэй маргаанд тооцогдоно” гэсэн агуулгаар шүүхээс хэргийг хэрэгсэхгүй болгох нь буруу жишиг юм.

6. Иргэний хэргийг залилах гэмт хэргээс ялгахдаа дараах нөхцөл байлдалд анхаарах учиртай. Үүнд:

- Иргэний хууль тогтоомжийн дагуу үүсэж, гэрээний биелэлтийн талаар мэдээлэл солилцон, харилцан гомдлын шаардлага гарган гэрээгээ дүгнэж байгаад эцэст нь эрсдэлд орсны улмаас үүссэн маргаан, гэрээний эрсдэлийг залилах гэмт хэрэг гэж үзэхгүй;
- Харин гэрээгээр хүлээсэн үүрэг нь биелэгдэх боломжгүй болмогц түүгээр шалтаглаж бусдын эд хөрөнгө эсхүл түүнийг өмчлөх эрхийг бүгдийг нь юм уу заримыг нь шилжүүлэхгүй байх гэмт санаа зорилго өвөрлөж, үүнийгээ хэрэгжүүлэхийн тулд эзэмшигч, өмчлөгчийг төөрөгдүүлэх замаар хуурч мэхлэх, итгэл эвдэх, тодорхой үйлдэл хийсэн нь хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ажиллагааны явцад тогтоогдвол залилах гэмт хэрэг гэж үзэн, эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ;
- Байгалийн давагдашгүй хүч, нийгэм, эдийн засгийн харилцааны зохицуулалтын өөрчлөлт, гэнэтийн осол, өвчин эмгэг, хорио цээр зэрэг талуудаас үл шалтгаалах хүчин зүйл буюу нөхцөл байдал урьдчилан тооцоолох боломжгүйгээр гэнэт өөрчлөгдсөний улмаас гэрээний үүрэг биелэгдээгүйг залилах гэмт хэрэг гэж үзэхгүй;
- Залилах гэмт хэргийн бүрэлдэхүүний объектив талын шинж болох хуурч мэхлэх буюу итгэл эвдэх нь бусдын эд хөрөнгө эсхүл түүнийг өмчлөх эрхийг өөртөө олж авах санаа зорилго агуулж, үүнд чиглэсэн идэвхтэй үйлдлээр илэрдэг тул хуурч мэхлэх, итгэл эвдэх ямар нэгэн үйлдэл хийгээгүй бол гэмт хэрэгт тооцохгүй;
- Залилах гэмт хэргийн халхавч болсон гэрээ хэлцэл нь хуурч мэхлэх, итгэл эвдэх аргад үндэслэсэн, шунахайн сэдэлтээр, дан ганцаар ашиг олох, гэрээнд оролцогч нөгөө талаа хохироох зорилгоор хийгдсэн байдаг;



- Иргэний эрх зүйн гэрээний харилцаа нь талуудын чөлөөт байдал, тэгш эрх, харилцан тодорхой үр дүнд хүрэхийн тулд хийгддэг учир гэрээ анхнаасаа биелэгдэх бодит боломжгүй байсан нь тогтоогдсон, гэрээний нэг тал үүнийг урьдчилан мэдсээр байж байгуулсан, нөгөө тал (хохирогч) нь мэдээгүй буюу мэдэх боломжгүй байсан бол залилах гэмт хэрэг гэж үзнэ;
- Бусдын эд хөрөнгийг “зээл” нэрээр халхавчлан залилах нь уг зээлийг буцааж төлөх бодит баталгаагүй, тухайлбал, барьцааны хөрөнгөгүй, хөрөнгө нь байлаа ч эрхийн зөрчилтэй, тухайн эд хөрөнгийг барьцаалах бүрэн эрхгүй этгээд барьцаалсан, түүнчлэн Иргэний хуульд заасан барьцааны гэрээ байгуулах журмыг санаатай зөрчсөн байдаг зэргээр иргэний эрх зүйн зээлийн гэрээнээс ялгагдана;
- Гэрээний үүргийн биелэлтийг баталгаажуулах зорилгоор барьцааны гэрээ байгуулахад барьцаалсан эд хөрөнгө нь үүрэг гүйцэтгүүлэгч гэрээний үүргийн шаардлагаа хангуулж авахад ямар нэгэн саад бэрхшээлгүй, боломжтой байх ёстой тул барьцааны эд хөрөнгө үүрэг гүйцэтгүүлэгчийн шаардлагыг анхнаасаа хангах боломжгүй байсан, үүрэг гүйцэтгэгч үүнийг мэдэж байсан ч санаатайгаар нуун далдалсан нь тогтоогдвол залилах гэмт хэрэг гэж үзнэ;
- Гэрээний харилцаагаар халхавчлан бусдын эд хөрөнгийг залилах гэмт хэргийг мөрдөн шалгах, хянан шийдвэрлэхэд хуурч мэхлэх, итгэл эвдэх аргаар бусдын эд хөрөнгө эсхүл эд хөрөнгийн эзэмших эрхийг олж авах гэсэн субъектив санаа зорилготой байсан эсэхийг заавал тогтоосон байвал зохино.



## АШИГЛАСАН МАТЕРИАЛ

### А. Хууль тогтоомж

1. БНМАУ-ын Үндсэн хууль, 1924, 1940, 1960.
2. Монгол Улсын Үндсэн хууль, 1992.
3. Шүүх цаазын бичиг, 1926, 1929, 1932.
4. БНМАУ-ын Эрүүгийн хууль, 1961, 1986.
5. Монгол Улсын Эрүүгийн хууль, 2002, 2015.
6. Монгол Улсын Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, 2017.
7. Зөрчлийн тухай хууль, 2017.

### Б. Нэг сэдэвт бүтээл, сурах бичиг, гарын авлага

1. Д.Адьяабазар, Монгол Улсын 1921 оноос хойших Эрүүгийн хууль тогтоомжийн хөгжилт, УБ., 1998.
2. Б.Ганболд, Гэмт хэрэг зүйлчлэлийн онол, УБ., 2005.
3. Д.Баярсайхан, Харьцуулсан Эрүүгийн эрх зүй, УБ., 2011.
4. Б.Жадамба, Ц.Чимэдлхам, Судалгааны арга зүй, УБ., 2011.
5. С.Жанцан, Монгол Улсын эрүүгийн эрх зүй, УБ., 2010.
6. Монгол Улсын Дээд шүүхийн тогтоолын эмхэтгэл, УБ., 2010.
7. Монгол Улсын Олон улсын гэрээний эмхэтгэл. УБ., 2003.
8. С.В.Боботов, Уголовное законодательство зарубежных стран, Под ред. И.Д.Козочкина, М., 2001.

9. Российское уголовное право, Особенная часть. Под ред. В.Н.Кудрявцева и А.В.Наумова, М., 2011.

## **В. Сэтгүүл**

1. “Төрийн мэдээлэл” сэтгүүл, 2002-2020.
2. “Шүүх эрх мэдэл” сэтгүүл, 2013-2020.
3. “Хууль дээдлэх ёс” сэтгүүл, 2013-2020 оны дугаарууд.
4. “Шихихутуг” сэтгүүл, 2010-2020 оны дугаарууд.
5. “Тэмт явдалтай тэмцэх асуудал” сэтгүүл, 2010-2020 оны дугаарууд.
6. “Монголын төр, эрх зүй” сэтгүүл, 2009-2020.

## **Г. Мэдээллийн сайтууд**

1. [www.shuukh.mn](http://www.shuukh.mn)
2. [www.1212.mn](http://www.1212.mn)
3. <http://www.legalinfo.mn/>
4. <http://www.suprem.justia.com/us/463/277/case.html>
5. <https://www.judoinstitute.mn>
6. [https://ru.qwe.wiki/wiki/Penal\\_code\\_\(South\\_Korea\)](https://ru.qwe.wiki/wiki/Penal_code_(South_Korea))
7. <http://ru.china-embassy.org/rus/zfhz/zgflyd/t1330730.htm>
8. <https://www.twirpx.com/file/239675>



## ХАВСРАЛТ

### Хавсралт 1. Анхан шатны шүүхийн шийтгэх тогтоолууд

№	Тогтоолын дугаар	Огноо	Зүйлчлэл	Ялын хэмжээ
1	147	2019-2-21	17.3 зүйлийн 2.2	4 жилийн хорих ял
2	644	2018-8-29	17.3 зүйлийн 2.2	2 жилийн хорих ял
3	461	2018-6-5	17.3 зүйлийн 1	250 цаг нийтэд тустай ажил
4	97	2020-1-28	17.3 зүйлийн 2.2 ба 2.1	4 жилийн хорих ял
5	61	2020-1-13	17.3 зүйлийн 3.1	5 жилийн хорих ял
6	03	2019-12-24	17.3 зүйлийн 3.1	6 жилийн хорих ял
7	122	2020-2-6	17.3 зүйлийн 3.1	6 жил 11 сарын хорих ял
8	30	2020-1-6	17.3 зүйлийн 3.1	6 жилийн хорих ял
9	961	2019-11-13	17.3 зүйлийн 3.1	6 жилийн хорих ял
10	758	2019-9-4	17.3 зүйлийн 3.1	6 жилийн хорих ял
11	777	2019-8-22	17.3 зүйлийн 3.1	6 жилийн хорих ял
12	1266	2019-8-12	17.3 зүйлийн 3.1	7 жилийн хорих ял
13	1098	2019-7-8	17.3 зүйлийн 3.1	10 жилийн хорих ял



14	377	2019-5-10	17.3 зүйлийн 3.1	6 жилийн хорих ял
15	344	2019-4-11	17.3 зүйлийн 3.1	6 жилийн хорих ял
16	835	2019-5-23	17.3 зүйлийн 3.1	6 жилийн хорих ял
17	843	2020-9-25	17.3 зүйлийн 3.1 23.2	7 жил 11 сарын хорих ял
18	53	2019-1-8	17.3 зүйлийн 3.1	6 сар тэнссэн
19	625	2019-4-19	17.3 зүйлийн 3.1	10 жилийн хорих ял
20	121	2019-1-23	17.3 зүйлийн 3.1	7 жилийн хорих ял
21	247	2019-2-12	17.3 зүйлийн 3.1	7 жилийн хорих ял
22	853	2018-11-6	17.3 зүйлийн 2.2	3 жил 6 сарын хорих ял
23	848	2018-11-5	17.3 зүйлийн 3.1	5 жилийн хорих ял
24	605	2018-7-20	17.3 зүйлийн 3.1	Зүйлчлэлийг 17.3 зүйлийн 1 болгож 1 жилийн хорих ял
25	671	2018-8-23	17.3 зүйлийн 1	3 жил 5 сарын хорих ял
26	2018-2-13	2018-2-13	17.3 зүйлийн 2.2.	3 жилийн хорих ял

*Хавсралт 2. Давж заалдах шатны шүүхийн магадлалууд*

№	Магадлалын дугаар	Огноо	Магадлалын агуулга
1	2020/ ДШМ/12	2020-12-24	БГДЭХАШШ-ийн 843 тоот шийтгэх тогтоолыг хянаад хэргийг буцааж шийдвэрлэсэн.
2	979	2018-10-25	СБДЭХАШШ-ийн 644-р шийтгэх тогтоолыг хэвээр үлдээсэн.
3	482	2020-4-21	БГДЭХАШШ-ийн 121 тоот шийтгэх тогтоолд өөрчлөлт оруулж хорих ялыг 4 жил болгосон.
4	236	2021-3-9	ЭХТА-ийн 17.3 дугаар зүйлийн 3.3-аар ял оногдуулсныг тогтоолд өөрчлөлт оруулж ялыг хөнгөрүүлсэн.
5	955	2020-7-30	БГДЭХАШШ-ийн 1189 тоот шүүгчийн захирамжийг хэвээр үлдээж хэргийг буцааж шийдвэрлэсэн.
6	679	2020-5-26	СБДЭХАШШ-ийн 728 тоот шүүгчийн захирамжийг хүчингүй болгож дахин хэлэлцүүлэхээр шийдвэрлэсэн
7	1043	2020-8-20	Анхан шатны шийтгэх тогтоолыг хүчингүй болгож хэргийг прокурорт буцаасан.
8	92 Дархан	2020-12-09	Сум дундын шүүхийн 341 тоот шийтгэх тогтоолыг хэвээр үлдээсэн.



9	949	2020-7-28	ЭХТА-ийн 17.3 дугаар зүйлийн 3.1-ээр 6 жил 6 сарын хорих ял оногдуулсан ялыг хөнгөрүүлсэн.
10	917	2020-7-9	СБДЭХАШШ-ийн 375 тоот тогтоолыг хэвээр үлдээсэн.
11	857	2020-7-2	Хан-Уул дүүргийн ЭХАШШ-ийн 946 тоот захирамжийг хүчингүй болгож дахин хэлэлцүүлэхээр шийдвэрлэсэн.
12	650	2020-5-21	БГДЭХАШШ-ийн 226 тоот шийтгэх тогтоолыг хянаад хэвээр үлдээсэн.
13	604	2020-5-14	БЗДЭХАШШ-ийн 249 тоот шийтгэх тогтоолыг хянаад хэвээр үлдээсэн.
14	598	2020-5-12	“Шүүгдэгч А.М-д зургаан жилийн хугацаагаар хорих ял шийтгэсүгэй” гэснийг “Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 2.2 дугаар зүйлийн 3 дахь хэсгийг журамлан тусгай ангийн 17.3 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 2.1 дэх заалтад зааснаар Шүүгдэгч А.М-д дөрвөн жил хорих ял шийтгэсүгэй” гэж өөрчилсөн.
15	729	2020-6-4	БГДЭХАШШ-ийн 2020 оны 4 дүгээр сарын 1-ний өдрийн 2020/ШЦТ/310 дугаартай шийтгэх тогтоолыг хүчингүй болгож, прокурорт буцаасан.

Хавсралт 3. Хяналтын шатны шүүхийн тогтоолууд

№	Тогтоолын дугаар	Огноо	Тогтоолын агуулга
1	338	2019-6-21	СБДЭХАШШ-ийн 644-р шийтгэх тогтоол, 979 тоот магадлалыг тус тус хэвээр үлдээсэн.
2	65	2019-2-18	БГДЭХАШШ-ийн 848 дугаар шийтгэх тогтоол, Нийслэлийн Эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүхийн 2018 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн 1 дүгээр магадлалд “Прокуророос Б.У-д Эрүүгийн хуулийн тусгай ангийн 17.3 дугаар зүйлийн 3.1-д заасан гэмт хэрэгт холбогдуулан яллах дүгнэлт үйлдэж ирүүлсэн хэргийн зүйлчлэлийг мөн хуулийн тусгай ангийн 17.3 дугаар зүйлийн 1 дэх хэсэг болгон өөрчилсүгэй”, “Б.У-г зохиомол байдлыг зориудаар бий болгох, бодит байдлыг нуух замаар бусдыг төөрөгдөлд оруулж, өмчлөгчийн эд хөрөнгийг шилжүүлэн авсан гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцсугай”, “Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 2.2 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт заасныг баримтлан шүүгдэгч Б.У-г Эрүүгийн хуулийн тусгай ангийн 17.3 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар 2 (хоёр) жил хорих ял шийтгэсүгэй”, “Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 7.6 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасныг баримтлан шүүгдэгч Б.У-д 2 (хоёр) жил хорих ял оногдуулсан шүүхийн шийдвэр биелүүлэхийг 2 (хоёр) жил хүртэл хугацаагаар хойшлуулсугай” гэсэн өөрчлөлт оруулав.



3	375	2019-9-9	<p>Баянзүрх дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2019 оны 2 дугаар сарын 14-ний өдрийн 259 дүгээр шийтгэх тогтоол, Нийслэлийн Эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүхийн 2019 оны 4 дүгээр сарын 25-ны өдрийн 378 дугаар магадлалын тогтоох хэсгийн 2 дахь заалтыг “Шүүгдэгч Л.Б-д Эрүүгийн хуулийн тусгай ангийн 17.3 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар 10,000 нэгжтэй тэнцэх хэмжээний буюу 10,000,000 төгрөгөөр торгох ял оногдуулсугай” гэж өөрчилжээ.</p>
4	538	2019-10-23	<p>1. Төв аймаг дахь сум дундын Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2019 оны 2 дугаар сарын 13-ны өдрийн 46 дугаар шийтгэх тогтоол, Төв аймгийн Эрүү, Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн 2019 оны 6 дугаар сарын 24-ний өдрийн 60 дугаар магадлалын тогтоох хэсэгт:          “Прокуророос шүүгдэгч Э.М-д 2015 оны Эрүүгийн хуулийн 17.3 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар яллах дүгнэлт үйлдэж ирүүлсэн хэргийг Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 34.19 дүгээр зүйлийн 1.1 дэх хэсэгт зааснаар хэрэгсэхгүй болгож, түүнийг цагаатгасугай” гэсэн нэмэлт заалт оруулжээ.</p> <p>2. Шийтгэх тогтоолын тогтоох хэсгийн 1, 2, 3 дахь заалтад шүүгдэгч Э.М-ийг гэм буруутайд тооцож, ял оногдуулсан хэсгийг хүчингүй болгосон байна.</p>



5	567	2019-10-30	<p>1. Сүхбаатар дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2019 оны 4 дүгээр сарын 16-ны өдрийн 359 дүгээр шийтгэх тогтоолын тогтоох хэсгийн 2 дахь заалтад “Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 2.2 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт заасныг журамлан” гэснийг хүчингүй болгон шийдвэрлэжээ.</p> <p>2. Шийтгэх тогтоол, түүнд өөрчлөлт оруулсан Нийслэлийн Эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүхийн 2019 оны 7 дугаар сарын 16-ны өдрийн 707 дугаар магадлалыг тус тус хэвээр үлдээж, шүүгдэгчийн өмгөөлөгч С.Оюунцэцэгийн хяналтын журмаар гаргасан гомдлыг хэрэгсэхгүй болгожээ.</p>
6	628	2019-12-02	<p>1. Баянгол дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2019 оны 7 дугаар сарын 17-ны өдрийн 631 дүгээр шийтгэх тогтоол, Нийслэлийн Эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүхийн 2019 оны 8 дугаар сарын 27-ны өдрийн 864 дүгээр магадлалыг бүхэлд нь хүчингүй болгож, шүүгдэгч Г.Я-д холбогдох хэргийг анхан шатны шүүхээр дамжуулан Баянгол дүүргийн прокурорын газарт буцаажээ.</p>



7	643	2019-12-13	<p>1. Сонгинохайрхан дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2019 оны 5 дугаар сарын 10-ны өдрийн 516 дугаар шийтгэх тогтоол, Нийслэлийн Эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүхийн 2019 оны 8 дугаар сарын 29-ний өдрийн 878 дугаар магадлалд:</p> <p>“Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 1.5 дугаар зүйлийн 1.2 дахь хэсэгт зааснаар шүүгдэгч С.Г-д холбогдох Эрүүгийн хуулийн 11.7 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1.1-д заасан гэмт хэргийг хэрэгсэхгүй болгож, түүнийг эрүүгийн хариуцлагаас чөлөөлсүгэй” гэсэн заалтыг нэмж, шийтгэх тогтоолын тогтоох хэсгээс шүүгдэгч С.Г-д Эрүүгийн хуулийн 11.7 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1.1-д зааснаар оногдуулсан нэг жил хорих ялыг нэмж нэгтгэсэн заалтыг тус тус хүчингүй болгосон байна.</p> <p>2. Шийтгэх тогтоолын тогтоох хэсгийн 3, 4 дэх заалтад “8 (найм) жил 6 (зургаа) сарын хорих ял” гэснийг “7 (долоо) жил 6 (зургаа) сар” гэж тус тус өөрчилжээ.</p>
---	-----	------------	---

8	84	2020-2-12	1. Баянзүрх дүүргийн эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2019 оны 8 дугаар сарын 2-ны өдрийн 1232 дугаар шийтгэх тогтоолд: “Баянзүрх дүүргийн прокуророос шүүгдэгч Л.У-д холбогдуулан шилжүүлсэн хэргээс “Рич альфа майнинг” ХХК-ийг хуурч 5,678,210 төгрөг залилсан гэх үйлдлийг Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 34.19 дүгээр зүйлийн 1.1-д зааснаар хэрэгсэхгүй болгосугай” гэсэн заалт нэмжээ.
9	216	2018-5-16	1. Сүхбаатар дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2017 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн 514 дүгээр шийтгэх тогтоолын тогтоох хэсгийн 6 дахь заалтын “Хан-Уул дүүргийн Цагдаагийн хэлтэст” гэснийг “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагад” гэж өөрчилж, тогтоолын бусад заалтыг хэвээр үлдээж, Нийслэлийн Эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүхийн 2018 оны 2 дугаар сарын 22-ны өдрийн 175 дугаар магадлалыг хүчингүй болгосон байна.
10	435	2019-9-25	Сонгинохайрхан дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2019 оны 3 дугаар сарын 6-ны өдрийн 285 дугаар шийтгэх тогтоол, Нийслэлийн Эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүхийн 2019 оны 5 дугаар сарын 28-ны өдрийн 513 дугаар магадлалыг тус тус хүчингүй болгож, шүүгдэгч Ц.Д-д



			холбогдох хэргийг анхан шатны шүүхээр дахин хэлэлцүүлэхээр Сонгинохайрхан дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхэд буцаажээ.
11	521	2019-10-21	<p>1. Хэнтий аймгийн Бор-Өндөр сум дахь сум дундын шүүхийн 2019 оны 4 дүгээр сарын 8-ны өдрийн 22 дугаар шийтгэх тогтоол, Хэнтий аймгийн Эрүү, Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн 2019 оны 7 дугаар сарын 3-ны өдрийн 30 дугаар магадлалд:</p> <p>“Шүүгдэгч А.У-г албан тушаалын байдлаа ашиглаж бусдын эд хөрөнгийг залилан мэхэлж авсан гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцож, 2002 оны Эрүүгийн хуулийн тусгай ангийн 148 дугаар зүйлийн 148.2 дахь хэсэгт зааснаар хоёр жил хорих ял шийтгэсүгэй”, “Шүүгдэгч А.У-д 2002 оны Эрүүгийн хуулийн тусгай ангийн 148 дугаар зүйлийн 148.2 дахь хэсэгт зааснаар оногдуулсан хоёр жилийн хорих ялыг Анхны ардчилсан сонгууль болж байнгын ажиллагаатай парламент байгуулагдсаны 25 жилийн ойг тохиолдуулан өршөөл үзүүлэх тухай 4 дүгээр зүйлийн 4.1-д зааснаар өршөөн хэлтрүүлсүгэй” гэсэн нэмэлт, өөрчлөлт оруулсан.</p>

12	63	2018-2-14	Сүхбаатар дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2017 оны 8 дугаар сарын 22-ны өдрийн 276 дугаар шийтгэх тогтоол, түүнд өөрчлөлт оруулсан Нийслэлийн Эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүхийн 2017 оны 11 дүгээр сарын 9-ний өдрийн 772 дугаар магадлалыг тус тус хүчингүй болгож, хэргийг дахин хэлэлцүүлэхээр анхан шатны шүүхэд буцаажээ.
13	64	2018-2-14	Сүхбаатар дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2017 оны 8 дугаар сарын 21-ний өдрийн 274 дүгээр цагаатгах тогтоолыг хүчингүй болгосон Нийслэлийн Эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүхийн 2017 оны 11 дүгээр сарын 9-ний өдрийн 774 дүгээр магадлалыг хэвээр үлдээсэн байна.
14	314	2018-6-27	Чингэлтэй дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2017 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн 13 дугаар шийтгэх тогтоол, Нийслэлийн Эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүхийн 2018 оны 4 дүгээр сарын 12-ны өдрийн 363 дүгээр магадлалыг тус тус хэвээр үлдээж, шүүгдэгч Ц.С-ийн өмгөөлөгч Б.Тэнгисийн хяналтын шатны шүүхэд гаргасан гомдлыг хэрэгсэхгүй болгожээ.



15	118	2018-3-14	Сүхбаатар дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2017 оны 9 дүгээр сарын 28-ны өдрийн 328 дугаар шийтгэх тогтоолд өөрчлөлт оруулсан Нийслэлийн Эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүхийн 2017 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн 2 дугаар магадлалыг хэвээр үлдээжээ.
16	158	2018-4-11	Хан-Уул дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2017 оны 11 дүгээр сарын 3-ны өдрийн 309 дүгээр шийтгэх тогтоолд өөрчлөлт оруулсан Нийслэлийн Эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүхийн 2018 оны 1 дүгээр сарын 18-ны өдрийн 59 дүгээр магадлалыг хэвээр үлдээсэн байна.

# ШҮҮХИЙН ШИЙДВЭРИЙН СУДАЛГАА ХАРИУЦСАН РЕДАКЦЫН ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮДИЙН ТАНИЛЦУУЛГА

ДАШНЯМЫН ЗОЛЖАРГАЛ (LL.M.)

Өмгөөллийн DB&GTS ХХН-ийн гишүүн хуульч



Монголын санхүү, хөрөнгийн зах зээлийн чадварлаг мэргэжилтнүүдийн нэг бөгөөд компанийн эрх зүй, эрчим хүч, эрдэс баялгийн салбараар мэргэшсэн хуульч юм. Хуулийн фирмээ байгуулж ажиллахаасаа өмнө тэрээр Монголын томоохон арилжааны банканд хуульчаар ажилласан туршлагатай.

МУИС-ийн ХЗС-ийн Олон улсын эрх зүйн бакалавр, 2004 онд АНУ-ын Оклахомагийн Их сургуулийг Бизнесийн удирдлагын магистр, Харвардын Их сургуулийн Хуулийн сургуулийг хууль зүйн магистр зэрэгтэй тус тус дүүргэсэн.

АЛТАНГЭРЭЛИЙН БЯМБАЖАРГАЛ (S.J.D.)



МУИС-ийн ХЗС-д төрийн захиргаа, Монгол Улсын Үндсэн хуулийн эрх зүй, Үндсэн хуулийн процессын эрх зүй, харьцуулсан эрх зүйн хичээл заадаг. ХЗС-ийн эрдэмтэн нарийн бичгийн даргын хувиар эрдэм шинжилгээний ажил, бүтээл түүрвил, улирал тутмын “Эрх зүй” сэтгүүлийг эрхлэн гаргах ажил хариуцан ажиллаж байв. 2021 оноос Монгол Улсын Ерөнхийлөгчийн Хууль зүйн бодлогын зөвлөхөөр томилогдон ажиллаж байна.

МУИС-ийн ХЗС-ийг дүүргэж, БНСУ-ын Күүкмений Их сургуульд хууль зүйн докторын зэрэг хамгаалсан.

## НАРАНЧУЛУУНЫ ОТГОНЧИМЭГ (LL.M.)



Захиргааны эрх зүйн чиглэлээр мэргэшсэн хуульч, судлаач бөгөөд УИХ-ын Тамгын газар, олон улсын хөгжлийн хөтөлбөрүүдэд зөвлөх зэргээр мэргэжлээрээ 22 жил ажилласан туршлагатай хуульч юм. 2021 оноос УДШ-ийн дэргэд байгуулагдсан Шүүхийн сургалт, судалгаа, мэдээллийн хүрээлэнгийн захирлаар ажиллаж байна.

МУИС-ийн ХЗС-ийг магистрын зэрэгтэй, Лондоны Kings college-ийг хууль зүйн магистр зэрэгтэй төгссөн.

## ГАНЧУЛУУНЫ ОЮУНБОЛД (LL.M.)



Криминологи, эрүүгийн болон эрүүгийн байцаан шийтгэх эрх зүй, шүүхийн шийдвэр биелүүлэх эрх зүйн чиглэлээр мэргэшиж судалдаг ба практикийн болон судалгааны байгууллагад 18 жил ажилласан туршлагатай.

Цагдаагийн академийг эрх зүйн бакалавр зэрэгтэй төгсөж “Эрүүгийн байцаан шийтгэх хугацаа” сэдвээр хууль зүйн ухааны магистрын зэрэг хамгаалсан. Тэрчлэн Хүмүүнлэгийн ухааны их сургуулийн мэргэжлийн англи хэлний ангид суралцаж менежментийн бакалаврын зэрэгтэй төгссөн.

## СҮХЭЭГИЙН БИЛГҮҮН (LL.M.)

ШЕЗ-ийн Тамгын газрын дарга



Хууль зүйн судалгаа, сургалт, шүүхийн захиргааны чиглэлээр ажилладаг.

МУИС-ийн ХЗС-д суралцаж, “Монгол Улсад эрх зүйн зайлшгүй процессыг төлөвшүүлэх нь” сэдвээр, Япон Улсын Кюсюгийн Их сургуульд суралцаж “Монгол Улс дахь нийтийн ашиг сонирхлыг шүүхэд төлөөлөн хамгаалах тогтолцоог бэхжүүлэх нь” сэдвээр хууль зүйн магистрын зэрэг тус тус хамгаалсан.

Харьцуулсан эрх зүй, хүний эрхийн чиглэлээр судалгаа хийдэг.





ISBN 978-9919-9812-1-1



9 789919 981211